

# ИТГЭЛДЭЭ ҮНЭНЧ БАЙХ нь



СУДРЫН ЗААЛТ

# ИТГЭЛДЭЭ ҮНЭНЧ БАЙХ нь

СУДРЫН ЗААЛТ

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн  
Юта дахь Солт Лейк Хотод хэвлэв.

Хавтас: Саймон Деверийн *Light and Truth* буюу / Гэрэл ба Үнэн/  
© Саймон Деверийнх

© 2004 by Intellectual Reserve, Inc.  
Бүх эрх хамгаалагдсан.  
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв

Англи эхийн зөвшөөрөл: 7/04  
Орчуулгын зөвшөөрөл: 7/04  
*True to Faith*-ын орчуулга  
Mongolian

# ТЭРГҮҮН ЗӨВЛӨЛИЙН ЗАХИАС БИЧИГ

Энэ ном нь судруудыг болон хожмын үеийн бодлогчдын сургаалуудыг судлахад тань хамтрагч болох зорилготойгоор бүтээгдсэн юм. Бид та нарыг сайн мэдээний зарчмуудыг судалж, хэрэглэхдээ үүнтэй холбож авч үзэхийг сайшсаан дэмжиж байна. Та нар үг хэлэхээр бэлдэх, хичээл заах, Сүмийн тухай асуултанд хариулахдаа үүнийг эх сурвалж хэмээн үзэж ашиглана уу.

Сайн мэдээний үнэнийг судлах тусам та өөрт байгаа Тэнгэрлэг Эцэгийн мөнхийн төлөвлөгөөний ойлголтыг нэмэгдүүлэх болно. Та амьдралынхаа утга учир болох энэхүү ойлголтын хамтаар ухаалаг сонголтуудыг хийж, Бурханы хүсэл зорилгод нийцүүлэн амьдарч, амьдралдаа баяр баясгаланг олох чадвартай байх болно. Таны гэрчлэл хүчтэй өсөн нэмэгдэх болно. Та итгэлдээ үнэнч хэвээр үлдэнэ.

Бид голчлон залуучууд, ганц бие насанд хүрэгчид болон шинээр хөрвөгчдөд анхаарлаа хандуулж байна. Та хувийн тогтмол залбирал болон судар, сайн мэдээний сургаалуудыг суналснаар та нарыг хуурч, та нарт хор хүргэх хилэнцэт нөлөөллийг эсэргүүцэхэд бэлтгэгдэх болно.

Энэхүү ном та бүхнийг Аврагч руу ойртуулах, Түүний жишээг дагах хичээл зүтгэлд тань батжуулах болтугай.

Тэргүүн Зөвлөл



# САЙН МЭДЭЭНИЙ СЭДВҮҮДИЙГ

## ЦАГААН ТОЛГОЙН ДЭС ДАРААЛЛААР

## ЗОХИОН БАЙГУУЛАВ

### Аароны Санваар

Бошиглогч Иосеф Смит Мормоны Номыг орчуулахдаа тэрээр нүүглүүдийн учалын төлөөх баптистм тэнд дурдагдсан гэдгийг олж мэдсэн юм. 1829 оны Тавдугаар сарын 15-нд тэрээр өөрийн бичээч Оливер Каудеритайгаа Их Эзэнээс баптистын талаар асуухаар ой руу явжээ. Тэднийг залбирч байхад “Нэгэн тэнгэр элч цацарсан гэрэл дунд доошлон бууж иржээ.” Энэхүү элч нь Есүс Христэд зуун зууны тэргээ баптистм хүртээсэн бошиглогч Иохан Баптист байлаа. Одоо амилуулагдсан бие болох Иохан Баптист Иосеф, Оливер хоёр дээр гар тавин, Агуу Их Урвалтын үед дэлхийгээс авагдсан Аароны Санваарыг тус бүрт нь хүртээсэн юм. Энэхүү эрх мэдлээр Иосеф, Оливер хоёр бие биедээ баптистм хүртээж чадсан байна (Иосеф Смитийн Түүх 1:68–72).

Өнөөдөр Сүмийн зохистой эрэгтэй гишүүд 12 нааснаас эхлэн Аароны Санваарыг хүлээн авч болдог. Тэд санваарын ёслолуудад оролцох ба үйлчлэл үзүүлэх олон боломжуудийг хүлээн авдаг. Тэд үүргээ зохистойгоор биелүүлэхдээ сайн мэдээний адислалыг хүлээн авах бусад хүмүүст туслахаар Их Эзэний нэрээр үйлддэг.

Аароны Санваарын албан тушаалтууд нь бишоп, санваартан, багш болон дикон юм. Диконууд ариун ёслолыг тэргүүлэх санваарын ахлагчийн (ихэвчлэн бишоп буюу салбарын ерөнхийлөгч) зөвшөөрлөөр түгээдэг. Тэд бишоп буюу салбарын ерөнхийлөгчид Сүмийн гишүүдийг үйлчлэл үзүүлэх, мацаг барилтын өргөлийг цуглувулах зэрэг түр зуурын үйл хэргийг дэмжин, харж хандахад нь тусалдаг. Багш нар диконы бүх үүргүүдийг гүйцэтгэж

## *Абрахамын Гэрээ*

болов ба түүнчлэн үйлчлэх бусад боломжуудийг хүлээн авдаг. Тэд ариун ёслолын талх, усыг бэлдэх, гэрийн багшар явах зэргээр үйлчилдэг. Санваартнууд дикон болон багшийн үүргүүдийг гүйцэтгэж болно. Тэд тэргүүлэх санвааарын ахлагчийн зөвшөөрөлтэйгөөр ариун ёслолыг адислах, баптисм хүртээх мөн бусад хүмүүсийг санваартан, багш болон диконы албан үүрэгт томилж болдог.

Аароны Санваар бол “Дээд буюу Мелкизедек Санвааарын хавсралт болж байдаг” (С ба Г 107:14). Үүнийг ихэнхдээ бэлтгэл санваар гэж нэрлэдэг. Аароны Санваарт үйлчилдэг Санвааарыг атгагч нь Мелкизедек Санваар болон ариун сүмийн адислалуудыг хүлээн авах, бүрэн цагийн номлолд үйлчлэх, хайртай эцэг, эх байх, Их Эзэнд амьдралынхаа туршид үйлчлэх зэргээ үргэлжлүүлэхэд бэлтгэдэг.

Мелкизедек Санваар; Санвааарыг *мөн үз*.

## **Абрахамын Гэрээ**

Абрахам сайн мэдээг хүлээн авч, дээд санваартнаар томилогдсон (С ба Г 84:14; Абрахам 1:2-ыг үз). Тэрээр хожим нь өргөмжлөлийн гэрээ болох сэлэстиэл гэрлэлт хийсэн (С ба Г 131:1-4; 132:19, 29-ийг үз). Тэр байгуулсан гэрээгээр Их Эзэнээс өөрийн гэр бүлтэй холбоотой агуу том адислалыг хүлээн авсан юм. Эдгээр амлалтуудын дотор:

- Түүний үр сад тоолшгүй олон болно (Эхлэл 17:5-6; Абрахам 2:9; 3:14-ийг үз).
- Түүний үр удам сайн мэдээг хүлээн авч, санвааарыг үүрнэ (Абрахам 2:9-ийг үз).
- Түүний үр удмын тохинууллаар дамжуулан “Дэлхийн гэр бүлүүд авралын адислалууд, бүр мөнх амьдралын адислалууд болох Сайн Мэдээний адислалуудаар адислагдах болно” (Абрахам 2:11).

Их Эээнээс хүлээн авсан Абрахамын бүх гэрээ болон амлалтууд нь Абрахамын гэрээ гэж нэрлэгддэг. Энэ бол Абрахамын бүх үр удамд хүрсэн мөнхийн гэрээ билээ (Эхлэл 17:7-г үз). Абрахамын удам хэмээн тооцогдохын тулд хувь хүн сайн мэдээний ёслолууд болон хуулийг дагах ёстой. Тийнхүү хэдийгээр хүн Абрахамын шууд удам биш ч гэсэн Абрахамын гэрээний бүх адислалыг хүлээн авч чадна (Галат 3:26–29; 4:1–7; С ба Г 84:33–40-ийг үз).

Та бол Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүний хувьд гэрээн дор төрсөн хүүхэд мөн (3 Нифай 20:25–26-г үз). Та сайн мэдээг хүлээн авч, Абрахам, Исаак, Иаковт өгөгдсөний адил амлалтыг өвлөн авсан билээ. Та авралын ёслолыг хүлээн авах, үүнтэй холбогдох гэрээнүүдийг сахихад итгэлтэй байдлынхаа дагуу санваарын мөн мөнх амьдралын адислал авах эрхтэй. Дэлхийн үндэстнүүд таны хичээл зүтгэл болон таны үр удмын хөдөлмөрөөр адислагдах болно.

Гэрээ; Ёслолууд; Мөнх Амьдрал; Патриархын Адислалууд; Санваарыг мөн үз.

## Аврагдсан (Авралыг үз)

### Аврал

Христийн шашинтай бусад хүмүүстэй ярилцаж байхад тань “Та аврагдсан уу?” хэмээн зарим үед асууж болох юм. Энэ асуултыг асууж байгаа хүмүүс ихэвчлэн Есүс Христийг өөрийн Их Эзэн бөгөөд Аврагчаа хэмээн хүлээн зөвшөөрсөн гэдгийг тунхаглах буюу чин сэтгэлээ илчлэн хэлэх үйлтэй холбоотой юм. Уг асуултыг асууснаар тэд Төлөөлөгч Паулын бичсэн дараах үгсэд өөрсдийнхөө итгэлийг харуулдаг:

“Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл,

## *Аврал*

аврагдах болно. Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрөн авралд хүрнэ” (Ром 10:9–10).

“Та Аврагдсан уу?” Гэсэн Асуултанд Хариулах нь

Ром 10:9–10-т аврагдсан ба аврал хэмээх үгнүүд нь Есүс Христтэй байгуулсан гэрээний харилцааг чухалчлан үздэг. Энэхүү гэрээний харилцаагаар дамжуулан, хэрэв бид дуулгавартай байвал нүглийн мөнхийн үр дагавруудаас аврал ирдэг гэж бидэнд итгүүлдэг. Итгэлтэй Хожмын Үеийн Гэгээнтэн бүр энэхүү уттын дагуу аврагдах болно. Бид сэргээгдсэн сайн мэдээнд хөрвүүлэгдсэн юм. Баптисмын ёслолоор дамжуулан бид Түүний нэрийг өөрсөд дээрээ авч, Аврагчтай гэрээний харьцаатай болсон. Бид баптисмын гэрээг ариун ёслолоос хүртэн шинэчилдэг.

## *Аврал Хэмээх Үгийн Ялгаатай Утгууд*

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн сургаалд *аврагдсан*, *аврал* хэмээх нэр томъёонууд хэд хэдэн утгатай байдаг. Эдгээр утгуудын дагуу “Та аврагдсан уу?” гэсэн асуултын хариулт “тийм” эсвэл болзотойгоор “тийм” гэсэн хоёр янз байна. Доорх тайлбарууд нь *аврал* хэмээх үгийн зургаан өөр утга юм.

*Биеийн Үхлээс Аврагдах Аврал.* Мэдээж бүх хүмүүс үхнэ. Гэвч Цагаатгал болон Есүс Христийн Амилуулалтаар дамжин бүх хүмүүс амилууллагдан—биеийн үхлээс аврагдана. “Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьдруулагдах болно” хэмээн Паул гэрчилсэн юм (1 Коринт 15:22).

*Нүглээс Аврагдах Аврал.* Аврагчийн Цагаатгалаар дамжуулан нүглээс цэвэршигдэхийн тулд та Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлж, наманчилж, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авах ёстой (Үйлс 2:37–38-ыг үз).

Тодорхой санваарын эрх мэдлээр дамжуулан хэрэв та баптисм хүртээд, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авсан бол болзолтойгоор аль хэдийн нүглээс аврагдсан билээ. Эцсээ хүртэл итгэлтэйгээр тэвчиж, газар дэлхий дээрх амьдралаа дуусгах хүртлээ та нүглээс бүрмөсөн аврагдаж чадахгүй.

Нүгэлдээ аврагдаж чадахгүй гэдгийг анхаар; та зүгээр Христэд итгэдгээ амьдралынхаа үлдсэн хугацаанд нүгэл үйлдэх нь маргаангүй гэсэн ойлголтой байгаагаа тунхагласнаар болзолт бус авралыг хүлээн авч чадахгүй (Алма 11:36–37-г үз). Бурханы алдар суугаар дамжуулан та нүглээсээ аврагдаж чадна (Хиламан 5:10–11-ийг үз). Энэхүү адислалыг хүлээн авахын тулд та Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлж, зарлигуудыг сахихаар хичээж, нүглээ орхин, ариун ёслолоор дамжуулан цэвэршигдэн, наманчлалаа шинэчлэх ёстой.

*Дахин Төрөх нь.* Дахин төрсөн эсэхийг тань заримдаа асууж болох юм. Сүнсний дахин төрөлтийн зарчим судруудад тогтмол гардаг. Шинэ Гэрээ бид “дахин төрөх” ёстой бөгөөд “ус болон сүнснээс төрөхгүйгээр бид Бурханы хаанчлалд орж чадахгүй” гэсэн Есүсийн заасан зүйлийг агуулдаг (Иохан 3:3, 5). Энэхүү заасан зүйл нь Мормоны Номонд батлагдсан байдаг: “Бүх хүн төрөлтөн, тийм ээ, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, бүх үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүс дахин төрөх ёстой. Бурханаар төрөх, эгэл мөн унасан байдлаасаа, зөв шударга байдалд орж өөрчлөгдөн, Бурханаар гэтэлгэгдэн, түүний хөвгүүд мөн охид болох буюу; Мөн тийн тэд шинэ бүтээлүүд болох болно; мөн үүнийг хийхгүйгээр, тэд Бурханы хаант улсыг өвлөж чадах арга үгүй бөлгөө” (Мозая 27:25–26).

Энэхүү дахин төрөлт бол биднийг баптисм хүртээд, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авсны дараа тохиох явц юм. Энэ нь “үлдсэн бүх өдрүүддээ түүний бидэнд зарлиглах бүх зүйлүүдэд түүний зарлигуудад дуулгавартай

## *Аврал*

байх” бидний бэлэн байдлын үр дүнгээс үүдэлтэй (Мозая 5:5). Дараа нь бидний “зүрх сэтгэл түүний нэрэнд итгэх итгэлээр өөрчлөгджэй, тиймийн тул, бид түүнээс төрдөг” (Мозая 5:7). Хэрэв та баптисм хүртэж, Есүс Христийн нэрийг өөртөө авах гэрээг Ариун Сүнсний бэлгийн хамт хүлээн авсан бол, та дахин төрсөн гэж хэлж болно. Хүндэтгэлийн өдөр ариун ёслолоос хүртэх бүртээ та дахин төрлтөө шинэчилж чадна.

*Тоомжиргүй Байдлаас Аврагдах Аврал.* Олон хүмүүс сэргээгдсэн сайн мэдээний гэрлийг мэдэхгүйгээр харанхуй байдалд амьдардаг. Тэд “үүнийг хаанаас олохыг мэддэггүйн улмаас гагцхүү үнэнээс хол байдаг” (С ба Г 123:12). Их Эзэний Сүмийн гишүүний хувьд та энэхүү байдлаас аврагдсан билээ. Бурхан Эцэг, Есүс Христ, амьдралын зорилго, авралын төлөвлөгөө, мөнхийн чадавхийн тухай мэдлэг танд байгаа. “Би бол ертөнцийн гэрэл мөн. Намайг дагадаг хүн харанхуй дотор явахгүй, харин амийн гэрэлтэй байх болно” хэмээн тунхагласан Аврагчийн шавь ёсоор та амьдарч чадна (Иохан 8:12).

*Хоёр дахь Үхлээс Аврагдах Аврал.* Судрууд заримдаа хоёр дахь үхлээс аврагдах авралын тухай өгүүлдэг. Хоёр дахь үхэл бол алдар суугийн аливаа хаант улсад оршихыг үгүйсгэн, зөв шударга байдлаас хаягдсан сүүлчийн сүнслэг үхэл билээ (Алма 12:32; С ба Г 88:24-ийг үз). Энэхүү хоёр дахь үхэл Сүүлчийн Шүүлт хүртэл ирэхгүй ба цөөн хэдэн хүнд л энэ нь ирэх болно (С ба Г 76:31–37-г үз). Дэлхий дээр амьдарч байсан бараг хүн бүрт хоёр дахь үхлээс аврагдахыг ятгасан (С ба Г 76:40–45-ыг үз).

*Мөнх Амьдрал буюу Өргөмжлөл.* Судруудад аврагдсан ба аврал хэмээх үгсийг ихэнхдээ мөнх амьдрал буюу өргөмжлөлтэй холbon үздэг (Абрахам 2:11-ийг үз). Мөнх амьдрал бол Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийг танин мэдэх, тэдэнтэй үүрд хамт сэлэстиэл хаант улсын хамгийн дээд

зэрэглэлийг өвлөн амьдрахыг хэлнэ (Иохан 17:3; С ба Г 131:1-4; 132:21-24-ийг үз). Энэхүү агуу бэлгийг хүлээн авахын тулд бид нүглээ наманчлан, баптисм хүртэж, санваарын эрх мэдэл бүхий хүнээр гишүүнээр батлуулахаас илүү их зүйл хийх ёстай. Эрэгтэйчүүд Мелкизедек Санваар хүлээн ав, Сүмийн бүх гишүүд ариун сүмийн нандин гэрээ болон мөнхийн гэрлэлтээ сахих ёстай.

Хэрэв бид *аврал* хэмээх үгийг мөнхийн амьдрал гэдэг утгаар хэрэглэдэг бол бидний хэн маань ч зуурдын байдалд аврагдсан гэж хэлж чадахгүй. Тэрхүү алдар суут бэлэг зөвхөн Сүүлчийн Шүүлтийн дараа л ирж чадна.

Нэмэлт судрууд: Матай 10:22; Марк 16:16; Ефес 2:8-10; Иаков 2:14-18; 2 Нифай 25:23, 26; Мозая 5:8-15; 3 Нифай 9:21-22; Моронай 10:32-33; Итгэлийн Тунхаг 1:3

Авралын Төлөвлөгөө; Алдар Суугийн Хаант Улсууд; Ач Ивээл; Баптисм; Есүс Христийн Цагаатгал; Мөнх Амьдралыг *мөн* үз.

## Авралын Төлөвлөгөө

Зуурдын байдлын өмнөх оршихуйд Тэнгэрлэг Эцэгтэй адилхан болж, бүрэн баяр баясталанг хүлээн авахыг бидэнд боломжтой болгож өгөхийн тулд Тэрээр төлөвлөгөө бэлтгэсэн. Судрууд энэхүү төлөвлөгөөг “авралын төлөвлөгөө” (Алма 24:14; Мose 6:62); “аз жаргалаын төлөвлөгөө” (Алма 42:8), “гэтэлгэлийн төлөвлөгөө” (Алма 12:30), “нигүүлслийн төлөвлөгөө” (Алма 42:15) хэмээн нэрлэдэг.

Авралын төлөвлөгөө бол сайн мэдээний бүрэн байдал юм. Энэ нь Бүтээлт, Уналт, Есүс Христийн Цагаатгал болон бүх хууль, ёслолууд мөн сайн мэдээний заадаг зүйлсийг агуулдаг. Сонгох болон өөрсдийнхөө төлөө үйлдэх чадвар болох ёс суртахууны сонголт нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд мөн зайлшгүй хэрэгтэй юм. Энэ төлөвлөгөөний учир бид Цагаатгалаар дамжуулан

төгөлдөржиж, бүрэн баяр баясгаланг хүлээн авч, Бурханы оршихуйд үүрд амьдарч чадна. Бидний гэр бүлийн харилцаа мөнхөд үргэлжилж чадна.

Та бол Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд оролцогч ба мөнхийн туршилаа гурван гол хэсэгт хуваагдана: зуурдын байдлын өмнөх амьдрал, зуурдын амьдрал болон үхлийн дараах амьдрал. Та төлөвлөгөөг ойлговол олон хүмүүсийн асуудаг асуултуудад хариулах хариултаяа олно: Бид хаанаас ирсэн бэ? Бид яагаад энд байна вэ? Энэ амьдралын дараа хаашаа явах вэ?

### Зуурдын Байдлын Өмнөх Амьдрал

Дэлхийд мэндлэхээсээ өмнө та Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд Түүний сүнсний хүүхдүүдийн нэг болж амьдарч байсан. Энэхүү зуурдын байдлын өмнөх амьдралд та Тэнгэрлэг Эцэгийн бусад сүнсэн хүүхдүүдийн хамтаар зөвлөлд оролцсон. Зөвлөлд Тэнгэрлэг Эцэг Өөрийн аз жаргалын агуу төлөвлөгөөг танилцуулсан (Абрахам 3:22-26-г үз).

Аз жаргалын төлөвлөгөөнд нийцүүлэн зуурдын байдлын өмнөх Эцэгийн сүнснүүдийн Анхны Хүү Есүс Христ Аврагч байхаар гэрээ байгуулсан юм (Моце 4:2; Абрахам 3:27-г үз). Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг дагасан тэдэнд дэлхийд ирж, зуурдын байдлыг туулж, мөнх амьдралын зүг дэвшихийг зөвшөөрчээ. Бурханы өөр нэг хүү, Люсифер тэрхүү төлөвлөгөөний эсрэг босч, “хүмүүний сонгох эрхийг эрэлхийлсэн” юм (Моце 4:3). Тэрээр Сатан болж, түүний дагалдагчид тэнгэрээс хөөгдөж бие махбодь хүлээн авах, мөн зуурдын байдлыг туулах эрхээсээ татгалзжээ (Моце 4:4; Абрахам 3:27-28-ыг үз).

Зуурдын байдлын өмнөх амьдралд та өөрийгөө таньж хөгжүүлсэн, мөн өөрийн сүнслэг боломж бололцоогоо нэмэгдүүлсэн. Сонголт хийх бэлгээр адислагдаж, та Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг дагана гэсэн чухал

шийдвэрийг гаргасан. Энэхүү шийдвэр нь тэр үед но-лоөлсон бөгөөд одоо ч мөн адил. Та үнэнийг эрэлхийлэхэд суралцаж, оюуны чадамж өсч, өсөлт хөгжилтөө цааш үргэлжлүүлж болох дэлхийд ирэхээр бэлтгэсэн юм.

### Зуурдын Амьдрал

Эдүгээ та зуурдын амьдралд амьдарч байна. Таны сүнс зуурдын амьдралын өмнөх амьдралд боломжгүй байсан арга замд өсч хөгжих боломжуудыг олгохоор биетэй тань нэгдсэн. Оршин байх энэхүү хэсэг бол Христэд ирэхээр сонгож, мөнхийн амьдралын төлөө зохистой байхаар бэлтгэж, өөрийгөө нотлон харуулахад суралцах цаг хугацаа юм. Түүнчлэн энэ нь үнэнийг олоход, авралын төлөвлөгөөний гэрчлэлийг олж авахад нь бусад хүмүүст тусалж чадах танд зориулсан цаг хугацаа мөн.

### Үхлийн дараах Амьдрал

Таныг нас барахад сүнс тань сүнсний дэлхийд очиж, амилуулалтыг хүлээдэг. Амилуулалтын үед таны сүнс, бие хоёр эргэн нэгдэж, мөн та шүүгдэж, алдар суугийн хаант улсад орох болно. Таны өвлөн авах алдар суу таны хөрвүүлгийн байдал болон Их Эзэний зарлигуудад дуулгавартай байсан эсэхээс хамаарах болно (“Алдар Суугийн Хаант Улс” х.14-ийг үз). Энэ нь “Есүсийн гэрчлэлийг хүлээн авсан” төлөв байдлаас хамаарна (С ба Г 76:51; мөн шүлэг 74, 79, 101-ийг үз).

Төлөвлөгөөний Тухай Мэдлэгээр Дамжин Ирэх  
Адислалууд

Авралын төлөвлөгөөний тухай гэрчлэл таныг амьдралын бэрхшээлүүдтэй тэмцэлдэхэд тань найдвар, зорилгыг өгнө. Та бол Бурханы хүүхэд, та дэлхийд төрөхөөсөө өмнө Түүний оршихуйд амьдарч байсан

## **Агуу Үнэт Сувд**

хэмээх мэдлэгт тайтгаралыг олж авч чадна. Зуурдын амьдралд үйлдсэн үйлдэл тань мөнхийн хувь тавиланд нөлөөлдөг гэдгийг ухаарснаар та одоогийнхoo амьдралын утгыг мэдэж авч чадна. Энэхүү мэдлэгээр та чухал шийдвэрүүдээ амьдралын нөхцөл байдлын өөрчлөлтөөс илүү мөнхийн үнэнд үндэслэж чадна. Та үргэлжлүүлэн гэр бүлийн гишүүдтэйгээ харьцах харилцаагаа гэр бүл мөнх байж чадна гэдэг амлалтанд талархан дээшлүүлж чадна. “Зөв шударгын үйлсүүдийг хийх тэрээр шагналаа, бүр энэ дэлхийд амар амгаланг хийгээд ирэх дэлхийд мөнх амьдралыг хүлээн авах болно” гэдгийг мэдсэнээр та Цагаатгалын талаарх гэрчлэл болон Их Эзэний зарлигууд, ёслолууд, гэрээ мөн сайн мэдээнд баяр баясгаланг олж чадна (С ба Г 59:23).

Нэмэлт судрууд: 2 Нифай 2:5–30; 10:23–25; Алма 12:24–37; 22:12–14; 42; Моце 6:47–62

Алдар Суугийн Хаант Улс; Амилуулалт; Биеийн Үхэл; Бурхан Эцэг; Бүтээлт; Диваажин; Есүс Христ; Есүс Христийн Цагаатгал; Сайн Мэдээ; Сонголт; Сүнслэг Үхэл; Там; Тэнгэр; Уналтыг мөн үз.

## **Агуу Үнэт Сувд** (Судруудыг үз)

### **Аз Жаргал**

Лихай Бурханы “мөнхийн зорилгуудыг” гэрчлэн хэлэхдээ, “мөн тэд баясгалантай байж болохын тулд хүмүүн байх бөлгөө” гэдгийг сургамжилсан (2 Нифай 2:15, 25).

Бурхан биднийг үүрдийн, үнэн аз жаргалыг олоосой гэж хүсдэг. Бидний аз жаргал бол Түүний бидэнд өгдөг сайн мэдээний сургаалууд, зарлигууд, санваарын ёслолууд, гэр бүлийн харилцаа, бошиглогчид, ариун сүмүүд, бүтээлтийн гоо сайхан хийгээд тэр ч байтугай бусармаг зүйлийг мэдрэх боломж зэрэг бүхий л адислалуудын шийдэл билээ. Түүний авралын төлөвлөгөөг “агуу их аз

жаргалын төлөвлөгөө” гэж нэрлэдэг (Алма 42:8). Тэрээр Цагаатгалыг гүйцэлдүүлэхээр Өөрийн Хайрт Хүүг илгээсэн, тиймээс бид энэ амьдралд аз жаргалтай байж чадах бөгөөд мөнхөд бүрэн баяслыг хүлээн авч чадна.

Олон хүмүүс жаргал болон ололт амжилтыг Их Эзэний зарлигуудад харшилах үйл ажиллагаануудаас олохыг хичээдэг. Тэд Бурханы төлөвлөгөөг үл хайхран үнэн аз жаргалын эх сурвалжаас татгалздаг. Тэд “бүх хүмүүн өөрийн адил зовлонт байж болохыг эрэлхийлдэг” чөтгөрт автагддаг (2 Нифай 2:27). Тэд цаашдаа Алмагийн хүү Кориантонд өгсөн сануулгын үнэнийг сурдаг, “ёс бус гэдэг нь хэзээ ч аз жаргал байгаагүй” (Алма 41:10).

Бусад хүмүүс нь амьдралаа хөгжилтэй өнгөрүүлэхийг хичээдэг. Тэд ийм гол зорилготойгоор зуурдын таашаал авахын тулд үүрдийн аз жаргалаас өөрсдийгөө холдуулдаг. Тэд өөрсдийгөө үүрдийн сүнслэг өсөлт, үйлчлэл хийгээд шаргуу хөдөлмөрөөс ирдэг баяр баяслаас холдуулдаг.

Аз жаргалтай байхаар эрэлхийлэхдээ, жинхэнэ аз жаргалтай байх цорын ганц зам бол сайн мэдээгээр амьдрах нь юм гэдгийг сана. Та зарлигуудыг сахиж, хүч чадлын төлөө залбирч, нүглүүдээ наманчилж, сэтгэл сэргээсэн сайхан үйл ажиллагаануудад оролцож, мөн утга төгөлдөр үйлчлэл үзүүлэхийг хичээнээр амар амгалан, мөнхийн аз жаргалыг олох болно. Хайрт Тэнгэр дэх Эцэгийн тогтоож өгсөн хязгаар дотор байхдаа та баяр хөөртэй байхыг сурах болно.

Таны аз жаргал халдвартай байж болно. Бусад хүмүүс таныг ажиглах үедээ, тэд таны баяр баяслыг сурч, мэдэж авахыг хүсч болно. Тэгээд тэд Есүс Христийн сайн мэдээгээр амьдарснаар дамжин ирдэг аз жаргалыг амсч чадна.

Нэмэлт судрууд: Дуулал 35:9; 2 Нифай 5:27; Мозая 2:41; 3 Нифай 17:18–20; 4 Нифай 1:15–16; С ба Г 18:10–16

Авралын Төлөвлөгөө; Номлогчийн Ажил; Үйлчлэлийг мөн үз.

## **Айлчлагч Багшаар Явах нь** (Нийгмийн Халамжийн Бүлгийг үз)

### **Алдар Суугийн Хаант Улсууд**

Бүх хүмүүс Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан амилуулагдах болно (Алма 11:42–45). Бид амилуулагдсныхаа дараа Их Эзэний өмнө зогсоод шүүгдэх болно (Илчлэлт 20:12; 3 Нифай 27:14-ийг үз). Хүн бүр тодорхой алдар суугийн мөнхөд орших газарт томилогдох болно. Их Эзэн “Миний Эцэгийн гэрт олон байр бий” хэмээн хэлэхдээ энэ зарчмыг заажээ (Иохан 14:2).

Сэлэстиэл хаант улс, тэррэstriэл хаант улс, мөн тэлэстиэл хаант улс гэсэн алдар суугийн гурван хаант улс байдаг. Таны өвлөн авах алдар суу нь таны хөрвүүлгийн гүн, Их Эзэний зарлигуудад хэр дуулгавартай байснаас шалтгаална. Энэ нь “Есүсийн тухай гэрчлэлийг хүлээн авсан маягаас” тань хамаарах болно (С ба Г 76:51; мөн түүнчлэн 74, 79, 101 дүгээр шүлгүүдийг үз)

### **Сэлэстиэл Хаант Улс**

Сэлэстиэл хаант улс бол алдар суугийн хаант улсын хамгийн дээд нь юм. Энэхүү хаант улсад байх тэд Бурхан Эцэг болон Түүний Хүү Есүс Христийн оршихуйд үүрд амьдрах болно. Сэлэстиэл алдар сууг өвлөж, мөн уг агуу адислалуудыг хүлээн авахад нь бусдад туслах нь таны зорилго байх ёстой. Ийм зорилгыг нэг оролдлогоор олж авч чадахгүй; энэ нь амьдралынхаа турши зөв шударга байж, мөн байнгын зорилготой байсны үр дүн юм.

Сэлэстиэл хаант улс бол “Есүсийн гэрчлэлийг хүлээн авч” мөн “өөрийн цус ургалтаар дамжуулан энэхүү төгс цагаатгалыг хийсэн шинэ гэрээний зууч Есүсээр дамжин төгс болгогдсон” хүмүүст зориулан бэлтгэсэн газар юм (С ба Г 76:51, 69). Энэхүү бэлгийг өвлөн авахын тулд

бид авралын ёслолуудыг хүлээн авч, зарлигуудыг сахиж, мөн нүглүүдээ наманчлах ёстой. Сэлэстиэл алдар сууг хүлээн авах тэдний талаарх нарийн тайлбаруудыг Сургаал ба Гэрээ 76:50-70, 92-96-гаас үз.

Сэлэстиэл алдар сууг өвлөн авахад шаардлагатай ойлголтыг нь тэлсэн илчлэлтийг Бошиглогч Иосеф Смит 1836 оны Нэгдүгээр сард хүлээн авчээ. Түүнд тэнгэр нээгдэж, тэрээр сэлэстиэл хаант улсыг харжээ. Хэдийгээр түүний том ах Алвин нь баптисмын ёслолыг хүлээн авахаасаа өмнө нас барсан ч тэнд Алвин байгааг хараад тэрээр маш их гайхжээ (С ба Г 137:1-6-г үз). Тэгээд Их Эзэний дуу хоолой Бошиглогч Иосефт хэлсэн нь:

“Энэ сайн мэдээний тухай мэдлэггүйгээр нас барсан тэд бүгд, үүнийг хүлээн авч болох тэд, хэрэв үлдэх нь тэдэнд зөвшөөрөгдсөн аваас, Бурханы сэлэстиэл хаант улсыг өвлөгчид байх болно;

“Тэрчлэн үүнээс хойш үүний тухай мэдлэггүйгээр нас барах тэд бүгд, үүнийг бүх зүрх сэтгэлээрээ хүлээн авч болох тэд, уг хаант улсыг өвлөгчид байх болно;

“Учир нь Их Эзэн бибээр, бүх хүмүүнийг ажлуудынх нь дагуу, зүрх сэтгэлийнх нь хүслийн дагуу шүүх болно” (С ба Г 137:7-9).

Энэ илчлэлтийг тайлбарлан Бошиглогч Иосеф хэлэхдээ, “тэрчлэн хариуцлагын насанд хүрэхээсээ өмнө нас барсан бүх хүүхэд тэнгэрийн сэлэстиэл хаант улсад аврагддагийг бибээр болгоов” гэжээ ( С ба Г 137:10).

Бошиглогч Иосефт өгөгдсон өөр нэг илчлэлтээс бид сэлэстиэл хаант улсад гурван зэрэглэл байдгийг сурч авсан билээ. Бид хамгийн дээд зэрэглэлд өргөмжлөгдөж, гэр бүлийн харилцаагаа үргэлжлүүлэхийн тулд “гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээнд орж, уг гэрээндээ үнэнч байх ёстой. Өөрөөр хэлбэл, ариун сүмийн гэрлэлт бол сэлэстиэл алдар суугийн хамгийн дээд зэрэглэлийг олж авах шаардлага юм (С ба Г 131:1-4.) Энэ боломж нь гэрлэлтийн

## *Алдар Сүүгийн Хаант Улсууд*

шинэ бөгөөд үүрдийн гэрээнд ороход зохистой бүх хүмүүст энэ амьдралд эсвэл ирэх амьдралд ирэх болно.

### **Тэррэstriэл Хаант Улс**

Тэррэstriэл алдар сууг өвлөн авах хүмүүс “Эцэгийн бүрэн байдлыг бус харин Хүүгийн оршихуйг хүлээн авдаг. Иймийн тул, тэд бол сэлэстиэл биес бус тэррэstriэл биес бөгөөд нарнаас сар ялгардаг шиг алдар сууд ялгардаг болой” (С ба Г 76:77–78). Ерөнхийд нь хэлэхэд, тэррэstriэл хаант улс дахь хувь хүмүүс нь “хүмүүжний башир аргаар харалган болсон” шударга сайн хүмүүс юм (С ба Г 76:75). Энэ бүлэг хүмүүс дотор “Есүсийн тухай гэрчлэлд нэн хүчтэй биш” Сүмийн гишүүд багтдаг. (С ба Г 76:79). Үүнд түүнчлэн сайн мэдээг зуурдын амьдралд хүлээн авах боломжоос татгалзсан боловч, зуурдын амьдралын дараах сүнсний дэлхийд хожим нь үүнийг хүлээн авсан хүмүүс багтдаг (С ба Г 76:73–74-ийг үз). Тэррэstriэл алдар сууг өвлөн авах хүмүүсийн талаар илүү ихийг сурахын тулд Сургаал ба Гэрээ 76:71–80, 91, 97-г үз.

### **Тэлэстиэл Хаант Улс**

Тэлэстиэл алдар суу нь “Есүс Христийн сайн мэдээг, түүнчлэн Есүсийн тухай гэрчлэлийг хүлээн аваагүй” хувь хүмүүст хадгалагдан үлддэг (С ба Г 76:82). Эдгээр хүмүүс өөрсдийнхөө алдар сууг зарим үед там хэмээн нэрлэгддэг сүнсний шоронгоос гэтэлгэгдсэнийхээ дараа хүлээн авах болно (С ба Г 76:84, 106-г үз). Тэлэстиэл алдар сууг өвлөн авах хүмүүсийн талаарх нарийвчилсан тайлбар нь Сургаал ба Гэрээ 76:81–90, 98–106, 109–112-т бий.

### **Мөхөл**

Зарим хүмүүс алдар суугийн ямар ч хаант улсад амьдрахад зохистой бус байх болно. Тэднийг “мөхлийн

хөвгүүд” хэмээн нэрлэх ба тэд алдар суугийн хаант улс бус хаант улсыг тэсэн гарах болно (С ба Г 76:32; 88:24). Энэ нь “[Бурханы] сүр хүчийг мэддэг, мөн үүнийг хүртэгсэд болгогдсон, мөн чөтгөрийн хүчээр дамжин өөрсдийгөө ялагдсан байхыг, мөн үнэнийг үгүйсгэхийг хийгээд [Бурханы] хүчийг эсэргүүцэхийг зөвшөөрсөн тэд болой” (С ба Г 76:31; мөн шүлэг 30, 32–49-ийг үз).

Нэмэлт судрууд: 1 Коринт 15:40–42; С ба Г 88:20–39; 130:18–19

Авралын Төлөвлөгөө; Есүс Христийн Цагаатгал; Мөнхийн Амьдрал; Там; Тэнгэрийг мөн үз.

## Амар Амгалан

Олон хүмүүс дайн дажин байхгүй бол амар амгалан байна гэж үздэг. Гэвч бид амар амгаланг дайны үед ч мэдээрч чаддаг ч дайн байлдаан байхгүй үед ч амар амгалангаар дутмаг байдаг. Зөрчилдөөн байхгүйн улмаас зүрх сэтгэлд амар амгалан ирдэг нь хангалттай биш юм. Амар амгалан нь сайн мэдээгээр дамжин—Есүс Христийн Цагаатгал, Ариун Сүнсний тохинуулал, зөв шударга байдал, чин сэтгэлийн наманчлал болон идэвх чармайлттай үйлчлэлээр дамжуулан ирдэг.

Тэр ч байтугай дэлхий, таны эргэн тойронд бачимдан байхад та дотроо амар амгаланг хүлээн авч чадна. Та сайн мэдээний гэрчлэлдээ үнэнч байж, таныг хайрладаг, хамгаалдаг Тэнгэрлэг Эцэг болон Есүсийг санан дурсваас энэхүү адислал нь тантай хамт байх болно.

Амар амгаланг өөртөө мэдэрдэг бол та, гэр бүл, нийгэмд мөн дэлхийд амар амгалангийн нөлөө байж чадна. Та зарлигуудыг дагаж, үйлчлэл үзүүлж, гэр бүлийн гишүүд болон хөршдөө санаа тавьж, сайн мэдээг хуваалцах үед та амар амгалангийн төлөө ажиллаж байдаг. Та хэзээд нэгнийхээ шаналлыг тайтгаруулахаар туслахдаа амар амгалангийн төлөө ажиллаж байгаа юм.

Аврагчийн доорх үгс нь бидэнд сайн мэдээний өгдөг амар амгаланг хэрхэн хүртэхийг заадаг:

“Туслагч буюу Миний нэрээр Эцэгийн минь илгээх Ариун Сүнс та нарт бүх зүйлсийг заах бөгөөд Миний та нарт хэлсэн бүгдийг сануулах болно.

“Амар амгаланг би та нарт үлдээнэ. Би Өөрийн амар амгаланггаа та нарт өгнө. Ертөнцийн өгдгөөс өөр юмыг та нарт өгч байна. Та нар эзүрхээ бүү зовоо. Бүү ай” (Иохан 14:26–27).

“Сайныг үйлдэхээс бүү ай, хөвгүүд минь, учир нь та нар юу тарина, та нар мөн түүнчлэн хурааж авах болно; тиймийн тул, хэрэв та нар сайныг таривал та нар шагналдаа түүнчлэн сайныг хурааж авах болно.

“Тиймийн тул, бүү ай, бяцхан сүрэг; сайныг үйлдэг-түн; дэлхий хийгээд там та нарын эсрэг нэгдэг, учир нь хэрэв та нар миний хадан дээр баригдсан байх аваас, тэд дийллэх нь үгүй.

“Болгоогтун, би та нарыг зэмлэх нь үгүй; өөрсдийнхөө замаар явж мөн нүглийг дахин бүү үйлд; та нарт миний зарли-гуудыг ажлыг буурь суурьтайгаар гүйцэтгэгтүн.

“Санаа бодол болгондоо над уруу харагтуун; бүү эргэлз, бүү ай.”

“Болгоогтун, Миний хажуу талыг цоо хатгасан шархыг, мөн түүнчлэн миний гар мөн хөлөн дэх хадаасны ормуудыг болгоогтун; итгэлтэй байгтуун, миний зарли-гуудыг сахигтуун, мөн та нар тэнгэрийн хаант улсыг өвлөх болно” (С ба Г 6:33–37).

“Миний дотор та нарыг амар амгалан бай гэж Би та нарт эдгээр зүйлсийг хэллээ. Ертөнцөд та нар зовлон-той байна. Гэвч зоригтой байгтуун. Би ертөнцийг ялсан” (Иохан 16:33).

Та Аврагчийг санан дурсаж, Түүнийг дагаваас, та үнэхээр урам зоригтой байж чадна. Та бүхий л цаг үед үргэлж, бодит амар амгаланг амсаж чадна. Түүний

Амилуулалтын дараа Өөрийн шавь нартаа Аврагчийн анхны үгсэд найдварыг та нар олж чадна: “Амар амгалан та нартай хамт байх болтугай” (Иохан 20:19).

Нэмэлт судар: С ба Г 59:23

Ариун Сүнс; Дайн; Есүс Христ; Найдвар; Үйлчлэл; Хайр; Энэрэлийг мөн үз.

## Амилуулалт

Адам, Ева хоёрын Уналтаас болж биеэс сүнс салах бие махбодийн үхлээс хамааралтай болдог. Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан бүх хүмүүс амилуулагдан—бие махбодийн үхлээс аврагдана (1 Коринт 15:22-ыг үз). Амилуулалт гэдэг нь сүнс биетэйгээ төгс төгөлдөр, үхэшигүй байдалд эргэн нэгдэж, дахин үхлээс хамааралгүй болох болно (Алма 11:42–45-ыг үз).

Аврагч бол амилуулагдах дэлхий дээрх анхны хүн байв. Тэрээр булашнаасаа боссон гэдгийг гэрчлэх хэд хэдэн шастирыг Шинэ Гэрээ агуулдаг (Матай 28:1–8; Марк 16:1–14; Лук 24:1–48; Иохан 20:1–19; 1 Коринт 15:1–8; 2 Петр 1:16–17-г үз).

Амилсан Аврагч Төлөөлөгчид дээрээ ирэхдээ, Түүнийг яс, махан биетэй гэдгийг ойлгоход нь тэдэнд Тэрээр тусалжээ. “Миний гар, Миний хөлийг хараач. Энэ бол Би Өөрөө байна. Надад гараа хүргээд үз. Учир нь сүнсэнд та нарын харж байгаа Над шиг яс, мах байдаггүй” хэмээн Тэрээр хэлжээ (Лук 24:39). Түүнчлэн Тэрээр Амилсныхаа дараа Нифайчууд дээр хүрч иржээ (3 Нифай 11:10–17-г үз).

Амилуулалтын үед бид “[өөрсдийн] үйлдлүүдийн дагуу шүүгдэнэ. . . . Бид Бурханы өмнө одоогийнхoo мэдэж буйгийн адил мэдлэгтэйгээр, мөн өөрсдийн бүх гэмийн тодорхой дурдатгалтайгаар зогсоохор аваачигдах” болно (Алма 11:41, 43). Бидний хүлээн авах мөнхийн алдар суу бидний итгэлтэй байдлаас хамаарна. Хэдийгээр

## Анхны Нүгэл

бүх хүмүүс амилуулагдах боловч зөвхөн Христэд ирж, Түүний сайн мэдээний бүрэн байдлаас хүртсэн тэд л сэлэстиэл хаант улсад өргөмжлөлийг өвлөн авах болно.

Амилуулалтын гэрчлэл болон ойлголт таныг амьдралын бэрхшээл, сорилт, ялалтыг туулах аваас найдвар болон хэтийн зорилгыг өгнө. Аврагч амьдардаг, Түүний Цагаатгалаар дамжуулан “тэрээр үхлийн хүлээсийг тасчиж, ингэснээр булаш ялалт үгүй байж, мөн үхлийн шаналал нь сүр жавхланд найдах найдвараар уужруулагдсан байх болно” хэмээх итгэлд та тайтгарлыг олох болно (Алма 22:14).

Нэмэлт судрууд: Исаиа 25:8; 26:19; Иохан 5:25–29; 11:25–26; 1 Коринт 15; Инос 1:27; Алма 40:23–26; 41; Мормон 9:12–14; С ба Г 88:15–16; 93:33–34; Моисе 1:39

Аврал; Авралын Төлөвлөгөө; Алдар Суугийн Хаант Улс; Биеийн Үхэл; Бодгаль; Есүс Христийн Цагаатгалаыг мөн үз.

## Анхны Нүгэл

Адам Ева хоёрын Уналтаас болж бүх хүмүүс Бурханаас салж, бие махбодийн үхлийн хараат болж, уналтын байдалд амьдардаг. Гэсэн хэдий ч, олонхын нэрлэдэг “анхны нүглээр” бид буруушаагдаагүй билээ. Өөрөөр хэлбэл, бид Едений цэцэрлэгт үйлдсэн Адамын гэмд хариуцлага хүлээхгүй. Бошиглогч Иосеф Смит “Адамын зөрчлийн улмаас бус, хүмүүн өөрсдийнхөө нүглүүдийн улмаас шийтгэгдэх болно гэдэгт бид итгэдэг” хэмээн хэлжээ (Итгэлийн Тунхаг 1:2).

Цагаатгалаар дамжин, Аврагч Едений цэцэрлэгт үйлдсэн гэмийн төлөөсийг төлсөн юм (Моисе 6:53-ыг үз). Тэр амилуулалтын баталгаа болон Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд үүрд амьдрахаар буцаж очиж чадна гэсэн бидний итгэл дээр үндэслэсэн амлалтыг өгсөн.

Уналтыг мөн үз.

## Аравны Нэг

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүний адислалуудын нэг нь аравны нэгийг төлөх эрх юм. Аравны нэгийн хуулиар амьдарснаар та дэлхий дээрх Бурханы хаант улсыг барихад оролцдог.

### Аравны Нэгийн Зорилго ба Тодорхойлолт

Аравны нэгээ бүрэн төлөхийн тулд та орлогынхоо арав хуваасны нэгийг Их Эзэнд Түүний Сүмээр дамжуулан өгдөг. Бишопын зөвлөл эсвэл салбарын ерөнхийлогчийн зөвлөлийн гишүүнд аравны нэгээ төлдөг.

Орон нутгийн удирдагчид аравны нэгийн сангаа шууд Сүмийн албан байр луу шилжүүлдэг. Зөвлөл тэрхүү ариун санг ашиглах тодорхой замыг шийддэг. Энэхүү зөвлөл нь Тэргүүн Зөвлөл, Арванхоёр Төлөөлөгчид болон Тэргүүлэгч Бишопын Зөвлөлөөс бүрдэнэ. Илчлэлтийн дагуу ажилласнаар тэд Их Эзэнээр удирдуулан шийдвэр гаргадаг (С ба Г 120:1-ийг үз).

Аравны нэгийн сан нь үргэлж Их Эзэний зорилгуудад—ариун сүм, цуглааны байрыг барих болон засварлах, номлогчийн ажлыг дэмжих, дэлхий дахинаа Сүмийн ажлыг биелүүлэхэд үргэлж хэрэглэдэг.

### Аравны Нэгийг Бүрэн Төлөхийн Адислал

Аравны нэгийн хууль нь золиослолыг шаарддаг хэдий ч хууль дахь таны дуулгавартай байдал урьд өмнө нь золиосолж байсан зүйлээс чинь агуу их адислалуудыг авчирдаг. Бошиглогч Малахи заахдаа:

“Миний өргөөнд хоол хүнс байхын тулд бүхий л аравны нэгээ агуулахад авчир. Би та нарын төлөө тэнгэрийн цонхыг нээж, та нарын төлөө ивээлийг хальтал астах эсэхийн талаар Намайг одоо үүгээр шалга, гэж түмэн цэргийн Эзэн айлдаж байна” (Малахи 3:10).

## *Арван Зарлиг*

Эдгээр адислалууд нь орлогынхоо арван хувийг, тэр ч байтугай маш бага үнийн дүнг ч бүрэн төлдөг хүмүүст ирдэг юм. Энэ хуулийг дагаснаар Их Эзэн таныг сүнслэгээр болон материаллаг аль алинаар нь адисладаг.

### *Аравны Нэг Төлөх Амлалт Өгөх нь*

Хэрэв та хараахан аравны нэгээ төлөх тогтсон загварыг бий болгоогүй бол танд орлогынхоо аравны нэгийг өгөх боломжтой байдаг гэдэгт итгэхэд хүндрэл учирч болно. Гэвч итгэлтэй аравны нэг төлөгчид аравны нэгээ төлөхгүй байж чадахгүй гэдгийг мэдэж авдаг. Маш бодит, гайхалтай замаар тэнгэрийн цонх нээгдэж, адислал тэдний дээрээс асгардаг.

Аравны нэгийг төлөх нь их мөнгө төлөхдөө бус итгэл байгаа учраас гэдгийг сана. Их Эзэнд итгэ. Тэр зарлигуудыг бидний тусын тулд өгсөн бөгөөд Тэрээр дагалдах амлалтуудыг өгсөн. “Их Эзэний зарлигуудыг сахихдаа итгэлтэй байцгаая; тэрээр бүхий л дэлхийнхээс илүү чадалтай” хэмээн хэлсэн Нифайн итгэлд хүч чадлыг эрэлхийл (1 Нифай 4:1).

Мацаг ба Мацгийн Өргөлүүдийг мөн үз

## **Арван Зарлиг**

Арван зарлиг бол бидний мөнхийн өргөмжлөлд зайлшгүй хэрэгтэй мөнхийн сайн мэдээний зарчмууд юм. Их Эзэн тэдгээрийг Мосед эрт цагт илчилсэн (Египетээс гарсан нь 20:1-17-г үз) өгөөд Тэрээр тэдгээрийг хожмын үеийн илчилэлд дахин мэдэгдсэн билээ (С ба Г 42:18-29; 59:5-13; 63:61-62-ыг үз). Арван зарлиг нь сайн мэдээний чухал хэсэг юм. Эдгээр зарлигуудад дуулгавартай байх нь бусад сайн мэдээний зарчмуудад дуулгавартай байх замын эхлэл болдог.

Дараах Арван Зарлиг нь өнөөдөр бидний амьдралд хэрхэн хэрэгжиж байдаг талаар богино тайлбарыг агуулдаг:

1. “Чи надаас өөр бурхадтай байж болохгүй” (Египетээс гарсан нь 20:3). Бид “Бурханы алдар суу-гийн төлөө бүхнээ зориулах” ёстай (С ба Г 82:19). Бид Их Эзэнийг бүхий л зүрх сэтгэл, хүч, бодол санаа болон хүч чадаараа хайлрлаж, үйлчлэх ёстай (Дэд хууль 6:5; С ба Г 59:5-ыг үз).
2. “Чи өөртөө зориулан ямар нэгэн дүрсийг бүү хий” (Египетээс гарсан нь 20:4). Энэхүү зарлигт Их Эзэн хиймэл шүтээнд сүсэглэхийг зэмлэдэг. Олон янзын хиймэл шүтээн байдаг. Зарим хүмүүс сийлсэн дүрс, чулуун хөшөөний өмнө бөхийдөггүй, харин мөнгө, материаллаг эд зүйлс, бодол санаа буюу алдар хүнд зэрэг бусад хиймэл шүтээний оронд Бурханыг орлуулан байрлуулдаг. Тэдний амьдралд “тэдний хөрөнгө нь тэдний бурхан. Тэдний хөрөнгө нь тэдэнтэй хамт түүнчлэн мөхөх болно” (2 Нифай 9:30).
3. “Чи өөрийн Бурхан Эзэний нэрийг дэмий бүү дурд” (Египетээс гарсан нь 20:7). Энэхүү зарлигийн тайлбарыг “Бохир Хэллэг” х.56-г
4. “Амралтын өдрийг ариунаар нь сахихын тулд санаг-тун” (Египетээс гарсан нь 20:8). Энэхүү зарлигийн тайлбарыг “Хүндэтгэлийн Өдөр” х.217–18-ыг үз.
5. “Эцэг эхээ хүндэл” (Египетээс гарсан нь 20:12). Биднийг өсөж том болсон ч холбоотой үлддэг зарлиг. Бид эцэг эхээ хүндлэх замыг үргэлж хайж байх ёстай.
6. “Чи хүн алах ёсгүй” (Египетээс гарсан нь 20:13). Дайнд явахыг шаардсан хүмүүст энэ зарлиг хэрхэн хамаардаг тухай тайлбарыг “Дайн” х.82-ыг үз

7. “Чи бүү завхайр” (Египетээс гарсан нь 20:14). Хожмын өдрүүдийн илчлэлд Их Эзэн зөвхөн завхайрахыг зэмлээгүй, мөн “үүнтэй адилханыг ч” (С ба Г 59:6) мөн зэмлэсэн. Далдуур явалдах, ижил хүйтэнтэйгээ явалдах, болон бусад бэлгийн нүглүүд нь долдугаар зарлигийг зөрчиж буй явдал юм. Нэмэлт тайлбарыг “Ариун явдал” х.35-ыг үз.
8. “Чи хулгай бүү хий” (Египетээс гарсан нь 20:15). Хулгай хийх нь шударга бус хэлбэр. Шударга байдлын тайлбарыг х.223-ыг үз.
9. “Чи хөршийнхөө эсрэг худал бүү гэрчил” (Египетээс гарсан нь 20:16). Худал мэдүүлэг өгөх нь өөр нэг шуударга бус явдал юм. Шударга байдлын тайлбарыг х.223-ыг үз
10. “Чи хөршийнхөө гэр оронд бүү шунахайр” (Египетээс гарсан нь 20:17). Өөр хүнд хамаарах зүйлст шунахайрах буюу атаархах нь бодгалийг гэмтээнэ. Бидний бодол санааг үгүйрүүлж, байнгын аз жаргалгүй, сэтгэл ханамжгүй байдалтай болгоно. Энэ нь ямагт өөр нүглүүд болон санхүүгийн асуудалд хүргэдэг.

Хэдийгээр Арван Зарлигийн жагсаалт ихэнх зүйлсийг бил хийх ёсгүй гэх боловч тэдгээр нь мөн бидний хийх ёстой зүйлсийг харуулж байдаг. Аврагч Арван Зарлигаа хоёр зарчмаар— Их Эзэнийг хайрлах хайр мөн анд нөхдөө хайрлах хайрыг харуулсан.

“Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа өөрийн Бурхан Эцэгээ хайрла.

“Энэ бол агуу нь бөгөөд, хамгийн чухал зарлиг мөн.

“Удаахи нь чи хөршөө өөрийн адил хайрла гэсэнтэй адил юм” (Матай 22:37-39).

Нэмэлт судрууд: Мозая 12:33-36; 13:11-24

Ариун Явдал; Бишрэн Шүтэх, Бохир Хэл Яриа; Дайн; Дуулгавартай Байдал; Сонголт; Хүндэтгэл; Хүндэтгэлийн Өдөр; Шударга Байдлыг мөн үз.

## Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга (Сүмийн Захиргааг үз)

### Ариун Ёслол

Цовдлуулалтынхаа өмнөх орой, Есүс Христ Төлөөлөгчидтэйгөө уулзаж, ариун ёслолыг зааж өгсөн. “Тэр талх аван, талархлаа илэрхийлээд, хувааж тэдэнд хэлрүүн, Энэ бол та нарт өгсөн миний бие: намайг санан дурсахын тулд үүнийг хий. Үүнтэй адил мөн оройн зоогийн дараа аяга авч хэлрүүн, Энэ аяга бол та нарын төлөө асгаруулсан миний цусны шинэ гэр билээ” (Лук 22:19–20). Амилуулалтынхаа дараа Тэр Нифайчуудын дунд ариун ёслолыг зааж өгчээ (3 Нифай 18:1–11-ийг үз).

Өнөөдөр бид Есүс Христийн цагаатгах золиослолыг дурсан санахын тулд талх, усыг хүртдэг. Энэхүү ёслол нь бидний сүсэг бишрэл мөн сүнсний хөгжилтөнд асар их хэрэгтэй юм. Үүний ач холбогдлыг тунгаан бодох тусам бидний хувьд энэ нь илүү эрхэм болдог.

Аврагч болон Түүний Цагаатгалыг Дурсан Санах нь

Ариун ёслол нь амьдрал, тохинуулал болон Бурханы Хүүгийн Цагаатгалыг талархалтайгаар дурсах боломжийг танд олгодог.

Хэрчсэн талхаар та Түүний биеийг дурсан санадаг. Түүний бие махбодийн зовлон шаналал—ялангуяа загалмай дээрх Түүний шаналлыг бодож эргэцүүлж болно. Түүний нигүүлсэл, алдар суугаар дамжуулан бүх хүмүүс амилуулагдаж, Бурхантай байх мөнхийн амьдралыг авах боломж өгөгдөнө.

## Ариун Ёслол

Жижигхэн аягатай усаар та Аврагч Өөрийн цусаар асар хүчтэй сүнсний шаналал, зовлон зүдгүүрт Гетсеманий Цэцэрлэгээс эхлэн асгаруулсаныг дурсаж чадна. Тэрээр “сэтгэл минь үхтлээ зовж байна” хэмээн хэлжээ (Матаий 26:38). Эцгийн хүсэлд захируулан, Тэр бидний бодож байгаагаас ч илүү зовж шаналсан: “Арьсных нь сүв бүрээс цус шүүрэх, өөрийнхөө хүмүүсийн ёсон бус мөн жигшүүрт хэргүүдийн төлөөх түүний тарчлал нь ийм агуу их байх болно” (Мозая 3:7). Түүний асгаруулсан цусаар дамжуулан Есүс Христ таныг болон бүх хүмүүсийг судрын хэлдэгээр Адамын зөрчлийн “анхны гэмээс” аварсныг дурсан санаж чадна (Моше 6:54). Тэр мөн бидний нүгэл, уй гашуу хийгээд Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийн зовиурын төлөө наманчилж, сайн мэдээгээр амьдардаг тэдгээрийн нүглийн ангижралыг олгон шаналж зовсныг та санаж чадна (2 Нифай 9:21–23-ыг үз).

## Гэрээгээ Шинэчлэх болон Амлагдсан Адислалууд

Ариун ёслолоос хүртэхдээ та Бурханы Хүүг санан дурсах тань тэрхүү нандин ёслолоос цааш үргэлжилнэ гэдгийг Бурханд гэрчилдэг. Түүнийг үргэлж дурсан санана хэмээн та амладаг. Есүс Христийн нэрийг өөртөө авч, Түүний зарлигуудыг дагана гэдгээ та гэрчилдэг. Ариун ёслолоос хүртэн, эдгээр амлалтуудыг хийхдээ та баптистын гэрээгээ шинэчилдэг (Мозая 18:8–10; С ба Г 20:37-г үз).

Баптистын гэрээгээ сахиснаар та агуу адислалуудыг хүлээн авна. Та үүнийг шинэчилвэл, нүглийг тань училна гэсэн амлалтаа Их Эзэн шинэчилдэг. Нүглээсээ цэвэршвэл та “түүний Сүнстэй үргэлж хамт байх” боломжтой болно (С ба Г 20:77). Сүнсний байнгын нөхөрлөл бол зуурдын байдалдаа таны хүлээн авах хамгийн том бэлгүүдийн нэг юм. Сүнс таныг Есүс Христ болон Тэнгэр дэх Эцэгтэйгээ хамт байх мөнхийн амьдрал уруу

хөтлөх зөв шударга байдал хийгээд амар амгалангийн зам уруу удирдах болно.

### Зохистойгоор Хүртэх нь

Долоо хоног бүр ариун ёслолд бэлтгэхийн тулд амьдралаа хянан үзэж, нүглээ наманчлах цаг гарга. Ариун ёслолоос хүртэхдээ төгс төгөлдөр байх шаардлагагүй ч, даруу сүнстэй мөн зүрх сэтгэлдээ наманчлалтай байх хэрэгтэй. Долоо хоног бүр харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэйгээр нандин ёслолд бэлтгэх хэрэгтэй (3 Нифай 9:20-ийг үз).

Хэрэв та ариун ёслолд бишрэл хүндэтгэлтэйгээр хандвал, өөртөө дүн шинжилгээ хийх, наманчлах, мөн онцгой хүч чадал хийгээд Аврагчийн Цагаатгалыг байнга дурсан саналт— дахин бүхнээ зориулах долоо хоногийн боломж болох болно.

Нэмэлт судрууд: 1 Коринт 11:23–29; Моронай 4–5; С ба Г 20:75–79; 27:2 Гэрээ; Есүс Христийн Цагаатгалыг мөн үз.

**Ариун Ёслолын Цуглаан** (Ариун Ёслол; Золиослол; Хүндэтгэлийн Өдрийг мөн үз)

### Ариун Сүмүүд

Ариун сүмүүд нь бодит утгаараа Их Эзэний өргөө билээ. Их Эзэний зочилж болох сүсэг бишрэлийн ариун газар юм. Зөвхөн гэрийг л ариун сүмтэй адилтган үзэж болно.

Түүхийн явцад Их Эзэн ариун сүм барихыг хүмүүстгээ зарлиглажээ. Өнөөдөр Сүм дэлхий даяар ариун сүм барих, Тэнгэрлэг Эцэгийн тоо томшгүй хүүхдүүдэд ариун сүмийн адислалыг бүрэн боломжтой болгохоор Их Эзэний дуудлагыг анхааралтай дагаж байна.

## *Ариун Сүмүүд*

### Амьд Байгаа Хүмүүст Зориулсан Ёслолууд

Ариун сүмүүдийн үндсэн зорилго нь сэлэстиэл хаант улсын өргөмжлөлд шаардлагатай ёслолуудаар хангах учиртай. Ариун сүмийн ёслолууд нь агуу их адислалууд руу Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан хөтөлдөг. Сүмийн цуглаан, үйл ажиллагаанууд, номлогчийн хичээл зүтгэл, бидний заадаг хичээл болон бидний дуулдаг дууллууд—биднийг Аврагч руу, мөн ариун сүмд хийгддэг ажил руу чиглүүлэх ёстой.

Бидний ариун сүмд хүлээн авдаг ёслолуудын нэг нь индаумент юм. *Индаумент* хэмээх үг нь “бэлэг” гэсэн угтгатай ба ариун сүмийн индаument бол үнэхээр Бурханаас ирсэн бэлэг юм. Энэхүү ёслол нь цуврал зааварчилгаануудаас бүрддэг ба зөв шударгаар амьдрах хийгээд сайн мэдээний зарчмуудыг мөрдөх гэрээг оролцуулдаг. Энэхүү индаумент нь биднийг Аврагчид, Тэнгэрлэг Эцэгийн Төлөвлөгөөн дэх Түүний үүрэг болон Түүнийг дагах оөрсдийн амлалтанд төвлөрөхөд тусалдаг.

Өөр нэг ариун сүмийн ёслол бол эхнэр нөхөр хоёр нэг нэгэндээ мөнхөд лацдан холбуулдаг сэлэстиэл гэрлэлт юм. Ариун сүмд гүйцэтгэгдэх лацдан холболт нь хэрэв эхнэр нөхөр хоёр хийсэн гэрээндээ итгэлтэй байвал мөнхөд үргэлжилдэг.

Ариун сүмд гэрлэсэн хосоос төрсөн хүүхэд гэрээнд төрдөг. Эдгээр хүүхдүүд нь шууд мөнхийн гэр бүлийн нэг хэсэг болдог. Гэрээнд төрөөгүй хүүхдүүдийн өргөж авсан эцэг эх буюу төрсөн эцэг эх нь бие биедээ лацдан холбогдвол мөн мөнхийн гэр бүлийн нэг хэсэг болж болдог.

Хэрэв та ариун сүмийн ёслолуудыг хүлээн авсан бол хийсэн гэрээгээ үргэлж санагтун. Боломжийнхoo хэрээр ариун сүмд ирж бай. Хэрэв та эцэг эсвэл эх бол хүүхдүүдээ ариун сүмийн ач холбогдлыг заа. Тэднийг ариун сүмд ороход зохистой байхаар бэлтгэхэд нь тусал.

Хэрэв ариун сүмийн ёслолуудыг хараахан хүлээн аваагүй бол өөрсдийгтэй одоо бэлтгэ. Боломж бүрдсэн үед баптистм хийгээд нас барагсдын төлөөх гишүүний баталгаанд оролцооор ариун сүм рүү яв.

### Нас Барагсдын Төлөөх Ёслолууд

Сайн мэдээний зайлшгүй хэрэгтэй ёслолыг хүлээн авалгүйгээр нас барсан хүмүүс тэдгээр ёслолуудыг ариун сүмд хийгддэг ажлаар дамжуулан хүлээн авч болно. Та энэхүү ажлыг өвөг дээдсийнхээ өмнөөс мөн нас барсан бусад хүмүүсийн өмнөөс хийж болно. Тэдний төлөө баптистм хүртэж, гишүүний баталгаа хийлгэж, индаумент хүлээн авч, мөн эхнэр, нөхөр, үр хүүхдүүдийг хамтад нь лацдан холбох боломжтой.

Нас барсан өвөг дээдсийнхээ бичээсийг идэвхтэйгээр эрж хайх хэрэгтэй бөгөөд ариун сүмийн ажил нь тэдний төлөө гүйцэтгэгдэж чадна.

Нас барагсдын төлөөх ариун сүмийн ажил болон гэр бүлийн түүхийн ажлын талаар илүү их мэдээллийг авахыг хүсвэл, “Гэр Бүлийн Түүхийн Ажил ба Угийн Бичиг” хуудас 68-ыг үз.

### Ариун Сүмд Орох Зохистой Байдал

Ариун сүмд орохын тулд та зохистой байх ёстой. Та өөрийн зохистой байдлаа хоёр ярилцлагаар баталгаажуулна—нэг нь бишопын зөвлөлийн гишүүн эсвэл салбарынхаа ерөнхийлөгчтэй, нөгөө дэх нь гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн эсвэл номлолын ерөнхийлөгчтэй. Санваарын удирдагчид эдгээр ярилцлагуудыг хувийн нууц, чанд байдлаар хадгална. Ярилцлага бүрт санваарын удирдагч таны хувийн харилцаа болон зохистой байдлын талаар асууна. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христийн Цагаатгалын талаар гэрчлэлийг асууж, мөн

## Ариун Сүмүүд

Сүмийн ерөнхий ба орон нутгийн удирдагчдыг дэмждэг эсэхийг асуух болно. Ёс суртахууны хувьд цэвэр, Мэргэн Ухааны Үгийг сахьдаг, аравны нэгийг бүрэн төлдөг, Сүмийн сургаалуудад нийцэж амьдардаг мөн Сүмийн эсрэг буй ёлэг хүмүүстэй холбоо сүлбээгүйгээ батлахыг асууна.

Ярилцлагын үеэр асуултууддаа боломжийн хариулт өгвөл, хэрэв та болон удирдагч таныг ариун сүмд орох зохистой хэмээн үзвэл, та ариун сүмийн бичиг авна. Та зохистой хэвээр үлдвэл дараагийн хоёр жилд ариун сүмд орж болохыг зөвшөөрөх энэхүү бичигт та болон санваа-рын удирдагч гарын үсэг зурна.

Ариун сүмийн эрхийн бичгийн ярилцлагууд амьдралынхаа хэв маяг, зохистой байдлаа хянах их боломжийг өгнө. Амьдралд тань ямар нэгэн зүйл болохоо байвал, бишоп буюу салбарынхаа ерөнхийлөгчтэй ариун сүмийн эрхийн бичиг авахаасаа өмнө сайн ярилц. Тэр таныг ариун сүмийн бичиг хүлээн авахаар зохистой байлгаж өөрийгөө бэлдэхэд тань туслах болно.

## Ариун Сүмийн Хувцас

Та ариун сүм рүү явахдаа сүмд өмсдөг хамгийн сайн гэсэн хувцсаа өмсөх хэрэгтэй. Ариун сүм дотор хувцсаа ариун сүмийн цагаан хувцсаар сольдог. Гадуур хувцсаа цоожтой хувийн хувцас солих газар сольдог. Ариун сүмд даруу байдал их голчилино.

Хувцсаа цоожтой ороөнд тавиад ертөнцийн сарниулах зүйлсийг ардаа үлдээ? Эргэн тойрон хүн бүр адил цагаан хувцастай байх тул ариун сүмд та бусадтай адил тэгш, нэгдсэн мэт сэтгэгдэл төрнө.

## Ариун Сүмийн Өмсгөл Өмсөх нь

Индаумент хүртэнгүүт та ариун сүмийн өмсгөлийг амьдралынхаа турш өмсөх адислалтай болдог. Индаumentэд өгөгдсөн зааврын дагуу өмсөх шаардлагатай байдаг. Зохистой байдлаас чинь хамаарах нандин эрх болон ариун сүмийн гэрээнүүдээ биелүүлэх итгэлтэй байдалтай холбоотой адислалуудыг сана.

Уг өмсгөл нь таны ариун сүмд хийсэн гэрээний байнгын сануулагч болдог. Үүнд үргэлж хүндэтгэлтэй ханд. Үүний ач холбогдлыг ойлгохгүй хүмүүст ил гарган үзүүлэх ёсгүй ба хувцасныхаа хэв загварт үүнийг тохируулах ёсгүй. Үүнийг зөв зохистойгоор нь өмсвөл уруу таталт болон хилэнцэтийн эсрэг хамгаалалтыг үзүүлдэг. Өмсгөл өмсөх нь Аврагчийг дагах дотоод амлалтын гаднах илрэл юм.

## Ариун Сүмд Орсноос Ирэх Адислалууд

Санваарын ариун ёслолууд гүйцэтгэгддэг газар байх үүднээс ариун сүм нь амар амгалан хийгээд илчлэлтийн газар бөлгөө. Түгшүүртэй байдалд орох буюу чухал шийдвэрүүд ухаан санаанаас чинь гарахгүй бол ариун сүмээс тусламж авч болно. Тэнд та сүнсний удирдамжийг хүлээн авдаг.

Заримдаа та оновчтой бодож, сэтгэж чадахгүй байна гэж бодож магад, учир нь бодол санаа анхаарал шаардагдах олон зүйлс хийгээд асуудлуудаар дүүрдэг. Ариун сүмд садаа болох зүйлгүй байж, төөрөгдөл хийгээд учир битүүлэг явдал замхарч, та урьд нь ойлгож байгаагүй зүйлээ ойлгох болно. Өөрт тулгарах бэрхшээлүүдтэй харьцах шинэ замыг олж чадна.

Их Эзэн ариун сүмд хийгдэх нандин ёслолын ажилд оролцвол таныг адислах болно. Түүний танд өгдөг адислалууд ариун сүмд таны байх хугацаагаар

## *Ариун Сүнс*

хязгаарлагдахгүй. Тэр таныг амьдралын бүхий л талаар адислах болно. Ариун сүм дэх таны ажил таныг хүчирхэгжүүлэх болон сүнслэг байдлын хувьд цэвэршүүлнэ.

Нэмэлт судрууд: Исаиа 2:1–3; С ба Г 88:119; 109–110; 124:39–41

Авралын Төлөвлөгөө; Гэр Бүлийн Түүхийн Ажил болон Угийн Бичиг; Гэрлэлт; Гэрээ; Ёслолуудыг мөн үз.

## **Ариун Сүнс**

Ариун Сүнс нь Бурхан Тэргүүтний гуравдагч гишүүн юм. Тэр бол яс мөн цусан бие махбодгүй хүн төрхтэй сүнс юм (С ба Г 130:22-ыг үз). Түүнийг Сүнс, Ариун Сүнс, Бурханы Сүнс, Их Эзэний Сүнс буюу Тайтгаруулагч гэж үздэг.

### **Ариун Сүнсний Үүргүүд**

Ариун Сүнс таныг Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христтэй хамт шударга амьдрах мөн сайн мэдээний адислалуудыг хүлээн авахад тань туслах хэд хэдэн үүргийг биелүүлэхээр төгс нэгдэлтэйгээр ажилладаг.

Тэрээр “Эцэг Хүү хоёрыг гэрчилдэг” (2 Нифай 31:18) ба “бүх зүйлсийн үнэнийг” зааж, илчилдэг (Моронай 10:5). Та зөвхөн Ариун Сүнсний хүчээр Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн баттай гэрчлэлийг хүлээн авч чадна. Таны сүнсэнд шивнэх түүний харилцаа нь таны төрөлхийн мэдрэхүйгээрээ дамжуулан хүлээн авч чадах ямар ч харилцаанаас илүү гүн гүнзгийй бөгөөд тодорхой байдаг.

Мөнхийн амьдрал руу хөтөлдөг зам дээр үлдэхийг хичээвэл Ариун Сүнс “та нарын хийвэл зохих тэр бүх зүйлүүдийг үзүүлэх болно” (2 Нифай 32:1–5-ыг үз). Тэр таныг шийдвэр гаргахад удирдаж, бие махбодын болон сүнсний аюулаас хамгаална.

Та түүгээр дамжуулан өөрийн болон таны хайрладаг, мөн үйлчилдэг хүмүүсийн тусын тулд Сүнсний бэлгийг хүлээн авч чадна (С ба Г 46:9–11-ийг үз).

Тэр бол Тайтгаруулагч юм (Иохан 14:26). Халамжит эцэг, эхийн тайтгаруулах дуу хоолой нь уйлж буй хүүхдийн уйлахыг болиулж чаддагийн адилаар Сүнсний шивнэлт нь таны айдас, доройтол, амьдралын тань бэрхшээлийг намжаан, таныг зовж шаналах үед тайвшруулна. Ариун Сүнс таныг “найдвар мөн төгс хайраар” дүүргэх ба танд “хаант улсын амар амгалангийн зүйлсийг заах” болно (Моронай 8:26; С ба Г 36:2).

Та түүний хүчээр дамжуулан нүглээ наманчлан баптиسم хүртэж, гишүүний баталгааны ёслолуудыг хүлээн авснаар цэвэршигдэж, гэрээндээ үнэнч хэвээр байх болно (Мозая 5:1–6; 3 Нифай 27:20; Моце 6:64–68-ыг үз).

Тэрээр Амлалтын Ариун Сүнс юм (Ефес 1:13; С ба Г 132:7, 18–19, 26-г үз). Энэхүү боломжинд, Тэр таны хүлээн авсан санваарын ёслолууд хийгээд байгуулсан гэрээ Бурханд хүлээн зөвшөөрч болохуйц гэдгийг баталж байдаг. Үүний баталгаа нь таны тууштай итгэлтэй байдлаас хамаарна.

## Ариун Сүнсний Бэлэг

Үнэнийг үнэнчээр эрэлхийлэгчид нь тэднийг Есүс Христ болон түүний сайн мэдээнд хөтлөн Ариун Сүнсний бэлгийн нөлөөллийг мэдэрч чадна. Гэсэн хэдий ч Ариун Сүнсээр дамжуулан өгөгдсон адислалуудын бүрэн байдал нь зөвхөн Ариун Сүнсний бэлгийг хүлээн авч, зохистой хэвээр байдаг хүмүүст боломжтой байдаг.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд баптиsm хүртсэний дараа нэг буюу түүнээс олон Мелкизедек Санваартан таны толгой дээр гар тавин санваарын нандин ёслолоор таны Сүмийн гишүүн болсныг баталдаг. Энэ ёслолын нэг хэсгийг гишүүний баталгаа

## *Ариун Сүнс*

хэмээн нэрлэдэг бөгөөд та үүгээр Ариун Сүнсний бэлгийг хүлээн авсан билээ.

Ариун Сүнсний бэлэг нь Ариун Сүнсний нөлөөллөөс өөр юм. Та баптисмын өмнө Ариун Сүнсийг үе үе мэдэрч, үүнээсээ үнэний гэрчлэлийг хүлээн авч чадсан. Одоо танд Ариун Сүнсний бэлэг байхад хэрэв зарлигуудыг сахидаг бол Бурхан Тэргүүтний гишүүнтэй байнга нөхөрлөх эрхтэй байна.

Ариун Сүнсний бэлгийг бүрэн дүүрэн хүртэхэд илчлэлт болон тайвшрууллыг хүлээн авах, сүнсний бэлгээр дамжуулан бусдыг адисалж мөн үйлчлэх, нүглээс ариусгагдаж, сэлэстиэл хаант улсад өргөмжлөл хүртэхэд хүлээн таарахуйц болох зэргийг багтаадаг. Эдгээр адисалууд нь өөрийн тань зохистой байдлаас хамаарна; та тэдгээрийг авахад бэлэн байвал тэдгээр нь бага баагаар ирдэг. Та өөрийнхөө амьдралыг Бурханы хүсэлтэй нийцүүлвээс аажимдаа Ариун Сүнсийг агуу ихээр хүлээн авна. Бурханы хаант улсын нууцууд нь “Түүнийг хайлрадаг, мөн түүний өмнө өөрсдийгөө цэвэршигүүлдэг тэдэнд Бурханы өгдөг гагцхүү Ариун Сүнсний хүчээр үзэгдэх мөн ойлгогдох боломжтой” хэмээн Бошиглогч Иосеф Смит тунхагласан юм (С ба Г 76:114–116-г үз).

“Их Эзэний Сүнс ариун бус дугануудад үл оршдог” гэдгийг сана (Хиламан 4:24). Хэдийгээр та Ариун Сүнсний бэлгийг хүлээн авсан ч Сүнс зөвхөн зарлигуудыг сахих үед таньтай хамт байх болно. Хэрэв Түүнийг бохир хэл яриа, цэвэр бус байдал, дуулгаваргүй байдал, бослого болон бусад нүглүүдээр гомдоовол Тэр холдох болно. Өөрийгөө цэвэр байлга. Амьдралаа сайн сайхнаар дүүргэ, тэгвээс Ариун Сүнсний байнгын нөхөрлөлд зохистой байж чадна.

Нэмэлт судрууд: Матай 3:11; Иохан 15:26; 16:13; Уйлс 2:38; 8:12–17; 19:1–6; 1 Коринт 2:9–14; 12:3; Галат 5:22–23; 1 Нифай 10:17–19; 2 Нифай 31:17; С ба Г 8:2–3; 39:20–24; 68:25–28; 121:46; Итгэлийн Тунхаг 1:4

Баптисм; Бурхан Тэргүүтэн; Гар Тавилт; Илчлэлт; Сүнслэг Бэлгүүдийг мөн үз.

## Ариун Сүнсний Бэлэг (Ариун Сүнсийг үз)

### Ариун Явдал

Ариун явдал гэдэг бол “Бурханд таалагдах” бэлгийн харьцааны цэвэр ариун байдал юм (Иаков 2:7). Ариун явдалтай байхын тулд та ёс суртахууны хувьд бодол санаа, үг яриа хийгээд үйлдлээрээ цэвэр ариун байх ёстай. Хэрэв та гэрлэсэн бол эхнэр буюу нөхөртөө бүрэн дүүрэн итгэх ёстай.

Эхнэр нөхрийн хоорон дахь бие махбодын дотночлол нь гайхамшигтай нандин зүйл билээ. Хүхдлүүдийг бүтээх ба гэрлэлтийн харьцаан дахь хайрын илрэл нь Бурханаар томилогдсон юм.

Өнөөдөр дэлхий ертөнцөд Сатан олон хүмүүст гэрлэлтээс гадуурх бэлгийн харьцааны дотночлол бол байх ёсны зүйл гэдэгт итгүүлэхийг зорьсоор байна. Гэвч Бурханы хараанд энэ бол их ноцтой нүгэл юм. Энэ бол Түүний бидэнд амьдралыг бүтээхээр өгсөн хүчийг завхруулж буй явдал. Бошиглогч Алма бэлгийн нүгэл нь Ариун Сүнсийг үгүйсгэх, аллага үйлдэхээс бусад нүглүүдийг бодвол илүү ноцтой нь юм хэмээн заасан (Алма 39:3–5-ыг үз).

Заримдаа хүмүүс гэрлэлтээс гадуурх бэлгийн харьцаанд хэрэв нөхцөн хоёр бие биендээ хайртай бол байж болох зүйл гэдгийг өөрсдөдөө итгүүлэхийг оролддог. Энэ бол худал хуурмаг зүйл юм. Ариун явдлын хуулийг зөрчин, өөр хэн нэгнийг ийм зүйл хийхэд нь дэмжинэ гэдэг бол хайрын илрэл биш юм. Бие биенээ хайрладаг хүмүүс нэг нэгнийхээ аз жаргал, аюулгүй байдлыг түр зуурын хувийн таашаалаар солин, хэзээ ч аюултай байдалд оруулдаггүй.

Хүмүүс нэг нэгнийгээ ариун явдлын хуулийг сахин хангалттайгаар хайрлаж халамжилвал тэдний хайр, итгэл, амлалт нь агуу их аз жаргал хийгээд эв нэгдлээс шалтгаалан өсдөг. Нөгөө талаар бэлгийн ёс суртахуунгүй байдалд бий болсон харилцаа удаан үргэлжилдэггүй. Бэлгийн ёс суртахуунгүй байдалд холбогдог хүмүүс үргэлж айж, ичих байдал болон бурууг мэдэрдэг. Хорсох, хардах, үзэн ядалт нь удалгүй тэдний харьцаанд нэгэнтээ оршиж байсан аливаа эерэг мэдрэмжинд нэвтрэн орж ирдэг.

Тэнгэрлэг Эцэг бидэнд өөрсдийгөө хамгаалах үүднээс ариун явдлын хуулийг өгсөн юм. Энэхүү хуульд дуулгавартай байх нь хувийн амар амгалан болон зан харьцааны хүч чадал мөн гэр орон дахь аз жаргалд зайлшгүй хэрэгцээтэй юм. Та өөрөө бэлгийн ариун байдлыг сахиваас гэрлэлтээс гадуурх хэн нэгэнтэй бие махбодын дотночлолыг хуваалцаад үргэлж ирдэг сүнслэг болоод сэтгэл санааны аюулаас зайлсхийх болно. Та Ариун Сүнсний удирдамж, хүч чадал, тайтгаруулалт болон хамгаалалтад мэдрэмтгий болох ба ариун сүмийн эрхийн бичгийг хүлээн авах, мөн ариун сүмийн ёслолуудад оролцох чухал шаардлагыг биелүүлэх болно.

### Бэлгийн Харьцааны Нүглүүд

Их Эзэн болон Түүний бошиглогчид бэлгийн харьцааны ёс суртахуунгүй байдлыг зэмлэдэг. Гэрлэлтээс гадуурх бүх бэлгийн харьцааны холбоо нь ариун явдлын хуулийг зөрчин, үүнд оролцсон тэдний хувьд бие махбодын хийгээд сүнслэг байдлын аюултай юм.

Арван Зарлигт гэрлэсэн эрэгтэй, эхнэрээсээ өөр хэн нэгэнтэй, эсвэл гэрлэсэн эмэгтэй нөхрөөсөө өөр хүнтэй бэлгийн харьцаанд орох буюу завхайрал үйлдэж болохгүй гэдэг зарлиг байдаг (Египетээс гарсан нь 20:14-ийг үз).

Төлөөлөгч Паул гэрлээгүй хүн өөр хэн нэгний хоорондох бэлгийн харьцаанд орох садар самууныг тэвчих нь Бурханы хүсэл гэж хэлсэн билээ (1 Тесалоник 4:3). Хожмын үеийн бошиглогчид эдгээр нүглүүдийн эсрэг мөн бэлгийн хүчирхийллийн хилэнцэт арга замын эсрэг олон дахин анхааруулан сануулдаг.

Ариун явдлын хуулийн бусад зөрчлүүдтэй адил ижил хүйстэнтэйгээ харьцаанд орох нь ноцтой нүгэл юм. Энэ нь хүмүүний бэлгийн харьцааны зорилгын эсрэг юм (Ром 1:24–32-ыг үз). Энэ нь хүмүүст хайр энхрийллийн харьцаа холбоо болон гэр бүлийн амьдралд авч болох адислалууд мөн сайн мэдээний авралын ёслолуудыг хүлээн авахад саад болж улмаар мушгин гүйвуулдаг.

Зөвхөн гэрлэлтээс гадуурх бэлгийн харьцаанаас зайлсхийх нь Их Эзэний хувийн ариун байдлын жишигт хангалттай бус юм. Их Эзэн Өөрийн шавь нараасаа ёс суртахууны хамгийн сайн жишиг, түүнчлэн гэрлэсэн хүн ханьдаа бодол санаа болон биеэрээ бүрэн үнэнч байхыг шаарддаг. Та нар Уулан дээрх Номлолд Тэрээр “Завхайрч болохгүй гэснийг сонссон. Харин би та нарт хэлье, эмэгтэй хүнийг тачаадан харах хүн бүр зүрхэндээ түүнтэй аль хэдийнээ завхайрсан хэрэг” гэж хэлжкээ (Матай 5:27–28). “Чи садар самууныг үйлдэх . . . тэрчлэн энэ мэт ямар ч зүйлийг үйлдэх ёсгүй” (С ба Г 59:6). Тэрээр Уулан дээрх Номлолдоо заасан тэрхүү зарчмыг дахин онцолсон. “Эмэгтэй хүнийг тачаангуйгаар харах тэрээр, эсвэл хэрэв хэн нэг нь зүрх сэтгэлдээ садар самууныг үйлдэх аваас, тэдэнд Сүнс байх нь үгүй, харин тэд итгэлийг үгүйсгэж, мөн эмээх болно” (С ба Г 63:16). Эдгээр сануулгууд нь гэрлэсэн бөгөөд ганц бие бүх хүмүүст хамаатай юм.

Хэрэв та бэлгийн харьцааны гэм нүгэл үйлдсэн бол бишоп буюу салбарын ерөнхийлөгчтэйгээ ярилц. Тэгвэл тэд наманчлалын үйл явцаар дамжуулан танд тусалж чадна (“Наманчлал”, х.133-аас үз).

## *Ариун Явдал*

Та бэлгийн уруу таталтанд, мөн ижил хүйстэнтэйгээ хурьцах гэсэн мэдрэмжтэйгээ тэмцэлдэж байгаа бол тэрхүү уруу таталтанд бүү бууж өг, та биеэ авч явах иймэрхүү байдлаас зайлсхийхийг сонгож чадна гэдэгтээ итгэлтэй бай. Энэ асуудлыг даван туулахаар ажиллах хүч чадлын төлөө залбирвал Их Эзэний тусlamжийг хүлээн авч чадна. Энэхүү явцын нэг хэсэгт та бишоп буюу салбарын ерөнхийлөгчөөсөө зөвлөмж хүсэх ёстой. Тэр танд тусална.

## *Ариун Явдлын Хуулийг Сахих нь*

Ямар ч хүчтэй уруу таталт байсан, хэрэв та Түүнийг дагахыг сонговол Их Эзэн тэдгээрийг сөрж зогсоход тань тусална. Төлөөлөгч Паул “та нарт учирсан сорилт нь хүнд тохиолддог л зүйл юм. Бурхан итгэмжит билээ. Тэр та нарыг хэрээс тань хэтэрсэн хүчээр сорихыг зөвшөөрдөггүй, харин сорилтыг тэсвэрлэж чадахын тулд сорилтой хамт мөн гарах замыг ч бас өгдөг юм” хэмээн тунхаглажээ (1 Коринт 10:13). Дараах зөвлөмж нь танд өнөөдрийн энэ дэлхий дээрх байнгын, ичгүүргүй уруу таталтуудыг даван туулахад тусалж чадна:

*Одоо ариун явдалтай байхаар шийд. Та энэ шийдвэрийг зөвхөн нэг л удаа хийх хэрэгтэй. Уруу таталт ирэхээс өмнө одоо энэ шийдвэрийг гаргаад, өөрийнхөө шийдвэрийг туштай, хөдөлшгүй, байхаар баттай амлалт өг. Зөвхөн гэрлэлтэд л байх ёстой тэрхүү хүчтэй сэтгэл хөдлөлийг сэргээх гэрлэлтээс гадуурх ямар нэг зүйлийг хэзээ ч хийхгүйн тулд одоо тууштай шийд. Тиймэрхүү сэтгэл хөдлөлийг өөр хэн нэгний бие, эсвэл өөрийнхөө биед бүү үүсгэ. Ханьдаа бүрэн дүүрэн үнэнч байна гэсэн шийдвэрийг одоо гарга.*

*Бодол санаануудаа хяна. Ямар ч хүн гэв гэнэт бэлгийн нүгэл үйлдлэггүй. Ёс суртахуунгүй үйлдэл үргэлж цэвэр бус бодлын араас орж ирдэг. Хэрэв та бодол санаагаа*

бузар булай, ёс журамгүй зүйлст хандуулдаг бол та аль хэдийнээ ёс суртахуунгүй байдлын анхны алхам хийчихсэн байна гэсэн үг. Нүгэл рүү хотөлж болох нөхцөл байдлаас зугтаа. Уруу таталтыг эсэргүүцэх хийгээд бодол санаагаа удирдах байнгын хүч чадлын төлөө залбир. Үүнийг өдөр тутмын залбирлуудын нэг хэсэг болго.

Порнографиас хол бай. Бэлгийн мэдрэмжийг төрүүлэх үүднээс хүмүүний бие буюу бэлгийн харьцааг үзүүлдэг, дүрсэлдэг ямарваа зүйлсийг бүү сонс, унш, үз. Порнографийн материалууд нь донтуулах буюу хөнөөх аюултай. Тэдгээр нь танаас өөрийгөө хүндэтгэх үзэл хийгээд амьдралын гоо сайхныг харах чадварыг булаан авч чадна. Тэдгээр нь таны замыг алдуулж, хилэнцэт бодол санаа хийгээд хүчирхийллийн холбоо руу хотөлнө.

Хэрэв та ганц бие мөн болзож байгаа бол болзоо хийж буй хүнээ хүндэтгэ. Хэзээ ч түүнийг тачаангүй хүсэлдээ ашиглах эд зүйл мэт бүү харьц. Та хоёр юу ч хийхгүйгээр дэмий байхгүйн тулд эрэг болон бүтээлч үйл ажиллагааг анхааралтайгаар төлөвлө. Өөрийгөө амархан удирдаж чадах аюулгүй газар бай. Бэлгийн дур хүсэл төрүүлэх ямар нэгэн үйл ажиллагаа, харилцан ярианд бүү оролц. Шунамхайран үнэсэлцэх, хамтдаа буюу дээр нь хэвтэх, эсвэл хувцастай, хувцасгүй үед нөгөө хүнийхээ хувийн, ариун хэсэгт хүрэх, шүргэлцэх зэрэгт бүү оролц. Өөртөө бас иймэрхүү үйлдлийг бүү гаргуул.

Хэрэв та гэрлэсэн бол бодол санаа, уг яриа, үйлдлээрээ ханьдаа үнэнч бай. Их Эзэн “чи эхнэрээ бүх зүрх сэтгэлээрээ хайрлаж мөн өөр хэнтэй ч биш харин түүнтэй нэгдэн нийлэх ёстой. Мөн эмэгтэй хүнийг тачаангүйгаар хардаг тэрээр итгэлийг үгүйсгэнэ, мөн Сүнстэй байх нь үгүй болно; мөн хэрэв тэрээр үл наманчилваас тэрээр зайллуулагдсан байх ёстой” хэмээн хэлсэн (С ба Г 42:22–23). Ямар нэгэн байдлаар бүү сээтгэнэ. Аль болох эсрэг хүйснийхээ хүнтэй ганцаараа үлдэхээс зайлсхий.

## *Arхи*

Хань тань үг яриа, үйлдлийг тань мэддэг эсэхийг, тэрээр үүнийг таашаадаг эсэхийг өөрөөсөө асуу. Төлөөлөгч Паулын зөвлөмжийг “Бузар муугийн аливаа хэлбэрийг цээрлэгтүн” санагтун (1 Тесалоник 5:22). Иймэрхүү нөхцөл байдлаас хол байвал уруу таталт даамжрах ямар ч боломж гарагчдай.

### Наманчлагчийг Уучлах нь

Хамгийн сайн арга бол бүрэн дүүрэн ёс суртахууны цэвэр байдал. Хожим наманчилна гэсэн бодолтойгоор бэлгийн нүгэл үйлдэх нь буруу юм. Энэ хандлага нь Их Эзэнд болон Түүнтэй хийдэг гэрээнүүддээ хүндэтгэл үзүүлэгчийг учраас нүгэл болдог. Гэсэн ч таныг бэлгийн нүгэл үйлдээд нүглээ наманчилвал Их Эзэн өршөөлийг үзүүлдэг.

Наманчлал нь хэцүү ч бас боломжтой зүйл юм. Та дахин цэвэр болно (Исаиа 1:18-ыг үз). Нүглийн цөхрөл нь уучлалын амар амгалангараар солигдож болдог. Наманчлахын тулд юу хийх ёстой талаар сурахын тулд “Наманчлал” х.133-ыг үз.

Дууллын үгээр удирдагдан ариун сүмд орохоор зохистой байх тэр өдрийн төлөө ажилла:

“Эзэний уул өөд хэн авирч болох вэ? Түүний ариун газарт хэн зогсож болох вэ?”

“Цэвэр гартай, ариун зүрхтэй хүн” (Дуулал 24:3–4).

Нэмэлт судрууд: Египетээс гарсан нь 20:14; 1 Коринт 6:18–20; Алма 38:12; 3 Нифай 12:27–30

Гэрлэлт; Порнографиг мөн үз.

**Архи** (Мэргэн Ухааны Үгийг үз)

**Ахлагч** (Мелкизедек Санваар; Санваарыг үз)

## Ахмад Иосеф Смит (Иосеф Смитийг үз)

### Ач Ивээл

Ач ивээл хэмээх үг нь олон судруудад хэрэглэгдсэнээр Их Эзэн Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан хүлээн авдаг тусlamж хийгээд тэнгэрлэг хүч чадалтай нэн их холбоотой. Төлөөлөгч Петр “Аврагч Есүс Христийн нигүүлсэл болон мэдлэг дотор өсөх” ёстай гэдгийг заажээ (2 Петр 3:18).

### Ач Ивээлээр Аврагдах нь

Хүн бүр уналтын улмаас зуурдын үхлийг туулах болно. Ач ивээлээр дамжуулан Аврагчийг цагаатгах золиослолыг боломжтой болгосон учраас бүх хүмүүс амилуулагдаж, үхэшгүй байдлыг хүлээн авах болно (2 Нираф 9:6-13-ыг үз). Гэвч амилуулалт дангаараа Бурханы оршихуй дахь мөнхийн амьдралыг хүлээн авахад биднийг тэнцэхүйц болгохгүй. Нүглүүд маань биднийг цэвэр бус, Бурханы оршихуйд амьдрахад нийцэхгүй болгодог ба “бидний хийж чадах бүхний дараа” биднийг цэвэршүүлж, төгс болгохын тулд бидэнд Түүний ач ивээл хэрэгтэй (2 Нираф 25:23).

“Бидний хийж чадах бүхний дараа” хэмээх хэлц нь Их Эзэний бүрэн дүүрэн ач ивээлийг хүлээн авах ба Түүнтэй хамт амьдрахад зохистой болгогдоход бидний талаас хичээл зүтгэлийг шаарддаг гэсэн утгатай юм. Их Эзэн биднийг Түүнд итгэх итгэлтэй байх, нүглээ наманчлах, баптиsm хүртэх, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авах мөн эцсээ хүртэл тэвчихийг багтаасан Түүний сайн мэдээг дагахыг зарлигласан (Иохан 3:3-5; 3 Нираф 27:16-20; Итгэлийн Тунхаг 1:3-4-ийг үз). Бошиглогч Моронай Аврагчид очих мөн Түүний сургаалуудыг даваас бидний хүлээн авах ач ивээлийн тухай бичжээ:

“Тийм ээ, Христэд ирэгтүн, мөн түүгээр төгөлдөржигтүн, мөн бүх бурханлиг бусаас өөрсдөө татгалзагтун; мөн хэрэв та нар бүх бурханлиг бусаас өөрсдөө татгалзаж, мөн Бурханыг өөрсдийн бүхий л хүч, оюун, мөн чадлаар хайрлах аваас, тэгвэл түүний ач ивээл нь та нарт хангалттайгаас түүний ач ивээлээр та нар Христээр төгс байж болно; мөн хэрэв Бурханы ач ивээлээр та нар Христээр төгс аваас, та нар Бурханы хүчийг явч үгүйсгэж чадахгүй болой

“Мөн тэрчлэн, хэрэв Бурханы ач ивээлээр та нар Христээр төгс, мөн түүний хүчийг эс үгүйсгэх аваас, тэгвэл Бурханы ач ивээлээр та нар Христээр ариусгагдсан; та нарыг нүглийн ангижралд хүргэх, Эцэгийн тэр гэрээн дэх Христийн цусны урсгалтаар буюу, тиймээс та нар ариун толбо үгүй болох болой” (Моронай 10:32–33).

Амьдралынхаа Туршид Ач Ивээлийг Хүлээн Авах нь

Таны туйлын авралд ач ивээл хэрэгтэйгээс гадна энэхүү бололцоо олгох хүч нь амьдралд тань өдөр бүр хэрэгтэй. Та Тэнгэрлэг Эцэгтээ хичээл зүтгэл, даруу төлөв байдалтайгаар дөхөн очвоос Тэрээр ач ивээлээрээ дамжуулан таныг өргөн, хүчирхэгжүүлэх болно (Сургаал Үгс 3:34; 1 Петр 5:5; С ба Г 88:78; 106:7–8-ыг үз). Түүний ач ивээлд найдах нь танд таныг зөв шударгаар өсөж, хогжих боломжийг олгодог. Есүс Өөрөө “тэрээр эхлээд бүрэн байдлыг хүлээн авсан нь үгүй, харин тэрээр бүрэн байдлыг хүлээн авах хүртлээ ач ивээлээс ач ивээлд үргэлжлүүлж байлаа” (С ба Г 93:13). Ач ивээл нь Бурханы хаант улсыг, өөрийн хүч чадлаараа үзүүлж чадахгүй үйлчлэлийг барьж бүтээхэд туслах боломжоор хангадаг (Иохан 15:5; Филиппой 4:13; Еврей 12:28; Иаков 4:6–7-г үз).

Хэрэв таны урам хугарч, цаашид сайн мэдээгээр үргэлжлүүлэн амьдрахад дэндүү хэцүү санагдвал ач

ивээлийн хүчээр дамжуулан олж авч чадах хүч чадлыг санагтун. Та тайвшрал хийгээд Их Эзэний үгст баталгааг олно: “Миний өмнө өөрсдийгөө даруусгадаг бүх хүмүүст миний ач ивээл хангалттай юм; учир нь хэрэв тэд миний өмнө өөрсдийгөө даруусгах, мөн надад итгэлтэй байх аваас, тэгвэл би тэдэнд сүл дорой зүйлүүдийг нь хүчирхэг болгож өгнө” (Ифэр 12:27).

Нэмэлт судрууд: Ййлс 15:11; Ром 5:2; 2 Нифай 10:24; 11:5

Аврал; Амилуулалт; Есүс Христийн Цагаатгалыг мөн үз.

## Баптисм

Мормоны Ном нь сайн мэдээнээс суралцаж, Мормон хэмээх газар баптисм хүртсэн хэсэг бүлэг хүмүүсийн тухай өгүүлдэг. Тэд тэнд байхдаа “Гэтэлгэгчийн мэдлэгт ирсэн” учраас баптисм хүртсэн цагаасаа хойш Мормоныг гоо үзэсгэлэнгийн газар хэмээн нэрийджээ (Мозая 18:30). Тэд гэрчлэл болон баптисмын гэрээгээ батжуулснаар Их Эзэнд, тэр ч байтугай сорилтын үед ч итгэлтэй хэвээр үлджээ (Мозая 23–24-ийг үз).

Мормоны Номын энэхүү шастирт гарах эдгээр хүмүүсийн адил, та баптисмынхаа гэрээ болон Их Эзэний өөрт тань өгсөн амлалтыг санаснаар баяртай байж чадна. Та баптисм саяхан хүртсэн ч бай, эсвэл олон жилийн өмнө хүртсэн ч бай баптисмын ёслолдоо хүч чадлыг олох болно.

Мөнх Амьдралын Зам Дээр Гарах нь

Баптисм бол сайн мэдээний аврах нэгдүгээр ёслол юм (Итгэлийн Тунхаг 1:4-ийг үз). Санваарын эрх мэдлээр баптисм болон гишүүний баталгаагаар дамжуулан та Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн болдог.

## Баптисм

Та баптисм хүртэхдээ Аврагчийн жишээг дагах хүслээ харуулдаг. Тэр хэдийгээр нүгэлгүй байсан ч бас баптисм хүртсэн юм. Иохан Баптист Тэрээр бүх “зөв шударга ёсыг биелүүлэхээр” баптисм хүртэх хэрэгтэй байсан гэж тайлбарласан (Матай 3:13–17-г үз).

Мөнх амьдралыг эрэгч бүгд баптисм хүртэж, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авч Аврагчийн жишээг дагах ёстой. Аврагч бидэнд “[Бидний] орох ёстой хаалга нь наманчлал мөн баптисм болой; мөн тэгээд Ариун Сүнсээр мөн галаар та нарын нүглүүдийн ангижрал ирэх бөлгөө. Мөн чингээд [бид] энэ мөнхийн амьдралд хүргэдэг тэр давчуу бөгөөд нарийн замд байх болой” (2 Нифай 31:17–18-ыг үз). Хэрэв бид өөрсдийн гэрээнүүдээ сахин, авралын бусад ёслолуудыг хүлээн авахаар эцсээ хүртэл тэвчвэл мөнх амьдралыг хүлээн авч чадна.

## Их Эзэний Зам дахь Баптисм

Аврагч санваарын эрх мэдэлтэй нэгэн гүйцэтгэх ёстай ба усанд умбуулагдан хийгдэх ёстой гэдгийг тодорхой болгон, баптисмын ёслолын жинхэнэ арга замыг Бошиглогч Иосеф Смитэд илчилсэн билээ:

“Бурханаас дуудагдаж, мөн баптисм хүртээх эрх мэдлийг Есүс Христээс авсан хүн, өөрийгөө баптисмд авчирсан тэр хүний хамт ус руу орж, түүнийг нэрээр нь дуудан хэллэх нь: Есүс Христийн итгэмжилснээр би таныг Эцэг, мөн Хүү, мөн Ариун Сүнсний нэрээр баптисм хүртээж байна. Амен.”

“Тэгээд тэрээр түүнийг усанд умбуулж, мөн уснаас дахин гаргана” (С ба Г 20:73–74).

Усанд умбуулагдана гэдэг бол хүний нүгэлт амьдралын төгсгөл болон Бурхан хийгээд Түүний хүүхдүүдэд үйлчлэх үйлчлэлд зориулагдсан сүнслэг амьдралд дахин төрөх явдал юм. Мөн үхэл хийгээд амилуулалтын бэлэгдэл юм (Ром 6:3–6-г үз).

## Бяцхан Хүүхдүүд ба Баптисм

Хожмын үеийн илчлэлтээс бид бяцхан хүүхдүүд нь Есүс Христийн нигүүлслээр дамжуулан гэтэлгэгдэнэ гэдгийг мэднэ. Их Эзэн “Тэд нүгэл үйлдэж эс чадна, учир нь тэд миний өмнө хариуцлага хүлээж эхлэх хүртэл бяцхан хүүхдүүдийг уруу татах хүч Сатанд өгөгдсөн нь үгүй” гэж хэлсэн байdag (С ба Г 29:46–47-г үз). Их Эзэний илчилснээр хариуцлага хүлээж эхлэх чадвартай ё болох найман нас хүрэх хүртэл тэдэнд баптисм хүртээдэггүй (С ба Г 68:27; Иосеф Смитийн Орчуулга, Эхлэл 17:11-ийг үз). Бяцхан хүүхдүүдэд баптисм хэрэгтэй гэж хэлэх хэн боловч “Христийн нигүүлслийг үгүйсгэж, мөн түүний цагаатгал болон түүний гэтэлгэлийн хүчийг юу ч бус хэмээн үнэлж буй хэрэг” (Моронай 8:20; мөн 8–19, 21–24-ийг үз).

## Таны Баптисмын Гэрээ

Та баптисм хүртсэнээр Бурхантай гэрээ байгуулсан юм. Та Есүс Христийн нэрийг өөр дээрээ авч, Түүний зарлигуудыг даган, Түүнд эцсээ хүртэл үйлчлэхээр амласан юм (Мозая 18:8–10; С ба Г 20:37-г үз). Ариун ёслол хүртэх болгондоо та уг гэрээгээ шинэчилдэг билээ (С ба Г 20:77, 79-ийг үз).

Есүс Христийн Нэрийг Өөр Дээрээ Авах нь. Есүс Христийн нэрийг өөр дээрээ авахдаа та өөрийгөө Түүнд хамааралтай гэдгээ хардаг. Та амьдралдаа түүнийг болон Түүний ажлыг эхэнд тавьдаг. Та өөрийнхөө хүсч байгаа зүйл болон дэлхий юу хүсч болохыг танд заадгаас илүүтэйгээр Түүний хүсч буй зүйлийг эрэлхийлэх болно.

Мормоны Номонд Хаан Бенжамин Аврагчийн нэрийг өөрсөд дээрээ авах нь яагаад чухал гэдгийг тайлбарладаг:

“Түүгээр аврал ирэх үүнээс өөр нэр гэж үгүй; тиймийн тул, би та нарыг Христийн нэрийг өөрсөд дээрээ

## *Баптисм*

амьдралын төгсгөлийг хүртэл дуулгавартай байхаар Бурхантай гэрээнд орсон та нар бүгдийг бөлгөө.

“Мөнхүү улиран тохиох дор үүнийг хийсэн нь Бурханы баруун гар талд олдсон байх болно, учир нь тэрээр өөрийн нэрлэгдсэн нэрээ мэдэх болно; учир нь тэрээр Христийн нэрээр нэрлэгдэх болно.

“Мөнхүү улиран тохиох дор, Христийн нэрийг өөр дээрээ авахгүй хэн боловч өөр ямар нэгэн нэрээр нэрлэгдэх ёстой; тиймийн тул, тэрээр Бурханы зүүн гар талд өөрийгөө олох буюу” (Мозая 5:8–10).

Зарлигуудыг Сахих нь. Таны баптисмын гэрээ бол дэлхийгээс салж, Бурханы гэрчээр “ямар ч цагт мөн бүх зүйлүүдэд мөн өөрийн байж болох хаана ч гэсэн” зогсоохор Бурханы хаант улсад ирэх үүрэг амлалт билээ (Мозая 18:9). Бурханы гэрчээр зогсох таны хичээл зүтгэл таны хэлдэг мөн хийдэг бүх зүйлийг хамруулдаг. Үргэлж Их Эзэний зарлигуудыг сахих мөн санан дурсахыг хичээ. Бодол санаа, хэл яриа болон үйл хөдлөлөө цэвэр байлга. Кино, зурагт, Интернет, хөгжим, ном сэтгүүл болон сонин гэх мэт зугацах зүйлсийг хайхдаа үзэж, харах, сонсоходо болгоомжтой хандаж, зөвхөн урамшуулан дэмжих тэрхүү зүйлүүдийг унши. Даруухан хувцасла. Мөнхийн зорилгодоо хүрэхдэд тань дэмжих найз нөхдийг сонго. Ёс суртахуунгүй порнографи, мөрийтэй тоглох, архи, тамхи, хориотой эм, хар тамхинаас хол бай. Өөрийгөө ариун сүмд ороход зохистой байлга.

Их Эзэнд Үйлчлэх нь. Өөрийгөө дэлхийн зүйлсээс салгах зарлигууд нь та өөрийгөө бусдаас алслагдмал байлгах хэрэгтэй гэсэн үг биш юм. Баптисмын гэрээний нэг хэсэг бол Их Эзэнд үйлчлэх бөгөөд анд нөхдөдөө үйлчлэхдээ Түүнд хамгийн сайнаар үйлчилдэг. Бошиглогч Алма

баптисмын гэрээний тухай заахдаа, бид “мөн нэг нэгний-хээ ачааг тэдгээр нь хөнгөн байж болохын тулд, мөн гашуудах тэдний хамт гашуудаход; тийм ээ, тайтгарал хэрэгтэй тэдгээрийг тайтгаруулахад” байх ёстой гэж хэлсэн (Мозая 18:8–9). Бусадтай харьцахдаа Есүс Христийн жишээг даган бүх хүмүүст сайхан сэтгэлээр хандан хүндэтгэлтэй бай.

### Баптисмын Амлагдсан Адислалууд

Та баптисм дээр хийсэн гэрээгээ сахиваас Их Эзэн итгэлийн тань төлөө таныг адислах болно. Таны хүлээн авдаг зарим адислал бол байнгын хамтрагч, нүглүүдийн тань учлал хийгээд сүнслэгээр дахин төрөх онцгой эрх юм.

*Ариун Сүнсний Байнгын Хамтрагч.* Баптисм хүртсэний тань дараа эрх мэдэл бүхий нэг буюу түүнээс дээш Мелкизедек санваар атгагчид таны толгой дээр гар тавин Ариун Сүнсний бэлгийг өгсон билээ. Энэхүү бэлэг нь таныг зохистой байхад Ариун Сүнсний байнгын хамтрагч байх эрхийг танд олгодог. Сүнсний байнгын хамтрагч бол зуурдын байдалд таны хүлээн авч чадах агуу их адислалуудын нэг юм. Ариун Сүнс таныг мөнх амьдрал руу хөтлөн зөв шударга, амар амгалангийн зам дээр удирдах болно.

*Нүглийн Учлал.* Баптисм хүртсэн болохоор та нүглийн ангижралыг хүлээн авч чадна. Өөрөөр хэлбэл, та Аврагчийн нигүүлслээр учлагдаж чадна. Энэхүү адислалаар танд цаашид Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд амьдрах зөвшөөрөл олгогддог.

Нүглийнхээ учлалыг хүлээн авахын тулд та Есүс Христэд итгэлтэй байж, чин сэтгэлээсээ наманчлан, зарлигуудыг нь үргэлж дагахыг хичээх ёстой. Бониблогч Мормон “Наманчлалын анхны үр жимс нь

## *Баптисм*

баптисм юм; мөн итгэлээр ирдэг баптисм нь зарлигуудыг биелүүлэхдээ хүргэдэг буюу; мөн зарлигуудыг биелүүлэх нь нүглийн ангижралыг авчирдаг” хэмээн сургамжилсан (Моронай 8:25). Та нар Бурханы өмнө өөрсдийгөө үргэлжлүүлэн даруусгах, өдөр тутмын залбирлаараа Түүнээс гүйх, тууштайгаар итгэлтэй байж, хэрэгцээ гарсан хүмүүст үйлчилвэл “нүглүүдийнхээ ангижралыг үргэлж хадгалах болно” (Мозая 4:11–12, 26-г үз).

Дахин Төрөх нь. Та баптисм хийгээд гишүүний баталгааны ёслолуудаар дамжуулан шинэ амьдралд дахин төрсөн юм. Аврагч Некодимд “Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалд орж чадахгүй” гэж хэлжээ (Иохан 3:5). Нярай хүүхэд шинэ орчинд орохтой адилаар таныг баптисмын гэрээнд ороход шинэ амьдрал эхэлсэн билээ. Та баптисмын гэрээгээ сахин, гэрээгээ шинэчлэхээр ариун ёслолоос хүртэж, нүглээ наманчилваас сүнслэг байдалдаа өсч, Аврагчтай улам адилхан болж чадна. Төлөөлөгч Паул биднийг баптисм хүртэхэд “бид мөн шинэ амийн дотор явах ёстой” гэж заасан (Ром 6:4).

## *Эцсээ Хүртэл Тэвчих нь*

Баптисм хүртээд, Ариун Сүнсний бэлэг хүлээн авсны дараагаар та одоо Тэнгэрлэг Эцэгтэйгээ эргэн амьдрах аяллын тань зөвхөн эхлэлийг тавих эдгээр ёслолуудын төлөө зөв шударга байдалтайгаар үргэлжлүүлэх ёстой. Бошиглогч Ниифай:

“Та нарыг энэ давчуу бөгөөд нарийн замд орсны дараа бүгд хийгдсэн эсэхийг би асууя? Болгоогтун, би та нарт хэлнэ. Үгүй учир нь аврах чадал бүхий түүний гавьяанд та нар бүрэн дүүрнээр даатган, түүнд хэлбэрэлтгүй итгэлтэйгээр Христийн үгсээр бус аваас өдий зэрэгт хүрээгүй болой.”

“Иймийн тул, та нар найдварын төгс гэрэлтэйгээр, мөн Бурханыг болон бүх хүмүүсийг хайрлах хайрыг агуулан Христэд тууштайгаар итгэн урагш тэмүүлэн, Христийн үгнээс зооглон, мөн эцсээ хүртэл тэвчих аваас, болгоогтун, Эцэгийн тийн хэлсэнчлэн: Та нарт мөнхийн амьдралд байх болно” хэмээн заасан (2 Нифай 31:19–20).

Нэмэлт судрууд: Үйлс 2:37–38; 2 Нифай 31:4–13; Алма 7:14–16; 3 Нифай 11:18–41; 27:13–22; С ба Г 39:5–6, 10; 76:50–53

Ариун Ёслол; Ариун Сүнс; Дуулгавартай Байдал; Итгэл; Наманчлал; Санваарыг мөн үз.

### **Библии (Судруудыг үз)**

## **Бие Махбодын Үхэл**

Бие махбодын үхэл нь сүнс зуурдын биеэс салахыг хэлнэ. Адамын Уналт дэлхийд бие махбодын үхлийг авчирсан (Мосе 6:48-ыг үз).

Үхэл бол Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөний нэгэн зайлишгүй хэсэг юм (2 Нифай 9:6-г үз). Бид мөнхийн эцэгтэй адил болохын тулд үхлийг туулах болон хожим төгс төгөлдөр, амилуулагдсан бие махбодыг хүлээн авах ёстой.

Бие махбод үхэхэд сүнс цааш үргэлжлэн амьдардаг. Сүнсний дэлхийд зөв шударга сүнснүүд “өөрсдийн бүх бэрхшээлүүд болон санаа зовох, мөн харамслаасаа амрах диваажин гэж нэрлэгдсэн аз жаргалын байдал, амар амгалангийн байдал, энхийн байдалд хүлээн авагдсан байна” (Алма 40:12). Сүнсний шорон хэмээх газар нь “үнэний тухай мэдлэггүйгээр, эсвэл бошиглогчдыг эсэргүүцсэний улмаас зөрчилд, нүглүүддээ нас нөхчсөн тэдэнд” зориулагдсан юм (С ба Г 138:32). Шорон дахь сүнснүүд “Бурханд итгэх итгэл, нүглээ наманчлах, нүглүүдийн

ангижралын төлөө төлөөлөн хийх баптисм, гар тавилтаар Ариун Сүнсний бэлэг хүртээхийг, мөн тэдний хувьд мэдэх шаардлагатай сайн мэдээний бүх зарчмуудыг мэдэх болой” (С ба Г 138:33–34). Хэрэв тэд сайн мэдээний зарчмуудыг хүлээн авч, нүглээ наманчлан, тэдний өмнөөс ариун сүмд гүйцэтгэсэн ёслолуудыг хүлээн авбал диваажинд тавтай морилох болно.

Есүс Христийн Амилуулалт хийгээд Цагаатгалын улмаас бие махбодын үхэл бол түр зуурынх байдаг. “Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амилуулагдах болно” (1 Коринт 15:22). Үүн бүр амилуулагдах болно гэсэн утга нь хүн бүрийн сүнс өөр өөрийнхөө биетэй дахин нэгдэнэ—“өөрсдийн зохих мөн төгс хэлбэртээ сэргээгдэж болох” бөгөөд дахин үхлийн бай болохгүй (Алма 40:23; Алма 11:44–45-ыг үз).

Магадгүй та гэр бүлийн тань гишүүн, эсвэл найзын тань үхэлд бий болдог зовлонг туулж өнгөрүүлсэн байх. Иймэрхүү үеүдэд зовлон шаналтыг мэдрэх нь төрөлхийн зүйл юм. Үнэндээ гаслан гашуудал гэдэг бол хайрын гүн илрэл юм. Их Эээн “чи хайранд хамтдаа амьдрах ёстой, ийнхүү чи нас нөхчсон тэднийг алдсаныхаа толое уйлах ёстой” гэж хэлсэн (С ба Г 42:45). Үхлийн зовлон шаналлаас зайлсхийх цорын ганц зам бол амьдралдаа хэнийг ч хайрлахгүй байх явдал юм.

Хэдийгээр хайртай нэгнийгээ нас бараад нь хайлан гашуудваас амилуулалтын амлалтад хийгээд гэр бүлүүд мөнхөд хамтдаа байж чадна гэдэг баталгаанд тайвшрагыг хүлээн авч чаддаг. Та нар “харууслын мөн түүнчлэн баяслын агуу их шалтгааныг харлаа, хүмүүний дундах үхэл мөн сүйрлээс үүдэх харууслын, мөн амьдралд хүргэх Христийн гэрлээс үүдэх баяслыг буюу” (Алма 28:14; 9–13-ыг үз).

Хайрлаж байсан хүмүүс тань нас бараад тайвшрагыг хүлээн авснаар та бас угтаа нас эцэслэх болно гэдэг

мэдлэгтэйгээр амар амгалан байж чадна. Та сайн мэдээгээр амьдарч чадвал Их Эзэний амлалтыг дурсан санаж чадна: “Нас нөхчсөн тэд үхлийг үл амсана, учир нь энэ нь тэдэнд тааламжтай байх болно” (С ба Г 42:46).

Нэмэлт судрууд: Исаиа 25:8; 1 Коринт 15:51–58; 2 Нифай 9:6–15; Мозая 16:6–8

*Авралын Төлөвлөгөө; Амигуулалт; Диваажин; Есүс Христийн Цагаатгальг мөн үз.*

## Биеэ Цоолох нь

Хожмын үеийн бошиглогчид эмнэлгийн зорилгоос бусад тохиолдолд биеэ цоолохыг сайшсаан дэмждэггүй. Хэрэв охид, хүүхнүүд чихээ цоолох хүсэлтэй байвал зөвхөн нэг хос даруухан ээмэг зүүхийг сайшсаан дэмждэг.

Энэхүү зөвлөмжийг үл хүндэтгэн үзэж буй аливаа хүн Их Эзэн болон өөрийгөө хүндэтгэхгүй байгаа хэрэг юм. Нэг л өдөр тэд энэ шийдвэртээ харамсах болно.

Төлөөлөгч Паул билдний бие хэрхэн чухал ач холбогдолтой хийгээд тэдгээрийг санаатайгаар хорлож буй аюулыг “та нар өөрсдөө Бурханы сүм мөн бөгөөд Бурханы Сүнс та нарын дотор оршидог гэдгийг мэддэггүй юм уу? Хэрэв хэн нэг нь Бурханы сүмийг устгавал Бурхан тэр хүнийг устгана. Учир нь Бурханы сүм бол ариун бөгөөд энэ нь та нар мөн” хэмээн заасан (1 Коринт 3:16–17).

Даруу Байдал; Шивээс Хийлгэхийг мөн үз.

## Бишоп (Сүмийн Захиргааг үз)

## Бишрэл Хүндэтгэл

Бишрэл хүндэтгэл бол агуу их хүндэтгэл мөн хайр юм. Бурхан уруу чиглэсэн бишрэл хүндэтгэл танд байгаа үед та Түүнийг хүндэтгэнэ, Түүнд талархлаа илэрхийлнэ, Түүний зарлигуудыг та дагах болно.

## **Бишрэн Шүтэх нь**

Өөрийн хандлага, биеэ авч явах байдалдаа бишрэл хүндэтгэлтэй бай. Бишрэл хүндэтгэлтэй зан байдалд залбирал, судар судлах, аравны нэг болон өргөлөө төлөх нь багтдаг. Даруу хувцаслан, цэвэр мөн урам хайрласан үг хэллэг хэрэглэхийг мөн багтаадаг. Бишрэл хүндэтгэлийн хэмжүүр бол хөгжим болон бусад зугацах зүйлийн сонголт, нандин зүйлсийн талаар ярих яриа, сүм болон ариун сүм рүү явахдаа хувцаслах хувцаслалт, үйл хөдлөлийн тань нотолгоо юм. Бусдад үйлчлэн, тэднийг хүндэтгэн сайн санаж хандахдаа та Бурханд бишрэл хүндэтгэлээ харуулдаг.

Илүү бишрэл хүндэтгэлтэй болсноор та амьдралдаа нилээд өөрчлөлт гарч байгааг ажиглах болно. Их Эзэн Өөрийн Сүнсээ тан дээр цутгах болно. Таны түгшүүр, төөрөгдөл багасна. Хувийн болон гэр бүлийнхээ асуудлуудыг шийдэхэд туслах илчлэлтийг хүлээн авна.

Бишрэл хүндэтгэл Бурхан руу таныг ойртуулдаг шиг, үл тоомсорлох байдал нь муу ёрын зорилгод тохирдог. Сатан таныг дэлхийн их шуугиан, хөөрөл, догдол, хэрүүл маргаан, хөнгөвтөр байдал руу уруу татах болно. Цэргийн дарга дайралтанд бэлтгэж байгаатай адил тэрээр Их Эзэн та хоёрын хоорондын харилцааг эвдэхээр тэрээр оролдоно. Иймэрхүү нарийн башир аргаас сэрэмжил, бүх чадлаараа бишрэл хүндэтгэлтэй байхыг хичээ.

Нэмэлт судрууд: Левит 26:2; Дуулал 89:5–7; Еврей 12:28; С ба Г 59:21; 63:61–62, 64; 109:21

Бишрэл; Даруу Байдал; Залбирал; Илчлэлт; Итгэл; Талархалыг мөн үз.

## **Бишрэн Шүтэх нь**

Бурханыг бишрэн шүтэх нь Түүнд хайр, хүндэтгэл, үйлчлэл болон бүхнээ зориулан өгөхийг хэлнэ. Их Эзэн Мосед “Бурханыг шүт, учир нь чи гагцхүү түүнд үйлчлэх ёстой” хэмээн зарлигласан (Мосе 1:15). Энэхүү цаг үед

Тэрээр: “Их Эзэн Бурханаа бүх зүрх сэтгэлээрээ, өөрийн бүх хүчин чадал, оюун хийгээд чадлаараа хайрлах ёстой; мөн Есүс Христийн нэрээр чи түүнд үйлчлэх ёстой” хэмээн зарлиглажээ (С ба Г 59:5). Хэрэв ямарваа хүн болоод юмсыг Бурханы хайрын дээр тавибал, та хуурмагаар сүсэглэн биширч байгаа хэрэг юм (Египетээс гарсан нь 20:3–6).

Эцэгийг шүтэн биширч чадах нэг зам бол залбирал билээ. Алма хүү Хиламандаа “Тийм ээ, мөн өөрт хэрэгтэй бүх дэмжлэгийн тул Бурханаас өгүй; тийм ээ, бүхий л үйлүүд тань Их Эзэний тул байг, мөн чи хаана ч явсан Их Эзэнтэй нэгдмэл; тийм ээ, бүх бодол санаа чинь Их Эзэнд чиглэсэн байг; тийм ээ, зүрх сэтгэлийн тань хайр Их Эзэний дээр үүрд байрласан байг” хэмээн заасан (Алма 37:36).

Сүмийн хурал цуглаанд шүтлэг бишрэлийн сүнсээр оролцох ёстой. Их Эзэн зарлиглахдаа: “Мөн чи өөрийгөө дэлхийгээс илүү бүрэн дүүрэн толбогүй байлгаж болгохын тулд, чи залбирлын өргөөнд очиж мөн миний ариун өдөрт ариун ёслолуудаа өргөх ёстой; учир нь үнэнээр энэ бол хөдөлмөрүүдээсээ амрахаар, мөн Бүхний Дээдэд чи бүхнээ зориулахаар чамд өгөгдсөн өдөр болой” (С ба Г 59:9–10).

Санваарын ёслолуудад оролцох нь мөн шүтлэг бишрэлийн нэг хэсэг билээ. Ариун ёслолоос хүндэтгэлтэйгээр хүртэн, ариун сүм рүү явах аваас та Тэнгэрлэг Эцэгийг санан дурсаж, бишрэн шүтдэг ба Түүний ХҮҮ Есүс Христэд талархлаа илэрхийлэх болно.

Шүтэн бишрэх гадаад илэрхийллээ харуулахдаа та хаана ч байсан, юм хийх болгондоо бишрэн шүтэх хандлагатай байх нь зүйтэй. Алма энэхүү зарчмыг шүтлэг бишрэлийн газраас хөөгдөн гарсан бүлэг хүмүүст заасан. Тэр тэднийг үнэн шүтлэг бишрэл нь долоо хоногийн нэг өдрөөр хязгаарлагдаггүй гэдгийг харахад тусалсан

## **Бодгаль**

(Алма 32:11-ийг үз). Нөгөөх бүлэг хүмүүстээ Алмагийн анд нөхөр Амюлек тэднийг “мөн байж болох газар бүртээ Бурханыг сүнсэнд бас үнэнд шүтэн бишрээсэй” хэмээн зоригжуулсан (Алма 34:38).

Нэмэлт судрууд: Дуулал 95:6–7; Мозая 18:25; Алма 33:2–11; С ба Г 20:17–19, 29; Итгэлийн Тунхаг 1:11

Бурхан Эцэг; Залбирал; Мацаг ба Мацгийн Өргөлүүд; Хайр; Хүндэтгэлийн Өдрийг мөн үз.

## **Бодгаль**

Бодгаль хэмээх нэр томъёог сударт хоёр замаар хэрэглэдэг. Нэгд, зуурдын байдалд буюу амилуулалтын дараа бие махбодитойгоо нэгдээгүй сүнсийг бодгаль гэж нэрлэдэг (С ба Г 88:15–16). Хоёрт, заримдаа сүнсийг бодгаль гэж нэрлэдэг (Алма 40:15–18; Абрахам 3:23-ыг үз).

Авралын Төлөвлөгөө; Амилуулалт; Сүнсийг мөн үз.

## **Боловсрол**

“Судлахаар мөн тэрчлэн итгэлээр суралцахыг эрэлхийлэгтүн” хэмээн Их Эзэн зарлиглажээ (С ба Г 88:118). Тэрээр биднийг сайн мэдээнээс суралцах мөн “тэнгэр дэх мөн дэлхий дэх мөн дэлхийн доорх зүйлүүдийн тухай; байсаар ирсэн зүйлүүд, байгаа зүйлүүд, удахгүй тохиох зүйлүүд; гэрт байгаа зүйлүүд, гадаа байгаа зүйлүүд; дайнууд болон үндэстнүүдийн ээдрээтэй байдал, мөн уг нутаг дээрх шүүлтүүд; мөн тэрчлэн улс орнуудын тухай хийгээд хаант улсуудын тухай мэдлэгт буюу—та нар бүх зүйлд бэлтгэгдсэн байж болохын тулд” ойлголт олж авахыг зөвлөсөн юм (С ба Г 88:78–80).

## Сургууль ба Мэргэжлийн Сургалт

Та ухаан санаа хийгээд гараа хөгжүүлэхээр үргэлж ажиллавал сонгосон талбartaа амжилт гаргаж чадна. Боловсролоо сайны нөлөө байхаар ашигла. Та ийнхүү үйлдвэл шударга байдалтай хүнээр олонд танигдах болно. Та ирэх боломжинд бэлтгэгдэж болох ба та нар гэр бүлдээ мөн Сүмдээ, нийгэмдээ үнэт хүчин зүйл болж болох юм.

Боломжийн шилдэг сургуулийг эрэлхийл. Зарим нэг бололцоотой сургалтууд нь коллеж, их сургууль, техникийн сургууль, гэрийн сургалттай сургууль, нийтийн боловсрол мөн хувийн сургалт билээ.

## Семинар болон Институт

Дэлхий даяар 14-өөс 18 нас хүртэлх Хожмын Үеийн Гэгээнтнүүд долоо хоногийн дундуур судруудаас сургамж заавар олгох семинарт явдаг. Шашны сургуулиуд нь долоо хоногийн дундуур 18-аас 30 хүртэлх насны Хожмын Үеийн Гэгээнтнүүдийг сайн мэдээний янз бүрийн хичээлүүдээр хангадаг.

Сайн мэдээний талаар илүү ихийг сурах явидаа бие биетэйгээ нөхөрлөдөг оюутнууд байгаа газарт эдгээр хөтөлбөрүүд сүнслэг хийгээд нийгмийн уур амьсгалыг бий болгож өгдөг.

Институт, семинарын талаар мэдээлэл авахыг хүсвэл орон нутгийн санваарын удирдагчдаа ханд.

## Насан Туршийн Сургалт

Амьдралынхаа турш боловсролтой болох боломжуудыг үргэлжлүүлэн эрэлхийл. Ингэх нь та нарт сонгосон мэргэжил хийгээд өөрийнхөө бусад ур чадвар, сонирхолдоо шинэлэг арга барилыг эзэмшихэд тусална. Та их

## **Бохир Хэллэг**

хурдацтайгаар өөрчлөгдөж байгаа дэлхийд өнөөдөр хийгээд ирээдүйд өөрийгөө боловсруулах цаг гаргах ёстой.

Албан ёсны сургалтын туслалцаатайгаар боловсроо нэмэгдүүлэхийн тулд та юм уншиж, үр өгөөжтэй соёлын үйл ажиллагаанд оролцон, музей болон түүхийн дурсгалт газруудаар явж, хүрээлэн буй орчноо ажиглан үргэлжлүүлэн суралцаж чадна.

Нэмэлт судруулд: Сургаалт үгс 1:5; С ба Г 130:18–19

## **Бохир Хэллэг**

Бохир хэллэг бол нандин зүйлсийг үл хүндэтгэн мөн хараан доромжлох явдал юм. Үүнд Бурхан Тэргүүтний аль нэг гишүүний нэрийг үл хүндэтгэн, замбараагүй хэрэглэхийг багтаадаг. Мөн аливаа цэвэр бус, бүдүүлэг хэл яриа зан байдлыг хамааруулна.

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ болон Ариун Сүнсний нэрийг үргэлж бишрэл хүндэтгэлтэйгээр хэрэглэ. Тэдний нэrsийг буруу хэрэглэхийг нүгэлд тооцдог. Бузар үгс, бүдүүлэг, балмад хэл яриа, үйлдэл мөн ёс суртахуунгүй тохуурхал, онигоо нь Их Эзэн болон бусдыг гомдоож буй хэрэг мөн.

Тэнэг хэл яриа таны сүнсийг гэмтээж, таныг байх ёстой хэмжээнээс чинь доошлуулна. Бусдыг танд тэнэг хэл яриа хэрэглүүлэхэд бүү нөлөөлүүл. Үүний оронд бусдад урам өгч сэргээдэг цэвэр хэл яриаг хэрэглэ. Соёлтой харьцаатай найз нөхдийг сонго. Эргэн тойронд байгаа хүмүүсээ соёлтой боловсон харьцахыг урамшуулах үүднээс үлгэр жишээ үзүүл. Хэрэв найз нөхөд, танилууд тань бузар үгс болон муухай хэл яриа хэрэглэж байвал өөр үгс ашиглахыг урамшуулан дэмж. Хэрэв тэд эсэргүүцвэл соёлтойгоор тухайн газрыг орхиж, эсвэл ярианы сэдвээ өөрчил.

Танд хараал тавих зуршил байвал үүнийгээ таслан зогсоо. Өөрчлөлт хийх шийдвэр хийснээр эхэл. Тусlamж хүсэн залбир. Хэрэв чи бузар үгс хэрэглэхээр уруу татагдах бол чимээгүй бай эсвэл өөр байдлаар үгээ хэл.

Нэмэлт судрууд: Левит 19:12; С ба Г 63:60–64

Даруу Байдал; Уруу Таталтыг үз.

### Бошиглогол (Илчлэлт; Сүнслэг Бэлгийг үз)

#### Бошиглогчид

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүдийн хувьд бид Моисе, Исаа, Петр, Паул, Нифай, Мормон болон бусад судрын бошиглогчидтой адил Их Эзэнтэй ярихаар дуудагдсан амьд бошиглогч доор бурханлигаар нөлөөлөгдөн удирдуулахаар адислагдсан билээ. Бид Сүмийн Ерөнхийлөгчийг бошиглогч, үзмэрч, илчлэгч–дэлхий дээрх Сүмийг бүхэлд нь удирдах илчлэлт хүлээн авдаг цорын ганц хүн хэмээн дэмждэг. Мөн бид Тэргүүн Зөвлөлийн зөвлөхүүд болон Арванхоёр Төлөөлөгчдийн Чуулгын гишүүдийг бошиглогч, үзмэрч болон илчлэгчид хэмээн дэмждэг.

Эртний бошиглогчдын адил өнөөдөр бошиглогчид Есүс Христийг гэрчилж, Түүний сайн мэдээг заадаг. Тэд Бурханы хүсэл болон үнэн шинж чанарыг гаргаж ирдэг. Тэд нүглийг буруушаан, үүний үр дагаврыг сануулан ил тод зоригтойгоор хэлдэг. Зарим үед тэд бидний тусын тулд ирээдүйн үйл явдлыг бошиглоо кор бурханлигаар нөлөөлөгдөж болно.

Та үргэлж амьд бошиглогчид итгэж болно. Тэдний заадаг зүйдүүд нь “Их Эзэн миний бие ярьснаа би ярилаа, мөн би өөрийгөө зөвтгөх нь үгүй; мөн тэнгэр хийгээд газар үгүй болсон ч, миний үг алга болох нь үгүй, харин миний өөрийн дуу хоолой байна уу, эсвэл миний

## **Бурхан Тэргүүтэн**

үйлчлэгчдийн дуу хоолой байна уу, энэ нь яг адил, бүгд биелэгдэх болно” хэмээн тунхагласан Их Эзэний хүсэл зоригийг тусгадаг ( С ба Г 1:38 ).

Таны аюулгүй байдал Их Эзэний Өөрийн бошиглогчдоороо, ялангуяа сүмийн өнөөгийн Ерөнхийлөгчөөр дамжуулан өгсөн үгсийг хатуу дагах явдал юм. Амьд бошиглогчийн үгсийг үл тоомсорлодог тэд унах болно хэмээн Их Эзэн сэргэжлүүлсэн (С ба Г 1:14–16-г үз). Сүмийн Ерөнхийлөгчийн үгсийг дагадаг хүмүүст агуу их адислалуудыг Тэрээр мөн амладаг:

“Та нар миний өмнө бүхий л цэвэр ариун байдалд алхан, та нарт түүний өгөх түүний бүх үгсэд хийгээд зарлигуудад анхаарал тавигтуун;

“Учир нь түүний үгийг та нар миний амнаас гарсан мэтээр бүхий л тэвчээр хийгээд итгэлд хүлээн авах ёстой.

“Учир нь эдгээр зүйлүүдийг хийснээр тамын үүд та нарыг дийлэх нь үгүй, тийм ээ, мөн Их Эзэн Бурхан харанхуйн хүчийг та нарын өмнөөс сарниулж, мөн та сайн сайхан хийгээд түүний нэрийн алдар суугийн төлөө тэнгэрийг сэгсрэхэд хүргэх болно” (С ба Г 21:4–6).

Нэмэлт судрууд: Шастирын дэд 20:20; Амос 3:7; Ефес 2:19–20; 1 Нифай 22:1–2; Мозая 13:33–35; С ба Г 107:91–92; Итгэлийн Тунхаг 1:6

## **Бурхан Тэргүүтэн**

Итгэлийн тунхаг нэгдүгээрт “Бурхан, Мөнхийн Эцэг, мөн Түүний Хүү Есүс Христ, мөн Ариун Сүнсэнд бид итгэдэг” гэжээ. Эдгээр турван биет нь Бурхан Тэргүүтнийг бүрдүүлдэг. Тэд энэ дэлхийг болон Тэнгэр дэх Эцэгийн бусад бүх бүтээлтийг захирдаг.

Бурхан тэргүүтний жинхэнэ сургаал нь Аврагчийн зуурдын байдлын тохинуулал хийгээд Түүний Төлөөлөгчдийн үхлийн дараа бий болсон урвалтад

алдагдсан юм. Энэхүү сургаал нь 14 настай Иосеф Смитийг Анхны Үзэгдэл хүлээн авах үед сэргээгджээ (Иосеф Смитийн Түүх 1:17-г үз). Бид Анхны Үзэгдлийн Бошиглолын шастираас мөн түүний бусад сургаалаас Бурхан Тэргүүтний гишүүд нь гурван салангид биет гэдгийг мэддэг. Эцэг Хүү хоёрт бодит махран бие маҳбод байдаг бол Ариун Сүнс нь хүн төрхтэй сүнс юм (С ба Г 130:22).

Хэдийгээр Бурхан Тэргүүтний гишүүд нь өөр өөр үүрэгтэй тус тусдаа биетэй боловч тэд сайн мэдээ, зорилгын хувьд нэг юм. Тэд Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр төгс нэгдсэн байдаг.

Нэмэлт судрууд: Матай 3:13–17; Иохан 14:6–10; 17:6–23; Үйлс 7:55–56; 2 Нифай 31:18; Мормон 7:5–7; С ба Г 76:20–24

Ариун Сүнс; Бурхан Эцэг; Есүс Христийг үз.

## Бурхан Эцэг

Бурхан Эцэг бол бидний итгэж, бишрэн шүтдэг Агуу Биет юм. Тэр бол Бүтээгч, Удирдагч, бүх зүйлийн Хамгаалагч юм. Тэрээр төгс төгөлдөр, Түүнд бүх хүч байдаг ба бүх зүйлийг мэддэг. Тэр “хүмүүнийхтэй адил мэдрэгдэх маҳ хийгээд ясан биетэй” (С ба Г 130:22).

Бидний Тэнгэрлэг Эцэг бол шүүлт, хүч чадал, мэдлэг болон хүчний Бурхан боловч Тэр мөн нигүүлсэл, зөөлон сэтгэл, энэрлийн төгс Бурхан юм. Хэдийгээр бид “бүх зүйлүүдийн утгыг мэдэхгүй ч” бид Тэр биднийг хайрладаг хэмээх лавтай мэдлэгээр амар амгаланг олж чадна (1 Нифай 11:17-г үз).

## Бидний Сүнсний Эцэг

Амьдралын талаарх агуу их асуултуудын нэг бол “Би хэн бэ?” гэсэн асуулт юм. Хүүхдийн Хэсгийн хайлам дуу бяцхан хүүхдүүдийг ч мөн асуултад хариулахад

## Бурхан Эцэг

тусалдаг. Бид “Би Бурханы хүүхэд, тэрээр намайг энд илгээсэн билээ” хэмээн дуулдаг. Бид бол Бурханы хүүхдүүд гэсэн мэдлэг хүч чадал, тайвшрал, болон итгэл найдварыг өгдөг.

Та бол зуурдын байдлын өмнөх амьдралд сүнсээр төрсөн Бурханы хүүхэд мөн. Түүний хүүхэд ёсоор танд тэнгэрлэг, мөнхийн боломж байгаа гэдэгт итгэлтэй бай, мөн Тэр энэхүү боломжинд хүрэх чин сэтгэлийн хичээл зүтгэлд тань туслах болно.

## Агуу Бүтээгч

Тэнгэрлэг Эцэг бол Агуу Бүтээгч юм. Есөс Христээр дамжуулан Тэр тэнгэр, газар дэлхий хийгээд түүн дээр байх бүх зүйлсийг бүтээжээ (Мосе 2:1-ийг үз). “Бүх зүйл Бурхан байдгийг үзүүлдэг; тийм ээ, бүр газар дэлхий, мөн үүний гадаргуу дээрх бүх зүйл, тийм ээ, мөн үүний хөдөлгөөн, тийм ээ, мөн өөрсдийн байнгын замаар хөдлөх тэр бүр гарагууд Эрхэм Агуу Бүтээгч байдгийг гэрчилдэг” хэмээн Алма хэлжээ (Алма 30:44).

Цагаас цагт бүтээлийн гоо сайхныг тунгаан бод: модод, цэцэгс, амьтад, уул нурууд, далайн давалгаа, сая төрсөн хүүхэд. “Бурхан өөрийн алдар суу мөн хүч чадлаараа хөдөлж” байгаагийн баталгаа болсон тоо томшгүй олон одыг харан тэнгэр өөд шильтэх цаг гарга (С ба Г 88:41–47-г үз).

## Авралын Төлөвлөгөөний Зохиогч

Тэнгэр дэх эцэг маань биднийг Өөртэйгөө мөнхөд хамт амьдраасай гэж хүсдэг. Түүний ажил, алдар суу бол “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах” нь юм (Мосе 1:39). Үүнийг боломжтой болгохын тулд тэр авралын төлөвлөгөөг бэлтгэсэн

юм. Тэрээр Өөрийн хайрт Хүү Есүс Христийг үхлийн хүлээсийг тайлцуулахаар, дэлхийн нүглийг цагаатгахаар илгээжээ: “Бурхан өртөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм” (Иохан 3:16). Энэхүү золиослол нь Эцэг биднийг хайрладагийн агуу илрэл юм.

### Бурхан Эцэгийг Танин Мэдэх нь

Бурханы хүүхдүүдийн хувьд Тэр биднийг Өөрийн бусад бүх бүтээлээсээ тусгаарласнаар бид Түүнтэй онцгой харилцаатай байдаг. Тэнгэр дэх Эцэгээ мэдэхийг эрэлхийл. Тэр чамд хайртай, та залбирвал Тэр танд Өөрт нь ойртон очих үнэт боломжийг өгсөн юм. Чин сэтгэлийн болон төлөв даруу байдлыг үзүүлсэн таны залбирлууд түүнд хүрч хариулагдах болно.

Түүнчлэн та Түүний Хайрт Хүүгийн талаар сурч мэдэн, сайн мэдээг амьдралдаа хэрэглэн Эцэгээ таньж болно. Аврагч шавь нартаяа: “Хэрэв та нар намайг мэдсэн бол Миний Эцэгийг ч мөн мэдэх байсан . . . намайг харсан хүн Эцэгийг харсан” хэмээн сургасан юм (Иохан 14:7, 9).

Та судруудаас болон хожмын үеийн бошиглогчдын үгсээс суралцан мөн үйлчлэл үзүүлснээр Бурхан Эцэгт ойр байж чадна. Та Бурханы хүсэл болон Түүний хүссэнээр амьдарваас Түүнтэй болон Түүний Хүүтэй улам адил болж чадна. Та өөрийгөө тэдний оршихуйд эргэн очиж амьдрахад бэлтгэ.

Нэмэлт судрууд: Иохан 14:6, 21–24; 17:3; Мозая 4:9; С ба Г 132:22–24; Итгэлийн Тунхаг 1:1

Авралын Төлөвлөгөө; Бурхан Тэргүүтэн; Бүтээлтийг мөн үз.

## Бусдыг Шүүх нь

Бусдыг ямар нэг байдлаар шүүх нь буруу гэж зарим хүмүүс үздэг. Бусдыг шударга бусаар шүүх буюу зэмлэх нь буруу байдаг ч танд амьдралынхаа турш бодол санаа, нөхцөл байдал, хүмүүсийн талаар шүүн үзэж байх хэрэгтэй байдаг. Таныг шүүхийн тулд Их Эзэн олон зарлиг өгсөн билээ. Жишээ нь: Тэрээр “хуурамч эш үзүүлэгчдээс болгоомжил . . . та нар тэднийг үр жимсээр нь танина” (Матай 7:15–16) мөн “Та нар ёс бусчуудын дундаас гарч явагтун” (С ба Г 38:42). Та найз нөхдөө сонгох, засгийн газрын удирдагчдыг сонгох, мөн мөнхийн хания сонгох зэрэг олон чухал шийдвэрүүддээ хүмүүсийг шүүн үзэх хэрэгтэй болдог.

Шүүлт нь сонголтын чухал хэрэглээ бөгөөд ялангуяа таныг бусад хүмүүсийн тухай шүүлт хийхэд маш их анхаарал шаарддаг. Таны бүхий л шүүлтүүд нь шударга жишигээр удирдагдах ёстай. Хүн бүрийн зүрх сэтгэлийг мэддэг зөвхөн Бурхан л хувь хүмүүсийн хамгийн эцсийн шүүлтийг хийж чадна гэдгийг сана (Илчлэлт 20:12; 3 Нифай 27:14; С ба Г 137:9).

Биднийг бусдыг шүүх байдалд удирдахын тулд Их Эзэн сануулгыг өгсөн: “Та нар ямар шүүлтээр шүүнэ, та нар түүгээрээ шүүгдэх болно; мөн та нар ямар хэмжээгээр хэмжинэ, та нар тэрчлэн хэмжигдэх болно. Мөн та яагаад ах дүүсийнхээ нүдэн дэх үртсийг болгоодог хэрнээ өөрийнхөө нүдэн дэх дүнзийг анзаардаггүй билээ? Эс бөгөөс та ах дүүдээ: Нүдэн дэх үртсийг чинь аваад өгье хэмээн—мөн болгоогтун, өөрийн тань нүдэнд дүнз байхад хэрхэн хэлэх вэ? Хоёр нүүртэн та эхлээд өөрийнхөө нүднээс дүнзээ гаргаж хая; мөн тэгээд та ах дүүгийнхээ нүднээс үртсийг авч хаяхдаа сайн харах болно” (3 Нифай 14:2–5).

Энэхүү судрын хэсэгт Их Эзэн бидний олж хардаг бусдын буруу бол тэр хүний нүдэн дэх жаахан үртэс мэт

байдаг бол бидний өөрсдийн буруу үүнтэй харыцуулвал бидний өөрсдийн нүдэнд аварга том дүнз мод мэт байдаг гэдгийг заадаг. Бид өөрсдийгөө хөгжүүлэхийн төлөө ажиллах ёстой атал заримдаа бусдын алдаан дээр төвлөрдөг.

Бусдын тухай таны шударга шүүлт тэдэнд хэрэгцээтэй удирдамж нь болж өгдөг бөгөөд зарим тохиолдолд та болон таны гэр бүлд хамгаалалт болдог. Шүүн үзэхдээ анхааралтай ханд. Чадах чинээгээрээ хүмүүсийг шүүхээс илүүтэйгээр хүмүүсийн нөхцөл байдлыг шүү. Боломжтой бол, хангалттай баримт нотолгоотой болохоос нааш шүүлт бүү гарга. Шийдвэрүүдийг тань удирдаж чадах Ариун Сүнсэнд үргэлж мэдрэмжтэй бай. Хүү Кориантондоо өгсөн Алмагийн зөвлөгөөг санагтун: “өөрийн ах дүүст нигүүлсэнгүй байхаа мэд; шударгаар харьц, зөв шударгаар шүү, мөн үргэлж сайныг үйлд” (Алма 41:14).

Нэмэлт судрууд: 1 Самуел 16:7; Моронай 7:14–19; С ба Г 11:12

Нигүүлсэл; Өршөөл; Хайр; Энэрэлийг мөн үз.

## Бүсийн Эрх Мэдэлтэй Дал (Сүмийн Захиргааг үз)

### БҮТЭЭЛТ

Есүс Христ Тэнгэрлэг Эцэгийн удирдамж дор тэнгэрүүд болон дэлхийн ертөнцийг бүтээсэн. (Мозая 3:8 Мое 2:1-ийг үз). Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан илчлэгдсэн судраас бид Бүтээлийн ажилд, Их Эзэн урьд нь оршиж байсан элементүүдийг зохион байгуулсан гэдгийг мэдэж авдаг. (Абархам 3:24-ийг үз). Тэрээр дэлхийг зарим хүмүүсийн итгэдгийн адилаар “юу ч үгүй зүйлээс” бүтээгдэгүй юм.

Түүнчлэн судрууд Адамыг “бүх хүн төрөлхтний анхны хүн” байсан гэж заадаг (Мое 1:34). Бурхан Адам Ева

## *Бэлгийн Харилцааны Ёс Суртахуунгүй Байдал*

хоёрыг Фөрийн дүрээр мөн Фөрийн Цорын Ганцын дүрээр бүтээсэн юм (Мосе 2:26–27-г үз).

Бүтээлт нь Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөний зайлшгүй нэг хэсэг юм. Бие махбодь хүлээн авч мөн сонголтоо хэрэгжүүлж болох дэлхий рүү ирэх боломжийг энэ нь хүн бүхэнд олгодог. Өмнөх оршихуйн Бурхадуудын Зөвлөлд дараах тунхаглалыг хийсэн: “Бид доошоо явцгаах болно, учир нь тэнд орон зай буй, мөн бид эдгээр материалуудаас авч, мөн дээр нь тэд оршин сууж болох дэлхийг бид хийх болно; мөн Их Эзэн, тэдний Бурхан тэдэнд зарлиглах бүх зүйл юуг ч гэсэн тэд хийх нь үү гэдгийг харахын тулд үүгээр бид тэднийг нотлох болно” (Абрахам 3:24–25).

Та бол Бурханы хүүхэд бөгөөд таны бие Түүний дүр төрхөөр бүтээгдсэн юм. Та эдгээр адислалуудад талархлаа илэрхийлэхийн тулд Мэргэн Ухааны Үг болон бусад сүнсний хийгээд бие махбодын эрүүл мэндтэй холбоотой зарлигуудыг дагаснаар биедээ анхаарал тавьж чадна (С ба Г 89-ийг үз; С ба Г 88:124-ийг үз). Та бусад хүмүүсийг Бурханы хүүхдүүд мэтээр хүндэтгэж чадна.

Бүтээлтийн бүхий л гоо сайхныг өвлөгчийн хувьд та эх дэлхийгээ хайрлаж, хойч үедээ зориулан хадгалахад нь тусалж чадна.

Нэмэлт судрууд: Эхлэл 1–2; Еврей 1:1–2; 1 Нифай 17:36; С ба Г 38:1–3; 59:16–20; Мose 1–3; Абрахам 4–5

Авралын төлөвлөгөө; Бурхан Эцэг; Есүс Христийг мөн үз.

## **Бэлгийн Харилцааны Ёс Суртахуунгүй Байдал** (Ариун явдлыг үз)

**Гадас** (Сүмийн Захиргааг үз)

## Гар Тавилт

Гар тавилт нь гишүүний баталгаа, томилолт, гишүүдийг дуудлагат ажилд томилох, өвчтөнийг эдгээх болон бусад санваарын адислалууд зэрэг санваарын олон ёслолуудыг гүйцэтгэхэд зориулан Их Эзэний илчилсэн жаяг юм (С ба Г 42:44; Итгэлийн Тунхаг 1:4–5-ыг үз). Ёслолыг хүлээн авч байгаа хүний толгой дээр зохистой санваарын эрх мэдэл бүхий хүмүүс гарaa тавьдаг. Ийнхүү үйлдсэнээр, тэд Их Эзэний хүүхдүүдийг адислах Түүний гар дахь зэмсэг лугаа адил үйлчилдэг. (С ба Г 36:2-г үз).

Энэ жаягийг үргэлж санваартнууд ашигладаг. Адам өөрийн зөв шударга эрэгтэй үр удмаа гар тавьснаар томилсон (С ба Г 107:40–50-ийг үз). Иаков Ефрайм, Манассе хоёрт адислал өгөхдөө тэдний толгой дээр гарaa тавьсан (Эхлэл 48:14–19-ийг үз). Алма Бурханы жаягийн дагуу гар тавьснаар санваартнууд болон ахлагч нарыг томилсон юм (Алма 6:1). Төлөөлөгч Петр, Иохан хоёр Ариун Сүнсний бэлгийг гар тавьснаар өгсөн (Үйлс 8:14–17-г үз). Энэ эрин үед, Иохан Баптист Иосеф Смит, Оливер Каудери хоёр дээр гар тавьснаар Аароны Санваарыг олгосон (Иосеф Смитийн Түүх 1:68–69-ийг үз).

Нэмэлт судрууд: Тооллого 27:18–23; Үйлс 19:1–6; 1 Тимот 4:14; С ба Г 33:15; 35:6

Ариун Сүнс; Санваарыг мөн үз

## Гишүүний Баталгаа (Ариун Сүнс; Гар Тавихыг үз)

### Гэр Бүл

1995 оны Есдүгээр сарын 23-нд Сүмийн 15 дахь Ерөнхийлөгч Гордон Б. Хинкли дараах тунхаглалыг ерөнхий Нийгмийн Халамжийн Хурал дээр уншжээ. Энэхүү “Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг” хэмээх

гарчигтай бурханлиг тунхаглал нь Сүмийн зохиогчийн эрхтэй гэр бүлийн талаарх мэдэгдэл болсон билээ:

“Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Зөвлөлийнхөн бид эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлтийг Бурхан заясан бөгөөд гэр бүл нь Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь заяаны төлөөх Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдгийг чин сэтгэлээсээ тунхаглаж байна.

“Бурхан бүх хүн төрөлхтөн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг өөрийнхөө дүр төрхөөр бүтээсэн. Хүн бүр тэнгэрлэг эцэг эхийн хайртай сүнслэг хүү, охин нь бөгөөд ийм учраас хүн бүр бурханлиг шинж чанар, хувь тавилантай юм. Хүйс бол хувь хүний мөнх бус байдлын өмнөх, мөнх бус болон мөнхийн амьдралын тодорхойлолт ба зорилгын салшгүй шинж чанар юм.

“Мөнх бус байдлын өмнөх амьдралдаа сүнслэг хөвгүүд, охид Бурханыг Мөнхийн Эцэг хэмээн мэдэж, биширдэг байсан бөгөөд мөнхийн амьдралыг өвлөн авах тэнгэрлэг хувь заяагаа бүрэн дүүрэн ухааран ойлгож төгс төгөлдөр болон хөгжин дэвшихийн тулд бие маходтой болж энэ дэлхийд амьдрах тухай Түүний төлөвлөгөөг хүлээн зөвшөөрсөн юм. Аз жаргалын тэнгэрлэг төлөвлөгөө нь насан эцэслэсний дараа гэр бүлийн холбоог мөнхжих боломж олгодог. Ариун Сүмүүдэд гүйцэтгэдэг нандин ёслол ба гэрээнүүд нь хувь хүмүүс Бурханы хүрээлэлд эргэн очих, гэр бүлүүд мөнхөд нэгдэх боломжтой болгодог.

“Бурханы Адам, Ева хоёрт өгсөн анхны зарлиг нь тэд эхнэр нөхрийн хувьд эцэг эх болж чадах боломжийн талаар байлаа. Өөрийн хүүхдүүддээ, өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж газар дэлхийг дүүргэ хэмээсэн Бурханы зарлиг нь хүчин төгөлдөр байгааг бид тунхаглаж байна. Түүнчлэн үр удмаа үлдээх энэхүү нандин хүч нь зөвхөн

хууль ёсоор гэрлэсэн эхнэр нөхөр болох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой хэмээн Бурхан зарлигласныг тунхаглаж байна.

“Мөнх бус амьдралыг бий болгох арга зам нь Тэнгэрээс тогтоогдсон гэдгийг бид тунхагладаг. Бурханы мөнхийн төлөвлөгөөн дэх амьдралын цэвэр ариун байдал болон үүний чухал ач холбогдлын талаар бид батлан хэлж байна.

“Нөхөр, эхнэр хоёр нь бие биенээ болон үр хүүхдээ хайрлан, халамжлах албан ёсны хариуцлага хүлээнэ. ‘Үр хүүхдээ бол Их Эзэний өв юм’ (Дуулал 127:3). Эцэг эхчүүд хүүхдүүдээ хайраар болон зөв шударга байдлаар өсгөн хүмүүжүүлж бие бялдар болон оюун санааных нь хэрэгцээг хангаж, бие биенээ хайрлан, үйлчилж, Бурханы зарлигуудыг дагаж, хаана ч амьдарсан хуулиа хүндэтгэн сахидаг иргэд байхыг зааж сургах нандин үүрэгтэй юм. Эхнэр, нөхөр, эцэг эхчүүд үүргээ хэрхэн биелүүлснээрээ Бурханы өмнө хариуцлага хүлээнэ.

“Гэр бүл Бурханаас заяагддаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэр бүл болох нь Түүний мөнхийн төлөвлөгөөний зайлишгүй нэг хэсэг юм. Хүүхдүүд нь гэр бүлийн дотор төрж, гэрлэлтийн тангаргаа үнэнчээр сахидаг эцэг эхээр өсгүүлэх эрхтэй юм. Их Эзэн Есүс Христийн заасан зүйлд үндэслэн гэр бүл аз жаргалд хүрнэ гэдэгт итгэж болно. Аз жаргалтай гэрлэлт болон гэр бүлүүд нь итгэл, залбирал, наманчлал, өршөөл, хүндэтгэл, хайр энэрэл, өрөвч сэтгэл, ажил хөдөлмөр ба гэр бүлээрээ үр бүтээлтэй ажиллах зарчмуудын дор оршин амьдарна. Тэнгэрийн загвараар эцэг нь өрх гэрээ хайр болон зөв шударга ёсоор тэргүүлэн удирдаж, амьдралын хэрэгцээт зүйлсээр нь хангаж гэр бүлээ хамгаалах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ хайраар өсгөн хүмүүжүүлэх явдал юм. Энэхүү нандин үүргээ биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгш туслах ёстой. Тахир дутуу

## Гэр Бүлийн Залбиral

болов, нас нөгчих болон бусад нөхцөл байдалд хувь хүн зайлшгүй дасан зохицох шаардлага гарч болно. Төрөл төрөгсөд нь хэрэгтэй үед туслан дэмжвэл зохино.

“Ариун явдлын гэрээгээ зөрчин, хань ижил, үр хүүхэдтэйгээ зүй бузаар харьцсан, гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй хувь хүн хожмын нэг өдөр Бурханы өмнө өчиг мэдүүлэх болохыг бид анхааруулж байна. Түүнчлэн гэр бүлээ сарниулбал эрт эдүгээгийн бошиглогчдын зөgnөн хэлснээр хувь хүн, нийгэм, улс үндэстнүүдэд гай гамишиг авчрах болно гэдгийг бид сануулж байна.

“Итгэл хүлээсэн иргэд, төрийн албан хаагч та бүхнийг нийгмийн үндсэн нэгж болох гэр бүлийг бэхжүүлэн авч явах эдгээр арга замыг ямагт хэрэгжүүлэгтүн хэмээн уриалан дуудаж байна” (*Ensign*, 1995 оны Арваннэгдүгээр сар, 102).

Ариун Сүмүүд; Гэр Бүлийн Үдэш; Гэрлэлтийг мөн үз

## Гэр Бүлийн Залбиral (Залбирыг үз)

### Гэр Бүлийн Түүхийн Ажил болон Угийн Бичиг

1836 оны Дөрөвдүгээр сарын 3-нд бошиглогч Елиа Иосеф Смит, Оливэр Каудри хоёр дээр Көртлэндийн Ариун сүмд иржээ. Гэр бүлүүдэд тэр үр удмыг лацдан холбох боломжтой болгохын тулд тэдэнд санваарын лацдан холболтын хүчийг хүртээсэн юм. Энэхүү хүчийг хүртээхдээ тэрээр “эцгүүдийн зүрхийг хүүхдүүд рүү нь, хүүхдүүдийн зүрхийг эцгүүд рүү нь эргүүлэхийн тулд” Их Эзэний өөрийг нь илгээсэн бошиглолыг гүйцэлдүүлсэн юм (С ба Г 110:14–16; Малахи 4:5–6-г үз).

Та гэр бүлийн түүхийн ажлаар дамжуулан энэхүү бошиглолыг үргэлжлүүлэн гүйцэлдүүлэхэд оролцож чадна. Та өвөг дээдсийнхээ тухай ё мэдэж авч, тэднийг

хайрлах хайрыг өсгөн нэмэгдүүлж чадна. Тэдний итгэл хийгээд урам зоригийн түүхүүдээр та сүнслэгээр нөлөөлөгдөж чадна. Та тэрхүү өвийг үр хүүхдүүддээ дамжуулж чадна.

Эдгээр нь гэр бүлийн түүхийн ажлаас ирдэг мөнхийн ашиг тусууд боловч уг гарлын цэдгүүдийг цуглуулахын тулд Сүмийн гаргаж байгаа агуу их хичээл зүтгэлийн гол шалтгаан биш юм. Сүмийн бүхий л гэр бүлийн түүхийг эрэлхийлэгчдийг “эцэг болон хүүхдүүдийн . . . хоорондох гагнаас”-ыг бий болгох хэрэгцээнд чиглүүлдэг (С ба Г 128:18). Энэхүү гагнагч холбоос нь өвөг дээдсийнхээ өмнөөс хүлээн авдаг ариун сүмийн нандин ёслолуудаар дамжуулан санваарын хүчээр бий болдог.

### Нас Барагсдыг Аврах нь

Тэнгэрлэг Эцэгийн олон хүүхдүүд сайн мэдээний бүрэн байдлыг хүлээн авах боломжгүйгээр нас бардаг. Түүний нигүүлсэл хийгээд хэмжээлшгүй их хайранд Их Эзэн тэдэнд сайн мэдээний гэрчлэлийг олж авах болон санваарын авралын ёслолуудыг хүлээн авах замыг бэлтгэсэн юм.

Сайн мэдээ нь Сүнсний дэлхийд сайн мэдээ “үнэний тухай мэдлэггүйгээр, эсвэл бошиглогчдыг эсэргүүцсэний улмаас зөрчилд, нүглүүдээ нас нөхчсон тэдэнд ийнхүү номлогддог байв. Бурханд итгэх итгэл, нүглээс наманчлах, нүглүүдийн ангижралын төлөө төлөөлөн хийх баптиسم, гар тавилтаар Ариун Сүнсний бэлэг хүртээхийг тэдэнд заадаг байлаа, мөн тэд махран бие дэх хүмүүсийн дагуу шүүгдэж, харин Бурханы дагуу сүнсэнд амьдрахад өөрсдийгөө тохирохоор болгохын тулд тэдний хувьд мэдэх шаардлагатай сайн мэдээний бусад бүх зарчмыг болов (С ба Г 138:32–34).

Сүнсний дэлхий дэх олонх нь үүнийг хүлээн авна. Хэдий тийм ч, тэд өөрсдөө санваарын ёслолуудыг хүлээн

## *Гэр Бүлийн Түүхийн Ажил болон Угийн Бичиг*

авч чадахгүй, учир нь тэдэнд бие махбод байхгүй. Бидэнд тэдний өмнөөс ёслолуудыг ариун сүмүүдэд хүлээн авах онцгой эрх байдаг. Эдгээр ёслолуудад баптисм, гишүүний баталгаа, Мелкизедек Санваарын томилолт (эрэгтэйчүүдэд), индаумент, гэрлэлтийн лацдан холболт болон хүүхдүүдийг эцэг эхтэй нь лацдан холбох зэрэг багтдаг. Есцэс Христийн Амилуулалтын дараахан Христийн шашинтай хүмүүст илчлэгдсэн байсан энэхүү ажлыг Их Эзэн Бошиглогч Иосеф Смитэд сэргээн илчилсэн юм (1 Коринт 15:29-ийг үз).

Нас барсан хүмүүсийн өмнөөс тэрхүү ёслолуудыг хүлээн авбал та тэдний хувьд Сион Уулан дээрх аврагч болно (Обадай 1:21-ийг үз). Таны идэвх чармайлтыг Аврагчийн цагаатгах золиослолын сүнктэй адилтгаж болно— тэдний өөрсдөө хүлээн авч чадахгүй авралын ажлыг та гүйцэтгэх болно.

**Гэр Бүлийн Түүхийн Ажил дахь Таны Үүрэг  
Хариуцлагууд:**

Гэр бүлийн түүхийн ажилд та 3 үндсэн үүрэгтэй:

1. Өөртөө ариун сүмийн ёслолуудыг хүлээн авах ба гэр бүлийнхээ ойр дотны гишүүддээ эдгээрийг хүлээн авахад нь туслах
2. Ариун сүмийн хүчин төгөлдөр эрхийн бичигтэй байх мөн боломжтой бол ариун сүмд тогтмол орох.
3. Гэр бүлийн түүхийн мэдээлэл цуглуул, ингэснээр та өвөг дээдстээ ариун сүмийн адислалуудыг хүлээн авахад нь тусалж чадна.

Та хаана амьдардаг, ямар нөхцөл байдалтай байгаагаасаа шалтгаалахгүйгээр ариун сүм болон гэр бүлийн түүхийн ажилд оролцдог байх хэрэгтэй. Та бүгдийг хийж чадахгүй байж болох ч зарим нэг зүйлийг хийж чадна.

Дараах санаанууд нь таныг үүнийг эхлэхэд тань хэрэг болж болох юм:

- Амьдралынхаа чухал явдлуудыг тэмдэглэ. Төрсөн огноо болон газар, баптиسم хүртсэн, гишүүний баталгаа хүлээн авсан огноог тэмдэглэ. Амьдралынхаа чухал, онцгой зүйлсийг, түүнчлэн хүүхдүүд болон хойч үеийнхний тань итгэлийг хүчтэй болгох хувийн тохиолдуудаа тэмдэглэх хувийн тэмдэглэл хөтөл.
- Өвөг дээдсийнхээ талаар сурч мэдэж ав. Ой ухаандаа хадгалагдсан мэдээлэл болон гэртээ байж болох эх сурвалжаас эхлэн тэмдэглэ. Таны тод санаж байгаа, эсвэл ах дүү нар, эцэг эх, авга ах, эгч, эмээ өвөө, буурал аав, ээжээсээ олж болох чухал мэдээллийг тэмдэглэ. Боломжтой бол гэрчилгээний хувь болоод энэ мэдээллийг агуулсан бусад бичиг баримтыг олж ав. Мэдээлэл их цуглуулах тусам та өөр газар, жишээ нь, нийтийн мэдээлэл хадгалах газраас хайхыг хүсч болох юм. Орон нутгийн хэсэг буюу салбарт танд тусалж чадах гэр бүлийн түүхийн зөвлөх байж болно. Мөн Сүмийн албан ёсны гэр бүлийн түүхэнд зориулсан вебсайт [www.familysearch.org](http://www.familysearch.org). руу орж болно.
- Өвөг дээдсээ олж тогтоосон бол олсон мэдээллээ угийн бичиг болон гэр бүлийн бичээсийн маягтад тэмдэглэ. Эдгээр маягтууд нь цаасаар болон Сүмээс гаргасан Өөрийн Өвөг Дээдсийн Файл гэх мэт программ хангамжийн хөтөлбөрөөр ч байгаа.

Сайн мэдээг хүлээн авалгүй нас барсан өвөг дээдсийнхээ тухай шаардлагатай мэдээллийг олж авсан бол тэдний төлөө ариун сүмийн ажил гүйцэтгэгдэхийг батал. Хэрэв та болон танай гэрийнхэн ёслолыг үйлдэх ариун

## Гэр Бүлийн Үдэш

сүмтэй ойролцоо амьдардаггүй бол, ариун сүмд орох өвөг дээдсийнхээ нэрсийг шилжүүлснээр бусад хүмүүс тэдний төлөө үйлдэж болох юм. Та ойролцоо гэр бүлийн түүхийн төв рүү зочлох боломжтой, эсвэл үүнийг хэрхэн хийх талаар орон нутгийнхаа хэсэг буюу салбарын гэр бүлийн түүхийн зөвлөгчидтэй зөвшилцэж болно.

“Нас барагсад хийгээд амьд байгаа хүмүүстэй холбогдсон зарчмуудад хөнгөмсгөөр хандах ёсгүйг би баттайгаар хэлж байна. Учир нь тэдний аврал шаардлагатай бөгөөд бидний авралд зайлшигүй чухал юм . . . бидэнгүйгээр тэд төгс болгогдож чадах нь үгүй—мөн өөрсдийн нас барагсадгүйгээр бид төгс болгогдож чадах нь үгүй” хэмээн Бошиглогч Иосеф Смит тунхаглажээ (С ба Г 128:15). Гэр бүлийн түүхийн ажилд оролцсоноор та болон таны өвөг дээдэс аврал өөд өсч хөгжинө.

Ариун Сүмүүдийг үз.

## Гэр Бүлийн Үдэш

Гэр орон гэдэг бол сайн мэдээг сурхамгийн чухал газар мөн. Энэ нь өөр ямар ч албан байгууллага гэр бүлийг орлож чадахгүй. Хожмын үеийн бошиглогчид эцэг, эхчүүдээс хүүхдүүдээ хайр болон сайн мэдээг зааж өсгөн хүмүүжүүлэхийг дахин давтан хүссээр иржээ.

1915 онд Ерөнхийлөгч Жозеф Ф. Смит Тэргүүн Зөвлөл дэх зөвлөхүүдийнхээ хамт гэр бүлийг бат бөх болгох Сүм даяарх хүчин чармайлтыг эхлүүлсэн билээ. Тэд Сүмийн эцэг эхчүүдийг хүүхдүүдээ долоо хоногт нэг удаа “Гэр Бүлийн Үдэшт” цуглуулахыг хүссэн. Гэр бүлүүд залбирах, хамтдаа дуулах, судраас унших, бие биендээ сайн мэдээг заах, мөн гэр бүлийн эв нэгдлийг бий болгох бусад үйл ажиллагаануудад оролцох цаг гаргадаг байжээ.

1970 онд Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит Даваа гарагийн үдшийг гэр бүлийн үдшийн цаг болгоход

зориулахаар Тэргүүн Зөвлөл дэх зөвлөхүүдийнхээ хамт цугларчээ. Тэрхүү мэдэгдлээс хойш Сүм Даваа гарагийг Сүмийн үйл ажиллагаануудаас чөлөөлж чадсанаар гэр бүлүүд энэхүү цагийг хамтдаа өнгөрүүлж чадах болсон юм.

Хожмын үеийн бошиглогчид Сүмийн гишүүдээс гэр бүлийн үдшийг нэн тэргүүнд тавихыг шаардсаар байна. Энэхүү хөтөлбөрт хичээнгүй хандвал бидний үе дэх гэр бүлүүдийг хилэнцэтээс хамгаалж, бидэнд одоо мөн мөнхөд хэмжээлшгүй их баяр баяслыг авчирна хэмээн амласан.

Сүмийн бүх гишүүд Даваа гарагийн үдшийг ариун үе болгон, гэр бүлийн үдэшт зориулах хэрэгтэй. Хэрэв та гэрлэсэн бол ханьтайгаа хамт долоо хоногийн гэр бүлийн үдшийг хамтдаа өнгөрөө. Хүүхдүүдээ гэр бүлийн үдэшт оролцуул. Хөтөлбөрийг тэдний хэрэгцээ сонирхолд нийцүүлэн зохиож, үүндээ тэднийг татан оролцуул. Хүүхдүүд тань том болж, нүүвэл гэр бүлийн үдшийг ханьтайгаа хамт үргэлжлүүлэн хий.

Хэрэв та ганц бие бол бишоп болон салбарын ерөнхийлөгчөөсөө гэр бүлийн үдшийг танд болон хэсэг мөн салбарынхаа бусад ганц бие гишүүдэд зориулан зохион байгуулахыг хүс. Тэрээр энэхүү хөтөлбөрийг зохион байгуулах үүрэг хариуцлагатай бөгөөд үүнийг тогтмол явуулах гэр бүлийн үдшийн ахлагчийг дуудаж болох юм.

Гэр бүлийн үдшийн санал болгосон загварыг дор үзүүлэв:

- Нээлтийн дуу
- Нээлтийн залбиral
- Судрын уншлага
- Хичээл
- Үйл ажиллагаа

## Гэрийн Багшлалт

- Хаалтын дуу
- Хаалтын залбирал
- Хөнгөн зууш

Гэр бүлийн үдэшт зориулсан хичээл бэлтгэхдээ судрууд, хожмын үеийн бошиглогчдын заасан зүйлс, мөн хувийн туршлага болон гэрчлэл дээр тулгуурлахаа сана. Энэхүү ном нь заахаар сонгох сэдвүүдэд тань тус болж чадна. Түүнчлэн Сүмийн хэвлэлүүд болох *Family Home Evening Resource Book* (31106), Евангелийн Үндсүүд (31110), Гэр Бүлийн Удирдамж (31180) болон Сүмийн сэтгүүлүүдийг үзэж болно.

Гэр Бүлийг мөн үз.

## Гэрийн Багшлалт (Санваарыг үз)

### Гэрлэлт

Өнөөдөр дэлхийд олон хүмүүс гэрлэлт болон гэр бүлийг үл тоомсорлож, мөн шоолж байна. Энэхүү маргаантай хийгээд устгах дуу хоолойнуудын дунд Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга үнэний байнгын дуу хоолойгоор хангаж өгсөн. Тэд “Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлтийг Бурхан заясан бөгөөд гэр бүл нь Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь заяаны төлөөх Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдгийг чин сэтгэлээсээ тунхагласан юм.” (“Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг, энэ номын хуудас 65–68-ыг үз).

Амьдралын хамгийн агуу баяр баясгаланг гэр бүлээс олдог. Баттай гэр бүлийн харилцаанд хүчин чармайлт шаардагдах боловч уг хүчин чармайлт нь энэ амьдралд болон мөнхөд агуу их аз жаргалыг авчирдаг. Өнгөрсөн хугацаанд та хэдийгээр тийм аз жаргалтай гэр бүлтэй байгаагүй ч, та аз жаргалтай, мөнхийн гэрлэлт болон

гэр бүлийн гишүүдтэйгээ хайрын харилцаатай байхыг эрэлхийлж чадна.

### Гэрлэлтийн Шинэ бөгөөд Үүрдийн Гэрээ

Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын төлөвлөгөөнд эрэгтэй, эмэгтэй хүмүүс бие биетэйгээ энэ амьдрал болон үүрд лацдан холбогдож чадна. Ариун сүмд лацдан холбогдож байгаа хүмүүс, хэрэв гэрээнүүддээ үнэнч байх аваас тэдний харилцаа үүрд үргэлжлэх болно. Тэд юу ч, бүр үхэл ч тэднийг салгаж чадахгүй гэдгийг мэддэг.

Мөнхийн гэрлэлтийн гэрээ нь өргөмжлөлд чухал шаардлагатай юм. Иосеф Смитээр дамжуулан Их Эзэн илчлэхдээ: “Сэлэстиэл алдар сууд гурван тэнгэр буюу зэрэглэл буй; хамгийн дээдхийг нь олж авахын тулд хүн санваарын энэхүү ариун жаягт (гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээг хэлж буй) орох ёстой; мөн хэрэв тэрээр үгүй аваас, тэрээр үүнийг олж авч чадах нь үгүй. Тэрээр нөгөөд нь орж болно, гэвч тэр нь түүний хаант улсын төгсгөл болой тэрээр өсөн нэмэгдэж үл чадна” гэжээ (С ба Г 131:1–4).

Хосууд лацдан холбох ёслолыг хүлээн авч, ариун сүмд ариун гэрээнүүдийг хийснийхээ дараа мөнхийн гэрлэлт болон өргөмжлөлийн адислалуудыг хүлээн авахын тулд цаашид итгэлтэй хэвээр байх ёстой. Их Эзэн хэлэхдээ:

“Хэрэв эр хүн миний хууль болох миний үгээр, мөн шинэ бөгөөд үүрдийн гэрээгээр нэг эхнэртэй гэрлэж, мөн энэ нь амлалтын Ариун Сүнсээр энэхүү хүч хийгээд энэхүү санваарын түлхүүрүүдийг миний томилсон, тослогдсон түүгээр тэдэн дээр лацдагдаж, мөн . . . хэрэв тэд миний гэрээг дагах аваас . . . миний үйлчлэгч тэдэн дээр юуг ч тавилаа гэсэн бүх зүйлд энэ нь тэдэнд хийгдэх болно, мөн тэднийг дэлхийгээс гадна байхад бүрэн

## *Гэрлэлт*

хүчтэй хэвээр байх болно” (С ба Г 132:19; Амлалтын Ариун Сүнсний тайлбарыг хуудас 32–34-ийг үз).

### **Гэрлэлтэд Бэлтгэх нь**

Хэрэв та ганц бие бол өөрийгөө гэрлэлтэнд анхааралтай бэлтгэ. Ариун сүмд гэрлэхийг юугаар ч орлуулж болохгүй гэдгийг сана. Зөв цаг үед зөв хүнтэй гэрлэхэд бэлтгэ. Гэрлэхээр найдаж байгаа хүнээ олохын тулд одооноос зохистой амьдар.

Зөвхөн өндөр жишигтэй, мөн хамт байхдаа өөрийнхөө өндөр жишигийг хадгалж болох хүмүүстэй болз. Болзож байгаа хүнтэйгээ хийх зүйлгүй байхгүйн тулд үр өгөөжтэй, бүтээлч үйл ажиллагаануудыг анхааралтай төлөвлө. Өөрийгөө хянаж болох аюулгүй газар бай. Сексийн мэдрэмж төрүүлэх харилцаан яриа болон үйл ажиллагаануудад бүү оролц.

Өөрийнхөө итгэлтэй ижил итгэлтэй хамтрагч эрж ол. Үргэлж хүндэлж, хүндэтгэж байх, амьдралд тань үргэлж дэмжиж байх хэн нэгнийг эрж хай. Гэрлэхээсээ өмнө өөрийнхөө бүх зүрх сэтгэл, хайр, үнэнч байх, итгэлтэй байх хүн олсон гэдэгтээ итгэлтэй байгаагаа баталгаажуул.

### **Гэрлээгүй Хүмүүстэй Зөвлөлд**

Сүмийн зарим гишүүд хэдийгээр гэрлэхийг хүсч байгаа ч өөрсдийнх нь буруугаас биш ч ганц бие хэвээр үлддэг. Хэрэв та ийм нөхцөлд байгаа бол, “Бурханыг хайрладаг тэдний сайн сайхны төлөө бүх юмыг хамтдаа ажиллуулна” гэдгийг сана (Ром 8:28). Хэрэв та зохистой хэвээр байх аваас хэзээ нэгэн өдөр танд энэ амьдралд эсвэл дараачийн амьдралд мөнхийн гэр бүлийн харилцааны бүх адислалууд өгөгдөх болно. Их Эзэн энэ амлалтыг

Өөрийнхөө хожмын үеийн бошиглогчдоор дамжуулан дахин давтан хэлсэн юм.

Хэрэв та ганц бие, гэрлэхийг хүсч байгаа бол найдвараа бүү хөсөрдүүл. Үүнтэй зэрэгцээд өөрийнхөө зорилгод хэт их анхаарал бүү тавь. Үүний оронд, зохицтой сайн сайхан үйл ажиллагаануудад оролц. Гэр бүл болон орон нутагтаа үйлчлэх арга замыг эрэлхийл. Сүмийн дуудлагуудыг хүлээн зөвшөөрч, чандлан биелүүл. Өөрийгөө бие махбод болон сүнслэг байдлын хувьд цэвэр ариун байлга. Хувийн амьдралаа хөгжүүлж, мөн осолт хөгжилт гаргахыг үргэлжлүүлэн суралц.

### Аз Жаргалтай Гэр Бүлтэй Болох нь

Хэрэв та гэрлэсэн бол эхнэр эсвэл нөхөр та хоёрын хоорондох нөхөрлөл болон хайр нь дэлхийн хамгийн аз жаргалтай харилцаа байх ёстай. Таны эхнэр, нөхөр бол бүх зүрх сэтгэлээсээ хайрла хэмээн Их Эзэний зарлигласан цорын ганц хүн байх ёстай. (С ба Г 42:22-ыг үз).

Гэрлэлт нь жинхэнэ утгаараа хамтрагчдын эн тэнцүү байдал, хэн нь ч нэгнийгээ захирахгүй боловч бие биенээ дэмжиж, тайтгаруулж, бие биендээ туслах явдал юм гэдгийг сана.

Гэрлэлт нь амьдралын ийм чухал харилцаа учраас үүнийг үнэлэх хэрэгтэй. Тийм их чухал биш амлалтуудад их ач холбогдол өгөх хэрэггүй. Бие биетэйгээ ярилцах цаг гаргаж, бие биеэ сонс. Ухаалаг мөн хүндэтгэлтэй бай. Хайрын сэтгэгдлээ ойр ойрхон илэрхийл.

Та хоёрын хооронд гэрлэлтийг тань үймүүлэх ямар ч зүйл орох ёсгүйг анхаар. Урган гарах сорилтуудаас үл хамааран гэрлэлтээ амжилттай байлгахыг хичээ.

Бие биедээ үнэнч бай. Бодол санаа, үг яриа, мөн үйлсээрээ гэрлэлтийнхээ гэрээнд үнэнч бай. “Чи эхнэрээ бүх зүрх сэтгэлээрээ хайрлаж, мөн өөр хэнтэй ч биш

## Гэрлэлт

харин түүнтэй нэгдэн нийлэх ёстой” хэмээн Их Эзэн хэлснийг сана (С ба Г 42:22). “Хэн ч биш” гэсэн хэлц нь ямар ч хүн, үйл ажиллагаа, эсвэл албан тушаал эхнэр, нөхөр та хоёрын харилцаанаас илүү дээгүүр тавигдахгүй гэдгийг заадаг.

Итгэлгүй болгох зам руу хөтлөх аливаа зүйлээс зайлсхий. Порнографи, муу уран зөгнөл болон сээтэгнэл зэрэг нь зан чанарыг тань аяндаа устгаж, гэрлэлтийн тань суурийг устгах болно.

Санхүүгээ зохицуулахын тулд хамтран ажилла. Төсөв бий болгож дагаж мөрдөхдөө хамтран ажилла. Үргүй зардал гаргахгүй байхыг сурч, орийн боолчлолд орохоос зайлсхий. Мөнгийг ухаалагаар зохицуулах болон өрөөс ангид байх нь гэр бүлд амар амгаланг авчирдаг.

Амьдралаа Есүс Христийн сайн мэдээнд төвлөрүүл. Бие биедээ хийсэн гэрээгээ сахихад нь тусал. Сүмд болон ариун сүмд хамтдаа яв. Судраас хамтдаа судал. Өглөө, үдэш бүр хамтдаа өвдөг сөгдөн залбирч, бие биенийхээ төлөө Бурханд талархаж, амьдралдаа, гэр орондоо, хайртай нэгнийхээ төлөө, зөв шударга хүсэлдээ түүний адислалуудыг асуу. Тэгвэл Бурхан таны өдөр тутмын Түүнтэй ярих харилцан ярианд Тэрээр өөр ямар ч эх сурвалжаас ирдэггүй амар амгалан болон баяр баяслыг авчрахад удирдах болно. Та хоёрын нөхөрлөл жил ирэх тусам сайхан болох болно; таны хайр хүчтэй болно. Бие биендээ талархах талархал тань өсөх болно.

Нэмэлт судрууд: Эхлэл 1:27–28; 2:18, 21–24; 1 Коринт 11:11; Ефес 5:22–33; Мose 2:27–28; 3:18, 21–24

Ариун Сүмүүд; Ариун Явдал; Гэр бүл; Нэгдмэл байдал; Салалтыг мөн γζ.

## Гэрчлэл

Гэрчлэл нь Ариун Сүнсээр өгөгдсөн сүнслэг гэрч билээ. Гэрчлэлийн үндэс суурь бол Тэнгэрлэг Эцэг амьдардаг мөн бидэнд хайртай; Есүс Христ амьдардаг; Тэр бол Бурханы Хүү, Тэрээр төгсөөшгүй Цагаатгалыг гүйцэтгэсэн; Иосеф Смит сайн мэдээг сэргээхээр дуудагсан Бурханы бошиглогч; бид өнөөдөр амьд бошиглогчоор удирдуулдаг; Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бол дэлхий дээрх үнэний Сүм гэсэн мэдлэг билээ. Энэхүү үндэс суурьтай гэрчлэл сайн мэдээний бүх зарчмуудыг хамруулахаар өсөн нэмэгддэг.

Гэрчлэлийг Олж Аван, Хүчирхэгжүүлэх нь

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүний ёсоор танд гэрчлэлээ олж авах нандин боломж хийгээд үүрэг хариуцлагатай байдаг. Гэрчлэлийг олж авснаар амьдралынхаа туршид тордох үүрэгтэй байдаг. Энэхүү амьдралд болон мөнх оршихуйд таны аз жаргал “Есүсийн тухай гэрчлэлд нэн хүчтэй” байх нь ихэд хамаарна (С ба Г 76:79; мөн шүлэг 51, 74, 101-ийг үз). Та энэхүү үйл явцад ажиллавал дараах зарчмуудыг сана:

*Гэрчлэлийн эрэл зөв шударга, чин сээтгэлийн хүслээс эхэлдэг. Тэнгэрлэг Эцэг таныг зүрхний шударга хүсэл болон Түүний хүслийг биелүүлэх хичээл зүтгэлийн дагуу адислах болно. Сайн мэдээний гэрчлэлгүй бүлэг хүмүүст хандан Алма заахдаа: “Хэрэв та нар миний үгсийг туршин, сэргээх чадвараа сэргээх аваас, мөн итгэлийн жижиг хэсэг ч гэсэн бодит болговол, тийм ээ, бүр та нарт итгэх хүслээс илүү нь байхгүй ч, энэ хүслийг өөрсөддөө хөгжихийг зөвшөөр, бүр та нар миний үгсийн нэгэн хэсгийг өөртөө байрлуулж чадахаар итгэлтэй бөлгөө” (Алма 32:27).*

## Гэрчлэл

Ариун Сүнсний нам гүм нөлөөллөөр дамжуулан гэрчлэл ирдэг. Гэрчлэлийн үр дүн гайхамшигтай, амьдрал өөрчлөгдмөөр байж болох ч, гэрчлэлийн бэлэг ихэвчлэн Бурханы хүчийг онцгойлон үзүүлж харуулахгүйгээр нам гүм лавтай итгэл дээр ирдэг. Тэнгэр элчтэй нүүр тулж уулзаж байсан мөн Бурханыг ширээндээ заларч байсныг харсан Алма ч мацаг барьж, залбирах хэрэгтэй болсон бөгөөд гэрчлэлээ Ариун Сүнсний хүчээр дамжуулан хүлээн авч чадсан (Алма 5:45-46; 36:8, 22-ыг үз).

Чиний гэрчлэл *туршлагуудаар дамжуулан аажимдаа өсөн нэмэгдэнэ*. Хэн ч бүрэн гүйцэд гэрчлэлийг нэг удаа л хүлээн авдаггүй. Туршлагуудаар дамжуулан гэрчлэл өсөж, хүчтэй болно. Хаана ч дуудагдсан ч Сүмдээ үйлчлэх хүслээ үзүүлвээс энэ нь оргөжинө. Зарлигуудыг дагах шийдвэр хийвээс энэ нь өсөж том болно. Бусдийг хүчирхэгжүүлэн, урамшуулваас гэрчлэл чинь өсөн хөгжиж буйг харна. Залбирч, мацаг барьж, судраас судалж, Сүмийн цуглаануудад оролцож, бусдын гэрчлэлээ хуваалцаж байгааг сонсвол, гэрчлэлээ хүчирхэгжүүлэх сүнслэг урмын мөчөөр чи адислагдах болно. Иймэрхүү мөчүүд нь та сайн мэдээгээр амьдрахыг хичээх үед амьдралын туршид ирнэ.

Та гэрчлэлээ хуваалцах бүр гэрчлэл чинь өсөн нэмэгдэх болно. Хуваалцахаасаа өмнө гэрчлэлээ бүрэн хөгжүүлэхээр бүү хүлээ. Гэрчлэлийн хөгжлийн нэг хэсэг хуваалцахад л ирдэг. Үнэндээ гэрчлэлээ бусадтай хуваалцвал эргээд өсөн нэмэгдсэн байхыг та олж харах болно.

## Гэрчлэл хуваалцах нь

Гэр бүлийн гишүүд болон найз нөхдийнхөө хамт мацгийн болон гэрчлэлийн цуглаанд хамт байж, мөн харилцан ярилцахад та гэрчлэлээ хуваалцах санаа төрж болно. Иймэрхүү мөчүүдэд та сэтгэл хөдөлгөм, урт яриа ярих хэрэггүй гэдгийг сана. Аврагч, Түүний заасан зүйлс

болон Сэргээлтийн тухай чин сэтгэлийн итгэлтэйгээр богино байвал гэрчлэл чинь хүчтэй байх болно. Удирдамжийн төлөө залбир, хэрхэн зүрхнийхээ мэдрэмжийг илэрхийлэн гаргахад Сүнс танд туслах болно. Их Эзэн танд өгсөн найдварт болон итгэлд бусдыг хуваалцахад нь тусалвал агуу их баяр хөөрийг та олох болно.

Нэмэлт судрууд: Иохан 7:17; 1 Коринт 2:9–14; Иаков 1:5–6; Моронай 10:3–5; С ба Г 6:22–23; 62:3; 88:81

Ариун Сүнс; Бурхан Эцэг; Есүс Христийн Цагаатгал; Залбирал; Илчлэлт; Мацаг ба Мацгийн Өргөлүүд; Сүнслэг Бэлгүүдийг мөн үз

## Гэрээ

Гэрээ нь Бурхан, хүн буюу бүлэг хүмүүсийн хоорон дахь ариун хэлэлцээр юм. Бурхан тодорхой нөхцлүүдийг тогтоодог бөгөөд тэдгээр байдлуудыг дагавал Тэр биднийг адисална хэмээн амладаг. Бид гэрээнүүдээ сахиагүй бол адислалуудыг хүлээн авч чадахгүй, зарим тохиолдолд бид дуулгаваргүй байсныхаа үр дүнд шийтгэлийг амсдаг.

Санваарын авралын бүх ёслолуудыг гэрээнүүд дагалддаг. Жишээ нь, та баптисм хүртэхдээ гэрээ байгуулдаг бөгөөд ариун ёслолоос хүртэх бүртээ тэрхүү гэрээг шинэчилдэг (Мозая 18:8–10; С ба Г 20:37, 77, 79-ийг үз). Хэрэв та Мелкизедек санваарыг хүлээн авсан бол та санваарын амлалт хийгээд гэрээнд ордог билээ (С ба Г 84:33–34-ийг үз). Ариун сүмийн индаумент болон лацдуулан холбох ёслол нь мөн нандин гэрээнүүдийг агуулдаг.

Их Эзэнтэй хийдэг гэрээнүүдээ үргэлж хүндэтгэж, дурсаж бай. Дараа нь та нар хийх бүх зүйлээ заалгах шаардлагагүй болно (С ба Г 58:26–28-ыг үз). Та нар Ариун Сүнсээр урамшуулагдаж болох ба Христийн удирдан чиглүүлэлт нь таны мөн чанарын нэг хэсэг болно. Их

## Дайн

Эзэний амласан ёсоор та нар “баяр хөөрийг авчирдаг, амьдарлыг авчирдаг тэрхүү нууцууд хийгээд амар амгалангийн зүйлүүдийг мэдэж болохын тулд илчлэлт дээр илчлэлт, мэдлэг дээр мэдлэг хүлээн авах болно” (С ба Г 42:61). Та нарын агуу их найдвэр тэнгэрлэг удирдамжаас ирдэг ариусгалыг талархан таалах ёстой; та нарын агуу айdas эдгээр адислалуудыг алдах болно.

Нэмэлт судруулд: Иеремиа 31:31–34; Мозая 5; Моронай 10:33; С ба Г 82:10; 97:8; 98:13–15

Абрахамын Гэрээ; Ариун Ёслол; Ариун Сүмүүд; Баптист; Гэрлэлт; Ёслолууд; Санваарыг мөн үз.

## Дайн

Хожмын өдрүүдэд “дайнууд хийгээд дайнуудын цуурхал сонсогдох болно, мөн бүхэл дэлхий үймээн самуунд байх болно, мөн хүмүүний зүрх сэтгэл мохон болно” хэмээн Их Эзэн хэлсэн (С ба Г 45:26).

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүдийн хувьд бид амар амгалангийн хүмүүс билээ. Бид амар амгалангийн Ханхүү Аврагчийг дагадаг. Дайн төгсөж, амар амгалан газар дэлхийд сэргээгдэх Түүний мянган жилийн хаанчлалыг бид тэсэн ядан хүлээдэг (Исаиа 2:4-ийг үз). Хэдийгээр энэ дэлхийд засгийн газрын удирдагчид заримдаа дайн тулалдаанд өөрийн улс үндэстнийг болон эрхэм зорилгоо хамгаалахаар цэргийн анги нэгтгэлээ илгээдэг гэдгийг бид мэднэ.

Цэрэгт Хожмын Үеийн Гэгээнтнүүд өөрийн улс орон болон Бурханыхаа хооронд хагарал гарна хэмээн бодох хэрэггүй. Сүмд “Хаад, ерөнхийлөгчид, мөн шүүгчдэд захирагдаж, хуулийг дуулгавартай дагаж, хүндлэн дээдэлж, мөн дэмжих ёстой гэдэгт бид итгэдэг” (Итгэлийн Тунхаг 1:12). Цэрэгт алба хааснаар энэхүү зарчимд бүхнээ зориулж байгаагаа харуулдаг.

Хэрэв Хожмын Үеийн Гэгээнтнүүд тулаанд явахаар дуудагдвал, тэд Мормоны Номын цэргийн агуу удирдагч Ахмад Моронайгийн жишээг дагаж чадна. Хэдийгээр тэр агуу дайчин байсан боловч, “цус урсалтанд баясдаггүй” (Алма 48:11). Тэрээр “Христийн итгэлд гүйвшгүй хүн байсан бөгөөд тулалдах гол шалтгаан нь ард түмнээ, эрхүүдээ, мөн төрөлх орноо, мөн шашин шүтлэгээ өмгөөлөхийн тулд байсан” билээ (Алма 48:13). Хэрэв Хожмын Үеийн Гэгээнтнүүд дайнд явах ёстай бол, тэд үнэн ба зөв шударгын сүнсүйгээр сайнныг үйлдэх хүсэлтэйгээр явах ёстай. Тэд Бурханы хүүхдүүдийг мөн эсрэг талынхаа хүмүүсийг ч гэсэн зүрх сэтгэлдээ хайрлах ёстай. Тэгвэл, хэрэв цус асгаруулахаар бол тэдний энэхүү үйлдлийг нүгэлд тооцохгүй.

Амар Амгалан; Иргэний Засаглал болон Хуулийг мөн үз.

**Дал** (Сүмийн Захиргааг γζ)

**Далын Чуулга** (Сүмийн Захиргааг γζ)

## Даруу Байдал

Даруу байх нь танд Түүний дэмжлэг байнга хэрэгтэй байдгийг ойлгох—Их Эзэнд хамааралтай байдгаа баяртайгаар мэдэгдэхэд оршдог юм. Даруу байдал гэдэг нь Өөрийнхөө авьяас билэг хийгээд ур чадварыг Бурханаас ирсэн бэлэг гэж ойлгож ухаарах явдал юм. Энэ бол сул дорой, зүрх зориггүй, эсвэл аймхай байгаагийн шинж тэмдэг биш; энэ бол та үнэн хүч чадлаа хаана оршдогийг мэддэгийн илрэл юм. Та даруу, зоригтой байж чадна. Та даруу, хичээл зүтгэлээр дүүрэн байж чадна.

Есүс Христ даруу байдлын агуу жишээ юм. Тэр зуурдын байдлын тохинууллынхаа үед Өөрийнх нь хүч чадал Тэрээр Эцэгээсээ хамааралтай байдаг учраас ирсэн

## **Дахин Төрөх нь**

гэдгийг үргэлж ухаарч ойлгож байсан. Тэрээр “Би өөрийн санаагаар юуг ч үйлдэж чадахгүй. Учир нь би өөрийн хүслийг бус, харин Намайг Илгээгчийн хүслийг хайдаг” гэж хэлжээ (Иохан 5:30).

Хэрэв та Их Эзэний өмнө даруу байваас Тэрээр чамайг хүчирхэгжүүлэх болно. “Бурхан бардам хүнийг эсэргүүцдэг, харин даруу хүнд нигүүлсэл хайрладаг . . . Эзэний оршихуйд өөрсдийгөө даруу болго” хэмээн Иаков заажээ (Иаков 4:6, 10).

Нэмэлт судрууд: Матай 18:4; 23:12; 26:39; Лук 22:42; 1 Петр 5:5–6; Мозая 4:11–12; 15:6–7; Алма 5:27–28; Хиламан 3:33–35; Ифэр 12:27; С ба Г 12:8; 67:10; 112:10; 136:32–33.

## **Дахин Төрөх нь** (Аврал; Баптисм; Хөрвүүлгийг үз)

### **Диваажин**

Судруудад диваажин хэмээх үгийг өөр, өөр байдлаар хэрэглэдэг. Нэгдүгээрт, зуурдын амьдралын дараах сүнсний дэлхийд аз жаргал хийгээд амар амгалангийн газрыг заадаг. Энэ нь баптисм хүртэж, итгэлтэй хэвээр үлдсэн хүмүүст зориулагдсан юм. (Алма 40:12; Моронай 10:34-ийг үз). Сүнсний шорон дахь тэдэнд Есүс христийн сайн мэдээг заах боломжтой, мөн өөрсдийн нүглийг наманчилж, ариун сүмд бидний хийдэг ажлаар дамжуулан баптисм болон гишүүний баталгааг хүлээн авдаг (С ба Г 138:30–35-ыг үз). Тэд үүнийг хийвэл диваажинд орж болох юм.

Диваажин хэмээх үгийн хоёр дахь хэрэглээг Аврагчийн Цовдлолтын талаар Лукийн шастирт өгүүлдэг. Есүсийг загалмай дээр байхад нэгэн хулгайч цовдлуулж байхдаа, “Есүс ээ, Та Өөрийнхөө хaanчлалд ирэхдээ намайг санаарай” гэжээ (Лук 23:42). Лук 23:43-т Их Эзэн, “Үнэнээр би чамд хэлье, өнөөдөр чи Надтай

Диваажинд байх болно” хэмээн хариулсан байдаг. Бошиглогч Иосеф Смит энэ нь буруу орчуулга бөгөөд: Их Эзэн үнэндээ тэрхүү хулгайчийг Түүнтэй хамт сүнсний дэлхийд байх болно хэмээн хэлсэн гэж тайлбарласан юм.

Диваажин хэмээх үг нь 2 Коринт 12:4-т байдаг. Энд сэлэстиэл хаант улсыг заадаг. Итгэлийн Тунхагийн гурват диваажингийн гэсэн үг нь Мянган Жил дэх дэлхий өртөнцийн алдар сууг дүрсэлдэг.

Авралын Төлөвлөгөө; Амилуулалт; Биеийн Ухлийг мөн γз.

**Дикон** (Аароны Санваар; Санваарыг γз)

**Донтолт** (Мөрийтэй Тоглох; Мэргэн Ухааны Үг;Pornографийг γз)

## Дуулгавартай Байдал

Зуурдын амьдралын өмнөх байдалд Тэнгэрлэг Эцэг Тэнгэрт агуу Зөвлөлийг хуралдуулсан юм. Тэнд бид газар дэлхий дээрх туршилтын цаг хугацааг багтаасан Түүний авралын төлөвлөгөөг сурсан юм: “Дээр нь тэд оршин сууж болох дэлхийг бид хийх болно; мөн Их Эзэн, тэдний Бурхан тэдэнд зарлигах бүх зүйл юуг ч гэсэн тэд хийх нь үү гэдгийг харахын тулд үүгээр бид тэднийг нотлох болно” (Абрахам 3:24–25). Газар дэлхий дээр байгаа нэг шалтгаан бол та Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудыг дагах хүслээ харуулахад оршино.

Зарлигууд нь эрх чөлөө, хувийн өсөлтийг хязгаарладаг тул төвөгтэй хэмээн ихэнх хүмүүс боддог. Гэвч Аврагч жинхэнэ эрх чөлөө нь зөвхөн Түүнийг дагаснаар ирдэг гэдгийг заасан: “Хэрэв та нар миний үгэн дотор байвал, үнэхээр Миний дагалдагчид байна. Тэгээд та нар үнэнийг ойлгож, үнэн та нарыг чөлөөлнө” (Иохан 8:31–32). Бурхан та нарын тусын тулд зарлигуудыг өгсөн юм. Тэдгээр нь та нарын аз жаргал болон бие махбодь,

## *Ерөнхий Эрх Мэдэлтнүүд*

сүнсний эрүүл байдалд зориулагдсан хайр халамж бүхий зааварчилгаа билээ.

Бошиглогч Иосеф Смит зарлигуудад дуулгавартай байх нь Бурханаас ирэх адислалуудыг хүлээн авах зам руу хөтөлдгийг заасан. Тэрээр хэлэхдээ: “Энэ дэлхийн сууринаас өмнө дээр нь бүх адислал тулгуурлагдсан хууль тэнгэрт эргэлт буцалтгүйгээр тогтоогдсон болой—мөн бид ямар ч адислалыг Бурханаас авлаа гэхэд, энэ нь тулгуурлагдсан тэрхүү хуульд дуулгавартай байснаар буюу” гэжээ (С ба Г 130:20–21). Хаан Бенжамин энэхүү зарчмыг заасан.“Та нарыг Бурханы зарлигуудыг дагадаг тэдний ивээгдсэн мөн баярт байдлыг тунхаглаасай хэмээн би хүсдэг” хэмээн тэрээр зөвлөсөн. “Учир нь болгоогтун, тэд бүх зүйлүүдэд, биеийн мөн сүнсний аль алинд нь ивээгдсэн; мөн хэрэв тэд төгсгөл хүртэл итгэлтэйгээр тэсвэл, тэгснээр тэд Бурхантай хэзээ ч төгсөшгүй аз жаргалын байдалд оршиж болохын тулд тэнгэрт хүлээн авагдах болой. Ай санагтун, эдгээр зүйлүүд үнэн гэдгийг санагтун; учир нь Их Эзэн Бурхан үүнийг ярьсан ажгуу” (Мозая 2:41).

Зарлигуудад бид дуулгавартай байх нь Тэнгэрлэг Эцэг хийгээд Есүс Христэд өгөх бидний хайр билээ. Аврагч “Хэрэв та нар намайг хайлрадаг бол, миний зарлигуудыг сахь” хэмээн хэлсэн (Иохан 14:15). Хожим нь Тэрээр “Би Эцэгийнхээ зарлигуудыг сахиж, түүний хайр дотор байдгийн адил, та нар миний зарлигуудыг сахвалил Миний хайр дотор байх болно” хэмээн тунхагласан юм (Иохан 15:10).

Нэмэлт судрууд: Иошуа 24:14–15; Номлогчийн үгс 12:13; Матай 7:21; Иохан 7:17; 1 Нираф 3:7; С ба Г 58:21–22; 82:8–10

Авралын Төлөвлөгөө; Сонголтыг мөн үз.

**Ерөнхий Эрх Мэдэлтнүүд** (Сүмийн Захиргааг үз)

## Есүс Христ

2000 оны Нэгдүгээр сарын 1-нд Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчид дараах тунхаглалыг гаргасан юм. “Амьд Христ” гэсэн гарчигтай энэхүү тунхаглал Их Эзэн Есүс Христийг гэрчилж, Түүний онцлог болон тэнгэрлэг үүргийг хураангуйлсан байдаг:

“Есүс Христ хоёр мянган жилийн өмнө мэндэлснийг дурсан хүндэтгэхдээ бил Түүний зүйрлэшгүй амьдрал болон агуу их цагаатгах золиослолын хэмжээлшгүй ач тусын бодит үнэнийг гэрчилдэг. Дэлхий дээр амьдарч байсан ба амьдрах бүх хүмүүст ийм хүчтэй нөлөө хэн ч үзүүлж байгаагүй.

“Тэр бол Хуучин Гэрээний Агуу Иехова, Шинэ Гэрээний Мессия билээ. Тэр бол Эцэгийнхээ удирдлаган дор дэлхийг бүтээсэн Бүтээгч ‘Бүх зүйл Түүгээр бий болсон, Түүнгүйгээр бий болсон юмс нэг ч үгүй’ (Иохан 1:3). Нүгэлгүй ч Тэрээр бүх зөв шударга ёсыг гүйцэлдүүлэхээр баптиسم хүртсэн юм. Түүнийг ‘явлж сайнныг үйлдсэнийих нь төлөө’ (Үйлс 10:38) үзэн ядаж байсан. Түүний сайн мэдээ бол амар амгалан хийгээд сайн санааны захиас юм. Тэр чин сэтгэлэсээ бүх хүнийг өөрийнх нь жишээг дагахыг хүссэн билээ. Тэрээр Палестины замаар явж, өвчтэй нэгнийг анагааж, сохор нэгнийг хараатай болгож, үхсэн нэгнийг амилуулж байв. Тэрээр мөнх байдал, мөнх байдлын өмнөх оршилын бодит үнэнийг, дэлхий дээрх бидний амьдралын зорилго болон ирэх амьдрал дахь Бурханы охид хөвгүүдэд өгөх боломжийн тухай заасан.

“Тэрээр Түүний агуу их цагаатгах золиослолыг сануулахаар ариун ёслолыг тогтоосон. Түүнийг баривчилж гүтгэлгээр яллаж цугларагсдын бахыг ханган шийтгэж Түүнд Калварын загалмай дээр үхэх ял оноосон юм. Тэрээр бүх л хүн төрөлхтний нүглийг цагаатгахын төлөө

амиа өгсөн юм. Энэ бол хэзээд дэлхий дээр амьдрах бүх хүнд зориулсан Түүний бэлэг билээ.

“Бүх хүн төрөлхтний түүхийн төв болж Бетlehemд төрөхөөсөө өмнө ч, мөн Калвараас хойш ч, амьдарч буй Түүний амьдралыг бид чин сэтгэлээсээ гэрчилж байна. Тэр бол Эцэгийн Ууган, махбодтой Төрсөн Ганц Хүү, дэлхийн Гэтэлгэгч юм.

“Тэрээр ‘нойрсогсдоос эхний үр жимс’ болохын тулд үхэгсдээс амилсан юм (1 Коринт 15:20). Амилсан Их Эзэний хувьд Тэрээр амьдралдаа хайлаж байсан хүмүүс дээрээ ирсэн. Тэрээр бас эртний Америкт буй ‘бусад хониндоо’ (Иохан 10:16) үйлчилсэн билээ. Орчин үед эртнээс амласан ‘цаг хугацааны бүрэн байдлын эрин үеийг’ (Ефес 1:10) эхлүүлэхээр Тэрээр Эцэгийнхээ хамт Иосеф Смит хүүгийн өмнө гарч ирсэн.

“Амьд Христийн тухай Бошиглогч Иосеф бичихдээ, Түүний мэлмий галын дөл лугаа адил байв; тэргүүнийх нь үс цэвэрхэн цас мэт цав цагаан байв; түүний төрх байдал нарны гэрлээс ч илүү хурцаар гялалзаж байлаа; Түүний хоолой агуу их усны хүнгэнэн урсах чимээ мэт Иеховагийн хоолойгоор хэлрүүн:

“‘Бибээр эхнийх мөн эцсийнх болой; Бибээр амьдардаг тэрээр болой, би бол алагдсан тэрээр бөлгөө; бибээр Эцэгийн өмнө та нарын өмгөөлөгч билээ’ (С ба Г 110:3–4)

“Түүний талаар Бошиглогч цааш тунхаглахдаа: ‘Мөн эдүгээ, түүний талаар өгөгдсөн олон гэрчлэлийн дараа, энэ бол түүний талаар бидний өгөх, хамгийн сүүлчийн гэрчлэл бөлгөө: Тэр амьд бөлгөө!

“‘Учир нь бид түүнийг бүр Бурханы баруун гар талд харсан билээ; түүнчлэн тэрээр Эцэгийн Төрсөн Ганц болой хэмээн гэрчлэх дуу хоолойг бид сонссон билээ—

“‘Ийнхүү түүгээр, мөн түүгээр дамжин, мөн түүнээс, дэлхийнүүд бүтээгдсэн мөн бүтээгддэг ажгуу, мөн

тэдгээрийн оршин суугчид нь Бурханы төрсон хөвгүүд хийгээд охид нь болгөө' (С ба Г 76:22–24).

"Есүс Христ өөрийн биеэр тулгуур чулуу нь болж, төлөөлөгч, бошиглогчдын . . . суурин дээр барьсан Сүм болон санваар нь дэлхий дээр сэргээгдсэн гэдгийг бид чин сэтгэлийнхээ үгээр мэдэгдэж байна" (Ефес 2:20).

"Хэзээ нэгэн цагт Тэрээр дэлхий дээр буцан ирэх болно гэдгийг бид гэрчилж байна. 'Мөн Их Эзэний алдар суу илэрхийлэгдэх болно, мөн бүх маханбодь хамтдаа Түүнийг үзнэ' (Исаиа 40:5). Тэрээр Хаадын Хааны хувьд удирдаж, Эздийн Эзний хувьд хаанчлах болно. Тэгээд Түүнийг шүтэн "өвдөг бүхэн сөгдөж хэл бүхнээр ярих болно" Хүн бүр Түүний өмнө хийсэн ажил хэрэг, зүрх сэтгэлдээ агуулсан хүслийнхээ дагуу шүүгдэх болно."

"Бид, Түүний томилсон Төлөөлөгчдийнх нь хувьд Есүс бол Амьд Христ, Бурханы үхэшгүй Хүү хэмээн гэрчилж байна. Тэр бол өнөөдөр Эцэгийнхээ баруун гар талд зогсох агуу Иммануэл Хaan. Тэр бол дэлхийн гэрэл, амьдрал ба итгэл найдвар. Түүний зам бол энэ амьдралд аз жаргал уруу хөтлөх зам бөгөөд ирэх дэлхийд мөнхийн амьдрал уруу хөтлөх жим юм. Тэнгэрлэг Хүүгийнх нь зүйрлэшгүй бэлгийнх нь төлөө Бурхандаа талархъя" (*Ensign*, 2000 Дөрөвдүгээр сар, 2–3).

Есүс Христийн Цагаатгалыг мөн үз.

## Есүс Христийн Хоёр дахь Ирэлт

Есүс Христ Өөрийн зуурдын байдлын тохинууллаа дуусгаад тэнгэрт дээш гарахад хоёр тэнгэр элч Түүний Төлөөлөгчдөд тунхаглахдаа, "Та нараас өргөгдөн тэнгэрт аваачигдсан энэ Есүс нь та нарын Түүний тэнгэр өөд явсныг нь харсан лугаа адил тийн бууж ирнэ" гэжээ (Үйлс 1:11). Аврагч дахин ирэхэд Тэр газар дэлхийг Өөрийн хаант улс болгоохор хүч хийгээд алдар суундаа

ирэх болно. Түүний Хоёр дахь Ирэлт Мянган Жилийн эхлэлийг тавина.

Хоёр дахь Ирэлт ёс бусчуудын хувьд айдас төрүүлэм, гашуудлын цаг байх боловч, зөв шударга хүмүүст амар амгалан мөн ялгуусан баярын өдөр байх болно. Их Эзэн тунхаглахдаа:

“Мэргэн хийгээд үнэнийг хүлээн авсан, мөн Ариун Сүнсийг зам заагчаа болгон авсан, мөн мэхлэгдээгүй тэд—үнэнээр би та нарт хэлнэ, тэд тас цавчигдан мөн галд хаягдахгүй, харин тэр өдрийг тэсэн гарах болно.

“Мөн дэлхий тэдэнд өв болон өгөгдөх болно; мөн тэд өсөн үржиж мөн хүчтэй болох болно, мөн тэдний үр хүүхдүүд нүгэлгүйгээр авралд өсөн өндийх болно.

“Учир нь Их Эзэн тэдний дунд байх болно, мөн түүний алдар суу тэдний дээр байх болно, мөн тэрбээр тэдний хаан хийгээд тэдний хууль тогтоогч байх болно” (С ба Г 45:57-59).

Их Эзэн Өөрийгөө яг хэдийд дахин ирэхээ илчлээгүй: “Тэрхүү цаг хийгээд өдрийг мэдэх хүмүүн үгүй, тэрчлэн тэнгэрт буй тэнгэр элчүүд ч үгүй бөгөөд, тэд түүнийг иртэл мэдэх нь үгүй” (С ба Г 49:7). Гэвч Тэр Төлөөлөгчиддөө өөрийн Хоёр дахь Ирэлтийн өмнөх үйл явдал, тэмдгийг илчилсэн. Бодшиглогдсон үйл явдал болон тэмдгүүд дотор:

- Сайн мэдээний үнэнээс уравсан урвалт (Матай 24:9-12; 2 Тесалоник 2:1-3-ыг үз).
- Есүс Христийн Сүмийн сэргээлт болон сайн мэдээний сэргээлт (Үйлс 3:19-21; Илчлэлт 14:6-7; С ба Г 45:28; 133:36-г үз).
- Санваарын түлхүүрүүдийн сэргээлт (Малахи 4:5-6; С ба Г 110:11-16-г үз).

- Мормоны Номыг урагш авчирсан нь (Исаиа 29:4–18; 3 Нифай 21:1–11-ийг үз).
- Дэлхий дахинаа сайн мэдээг номлох нь (Матай 24:14-ийг үз).
- Ёс бусчууд, дайн болон эмх замбараагүйдэл (Матай 24:6-7; 2 Тимот 3:1-7; С ба Г 29:17; 45:26–33; 88:91-ийг үз).
- Газар дэлхий хийгээд тэнгэр дэх тэмдгүүд (Иоел 2:30–31; Матай 24:29–30; С ба Г 29:14–16; 45:39–42; 49:23; 88:87–90-ийг үз).

Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн нарийн тодорхой цагийг бодож өөрийнхөө санааг бүү зовоо. Оронд нь Түүнийг ирэхэд бэлтгэлтэй байхаар амьдар. Сүүлчийн өдрүүдэд та эдгээр аюул гамшгийг ажиглавал шударга хүмүүст Хоёр дахь Ирэлтээс буюу үүний өмнө үзэгдэх тэмдгүүдээс айх хэрэггүй гэдгийг сана. Аврагчийн Төлөөлөгчдөө хэлсэн үгс танд хамаатай: “Бүү тэвдэн сандар, учир нь, мөн эдгээр бүх зүйл тохиоход та нарт өгөгдсөн тэрхүү амлалтууд биелэгдэх болно гэдгийг та нар мэдэж болох ажгуу” (С ба Г 45:35).

Нэмэлт судрууд: Лук 21:34–36; 2 Петр 3:10–14; С ба Г 133:42–52; Иосеф Смит—Матай

Авралын Төлөвлөгөө; Мянган Жил; Тэмдгүүдийг мөн үз.

## Есүс Христийн Цагаатгал

Цагаатгах гэдэг үг нь эвлэрүүлэх буюу нийцэл зохицлыг сэргээх гэсэн утгатай. Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан Бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ эвлэрч чадна (Ром 5:10–11; 2 Нифай 25:23; Иаков 4:11-ийг үз). Бид Түүний оршихуйд “Есүсээр дамжуулан төгс болгогдон” мөнхөд оршиж чадна (С ба Г 76:62, 69-ийг үз).

Есүс Христ “[Өөрийн] хүмүүсийг гэтэлгэхээр дэлхийн үүслээс бэлтгэгдсэн нь би болой” гэжээ (Ифэр 3:14). Тэнгэрлэг Эцэг зуурдын байдлын өмнөх сүнсний дэлхийд хэмжээлшгүй хийгээд мөнхийн Цагаатгалыг шаардсан авралын мөнхийн төлөвлөгөөг танилцуулсан. Зуурдын байдлын өмнөх сүнсний дэлхийд Есүс, тэр үеийнхээр Иехова, даруухнаар тэр төлөвлөгөөг биелүүлэн Эцэгийн хүслийг хийнэ хэмээн мэдэгджээ (Мосе 4:2-ыг үз). Тийнхүү Тэрээр дэлхийд ирэх, бидний гэм нүглийн төлөөх шийтгэлд шаналах, загалмай дээр үхэх хийгээд амилуулагдах—Цагаатгалыг биелүүлэхээр урьдчилан томилогдсон. Тэр “ертонцийн сууриас алагдсан Хонь” болсон юм (Илчлэлт 13:8; 1 Петр 1:19–20; Мose 7:47-г үз).

Цагаатгал нь Тэнгэрлэг Эцэгийн бидэнд өгсөн хайрын гүн илрэл билээ (Иохан 3:16-г үз). Мөн энэ нь Аврагчийн Эцэгийг болоод биднийг хайрлах хайрын агуу илэрхийлэл юм (Иохан 14:28–31; 15:9–13; 1 Иохан 3:16; С ба Г 34:3; 138:1–4-ийг үз).

### Цагаатгал дахь Бидний Хэрэгцээ

Бүх хүмүүс Адам Евагийн үр удам ёсоор Уналтын үр нөлөөг өвлөдөг. Бид бүгдээрээ Бурханы оршихуйгаас салан тусгаарлагдаж, сүнсний үхлийг туулдаг бөгөөд бид бүгдээрээ бие махбодын үхэл болох зуурдын үхэлд хамааралтай юм (Алма 42:6–9; С ба Г 29:41–42-ыг үз).

Бидний уналтын байдалд бид эсрэг тэсрэг байдал болоод уруу таталтад хамааралтай. Бид уруу татагдахдаа Бурханаас өөрсдийгөө холдуулж, Түүний алдар сууг олж авах байдлаа алддаг (Ром 3:23-ыг үз).

Мөнхийн шүүлт Уналтын үр нөлөөллүүд үлдэж, мөн бид өөрсдийнхөө хийсэн буруу зүйлд шийтгүүлэхийг шаарддаг. Цагаатгал хийгдээгүй байсан бол сүнсний болон зуурдын үхэл нь Бурхан болон бидний

хооронд гаталж боломгүй саадыг тавих байсан. Учир нь билд өөрсдийгөө Уналт, эсвэл нүглээс аварч чадахгүй, “цэвэр ариун бус зүйл тэнд оршиж чадах нь үгүй” тул билд Тэнгэрлэг Эцэгээс үүрд салгагдах байсан (Мосе 6:57).

Цорын ганц аврагдах зам нь хэн нэгэн нь билднийг аврах явдал байлаа. Бидэнд Уналтын ачааг тааварлах, билдний нүгэл гэмийн төлөөсийг төлөх, билдний оронд зогсон шүүлтийн шаардлагыг хангаж чадах хэн нэгэн хүн хэрэгтэй. Есүс Христ үргэлж ийм золиослолыг хийх цорын ганц чадвартай нэг нь байсаар ирсэн.

### Есүс Христ, Бидний Цорын Ганц Найдвар

Ертөнцийн үүслээс өмнө Аврагч билдний “энэ дэлхийд амар амгалан хийгээд ирэх дэлхийд мөнх амьдралыг хүлээн авах” цорын ганц найдвар байлаа (С ба Г 59:23).

Өөрийн амийг буцааж авахын тулд амиа өгөх хүч зөвхөн Түүнд л байсан. Тэр өөрийн зуурдын эх Маригаас үхэх чадварыг өвлөсөн. Тэр өөрийн үхэшгүй Эцэгээс үхлийг даван туулах хүчийг өвлөсөн. Тэрээр “Учир нь Эцэгт Өөрт нь амь байдгийн адил, Хүүд Өөрт нь амь байлгахыг Тэр Хүүдээ соёрхжээ” гэж тунхаглажээ (Иохан 5:26).

Зөвхөн Тэр л билднийг нүглээс гэтэлгэж чадна. Бурхан Эцэг Түүнд энэхүү хүчийг өгсөн юм (Хиламан 5:11-ийг үз). Аврагч энэхүү хүчийг хүлээн авах хийгээд Цагаатгалыг биелүүлэх чадвартай байсны учир нь Тэрээр Өөрийгөө нүглээс ангижруулсан явдал юм. “Тэрээр уруу таталтуудад орсон хэдий ч тэдгээрт анхаарал тавьсан нь үгүй” (С ба Г 20:22). Тэр төгс төгөлдөр, нүгэлгүй амьдралаар амьдарснаар шүүлтийн шаардлагаас чөлөөлөгдсөн юм. Түүнд гэтэлгэлийн хүч байсан мөн Түүнд шүүлтийн өр үгүй байсан тул Тэрээр наманчилсан тэдний өрийг төлж чадсан юм. Тэрээр:

“Эцэг минь нүгэл үйлдээгүй, таны таалалд нийцсэн түүний зовлон хийгээд үхлийг болгоогтун; мөн Хүүгийнхээ асгарсан цусыг; мөн та өөрөө алдаршсан байхын тулд таны өгсөн, бас түүний цусыг болгоогтун;”

“Иймийн тул, Эцэг минь, тэд надад ирж бас мөнх амьдралыг авч болохын тулд миний нэрэнд итгэх эдгээр ах дүүсийг минь өршөөгөөч” гэж хэлж чадна (С ба Г 45:4–5).

Үнэхээр, “хүмүүний үрсэд аврал ирж чадах тэр нэгээхэн ч өөр нэр өгөгдөхгүй, зөвхөн Төгс Хүчит Их Эзэн Христийн нэрээр мөн нэр дээр билээ” (Мозая 3:17).

### Цагаатгах Золиослол

Есүсийн цагаатгах золиослол нь Гетсеманий цэцэрлэгт, Калварын загалмай дээр болсон юм. Гетсеманид Аавынхаа хүсэлд захирагдсан ба бүх хүмүүсийн нүглийг Өөр дээрээ авч эхэлсэн. Бидний нүглүүдийн төлөө төлөөсийг төлөх үедээ Өөрийнхөө туулж өнгөрүүлсэн зүйлсийн заримыг Тэрээр илчилсэн:

“Хэрэв тэд наманчлах аваас тэд зовохгүй байж болохын тулд Бурхан, бибээр бүхний төлөө эдгээр зүйлүүдийг амссан билээ;

“Хэрэв тэд үл наманчлах аваас тэд бүр миний адилгаар зовох ёстой;

“Бүр бүхнээс хамгийн агуу Бурхан намайг өвдөхийн улмаас дагжин чичрэх, мөн сүв бүрээс цус шүүррэх, мөн бие хийгээд сүнс аль алиныг нь зовоход хүргэсэн тэрхүү зовлон нь—мөн намайг тэрхүү гашуун аяганаас уухгүй, мөн айснаас эргэн буцахад хүргэж болохоор байсан билээ—

“Гэсэн хэдий ч алдар суу нь Эцэгт байх болтугай, мөн би бээр хүртэж, мөн хүмүүний үрсийн төлөө өөрийн бэлтгэлүүдийг дуусгасан билээ” (С ба Г 19:16–19; мөн Лук 22:44; Мозая 3:7-г үз).

Тэрээр Өөрийгөө цовдлуулахаар—“дэлхийн нүглүүдийн төлөө загалмайд өргөгдөн мөн алагдсаныг” бодоход Аврагч бидний нүглүүдийн төлөө үргэлжлүүлэн шаналж зовсон (1 Нифай 11:33).

Тэр өөрийгөө загалмай дээр хөнөөлгөхийг хүлээн зөвшөөрсөн. Түүний биеийг Түүнийг амилуулагдах мөн “нойсогсдоос хамгийн анхны үр жимс” болох хүртэл агуйд тавьсан байв (1 Коринт 15:20). Түүний үхэл болон амилуулалтаар дамжуулан Тэр бид бүгдийн төлөө бие махбодын үхлийг даван туулсан. Тэрээр хожим хэлэхдээ:

“Бидний дэлхийд Эцэгийнхээ тааллыг гүйцэхээр ирсэн, Эцэг минь намайг илгээсний учир буюу” гэжээ.

“Мөн би загалмай дээр өргөгдөж болохын тулд, би загалмай дээр өргөгдсөний дараа, би бүх хүмүүнийг өөртөө татаж болохын тул, би хүмүүнээр өргөгдсөний адилаар хүмүүн нь миний өмнө зогсож, өөрсдийн үйлүүдээр тэдгээр нь сайн, эсвэл хилэнцэт байх эсэхээр нь шүүгдэхээр Эцэгээр өргөгдхийн тул Эцэг минь намайг илгээсэн—

“Мөн энэ шалтгааны учир би өргөгдөв; тиймийн тул тэд өөрсдийн үйлүүдийн дагуу шүүгдэж болохын тулд Эцэгийн хүчний дагуу би бүх хүмүүнийг өөртөө татах болно.

“Мөнхүү улиран тохиох дор, наманчлах, мөн миний нэрэнд баптисм хүртэх хэн боловч дүүргэгдэх болно; мөн хэрэв тэр эцсээ хүртэл тэвчих аваас болгоогтун, би дэлхийг шүүхээр зогсох тэр өдөр Эцэгийнхээ өмнө би түүний гэмгүйг үнэлнэ” (3 Нифай 27:13–16).

### Уналтаас Гэтэлгэх Бүх Дэлхийн Гэтэлгэл

Есүс Христ Цагаатгалаар дамжуулан бүх хүмүүсийг Уналтын үр нөлөөнөөс гэтэлгэдэг. Дэлхий дээр амьдарч байсан болон амьдрах бүх хүмүүс амилуулагдах ба шүүгдэхээр Бурханы мэлмийд авчрагдана (2 Нифай 2:5–10;

## Есүс Христийн Цагаатгал

Хиламан 14:15–17-г үз). Бид Аврагчийн нигүүлслийн бэлэг хийгээд гэтэлгэлийн алдар суугаар дамжуулан үхэшгүй мөнхийн бэлгийг хүлээн авах ба сүр жавхлант амилуулагдсан биетэйгээр үүрд амьдарна.

### Бидний Нүглийн Аврал

Хэдийгээр бид Уналтын бүх дэлхийн үр нөлөөнөөс гарцаагүй гэтэлгэгдсэн ч гэсэн өөрсдийнхөө нүгэлд хариуцлага хүлээнэ. Хэрэв “Христийн Цагаатгагч цусыг нөлөөлүүлэх” аваас бид нүглийнхээ толбоос цэвэрлэгдэж, учлагдаж чадна (Мозая 4:2). Бид Есүс Христэд итгэлтэй байж, наманчлан, нүглээс антижрахын тулд баптиسم хүртэж, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авах ёстой. Алма ийнхүү зөвлөжээ:

“Эдүгээ та нар наманчлах, мөн дахин төрөх ёстой гэдгийг би та нарт хэлнэ; учир нь та нар дахин төрөхгүй бол тэнгэрийн хаант улсыг өвлөж чадахгүй хэмээн Сүнс хэлдэг; тиймийн тул, ирэгтүн мөн наманчлалд баптиism хүртэгтүн, та нар нүглүүдээсээ угаалгаж болохын тулд, та нар дэлхийн нүглүүдийг зайлуулах тэр зөв шударга бус бүхнээс цэвэрлэж мөн аврах чадалтай тэр болох, Бурханы Хурганд итгэлтэй байж болохын тулд бөлгөө” (Алма 7:14).

### Мөнх Амьдралын Бэлэг

Мөнх амьдрал бол “Бурханы бүх бэлгүүдээс хамгийн агуу бэлэг” гэж Аврагч тунхагласан юм (С ба Г 14:7). Мөнх амьдралыг олж авахын тулд Бурханы оршихуйд сэлэстиэл хаант улсын хамгийн өндөр түвшинг өвлөн амьдарч суух зохистой байхад оршино. Энэхүү бэлэг нь зөвхөн Есүс Христийн цагаатгалаар дамжуулан боломжтой болдог. Мормон хэлэхдээ, “Мөн та нар юуны тулд найдах билээ? Болгоогтун, та нар Христийн Цагаатгал,

мөн түүний амилуулалтын хүчээр, мөнх амьдралд босгогдохын тулд би та нарт хэлнэ, түүнд итгэлтэйн тань учир болой” гэжээ (Моронай 7:41).

Энэхүү бэлгийг хүлээн авахын тулд тодорхой нөхцлүүдэд дасан зохицох хэрэгтэй. Бид Есүс Христэд итгэлтэй хэвээр байж, нүглээ наманчлан, эцсээ хүртэл итгэлтэйгээр тэвчих ёстой. Бид баптиسم, Ариун Сүнсний бэлэг, (эрэгтэйчүүдэд) Мелкизедек Санвааарын томилолт, ариун сүмийн индаумент болоод гэрлэлтийн лацдан холболт зэрэг авралын ёслолуудыг хүлээн авах ёстой. Бид эдгээр ёслолуудыг хүлээн авч, эдгээртэй холбогдох гэрээнүүдийг сахиснаар Христэд ирж, мөнх амьдралын бэлгийг бүрмөсөн хүлээн авдаг (Итгэлийн Тунхаг 1:3-ыг үз).

Өөрийнхөө хэмжээлшгүй их нигүүлсэл болон шударга ёсонд Их Эзэн түүнчлэн мөнх амьдралыг “энэ сайн мэдээний тухай мэдлэггүйгээр нас барсан тэд бүгд, үүнийг хүлээн авч болох тэд, хэрэв үлдэх нь тэдэнд зөвшөөрсөн аваас”, мөн тэрчлэн “хариуцлагын насанд хүрэхэсээ өмнө нас барсан бүх хүүхдүүдэд” өгнө (С ба Г 137:7, 10).

Аврагч бид бүгдийг мөнх амьдралыг хүлээн авахыг урьдаг: “Тэрээр бүх хүмүүнд урилгыг илгээх, учир нь нигүүлслийн мутар тэдний зүг сунгагдаж, мөн тэрээр: Наманчлагтун мөн би та нарыг хүлээн авах болно хэмээх болой. Тийм ээ, надад ирэгтүн, мөн та нар амьдралын модны үр жимснээс хүртэх болно; тийм ээ, та нар чөлөөтэйгөөр амьдралын талх мөн уснаас идэж мөн уух болно” (Алма 5:33–34).

Амар Амгаланг Олж, Цагааталаар Дамжуулан Эдгэрэх нь

Аврагчийн Цагаатгалын адислал мөнх оршихуйд үргэлжилдэг ч тэдгээр нь энэ амьдралд ч мөн ирдэг. Та Христ рүү ирвэл, Их Эзэний өмнө цэвэр байх баяр

баясгаланг мэдэх болно. Та нар их нүгэл болоод бослого эсэргүүцлийн дараа гэмшин, наманчлалын үйл явцаар эдгэрсэн Алмагийн хэлсний адил зүйлсийг хэлэх чадвартай байх болно. Тэрээр учлагдсаны дараа гэрчлэхдээ:

“Би өвчнөө цаашид санаж чадсангүй; тийм ээ, би нүглүүдийнхээ санамжид тарчлагдахгүй байсан болой.

“Мөн ай ямар баясал, мөн ямар гайхамшигт гэрлийг би болгоосон билээ; тийм ээ, миний бодгаль ямархуу шаналалд байсан шиг тийм үлэмжийн баяслаар дүүргэгдсэн байв!

“... Миний шаналал шиг тийм хурц мөн ийм гашуун нь байх аргагүй биз ээ... Нөгөө талаас нь бол миний баясал шиг ийм хурц бас амтлаг юу ч байж чадахгүй биз ээ” (Алма 36:19–21).

Аврагч нүглийн зовиураас гарах гэтэлгэлийг үзүүлэхийн хажуугаар сорилтын цагт амар амгаланг өгдөг. Түүний Цагаатгалын нэг хэсэгт Есүс Өөртөө өвчин, зовлон хийгээд бүх хүмүүсийн нүглийг үүрсэн (Алма 7:11–12-ыг үз). Тэр таны зовлон шаналлыг ойлгодог, учир нь Тэр үүнийг туулсан юм. Тэр энэхүү төгс төгөлдөр ойлголтоор танд хэрхэн туслахаа мэднэ. “Тэр та нарын төлөө зовдог учраас бүх зовнилоо Түүнд үүрүүл” (1 Петр 5:7).

Энэ амьдралын бүх алдас, өвчин зовлон, хагацал нь таны итгэл болоод зөв шударга ёс мөн Түүний цагаатгах золиослолоор дамжуулан бүрэн дүүрэн нөхөгдөж, зөв болж чадна. Энэ амьдралд хойшлуулагдсан адислалууд нь мөнх оршихуйд өгөгдөнө. Хэдийгээр тэр та нарын бүх зовлонг одоо арилгахгүй боловч, Тэр та нарыг “та нарын ачаануудыг хөнгөлөхөөр” тайвашрал хийгээд ойлголт, мөн хүч чадлаар адислах болно (Мозая 24:15).

“Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над руу ир. Би та нарт амралтыг өгье” гэж Аврагч хэлсэн (Матай 11:28). Өөр нэг тохиолдолд Тэр “Ертөнцөд та нар

зовлонтой байна. Гэвч зоригтой байгтун. Би ертөнцийг ялсан гэж айлдлаа” хэмээн Өөрийнхөө амар амгаланг дахин амласан (Иохан 16:33). Эдгээр нь энэ амьдралд хийгээд мөнх оршихуй дахь Цагаатгалын амлалтууд юм.

Нэмэлт судрууд: Исаиа 49:13–16; 53; Матай 26–28; Марк 14–16; Лук 22–24; Иохан 10:14–15; 11:25–26; 14:6; 15:13; 19–20; 1 Коринт 15:20–22; Еврей 4:14–16; 1 Иохан 1:7; 1 Нифай 10:6; 2 Нифай 2:1–10; 9; 25:23–26; Иаков 4:12; Мозая 3:1–19; Алма 22:14; 34:5–18; 42; Хиламан 5:9–12; 14:13–19; 3 Нифай 9:14–22; 27:13–22; Мормон 9:10–14; Ифер 12:27, 41; Моронай 8:5–26; 10:32–33; С ба Г 18:10–12; 19:15–24; 20:17–34; 45:3–5; 76:40–43; Моце 1:39.

Аврал; Авралын Төлөвлөгөө; Алдар Сүүгийн Хаант Улс; Амилуулалт; Баптиسم; Бурхан Эцэг; Ёслолууд; Итгэл; Мөнх Амьдрал; Наманчлал; Нигүүлсэл; Өршөөл; Сайн Мэдээ; Үхэл, Биеийн болон Сүнслэг Үхэл; Уналт; Шударга Ёсыг мөн үз.

## Ёслолууд

Сүмд ёслол нь санваарын эрх мэдлээр гүйцэтгэгддэг ариун нандин, албан ёсны зан үйл билээ. Зарим ёслолууд нь бидний авралд зайлшгүй хэрэгцээтэй. Эдгээр ёслолуудыг авралын ёслолууд гэж нэрлэдэг. Үүнд баптиism, гишүүний баталгаа, Мелкизедек Санваарын ёслол (эрэгтэйчүүд), ариун сүмийн индаумент, болон гэрлэлтийн лацдан холболт багтдаг. Дээрх ёслол тус бүрээр бид Их Эзэнтэй чухал гэрээ байгуулдаг.

Хүүхдэд нэр өгөх мөн адислах, тос ариулах, өвчтэй, зовлонд унасныг адислах зэрэг бусад ёслолууд нь мөн санваарын эрх мэдлээр гүйцэтгэгддэг. Хэдийгээр тэдгээр нь бидний авралд нэн шаардлагатай биш боловч бидэнд тайвширал, удирдамж мөн урам зориг өгдөг.

Ёслолууд болон гэрээнүүд нь бид хэн болохыг санаад бидэнд тусалдаг. Тэдгээр нь Бурханы өмнө гүйцэтгэх бидний үүргийг сануулдаг. Их Эзэн тэрхүү ёслолууд болон гэрээнүүдийг бид Түүн рүү очиход мөн

## Завхайрал

мөнх амьдралыг хүлээн авахад туслахын тулд бидэнд өгсөн юм. Бид тэднийг хүндэтгэх үед Тэр биднийг хүчирхэгжүүлдэг.

Та нар санваарын ёслолуудад оролцох олон боломжийг хүлээн авч болно. Та нарт иймэрхүү боломж олдвол уг ёслолыг гүйцэтгэх юм уу эсвэл хүлээн авахдаа өөрийгөө бэлтгэхэд чадах бүхнээ хий. Залбирч, мацаг барьж, санваарын удирдагчтайгаа зөвлөж, судраас болон хожмын үеийн бошиглогчдын үгсээс суралцсанаар та өөрийгөө бэлтгэж чадна. Хэрэв та санваартан бол ёслол үйлдэхдээ үргэлж сүнслэгээр бэлтгэгдсэн байх ёстой. Цэвэр, зохистой амьдралаар амьдарч, Ариун Сүнсний байнгын нөхөрлөлийг хүлээн авахыг хичээ.

Нэмэлт судрууд: С ба Г 84:19–21; Итгэлийн Тунхаг 1:3–5

Гэрээ; Сайн Мэдээ; Санваарыг мөн үз.

## Завхайрал (Ариун Явдлыг үз)

### Загалмай

Ихэнх Христийн сүмүүд загалмайг Аврагчийн үхэл хийгээд Амилуулалт, мөн итгэлийнхээ чин сэтгэлийн бэлэг тэмдэг болгон хэрэглэдэг. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүдийн хувьд бид мөн Аврагчийн зовлон шаналлыг бишрэл хүндэтгэлтэйгээр дурсан санадаг. Гэхдээ Аврагч амьдардаг учраас бид Түүний үхлийн бэлэг тэмдгийг итгэлийнхээ бэлэг тэмдэг болгон хэрэглэдэггүй.

Таны амьдрал итгэлийн тань илрэл байх ёстой. Та баптисм хүртэн, гишүүнээр батлуулах үедээ Есүс Христийн нэрийг өөртөө авахаар гэрээ хийсэн гэдгээ санаж бай. Найз нөхөд тань таныг ажиглахдаа Аврагч болон Түүний ажлыг хайрлах таны хайрыг мэдрэх боломжтой байх болно.

Загалмайн бэлэгдэл зүүдэг Сүмийн гишүүд нь зөвхөн Христийн санваартан гэдгээ харуулахын тулд цэргийн дүрэмт хувцсан дээрээ үүнийг зүүсэн Хожмын Үеийн Гэгээнтэн санваартнууд юм.

Амилуулалт; Есүс Христ; Есүс Христийн Цагаатгалыг мөн үз.

## Залбирал

Та бол Бурханы хүүхэд. Тэнгэрлэг Эцэг танд хайртай, таны хэрэгцээг мэддэг, Тэр таныг Түүнтэй залбирлаар дамжуулан харилцахыг хүсдэг. Түүнд залбир, өөр хэнд ч биш. Их Эзэн Есүс Христ зарлиглахдаа, “Та нар үргэлж миний нэрээр эцэгт залбирах ёстой” гэжээ (3 Нифай 18:19).

Бурхантай залбирлаар хандахыг та зуршил болговол Түүнийг таньж, Түүнд ойртон очих болно. Таны хүсэл Түүнийхтэй адил болно. Хэрэв та зөвхөн итгэлээр асуух аваас Түүний өөрт тань өгөхөд бэлэн байгаа адислалуудыг өөртөө болон бусдад олж авах чадвартай байх болно.

## Залбирлын Зарчмууд

Тэнгэрлэг Эцэг залбирлуудыг тань сонсож мөн хариулахад үргэлж бэлэн байдаг. Залбирлын тань хүч танаас хамаарна. Та залбирлаа амьдралынхаа нэгэн хэсэг болгохоор хичээвэл энэхүү зөвлөгөөг сана:

Залбирлаа утга учиртай болго. “Зүрх сэтгэлийнхээ үнэн хүслээр бус аваас, энэ нь түүнд ямар ч ашиггүй, учир нь Бурхан тийм нэгнийг хүлээн авдаггүй” гэдгийг Бощиглогч Мормон сануулсан (Моронай 7:9). Залбирлаа утга учиртай болгохи н тулд чин сэтгэлээсээ “зүрхнийхээ бүхий л эрч хүчээр” залбирах ёстой (Моронай 7:48). Залбирахдаа “Хоосон давталтаас” зайлсхий (Матай 6:7-г үз). Өөрийн үзэл бодол хийгээд хэрэглэх үгээ сайн цэгнэ.

Хайр, хүндэтгэл, бишрэл болон дотно байдлыг үзүүлэх уг хэллэг хэрэглэ. Энэхүү зарчмын хэрэглээ таны хэлж ярих уг хэлнээс ялгаатай байна. Хэрэв та Англиар залбирах бол, жишээ нь, чи, чиний, чинийх гэх мэт түгээмэл хэрэглэгддэг төлөөний үгсийн оронд Бурханд хандахаа судрын төлөөний үгсийг—танд, та, таны, таных хэмээн хэрэглэх хэрэгтэй. Хэлнүүдээс үл хамааран зарчим нь хэвээр үлддэг. Та залбирахдаа Бурхантай харьцах харилцаандаа хайрын, бишрэл хүндэтгэлийг дамжуулах үгсийг хэрэглэх нь зүйтэй. Магадгүй залбирлын хэл таны хувьд сурахад бэрхшээлтэй байгаа ч байнга залбирч, судраас уншвал аажимдаа эвтэйхэн болох болно.

Тэнгэрлэг Эцэгтээ үргэлж талархлаа илэрхийл. Та “өдөр бүр талархалтайгаар амьдрах ёстой, учир нь та нарын дээр түүний бэлэглэдэг тэр олон нигүүлсэл мөн ивээлүүд байдаг” (Алма 34:38). Адислалаа санах цаг гаргавал та Тэнгэрлэг Эцэг тань таны төлөө ямар их зүйл хийснийг мэдэх болно. Түүнд талархлаа илэрхийлж бай.

Хийж буй бүх зүйлдээ Тэнгэрлэг Эцэгийн удирдамж, хүч чадлыг эрэлхийл. Өөрийн хүү Хиламандаа Алма зөвлөхдөө “Өөрт хэрэгтэй бүх дэмжлэгийн төлөө Бурханаас гүй, тийм ээ, бүхий л үйлүүд тань Их Эзэний тулд байг, мөн чи хаана ч явсан Их Эзэн рүү чиглэсэн байг; тийм ээ, зүрх сэтгэлийн тань хайр Их Эзэний дээр үүрд байрласан байг. Бүх үйлүүдээ Их Эзэнтэй зөвлөгтүн, мөн тэрээр чамайг сайны тул чиглүүлэх болно; тийм ээ, чи энэ үдэш унтахаар хэвтэхдээ Их Эзэний тулд хэвт, тэрээр нойронд чинь чамайг манаж болохын тулд буюу; мөн өглөө босохдоо зүрх сэтгэл чинь Бурханд хандах талархлаар дүүрэн байг, мөн хэрэв чи эдгээр зүйлийг хийх аваас эцсийн өдөр өргөгдөх болно” (Алма 37:36–37; Алма 34:17–26-г мөн үз).

Залбирахдаа бусдын хэрэгцээг сана. “Аз жаргалын төлөө, мөн түүнчлэн та нарын эргэн тойронд байгаа тэдний зол жаргалын төлөө” залбир (Алма 34:27). Тэнгэрлэг Эцэгээс хэрэгцээтэй хүмүүсийг тайвшуулж, адислахыг хүс. Түүнээс Сүмийн Ерөнхийлөгч, бусад Ерөнхий Эрх Мэдэлтнүүд болон орон нутгийнхаа Сүмийн удирдагчдыг хүчирхэгжүүлж, урамшуулахыг гүй. Гэр бүлийн гишүүд болон наиз нөхдийнхөө сайн сайхны төлөө залбир. Засгийн газрын удирдагчдын төлөө залбир. Номлогчид болон зааж байгаа хүмүүсийг тань хамгаалж урамшуулахыг хүс.

Залбирагдаа юу багтаахыг мэдэхийн тулд Ариун Сүнсний удирдамжийг эрэлхийл. Ариун Сүнс танд хэлэх үгсийг тань чиглүүлж, залбирахыг зааж чадна (Ром 8:26; 2 Нирафай 32:8-ыг үз). Тэр чамд “Бурханы хүсэл зоригийн дагуу” залбирахад туслах болно (С ба Г 46:30).

Залбирагдаа дамжуулан хүсч буй зүйлээ хүртэж болохын тулд чадах бүхнээ хий. Тэнгэрлэг Эцэг таныг зөвхөн Θөрөөс нь адислал хүсэхээс илүү их зүйл хийхийг хүсэн хүлээдэг. Чухал шийдвэр гаргах үедээ “оюун бодолдоо судалж үзэхийг” Тэр өөрт тань хариулт өгөхөөсөө өмнө үргэлж шаарддаг (С ба Г 9:7–8-ыг үз). Удирдамж авах залбираг тань зөвхөн Ариун Сүнсний шивнэлтийг таньж байхын тулд зөвхөн таны хичээл зүтгэлээр үр дүнтэй байх болно. Θөрийнхөө болон бусдын сайн сайхны төлөөх залбираг тань “Гачигдсаныг, мөн нүцгэнийг хоосон буцааж мөн өвдсөн зовсонд үл очин, мөн хэрэв танд буй аваас хөрөнгөнөөсөө гачигдсан тэдэнтэй эс хуваалцвал” хоосон байх болно (Алма 34:28).

Хэрэв таны өмнө хүнд хэцүү даалгавар байвал, Тэнгэрлэг Эцэг таныг өвдөг сөхрөн тусламж гүйж, хөл дээрээ босон ажиллавал баярлана. Тэр таны бүхий л зөв шударга үйлд туслах болно, гэвч зарим үед Тэр таны Θөрийнхөө төлөө хийж чадах нэг зүйлийг хийх болно.

## Залбирал

### Хувийн Залбирал

Уулан дээрх Номлолдоо Есүс Христ зөвлөхдөө: “Харин чи залбирахдаа дотоод өрөөндөө орж хаалгаа хаагаад, нууцаар оршигч Эцэгтээ залбир. Нууцаар харгач Эцэг тань чамд буцааж төлнө” (Матай 6:6). Хувийн залбирал бол сүнсний өсөлт хөгжилтийн хамгийн зайлшгүй хэсэг юм.

Дор хаяж өглөө, орой бүр анхаарал сарниулах зүйлээс хол байх газрыг ол. Даруухнаар сөхрөн сууж, Тэнгэрлэг Эцэгтэйгээ хүүрнэ. Хэдийгээр та чимээгүй залбирах хэрэгтэй боловч, зарим үед сонсогдоо залбирах чармайлт гарга (С ба Г 19:28; 20:51-ийг үз).

Залбирал нь хоёр талын харилцаа гэдгийг сана. Залбиралаа төгсгөх үедээ түр зуур зогсолт хийж сонсож сур. Зарим үед Тэнгэрлэг Эцэг таныг өвдөг дээрээ сөхөрч байх үед зөвлөж, удирдаж, тайтгаруулах болно.

Залбирахад зохисгүй гэсэн санааг өөртөө бүү төрүүл. Энэхүү санаа нь таныг залбирах ёсгүй гэдгийг ятгах Сатаанаас ирдэг (2 Нифай 32:8-ыг үз). Хэрэв та залбирах хүсэлгүй бол, залбирах хүсэл төрөх хүртлээ залбир.

“Ялан дийлэгч болж гарахын тулд чи ямагт залбир, тийм ээ, чи Сатаныг ялж гарахын тулд, мөн түүний ажлыг дэмжиж байдаг Сатаны зарц нарын гараас зугтаахын тулд буюу” хэмээн Аврагч зарлиглажээ (С ба Г 10:5). Хэдийгээр чи үргэлж өвдөг дээрээ залбирдаггүй ч хувийн залбиралаа байнга хийвэл зүрх сэтгэлээ “дүүрэн байлгаж, залбиралаа үргэлжлүүлэн Бурханд хандуулж” чадна (Алма 34:27; мөн 3 Нифай 20:1-ийг үз). Өдрийн турш чи Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хайрт Хүүд зориулсан хайрын байнгын мэдрэмжтэй байж чадна. Та чимээгүйгээр Эцэгтээ талархлаа илэрхийлэн, үүрэг хариуцлагадаа өөрийгөө хүчирхэгжүүлэхээр асууж болно.

Уруу таталт эсвэл бие махбодийн аюулын үед та Түүнээс тусламж хүсч чадна.

### Гэр Бүлийн Залбирал

Хувиараа залбирахыг бидэнд зарлигласнаас гадна биднийг гэр бүлтэйгээ залбирахыг Аврагч бидэнд ухуулсан. “Гэр бүлдээ Эцэгт миний нэрээр үргэлж залбир, эхнэрүүд мөн хүүхдүүд тань ивээгдэж болохын тулд болой” хэмээн Тэрээр хэлжээ (3 Нифай 18:21).

Хэрэв та гэрлэсэн бол гэр бүлийн залбиралаа гэр бүлийнхээ амьдралын нэг хэсэг болго. Өглөө бүр, үдэш бүр даруухнаар хамтаяа сөхөрч суу. Гэр бүлийн гишүүн бүрт залбирах боломжийг олго. Тэнгэрлэг Эцэгийн өөр-сөдөө өгсөн адислалуудын талархалд хамтдаа нэгд. Бусдын төлөө залбирахад хэрэгтэй адислалуудыг гүй-хаар итгэлд нэгд.

Гэр бүлийн тогтмол залбираар дамжуулан та болон таны гэр бүлийн гишүүд Бурханд болон бие биен-дээ улам ойр байх болно. Хүүхдүүд тань Тэнгэр дэх Эцэгтэйгээ харилцаж сурна. Та нар бүгдээрээ бусдад үйлчлэхэд сайн бэлтгэгдэж, уруу таталтуудыг сөрж зогсоно. Танай гэр дэлхийн хилэнцэт нөлөөллөөс толгой хоргодох газар, сүнслэг хүч чадлын гэр байх болно.

### Нийтийн Залбирал

Зарим үед танаас Сүмийн цуглаан, анги дээр нийтийн залбирал хэлэхийг хүсч болох юм. Та энэхүү боломжийг хүлээн авах үедээ нийтийн номлол өгч байна гэж бодох бус харин Тэнгэрлэг Эцэгтэйгээ ярьж байгаа гэдгээ санаарай. Бусад хүмүүсийн юу гэж хэлэх талаар бүү санаа зов. Түүний оронд эгэл жирийн, чин сэтгэлийн залбирлыг хэл.

## Залбиралдаа Хариулт Хүлээн Авах нь

“Гүй тэгвэл та нарт өгнө. Хай, тэгвэл та нар олно. Тогш тэгвэл та нарт нээгдэнэ: гүйдаг хүн бүр авна, эрж хайдаг хүн олно, тогшдог хүнд нээгдэнэ” хэмээн Аврагч заажээ (Матай 7:7–8). “Мөн та нар хүлээж авах болно гэж итгээд, миний нэрээр Эцэгээс гүйх зөв болох юу боловч, болгоогтун энэ нь та нарт өгөгдөнө” хэмээн Тэрээр Нифайчуудад хэлжээ (3 Нифай 18:20).

Тэнгэрлэг Эцэг таны залбирлыг сонсдог. Таны хүс-сэн шиг хариулахгүй байж болох ч, Тэр Θөрийн цагтаа, Θөрийн хүсэл зоригийн дагуу хариултыг өгдөг. Учир нь Тэрээр танд юу хамгийн сайн бэ гэдгийг мэддэг, тэр ч байтугай таны хүсэлт гүйлт чин сэтгэлийн ч гэсэн Тэр зарим үед үгүй гэж хариулж болно.

Залбирлын хариу олон замаар ирдэг. Ихэнхдээ Ариун Сүнсний зөөлөн намуухан дуугаар дамжин ирдэг (“Илчлэлт” х.109–114-ийг үз). Амьдралын тань нөхцөл байдалд эсвэл чиний эргэн тойронд байгаа үйлдлүүдээр дамжуулан ирж болдог. Та Тэнгэрлэг Эцэгтэйгээ залбирлаар дамжуулан ойр байваас, Түүний нигүүлсэнгүй байдал хийгээд хүсэлт гүйлтиуд дахь мэргэн хариултыг та төвөгүйхэн таньж чадна. Тэр бол таны “хоргодах газар болон хүч чадал, зовлон дундах бодит тусламж” гэдгийг мэдэх болно (Дуулал 46:1).

Нэмэлт судрууд: Матай 6:5–15; Иаков 1:5–6; Инос 1:1–17; Мозая 4:11–12; 3 Нифай 13:6–7; 14:7–8; С ба Г 19:38; 88:63–65; Иосеф Смитийн Түүх 1:9–19

Бишрэн Шүтэх; Итгэл; Мацааг Барилт ба Мацаагийн Өргөлийг мөн үз.

**Засгийн Газар** (Иргэний Засгийн Газар болон Хуулийг үз)

## Золиослол

Золиослоно гэдэг нь өөрсөддөө байгаа үнэт зүйлээ илүү агуу зүйлийн сайн сайхны төлөө зориулахыг хэлнэ. Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн хувьд бид Их Эзэний болон Түүний хаант улсын төлөө дэлхийн зүйлсийг золиослох боломжтой. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд Их Эзэний шаардсан аливаа золиослолыг хийх хүсэлтэй байх хэрэгтэй. Хэрэв биднийг золиослол хийхийг шаардаагүй байсан бол бид мөнхийн авралд шаардлагатай итгэлийг хөгжүүлж хэзээ ч чадахгүй.

Есүс Христийн Цагаатгал нь сайн мэдээний төвд агуу их мөнхийн золиослол юм (Алма 34:8–16-г үз). Аврагч Цагаатгалыг гүйцэтгэхээс өмнө, Түүний гэрээт хүмүүс амьтныг Түүний золиослолын бэлэгдэл болгон золиосолж байв. Энэхүү дадал нь Цагаатгал өөд харахад нь тэдэнд тусалдаг байжээ (Моце 5:4–8). Амьтдаар золиослол хийх зарлиг нь Есүс Христийн үхлээр төгсгөл болсон юм. Өнөөдөр Сүмд ариун ёслолыг Аврагчийн цагаатгах золиослолыг дурсан санахаар хүртдэг.

Есүс Христийн цагаатгах золиослолыг дурсан санахаас гадна бид өөрсдөө харууссан зүрх гэмшсэн сэтгэлийн золиослолыг хийх хэрэгтэй. “Та нар цаашид цус урсган надад өргөл өргөхгүй; тийм ээ, та нарын тахилууд мөн хайлах өргөл нь зогсоогдох болно. . . . Та нар харууссан зүрх, гэмшсэн сэтгэлийг надад тахил болгон өргөх болно. Мөн харууссан зүрх гэмшсэн сэтгэлтэйгээр надад ирэх хэнийг боловч, түүнийг би галаар мөн Ариун Сүнсээр батлана” хэмээн Аврагч хэлсэн юм (3 Нифай 9:19–20).

Харууссан зүрх мөн гэмшсэн сэтгэлтэй байхын тулд Бурханы хүслийг болон Тэрээр Өөрийн Сүмийг удирдуулахаар дуудсан тэдний зөвлөгөөг хүлээн авч, даруу

## *Зуурдын Амьдралын Өмнөх Оршихүй*

байх ёстай юм. Энэ нь нүгэлдээ гүн гүнзгий гэмшилийг болон наманчлах чин сэтгэлийн хүслийг мэдрэх явдал юм. Бошиглогч Лихай золиослол өргөхийн чухлыг онцлохдоо: “Болгоогтун, харууссан зүрх мөн гэмшсэн сэтгэлтэй хэний төлөө боловч хуулийн шаардлагуудыг хангаж тэрээр нүглийн золиослол болгон өөрийгөө өргөх; мөн хуулийн бүх шаардлагууд өөр хэний төлөө боловч хангагдаж чадахгүй” гэжээ (2 Нифай 2:7). Хэрэв бид харууссан зүрх, гэмшсэн сэтгэлийн золиослолийг өргөхгүй бол, Цагаатгалаар дамжин ирдэг адислалуудыг бүрэн хүлээн авч чадахгүй.

Их Эзэний зарлигласан ёсоор та золиослол хийх хүсэлтэй бол Тэр таныг хүлээн авна. “Зүрх сэтгэл нь үнэнч шударга мөн харууссан мөн сэтгэл нь гэмшсэн гэдгийг мэддэг тэд, мөн гэрээнүүдээ золиослолоор дагахад бэлэн байгаа тэд—тийм ээ, Их Эзэн миний зарлигах золиослол бүрээр—тэд надаас хүлээн зөвшөөрөгддөг билээ” хэмээн Тэрээр заасан юм (С ба Г 97:8). Мөнхийн үзэл бодолтойгоор, та дэлхийн зүйлсийг орхих нь тийм ч их золиослол биш гэдгийг мэдэх болно. Таны хүлээн авдаг адислалууд ямар нэг зүйлийг орхихоос тань илүү агуу юм.

Нэмэлт судрууд: Матай 19:16–22; С ба Г 59:8

Ариун Ёслол; Дуулгавартай Байдал; Есүс Христийн Цагаатгал; Наманчлал; Үйлчлэл; Хайрыг мөн үз.

### **Зуурдын Амьдралын Өмнөх Оршихуй** (Авралын Төлөвлөгөөг үз)

#### **Жишиг Бүтээлүүд** (Судруудыг үз) 81

#### **Ижил Хүйстэнтэйгээ Бэлгийн Харьцаанд Орох** (Ариун Явдлыг үз)

## Илчлэлт

Илчлэлт бол Бурханаас хүүхдүүддээ өгөх харилцаа юм. Энэхүү удирдамж нь янз бүрийн аргаар дамжуулан хувь хүн, гэр бүл, Сүмийн хэрэгцээ болон нөхцөл байдлын дагуу ерөнхий байдалтайгаар ирдэг.

Өөрийнхөө хүсэл зоригийг Сүмийн гишүүддэд илчлэхдээ Их Эзэн бошиглогчооро дамжуулдаг. Судрууд нь Их Эзэний үгс олон илэрхийллүүдийг эртний болон хожмын үеийн бошиглогчдоор дамжуулан агуулдаг. Өнөөдөр Их Эзэн Өөрийн хүслээ Өөрийн сонгосон үйлчлэгчиддээ илчлэн Сүмээ цаашид удирдсаар байна.

Бошиглогчид нь илчлэлт авдаг цорын ганц хүмүүс биш юм. Итгэлтэй байдлынхаа дагуу та онцгой хэрэгцээ, хариуцлага, асуултууддаа тусlamж авахаар, мөн гэрчлэлээ хүчирхэгжүүлэхээр илчлэлт хүлээн авч чадна.

Ариун Сүнсээр Дамжуулан Илчлэлт Хүлээн Авахад Бэлтгэх нь

Судрууд үзэгдлийн, зүүдний, тэнгэр элчийн айлчлал зэрэг янз бүрийн илчлэлтийн талаар өгүүлдэг. Иймэрхүү замаар дамжуулан Их Эзэн Өөрийн сайн мэдээг хожмын өдрүүдэд сэргээж, зуурдын байдлын өмнөх оршихуйн, нас барагсдыг гэтэлгэх, мөн алдар суугийн гурван хаант улсын талаарх сургаалтай холбогдох үнэнүүдийг илчилсэн. Гэсэн хэдий ч, удирдагчид болон Сүмийн гишүүддэд өгөгддөг ихэнх илчлэлтүүд Ариун Сүнсний шивнэлтээр дамжин ирдэг.

Чимээгүй сүнсний өдүүлбэрүүд онцгой үзэгдэл юм уу эсвэл тэнгэр элчийн айлчлал шиг санагдахгүй байж болно, гэхдээ тэдгээр нь илүү хүчтэй, үүрдийн амьдрал өөрчлөхөөр юм. Ариун Сүнсний гэрч үзэж, харж, сонсох ямар ч зүйлээс илүү ач холбогдол бүхий сэтгэгдлийг бодгальд төрүүлдэг. Иймэрхүү илчлэлээр дамжуулан та

## Илчилэлт

сайн мэдээндээ үнэнч хэвээр үлдэх мөн ижил зүйлийг хийхэд бусдад туслах үүрдийн хүч чадлыг хүлээн авна.

Дараах зөвлөгөө нь таныг Ариун Сүнсний өдүүлбэрүүдийг хүлээн авахаар бэлтгэхэд туслах юм:

*Удирдамжийн төлөө залбир.* “Гүй тэгвэл та нарт өгнө. Хай, тэгвэл та нар олно. Тогш тэгвэл та нарт нээгдэнэ. Гуйdag хүн бүр авна, эрж хайдаг хүн олно, тогшдог хүнд нээгдэнэ” хэмээн Их Эзэн хэлжээ (Матай 7:7–8). Олж, хүлээн авахын тулд та эрж, хайж, асуух ёстой. Удирдамж авахын тулд Тэнгэрлэг Эцэгтээ залбиран—хэрэв та тогшигүй бол—илчлэлтийн хаалга танд онгойхгүй. Гэвч та Эцэгтээ даруу залбирлаар хандвал, улмаар та “баяр хөөрийг авчирдаг, амьдралыг авчирдаг тэрхүү нууцууд хийгээд амар амгалангийн зүйлүүдийг мэдэж болохын тулд илчлэлт дээр илчлэлт, мэдлэг дээр мэдлэг хүлээн авах болно” (С ба Г 42:61).

*Бишрэл хүндэтгэлтэй бай.* Бишрэл хүндэтгэл нь агуу их хайр хүндэтгэл, хайр мөн. Хэрэв бишрэл хүндэтгэлтэй, амар амгалан бол та илчлэлтийг урьдаг. Тэр ч бүү хэл, таны эргэн тойрны зүйлс хөл толгой нь олдохгүй байх үед ч та бишрэл хүндэтгэлтэй мөн Их Эзэнээс удирдамж авахад бэлтгэж чадна.

*Даруу бай.* Даруу төлөв байдал нь бишрэл хүндэтгэлтэй нягт холбоотой. Даруу төлөв байхдаа та өөрийгөө Их Эзэнээс хамааралтай гэдгээ ойлгох болно. “Мөн даруу байдал мөн зүрх сэтгэлийн хүлцэнгүй чанарын улмаас, найдвар мөн төгс хайраар дүүргэх Тайтгаруулагч болох тэр Ариун Сүнсний айлчлал нь ирэх болой” хэмээн Бошиглогч Мормон заажээ (Моронай 8:26).

*Зарлигуудыг сахь.* Зарлигуудыг сахиснаар та Ариун Сүнсний өдүүлбэрүүдийг дагах, таних, хүлээн авахад бэлтгэгдэж чадна. “Миний зарлигуудыг сахьдаг түүнд бибээр хаант улсынхаа нууцуудыг өгнө, мөн мөнхүү эдгээр нь үүрдийн амьдрал уруу урсагч амьд усны худаг

түүнд байх болно” хэмээн Их Эзэн амласан юм (С ба Г 63:23).

*Ариун ёслолоос зохицтойгоор хүрт.* Ариун ёслолын залбирал нь Ариун Сүнсний байнгын нөхөрлөлийг хэрхэн хүлээн авч болохыг заадаг. Ариун ёслолоос хүртэх үед та Бурханд Түүний Хүүгийн нэрийг өөртөө авах хүсэлтэй байгаа, Түүнийг болон Түүний зарлигуудыг үргэлж санан дурсаж байгаагаа гэрчилдэг. Таныг эдгээр гэрээгээ биелүүлэх аваас Ариун Сүнс тантай үргэлж хамт байна гэдгийг Тэнгэрлэг Эцэг амладаг (С ба Г 20:77, 79-ийг үз).

*Өдөр бүр судруудаас судал.* Судруудыг хичээнгүйгээр судалваас, та Их Эзэний илчилсэн хүслийг дагасан учраас амьдрал нь адислагдсан эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн жишээнээс суралцдаг. Мөн та амьдралдаа Ариун Сүнсийг ихээр хүлээн авч чадна. Уншаад тунгаан бодвоос судрын тодорхой нэг хэсэг танд хэрхэн хүрч байгаа эсвэл Их Эзэний тантай ярилцахыг хүсч байгаа зүйлсийн талаар илчлэлтийг хүлээн авч чадна. Судрын ууншилага нь таныг хувийн илчлэлтийг хүлээн авахад тусалдаг учраас та өдөр бүр судраас суралцах хэрэгтэй.

*Тунгаан бодох цаг гарга.* Сайн мэдээний үнэнийг тунгаан бодох цаг гаргахад та бодол санаа, зүрх сэтгэлээ Ариун Сүнсний удирдаж буй нөлөөллийн зүг нээдэг (1 Нифай 11:1; С ба Г 76:19; 138:1–11-ийг үз). Тунгаан бодох нь дэлхийн чухал бус зүйлсээс бодлыг таны салгаж, Сүнстэй ойр авчирна.

*Тодорхой нэг удирдамжийг эрэлхийлэхдээ бодол санаандаа судал.* Зарим үед Их Эзэний харилцаа зөвхөн бодол санаандаа судлан үзсэний дараа ирэх болно. Их Эзэн энэхүү явцыг Мормоны Номны ихэнх орчуулгад Иосеф Смитийн бичээчээр үйлчилж байсан Оливер Каудерид тайлбарлаажээ. Хэдийгээр Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Их Эзэн Оливер Каудерид орчуулах бэлэг өгсөн боловч, яагаад Оливер Мормоны Номыг орчуулах боломжгүй

байсныг тайлбарлан хэлэхдээ: “Болгоогтун, чи ойлгосонгүй; чи надаас асуухаас өөрөөр санаа тавиагүй байхад чинь, үүнийг чамд өгөх юм шигээр чи бодсон байна. Гэвч, болгоогтун, би чамд хэлнэ, чи үүнийг оюундаа тунгаан бодох ёстой; дараа нь энэ нь зөв үү гэдгийг чи надаас асуух ёстой, мөн энэ нь зөв аваас цээжин биеийг чинь чиний дотор шатахаар болгоно би; тиймийн тул, энэ нь зөв юм байна гэдгийг чи мэдрэх болно” (С ба Г 9:7–8).

Бурханы хүсэл зоригийг тэвчээртэйгээр эрэлхийл. Бурхан Өөрийгөө “өөрийнхөө цагт, мөн түүний өөрийнхөө замаар, мөн түүний өөрийнхөө хүсэл зоригийн дагуу” илчилдэг (С ба Г 88:63–68-ыг үз). Магадгүй илчлэлт нь танд “шат шатаар, дүрэм дүрмээр” ирж болно (2 Нифай 28:30; мөн Исаиа 28:10; С ба Г 98:12-ыг үз). Сүнслэг зүйлсийг бүү хүчил. Ийм маягаар илчлэлт ирдэггүй. Их Эзэний цаг хугацаанд итгэж, тэвчээртэй бай.

Ариун Сүнсний Өдүүлбэрүүдийг Танин Мэдэх нь

Дэлхийн чимээ шуугиан болон өнөөдрийн олон элчийн дундаас та Ариун Сүнсний шивнэлтүүдийг танихад суралцах ёстой. Ариун Сүнсний бидэнтэй ярилцдаг үндсэн арга замыг доор үзүүлэв:

Тэр бидний зүрх сэтгэл хийгээд оюунд намуухан зөвлөн дуугаар ярьдаг. “Чамд ирж мөн зүрх сэтгэлд чинь орших Ариун Сүнсээр оюунд чинь мөн зүрх сэтгэлд чинь би чамд ярих болно. Эдүгээ, болгоогтун, энэ бол илчлэлийн сүнс болой” хэмээн Их Эзэн заажээ (С ба Г 8:2–3). Зарим үед Ариун Сүнс сайн мэдээний үнэнийг ойлгоход эсвэл “оюун бодлыг тань эзэмдэж мөн таны бодол санааг хүчтэйгээр эзэмдэх” өдүүлбэр өгөхөд туслах болно (С ба Г 128:1). Хэдийгээр иймэрхүү илчлэлт танд хүчтэй нөлөө үзүүлж чадах ч, энэ нь бараг үргэлж чимээгүй намуухан зөвлөн дуугаар ирдэг (Хаадын дээд 19:9–12; Хиламан 5:30; С ба Г 85:6-г үз).

Тэрээр бодол санаагаар маань дамжуулан бидэнд сануулдаг. Хэдийгээр бид Сүнсний холбоог хоолой мэт дүрсэлдэг ч тэрхүү дуу хоолойг бид сонссноосоо илүүтэйгээр мэдэрдэг. Ариун Сүнсний шивнэлтуүдийг бид “сонсон” ярих зуур үргэлж сүнслэг өдүүлбэрийг “би . . . мэдэрлээ” гэж тайлбарлан хэлдэг. Хуудас 34-ын талаар ярилцсан Сургаал ба Гэрээний хэсэг 9-д Оливер Каудериid өгсөн Их Эзэний зөвлөгөө энэхүү зарчмыг заадаг. Гэхдээ энэ зөвлөгөө зарим үед буруугаар ойлгогддог. Тэрхүү хэсгийг уншсан Сүмийн зарим гишүүд Ариун Сүнсний өдүүлбэрийг хэзээ ч хүлээн аваагүй хэмээн айж төөрөлддөг. Учир нь хэзээ ч тэдний цээж шатах мэт мэдрэмжийг мэдэрч байгаагүй байдаг. Сургаал ба Гэрээний 9:8-д Их Эзэний хэлсэн сүүлчийн үг “Тиймийн тул, энэ нь зөв юм байна гэдгийг чи мэдэх болно” гэснийг анхаар. Судрын тэр хэсэгт дүрсэлсэн “шатах” гэсэн үг нь тайтгарал амарлингүй мэдрэмжийг чухалчлан үзэж байгаа болохоос бус халуун уур биш юм. Их Эзэний хүслийг амьдралдаа хайж, үргэлжлүүлэн дагаваас Ариун Сүнс хэрхэн биечлэн нөлөөлж байгааг таних болно.

Тэрээр амар амгаланг авчирдаг. Ариун Сүнсийг ихэнхдээ Тайвшруулагч гэж нэрлэдэг (Иохан 14:26; С ба Г 39:6-г үз). Их Эзэний хүсэл зоригийг Тэрээр илчлэхдээ, Тэрээр “чиний оюунд амар амгаланг ярих болно” (С ба Г 6:23). Түүний өгдөг амар амгалан худал сургаал юм уу эсвэл дэлхийн хуурамч нөлөөлөл байж таaraхгүй. Энэ нь Тэрээр Тайвшруулагчаа илгээнэ гэж шавь нартаа батлан хэлэхдээ Аврагчийн амласан амар амгалан юм: “Амар амгаланг би та нарт үлдээнэ. Би Өөрийн амар амгалангaa та нарт өгнө. Ертөнцийн өгдгөөс өөр юмыг Би та нарт өгч байна. Та нар зүрх сэтгэлээ бүү зовоо. Бүү ай” (Иохан 14:27).

## *Индаумент*

Нэмэлт судрууд: Амос 3:7; Матай 16:13–18; 1 Коринт 2:9–14; 12:3; Илчлэлт 19:10; Алма 5:43–48; 17:2–3; С ба Г 76:5–10; 121:26–33; Итгэлийн Тунхаг 1:7, 9

Ариун Сүнс; Бишрэл Хүндэтгэл; Залбирал; Итгэл; Судрууд; Сүнслэг Бэлгүүдийг мөн үз.

## **Индаумент** (Ариун Сүмийг үз)

### **Иосеф Смит**

1820 оны хавар 14 настай Иосеф Смит Есүс Христийн үнэний Сүмийг хайж байхдаа “Харин та нарын хэн нэгэн нь мэргэн ухаанаар дутвал, бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч Бурханаас гуйг. Тэгээд түүнд өгөгдөх болно” (Иаков 1:5; Иосеф Смитийн Түүх 1:11–12-ыг үз) хэмээх Библийн нэг хэсгээс уншжээ. Энгийн тууштай итгэлтэйгээр залуу Иосеф Смит тэрхүү хэсэгт байсан зөвлөгөөг дагасан юм. Тэр ганцаар ямар сүмд нэгдэх ёстойгоо мэдэхээр залбирсан тэр газар болох моддын цоорхой луу явав. Түүний залбирлын хариуд Бурхан Эцэг, Есүс Христ хоёр түүн дээр хүрч иржээ. Түүнийг оршин байгаа сүмийн алинд ч нэгдэх ёсгүйг хэлжээ (Иосеф Смитийн Түүх 1:13–20-ийг үз).

Иосеф Смитийг зохистой байдлаа батлахад түүнд Бурханы бошиглогч байх бурханлиг үүргийг өгсөн юм. Түүгээр дамжуулан Их Эзэн Мормоны Номыг авчрах, санваар сэргээх, сайн мэдээний үнэт үнэнийг илчилсэн, Есүс Христийн үнэний Сүмийг зохион байгуулах, болон ариун сүмийн ажлыг үндэслэх агуу гайхамшигтай ажлыг бүтээсэн. 1844 оны зургадугаар сарын 27-нд Иосеф, түүний ах Хайрум хоёрыг зэвсэглэсэн дээрэмчид дайран алжээ. Тэд өөрсдийн гэрчлэлээ өөрсдийнхөө цусаар лацадсан юм.

Бүрэн дүүрэн болох сэргээгдсэн сайн мэдээний гэрчлэл тань Иосеф Смитийн тэнгэрлэг үүргийн гэрчлэлийг

агуулах ёстай. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн үнэн байдал нь Анхны Үзэгдэл хийгээд Их Эзэний Бошиглогч Иосефт өгсөн бусад илэрхийллүүдийн үнэн байдал дээр тулгуурладаг. Сүмийн гурав дахь Ерөнхийлөгч Жон Тейлор, “Их Эзэний Бошиглогч хийгээд Үзмэрч Иосеф Смит энэ дэлхийд хүмүүний авралын тулд, зөвхөн Есүс Христийг эс тооцвол үүн дээр амьдарч асан аль ч бусад хүнээс илүү ихийг хийсэн билээ” гэжээ (С ба Г 135:3).

Нэмэлт судрууд: Исаиа 29:13–14; 2 Нифай 3:3–15; С ба Г 5:9–10; 135; Иосеф Смитийн Түүх

Бошиглогчид; Сайн Мэдээний Сэргээлтийг мөн үз.

## Иргэний Засгийн Газар ба Хууль

Сургаал ба Гэрээний 134-р хэсэгт Хожмын Үеийн Гэгээнтнүүд “дэлхийн засгийн газрууд хийгээд хуулиудад нийтэд нь итгэх бидний итгэл” гэдгийг гарган үзүүлдэг (С ба Г 134, хэсгийн гарчиг). Тус хэсэгт дараах мэдэгдлүүдийг хамруулдаг:

“Засгийн газрууд хүмүүний ашиг тусын тулд Бурханаас үндэслэн байгуулагдсан гэдэгт бид итгэдэг; мөн нийгмийн сайн сайхан хийгээд аюулгүй байдлын төлөө хуулиуд боловсруулах хийгээд тэдгээрийг хэрэглэхийн аль алиентай нь холбогдуулан тэрээр хүмүүний ажил үйлсийн төлөө хариуцлага хүлээлгэхээр болгодог билээ. . . .

“Бүх хүмүүн өөрсдийн харьялагддаг холбогдох засгийн газруудыг дэмжиж, мөн туслах үүрэгтэй байхын сацуу, өөрсдийн зүй ёсны хийгээд салшгүй эрхүүдийг ийм засгийн газруудаар хамгаалуулах ёстай; ийнхүү хамгаалагдсан иргэн бүр үймээн самуунд өдеөн хатгагдах хийгээд бослого тэмцэлд нийцэшгүй бөгөөд зохих ёсоор шийтгэгддэг байх ёстай; мөн бүх засгийн газрууд

өөрсдийн шүүлтүүдийнхээ дагуу олон нийтийн ашиг со-нирхлыг дээд зэргээр хангахад ийм хуулиудыг хэрэгжүүлэх эрхтэй; гэсэн хэдий ч, үүний сацуу, ухамсрын ариун нандин эрх чөлөөг дээдлэх учиртай гэдэгт бид итгэдэг.

“Хүн бүр өөрийнхөө албан тушаалд, гэм зэмгүй хүмүүсийг хамгаалах хийгээд гэм буруутнуудыг цээрлүүлэхийн тулд захирагчид болон шүүгчид ч хүндэтгэгддэг байх ёстой гэдэгт бид итгэдэг, мөн бүх хүмүүн хуулиудыг дээдлэн мөн хүндэтгэх үүрэгтэй, тэдгээргүйгээр энх амгалан хийгээд ээ эв нь эмх замбараагүй явдал хийгээд аллагаар түрэгдэх болой; бидний ашиг сонирхлуудыг хувь хүмүүсийн хувьд хийгээд улс үндэстнүүдийн хувьд, хүн болон хүний хооронд зохицуулах зорилгыг илэрхийлэхийн тулд хүмүүний хуулиуд үндэслэгдэн бий болдог билээ; мөн тэнгэрээс өгөгддөг бурханлиг хуулиуд, сүнсний зүйлүүдийн дүрмүүд, итгэл болон шүтлэг аль алинд нь хүмүүнээр өөрийг нь Бий Болгогчид хариулагдахаар тодорхойлогддог гэдэгт бид итгэдэг” (С ба Г 134:1, 5–6).

Сүм хийгээд мужийн тусгаарлах болон үндсэн элемент нь шашны эрх чөлөөг олгох засгийн газрын хариуцлага юм. Хожмын үеийн бошиглогчид энэхүү зарчмыг Итгэлийн Тунхагийн 11-р хэсэгт өгүүлснээр: “Ухамсринхаа шаардлагын дагуу Бүхнийг Чадгч Бурханыг шүтэн бишрэх онцгой боломжийг бид шаардаж байна, мөн энэхүү онцгой боломжийг бүх хүмүүнд зөвшөөрч, хэрхэн, хаана, эсвээс юуг бишрэн шүтэх нь тэдний хэрэг гэж хүлээн зөвшөөрдөг” болохыг дэмждэг. Сүм хийгээд мужийн тусгаарлалтад нийцүүлэн, Сүм ямар нэгэн улс төрийн нам болоод нэр дэвшигчийг дэмждэггүй. Улс төрийн зорилгоор байшин барилгыг ашиглах хийгээд тохижуулахыг зөвшөөрдөггүй. Сүм нь улс төрд оролцдоггүй боловч хэлэлцэж үзэх ёс суртахууны асуудал байгаа үед үргэлж мэдэгдэл хийдэг.

Хэдийгээр Сүм улс төрийн хувьд төвийг сахьсан байдалтай байдаг боловч Сүмийн удирдагч гишүүдийг иргэдийн үүргийн дагуу оролцохыг хөхүүлэн дэмждэг. Хожмын Үеийн Гэгээнтэн хүний ёсоор та нар амьдарч буй улсынхаа өөрсдийн байр суурийг ойлгох хэрэгтэй. Улс орныхоо хууль ёс, өв уламжлал, түүхээс суралц. Хэрэв сонгууль өгөх, засгийн газрын үйл хэрэгт оролцох боломжтой бол эрх чөлөө, зөв шударга ёс, үнэний зарчмуудыг хамгаалж, дэмжихээр идэвхтэй оролц.

Нэмэлт судрууд: С ба Г 98:10; Итгэлийн Тунхаг 1:12

## Итгэл

“Итгэл бол бидний найддаг зүйлсийн бодит байдал, харагдахгүй зүйлсийн баталгаа мөн” хэмээн Төлөөлөгч Паул заажээ (Еврей 11:1). Алма мөн адил мэдэгдлийг хийсэн юм: “Хэрэв та нар итгэлтэй аваас та нар үнэн мөн үл харагдах зүйлүүдэд найдах болой” (Алма 32:21).

Итгэл бол үйл хийгээд хүч чадлын зарчим юм. Та зохистой зорилгын төлөө хөдөлмөрлөх бүртээ итэлээ хөгжүүлж байдаг. Та хараахан харж чадахгүй зүйлдээ найддагаа харуулдаг.

### Их Эзэн Есүс Христэд Итгэх нь

Таныг аврал руу хөтлөхөд таны итгэл Их Эзэн Есүс Христ дээр төвлөрөх ёстой (Үйлс 4:10–12; Мозая 3:17; Моронай 7:24–26; Итгэлийн Тунхаг 1:4-ийг үз). Та Түүнийг амьдардаг, Түүний зан харьцааны зөв болол хийгээд Түүний хүслийн дагуу амьдрахыг хичээж байгаа мэдлэгтэй байгаадаа итгэлтэй байхдаа Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлж чадна.

Есүс Христэд итгэх итгэлтэй байна гэдэг нь Түүнд бүрэн дүүрэн итгэх—Түүний хэмжээлшгүй их хүч, оюун ухаан болон хайранд итгэнэ гэсэн утгатай юм. Энэ нь

Түүний сургаалд итгэх итгэлийг бас хамруулдаг. Энэ нь та Түүний ойлгодог бүх зүйлсийг ойлгохгүй боловч итгэж байна гэсэн үг. Тэрээр таны бүхий л өвчин зовлон, шаналлыг туулсан учраас таныг өдөр тутмын тань бэрхшээлүүдээс хэрхэн сугарч гарахад туслахыг мэддэг гэдгийг сана (Алма 7:11–12; С ба Г 122:8-ыг үз). Тэрээр “ертөнцийг ялсан” (Иохан 16:33) бөгөөд таны мөнх амьдралыг хүлээн авах замыг бэлтгэсэн юм. Та Түүний гүйлтийг санаж чадваас тэр үргэлж чамд туслахад бэлэн байдал: “Санаа бодол болгондоо над руу харагтуун; бүү эргэлз бүү ай” (С ба Г 6:36).

### Итгэлээр Амьдрах нь

Итгэл нь ажил хэрэг болгодоггүй итгэлээс хэд дахин илүү юм. Та итгэлээ амьдарч байгаа байдал—үйлдлээрээ дамжуулан илэрхийлдэг.

Аврагч “хэрэв та нар надад итгэлтэй байх аваас та нар миний хувьд зохистой болох аливаа зүйлийг хийх хүчтэй байх болно” хэмээн амласан (Моронай 7:33). Есүс Христэд итгэх итгэл таныг түүний төгс жишээг дагахад зорижжуулж чадна (Иохан 14:12-ыг үз). Итгэл тань сайн үйлс бүтээх, зарлигуудыг дагах болон нүглээ наманчлажад хөтөлж чадна (Иаков 2:18; 1 Нифай 3:7; Алма 34:17-г үз). Итгэл тань уруу таталтыг даван туулахад тусалж чадна. Алма хүү Хиламандаа “тэдэнд чөтгөрийн уруу таталт болгоныг, Их Эзэн Есүс Христэд итгэх өөрсдийн итгэлээр сөрөн зогсохыг заа” хэмээн зөвлөсөн (Алма 37:33).

Их Эзэн итгэлийн тань дагуу амьдралд тань хүчтэй гайхамшигуудыг бүтээх болно (2 Нифай 26:13-ыг үз). Есүс Христэд итгэх итгэл нь Түүний Цагаатгалаар сүнсний болон бие махбодын илааршлыг хүлээн авахад тусалдаг. Сорилтын цаг тулгарахад бэрхшээлтэй урам зоригтойгоор нүүр тулж, урагш алхах хүч чадлыг итгэл танд өгч чадна. Тэр ч байтугай ирээдүй тодорхой бус санагдахад

Аврагчид өгсөн итгэл тань танд амар амгаланг өгч чадна (Ром 5:1; Хиламан 5:47-г үз).

### Итгэлээ Хөгжүүлэх нь

Итгэл бол Бурханаас ирдэг бэлэг боловч итгэлээ улам бат бөх байлгахын тулд арчилж тордох ёстай. Итгэл бол яг л гарын тань булчинтай адил байдаг. Хэрэв та хөгжүүлвэл энэ нь улам хатуу болдог. Хэрэв булчингаа дээш нь сойгоод орхивол унжийсан сул болдог.

Итгэлийн бэлгийг Тэнгэрлэг Эцэгт хандан Есүс Христийн нэрээр залбирснаар тордож чадна. Та Эцэгтээ талархлаа илэрхийлж, Түүнээс өөртөө болон бусдад хэрэгтэй адислалыг гүйвал Түүнд ойртон очих болно. Та Цагаатгал нь нигүүлслийн төлөө залбирахыг танд боломжтой болгож өгсөн Аврагч руу ойртон очих болно (Алма 33:11-ийг үз). Та мөн Ариун Сүнсний намуухан удирдамжийг хүлээн авах чадвартай байх болно.

Зарлигуудыг сахиснаар өөрсдийн итгэлээ хөгжүүлж чадна. Бурханаас авсан бүхий л адислалуудын адил итгэлийг хувийн дуулгавартай байдал болон зөв шударга үйлдлээр дамжуулан олж авч, мөн өсгөж болдог. Хэрэв та итгэлээ боломжтой гэх хамгийн өндөр түвшинд хүргэн хөгжүүлэн баяжуулахыг хүсдэг бол байгуулсан гэрээнүүдээ сахих ёстой.

Та итгэлээ судруудаас болон хожмын үеийн бошиглогчдын үгсээс суралцан хөгжүүлж чадна. Бурханы үг итгэлийг хүчтэй болгоход тусалдаг хэмээн бошиглогч Алма сургажээ. Үгийг үртэй харьцуулан тэрээр “итгэх хүсэл” нь таныг “зүрх сэтгэлд тань суулгагдах” үгэнд “зай тавьж өгөхөд” хөтөлж болохыг хэлжээ. Дараа нь, бодгалийг тань баяжуулж, ойлголтыг тань тэлж эхлэх учраас уг үгс сайн гэдгийг та мэдрэх болно. Энэ нь итгэлийг тань хүчирхэгжүүлэх болно. Та нар үгийг зүрхэндээ тасралтгүй тордвол “агуу их шаргуу итгэл мөн тэвчээрээр түүнийг хүсэн

## **Итгэлийн Тунхаг**

хүлээх аваас, энэ нь үндэслэх болно; мөн болгоогтун энэ нь үүрдийн амьдралд хүргэх мод байх болно” (Алма 32:26–43-ыг үз).

Нэмэлт судрууд: Еврей 11; Иаков 1:5–6; 2:14–26; Ифэр 12:4–27; Моронай 7:20–48; С ба Г 63:7–11; 90:24

Баптисм; Бурхан Эцэг; Есүс Христ; Наманчлалыг мөн үз.

## **Итгэлийн Тунхаг**

Итгэлийн Тунхаг нь, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүдийн дунд бий болсон итгэл бишрэлийн 13 үндсэн зүйлийг илэрхийлдэг. Бошиглогч Иосеф Смит анх удаагаа тус Сүмийн гишүүд юунд итгэдгийг мэдэхийг хүссэн сонины редактор ноён Вентвордийн хүсэлтийн дагуу эдгээрийг хариулт болгон Жон Вентвордод явуулах захидалдаа бичсэн. Энэ нь хожим Сүмийн тогтмол хэвлэлд хэвлэгджээ. Итгэлийн Тунхагийг судар хэмээн үздэг ба энэ нь Агуу Үнэт Сувд дотор байдаг.

**Их Эзэний Сүнс** (Ариун Сүнс; Христийн Гэрлийг үз )

**Кофе** (Мэргэн Ухааны Үгийг үз)

## **Мацааг Барилт ба Мацгийн Өргөлүүд**

Мацааг барина гэдэг нь тодорхой хугацаанд сайн дураараа хоол, ундгүй байхыг хэлнэ. Мацааг барилтыг чин сэтгэлийн залбиралтай хослуулбал та болон бусад хүмүүс Бурханы адислалуудыг хүлээн авч чадна.

Мацааг Барилтын Зорилго

Нэгэн удаа Аврагч чөтгөрийг хүүхдээс зайлцуулж, энэхүү зарлигийг Өөрийн шавь нартаа залбирал болон

мацаг барилтын хүчний тухай заахдаа хэрэглэжээ. Шавь нар нь Түүнээс “бид яагаад түүнийг хөөн гаргаж чадсан-гүй вэ?” гэж асуухад Есүс “итгэл чинь бага учраас, Хэрэв та нарт гичийн үр төдийхөн итгэл байвал, энэ ууланд “эндээс тийшээ нүүр” гэж хэвлэл тэр нь нүүнэ. Та нарт боломжгүй юм гэж байхгүй болно. Гэвч энэ төрлийн чөтгөр нь мацаг барилт, залбирлаар л гардаг юм” гэж айлдажээ (Матай 17:14–21-ийг үз).

Энэхүү шастир нь залбирал болон мацаг барилтыг санваарын адислалыг өгч байгаа мөн хүлээн авч байгаа тэдэнд нэмэлт хүч чадал өгдөг гэдгийг зааж байна. Энэхүү шастирыг сайн мэдээгээр амьдрах хувийн идэвх чармайлтдаа хамруулж болно. Хэрэв танд даван туулахаар тэмцэлдэж байгаа алдаа дутагдал буюу нүгэл байвал хүсч байгаа уччлал эсвэл тусlamжийг хүлээн авахад тань залбирал болон мацаг барилт хэрэгтэй болно. Таны бэрхшээл Христийн хөөн зайлцуулсан чөтгөртэй адил зөвхөн залбирал хийгээд мацаг барилтаар л арилах болно.

Та олон янзын зорилгоор залбирч болно. Мацаг барилт нь Бурханыг шүтэн бишрэх болон Түүнд талархлаа илэрхийлэх нэг арга юм (Лук 2:37; Алма 45:1-ийг үз). Та Тэнгэрлэг Эцэгээс өвчтэй мөн зовж шаналсныг адислахыг хүсч мацаг барьж болно (Матай 17:14–21-ийг үз). Мацаг барилт нь танд болон таны хайрладаг тэдэнд хувийн илэрхийлэлтийг хүлээн авахад мөн үнэнд хөрвүүлэгдэхэд нь тусалж болно (Алма 5:46; 6:6-г үз). Та мацаг барилтаар уруу таталтыг эсэргүүцэх хүч чадлыг олж авч болно (Исаиа 58:6-г үз). Та өөрийгөө Бурханы өмнө даруусгах, Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэхийг хичээн мацаг барьж болно (Омнай 1:26; Хиламан 3:35-ыг үз). Та сайн мэдээг хуваалцах удирдамж хүлээн авах, эсвэл Сүмийн дуудлагуудыг эрхэмлэн биелүүлэхээр мацаг барьж болно (Үйлс 13:2–3; Алма 17:3, 9; 3 Нифай 27:1–2-ыг

## *Мацаг Барилт ба Мацгийн Өргөлүүд*

үз). Мацаг барилт нь зөв шударга, уй гашуу, эсвэл гунигтай дагалдаж болно (Алма 28:4–6; 30:1–2-ыг үз).

### **Мацаг Барилтын Ням Гараг**

Сүм сар бүрийн нэг Ням гарагийг, ихэвчлэн нэг дэх Ням гарагийг мацаг барилтын өдөр болгон тогтоосон. Зөв мацаг барилтын Ням гарагт дараалсан хоёр хоолгүйгээр мацаг барилтын болон гэрчлэлийн цуглаануудад оролцон, хэрэгцээ гарсан хүмүүсийг анхаарч халамжлан, мацаг барилтын өргөлийг өгөх зэрэг зүйлүүд ордог.

Таны мацаг барилтын өргөл дор хаяж өөрийн тань идээгүй хоёр хоолны үнэтэй тэнцэхээр байх нь зүйтэй. Хэрэв боломжтой бол энэхүү үнийн дүнгээс илүүг харамгүйгээр өг.

Сүмийн ахлагч нарын тогтоосон мацаг барилтын өдрүүдээс гадна өөрсдөө өөр өдөр, өөрийн болон бусдын хэрэгцээний дагуу мацаг барьж болно. Гэхдээ ойр, ойрхон буюу хэт урт хугацаагаар мацаг барьж болохгүй.

### **Жинхэнэ Мацаг Барилт**

Есүс Уулан дээрх Номлолд мацаг барилтын жинхэнэ аргыг заажээ. Мацаг баригч хоёр нүүр гаргагчдын эсрэг хэлэхдээ “тэд мацаг барьж байгаага хүмүүст харуулахын тулд нүүр царайгаа барайлгадаг байна.” Зөв шударга байдлаа гаднаа харуулахын оронд та залбирахдаа “Ингэснээр тэд мацаг барьж байгаага хүмүүст харуулахгүй, харин нууцаар оршигч Эцэгтээ харуулна. Тэгээд нууцаар хардаг Эцэг тань танд буцааж төлнө” (Матай 6:16–18).

Бошиглогч Исаиа мөн мацаг барилтын жинхэнэ мөн чанарын талаар заахдаа: “Нүгэл хилэнцийн хүлгийг мултлан, буулганы оосрыг тайлан, дарлагдагсдыг

чөлөөлж, аливаа буулгыг эвдэхийн тулд мацаг барилтыг би сонгосон бус уу? Өлсгөлөн нэгэнтэй талхаа хуваан, орон гэргүй ядуусыг гэртээ оруулан, нүцгэн нэгнийг хараад хувцаслаж, өөрийн цусан төрлөөс нуугдахгүй байх бус уу?” гэжээ (Исаиа 58:6–7).

Исаиа мөн мацаг барилтын хуулийг дагаснаар ирэх адислалуудыг гэрчилсэн: “Тэгвэл чиний гэрэл үүрийн гэгээ шиг цацарч, чиний эдгэрэлт үтэр түргэн болж, чиний үнэн зөв өмнө чинь явж, Эзэний цог жавхлан чиний арын хамгаалалт болно. Тэгээд чамайг дуудахад Эзэн хариулж, чамайг хашгирахад Тэр би энд байна гэж айлдана. Хэрэв та дундаасаа буулгыг зайлцуулж, хуруугаараа чичлэн зэрлэг балмад яриагаа боливол, хэрвээ чи өлсөгчдөд өөрийгөө өгч зовогсдын сэтгэлийг цатгавал, чиний гэрэл нь харанхуйд мандаж, чиний бүрхэг бүүдгэр нь үд дунд мэт байх болно. Эзэн ямагт удирдан, хатсан газарт чиний хүслийг хангаж чиний ясанд тэнхээ өгнө. Чи усалсан цэцэрлэг мэт, ширгэшгүй ундаргатай булаг мэт байх болно” (Исаиа 58:8–11).

Нэмэлт судрууд: 3 Нифай 13:16–18; С ба Г 59:12–14; 88:76, 119

Залбирлыг мөн үз.

## Мелкизедек Санваар

“Сүмд хоёр санваар, нэрлэвэл Мелкизедек болон Аароны Санваар буй” (С ба Г 107:1). “Бурханы Хүүгийн дэг жаягийн дагуух” Мелкизедек Санваар нь (С ба Г 107:3) үүний хамгийн агуу нь юм. Энэ нь “ерөнхийлөн удирдах эрхийг атгадаг бөгөөд сүм дэх бүх албан тушаалуудад байдаг” (С ба Г 107:8). Энэ нь түүнчлэн “сүмийн бүх адислалуудын түлхүүрүүдийг атгадаг” (С ба Г 107:18). Энэ нь бошиглогч Абрахамын үед амьдарч байсан дээд сан-

## *Мелкизедек Санваар*

ваартнаар нэрлэгдсэн юм (С ба Г 107:2–4; мөн Алма 13:14–19-ийг үз).

Сүмийн удирдагчид Мелкизедек Санваарын эрх мэдлээр дамжуулан сүмийг удирдаж, дэлхий даяар сайн мэдээг номлох ажлыг чиглүүлдэг. Мелкизедек Санваарын ёслолуудад “бурханлиг чанарын хүч илэрхийлэгддэг” (С ба Г 84:20).

Энэ агуу санваар нь Адамд өгөгдсөн бөгөөд Их Эзэний сайн мэдээгээ илчилсэн дэлхийн аль ч хэсэгт байсаар байна. Энэ нь Агуу Урвалтын үед авагдсан боловч 1829 оны Тавдугаар сард Төлөөлөгч Петр, Иаков, Иохан нар Иосеф Смит, Оливер Каудери хоёрыг томилох үед сэргэжээ.

Мелкизедек Санваарын албан тушаалууд нь Төлөөлөгч, Дал, патриарх, дээд санваар мөн ахлагч нар юм. Дээд Санваарын Ерөнхийлөгч нь Сүмийн Ерөнхийлөгч юм (С ба Г 107:64–66-г үз).

Сүмийн эрэгтэйчүүд ариун сүмийн индаументийг хүлээн авч мөн гэр бүлтэйгээ мөнхөд лацдан холбуулахын тулд зохистой Мелкизедек санваар атгагчид байх ёстай. Тэдэнд өвчтөнийг адислах, гэр бүлийн гишүүд мөн бусад онцгой адислал өгөх эрх мэдэл байдаг. Тэд тэргүүлэх санваарын удирдагчдын эрх мэдлээр Ариун Сүнсний бэлгийг өгч, бусад зохистой эрэгтэйчүүдийг Аароны болон Мелкизедек Санваарын албанд томилдог.

Эрэгтэй хүн Мелкизедек Санваарыг хүлээн авахдаа санваарын гэрээ хийгээд амлалтыг өгдөг. Тэр дуудлагаа эрхэмлэн биелүүлж, итгэлтэй байхаар гэрээлдэг, “мөнх амьдралын үгсэд хичээнгүйлэн анхаарал хандуулдаг”, мөн Бурханы амнаас урагш гардаг үг бүрээр амьдрах ёстай. Энэ гэрээг сахьдаг хүмүүс Сүнсээр ариусгагдаж, ‘Эцэгт байгаа бүхнийг өвлөн авах болно’ (С ба Г 84:33–44-ийг үз).

Аароны Санваар; Санваарыг мөн үз.

## Мормоны Ном (Судруудыг γз)

### Мөнх Амьдрал

“Учрыг болгоогтун, үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах нь миний ажил мөн миний алдар суу бөлгөө” хэмээн Их Эзэн тунхагла-жээ (Мосе 1:39). Үхэшгүй байдал гэдэг нь амилуулагдсан биет байдлаараа мөнхөд амьдрахыг хэлнэ. Хүн бүр Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан энэхүү бэлгийг хүлээн авна. Мөнх амьдрал буюу өргөмжлөл гэдэг нь бид Бурханы оршихуйд амьдрах болон гэр бүлээрээ байх тэрхүү сэлэстиэл хаант улсын хамгийн дээд түвшинд амьдрах амьдралыг өвлөн авна гэсэн үг юм (С ба Г 131:1-4-ийг γз). Энэ бэлгийг үхэшгүй байдалтай адил Есүс Христийн Цагаатгалаар боломжтой болгосон юм. Гэсэн хэдий ч энэ нь биднийг “сайн мэдээний хуулиуд хийгээд ёслолуудад дуулгавартай байхыг” шаарддаг (Итгэлийн Тунхаг 1:3).

### Мөнх Амьдралд Хүрэх Зам дээр Үлдэх нь

Та нар баптисм хүртээд Ариун Сүнсний бэлгийг хүлээн авсны дараа мөнх амьдрал уруу хөтлөх зам дээр гарсан билээ. Бошиглогч Нифай заахдаа:

“Та нарын орох ёстой хаалга нь наманчлал мөн баптисм болой; мөн тэгээд Ариун Сүнсээр мөн галаар та нарын нүглүүдийн ангижрал ирэх болой.

“Мөн чингээд та нар энэ мөнх амьдралд хүргэдэг давчуу бөгөөд нарийн замд байх болой; тийм ээ, та нар хаалгаар орсон бөлгөө; та нар Эцэг мөн Хүүгийн зарлигуудын дагуу хийсэн буюу; мөн хэрэв та нар уг замаар орвол та нар хүлээж авна хэмээн түүний өгсөн амлалт нь гүйцэлдэж, та нар Эцэг мөн Хүүг гэрчилдэг тэр Ариун Сүнсийг хүлээж авсан” гэжээ (2 Нифай 31:17-18).

Энэхүү “нарийн бөгөөд шулуун замаар” орсны дараа бид итгэлээрээ эцсээ хүртэл тэвчих ёстойг Нифай онцлон хэлсэн:

“Та нар энэ давчуу бөгөөд нарийн замд орсны дараа, бүгд хийгдсэн эсэхийг би асууя? Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй; учир нь аврах чадал бүхий түүний гавьяанд та нар бүрэн дүүрэн даатган, түүнд хэлбэрэлтгүй итгэл-тэйгээр Христийн үгсээр бус аваас өдий зэрэгт хүрээгүй билээ.

“Иймийн тул, та нар найдварын төгс гэрэлтэйгээр, мөн Бурханыг болон бүх хүмүүсийг хайрлах хайрыг агуулан Христэд тууштайгаар итгэн урагш тэмүүлэх ёстой. Иймийн тул, хэрэв та нар урагш тэмүүлэн, Христийн үгнээс зооглон, мөн эцсээ хүртэл тэвчих аваас, болгоогтун Эцэгийн тийн хэлсэнчлэн, та нарт мөнх амьдрал байх болно” (2 Нифай 31:19–20).

Одоо та баптиسم хүртэж, баталгаагаа авсан тул мөнх амьдрал өөд хүрэх өсөлтийн тань ихэнх нь хүлээн авч байгаа бусад авралын ёслолуудаас тань хамаарна: эрэгтэйчүүдэд Мелкизедек Санваарын томилолт; эрэгтэй, эмэгтэйчүүдэд ариун сүмийн индаумент болон гэрлэлийн лацдан холболт. Та эдгээр ёслолуудыг хүлээн аван тэднийг дагалдах гэрээнүүдээ сахих үед өөрийгөө сэлэстиэл алдар суугийн хамгийн дээд түвшинг өвлөхөд бэлдэнэ.

### Олж Авч Болохуйц Зүйл

“Нарийн ба шулуун замын” талаар өөрийнхөө өсөлт хөгжилтийг тунгаан бодож үзэхдээ мөнх амьдрал бол хүрч болохуйц юм гэдгийг ойлго. Их Эзэн таныг Түүн рүү эргэн очихыг хүсч байгаа бөгөөд Тэр хэзээ ч таны гүйцэтгэж чадахгүй ямар ч зүйлийг шаарддаггүй. Түүний бүхий л зарлигууд нь та нарын аз жаргалыг дэмжихэд чиглэгдсэн билээ. Та нар итгэлээ хөгжүүлж, түүнд бүх чадлаараа

үйлчилвэл Тэр хүч чадал өгч, Түүний зарлигласан болгоныг хийх замыг өгдөг (1 Нифай 3:7-г үз). Та агуу их хичээл зүтгэлээ өгч, нүглээ наманчилвал Есүс Христийн Цагаатгал таны амьдралдаа туулах сул тал, алдас мөн овчин зовлонг тань нөхөн төлөх болно гэдгийг санагтун: “Ач ивээллээр л бид аврагдана гэдгийг мэд, бидний хийж чадах бүхний дараа буюу” (2 Нифай 25:23).

Нэмэлт судрууд: Иохан 3:16; 17:3; 2 Нифай 9:39; Моронай 7:41; С ба Г 14:7; 50:5

Алдар Суугийн Хаант Улсууд; Ач Ивээл; Есүс Христийн Цагаатгалыг мөн үз.

## **Мөрийтэй тоглох нь**

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм нь мөрийтэй тоглох, түүнчлэн засгийн газраас санхүүжүүлдэг сугалааны эсрэг байдаг.

Мөрийтэй тоглох нь юу ч төлөлгүйгээр ямар нэгэн юм авах хүслийг бадраадаг. Энэхүү хүсэл нь сүнслэг байдлын хувьд хөнөөлтэй юм. Энэ нь оролцогчдыг Аврагчийн хайр хийгээд үйлчлэлийн заасан зүйлсээс хөндийрүүлж, бусармаг зүйлийн хувия хичээсэн байдал руу хөтөлдөг. Энэ нь арвич хямгач байдал болон сайн үйлс, бидний хийж гүйцэтгэдэг бүх зүйлд шударга идэвх чармайлтыг үзүүлэх хүслийг дордуулдаг.

Мөрийтэй тоглоомд оролцдог тэдгээр хүмүүс бага зүйлийг, эсвэл юу ч өгөлгүйгээр, хариуд нь үнэ бүхий зүйл авна гэсэн тэрхүү санаа нь хуурмаг байдгийг удахгүй мэдэж авдаг. Тэд их хэмжээний мөнгө, өөрсдийн нэр төр, гэр бүлийнхэн болон найз нохдийнхөө хүндэтгэлийг алддаг гэдгээ ухаардаг. Хууртагдаж, донтсон тэд өөр зорилгод, жишээлбэл гэр бүлийнхээ хэрэгцээг хангахад хэрэглэж болох мөнгөөрөө мөрийтэй тоглодог. Мөрийтэй тоглогчид сайн нэрээ алдан, хулгай хийхэд

## **Мэргэн Ухааны Үг**

хүрдэг тул заримдаа мөрийтэй тоглож алдсан өрөө төлөхдөө боолчлолд байдаг бөгөөд үнэхээр цөхрөнгө байдалд ордог.

Тэргүүн Зөвлөл биднийг манай нийгэмд мөрийтэй тоглох ямарваа нэг хэлбэрийн хууль ёсны болон засгийн газрын санхүүжилтэй байгууллагуудын эсрэг бусадтай хамтран зогсохыг дэмжсээр ирсэн юм.

Уруу Таталтыг мөн үз.

## **Мэргэн Ухааны Үг**

Мэргэн Ухааны Үг нь Их Эзэний бидний бие махбодь болон сүнслэг ач тусын тулд илчилсэн эрүүл мэндийн хууль юм. Сургаал ба Гэрээний хэсэг 89-т тэмдэглэсэн энэхүү илчлэлд Их Эзэн ямар хоол хүнс идэхэд сайн, ямар зүйлс бидний бие махбодид сайн биш гэдэг талаар өгүүлдэг. Тэрээр Мэргэн Ухааны Үгийг дагаснаар сүнслэг болон бие махбодийн адислалыг амладаг.

Мэргэн Ухааны Үгэнд Их Эзэн биднийг дараах зүйлсийг хэрэглэхгүй байхыг зарлигладаг:

- Спиртийн төрлийн ундаанууд (С ба Г 89:5–7-г үз).
- Тамхи (С ба Г 89:8-ыг үз).
- Цай болон кофе (С ба Г 89:9; хожмын үеийн бослоглогчид “халуун ундаа” цай болон кофег авч үздэг тухай заасан) .

Хүмүүс санаатайгаар бие махбодидоо хэрэглэдэг аливаа хортой зүйл нь Мэргэн Ухааны Үгтэй нийцдэггүй. Энэ хууль бус мансууруулах бодис нь өөрт нь донтсон хүмүүсийг сүйтгэж чаддаг. Эдгээрээс бүрмөсөн хол бай. Үүнийг бүү сонирх. Эмийг их хэмжээгээр хэрэглэх нь донтуулах мөхөлд мөн хотөлдөг.

Их Эзэн дараах хоол хүнс нь бие махбодид сайн хэмээн тунхаглажээ:

- Ургамал болон жимс болгоныг “ухаалгаар хийгээд талархалтайгаар” ашиглах ёстой (С ба Г 89:10–11-ийг үз).
- “Амьтад хийгээд агаарын жигүүртнүүдийн махыг арвич хямгачаар ашиглах ёстой” (С ба Г 89:12–13-ыг үз).
- Улаан буудай, эрдэнэ шиш, хөх тариа зэрэг үр тариа нь “амьдралын тулгуур” байна (С ба Г 89:14–17-г үз).

Мэргэн Ухааны Үгийг Сахиснаар Ирэх Адислалууд

Мэргэн Ухааны Үгийг сахисан тэдэнд Их Эзэн амлахдаа:

“Зарлигуудад дуулгавартай байдалд алхан, эдгээр айлдваруудыг санаж мөн хэрэгжүүлдэг бүх гэгээнтнүүд хүйсэндээ эрүүл энхийг хийгээд яснууддаа чөмөг хүлээн авах болно;

“Мөн мэргэн ухаан хийгээд мэдлэгийн агуу сан хөмрөгүүдийг, бүр нуугдмал сан хөмрөгүүдийг олж авах болно;

“Мөн гүйхэд мөн ядрах нь үгүй, мөн алхахад мөн цуцах нь үгүй байх болно.

“Мөн устгагч тэнгэр элч, Израилын хүүхдүүдийн дэргэдүүр өнгөрсний адил тэдний дэргэдүүр өнгөрч, мөн тэднийг хөнөөхгүй байх болно хэмээх амлалтыг Их Эзэн бибээр тэдэнд өгч байна” (С ба Г 89:18–21).

Донтолтыг Даван Туулах нь

Хамгийн сайн арга бол Их Эзэний Мэргэн Ухааны Үгэнд хориглодог зүйлсээс бүрмөсөн хол байх явдал юм.

## **Мянган Жил**

Гэхдээ та хэрэв эдгээр зүйлсийн аль нэгэнд донтсон бол та тэдгээрээс ангижирч чадна. Та хувийн оролдлого, Их Эзэний үзүүлж буй хүч, гэр бүл, найз нөхдийн тусlamж болон Сүмийн удирдагчдаас удирдамж авснаар дамжуулан тэрхүү донтуулагч зүйлсийг давж гарч чадна.

Тусlamжийн төлөө залбир, хэт хорхойтсоноос болох уруу таталтуудыг эсэргүүцэхийн тулд өөрийн хүчээрээ бүхнийг хий. Таны Тэнгэрлэг Эцэг таныг Мэргэн Ухааны Үгийг хадгалснаар ирэх адислалыг хүлээн авахыг хүсч байгаа ба Тэрээр таныг үүнийг хийх таны чин сэтгэлийн идэвх чармайлтанд чинь хүчирхэгжүүлнэ.

Нэмэлт судрууд: С ба Г 49:19–21; 59:15–20; 88:124; 89:1–4

Мөн Дуулгавартай Байдал; Уруу Таталтыг үз.

## **Мянган Жил**

Нэг мянган жил гэдэг нь 1000 жилийн хугацааг хэлнэ. Бид “Мянган Жилийн” тухай ярихдаа 1000 жилийг Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн дараах хугацаатай холбож үздэг (Илчлэлт 20:4; С ба Г 29:11-ийг үз). Мянган жилийн турш “Христ дэлхий дээр хувиараа хаанчлах болно” (Итгэлийн Тунхаг 1:10).

Мянган Жил дэлхий дээрх зөв шударга байдал хийгээд амар амгалангийн хугацаа байх болно. “Тэр өдөр хүмүүний дайсагнал, мөн амьтдын дайсагнал, тийм ээ, бүх махан бодын дайсагнал байхгүй болно” хэмээн Их Эзэн илчилжээ (С ба Г 101:26; Исаиа 11:6–9-ийг мөн үз). Сатан хүмүүний үрсийн зүрх сэтгэлд байргүй байхын тулд хүлэгдэх болно (С ба Г 45:55; Илчлэлт 20:1–3-ыг мөн үз).

Мянган Жилийн турш дэлхий дээр бүх хүмүүс сайн, шударга байх боловч ихэнх нь сайн мэдээний бүрэн байдлыг хүлээн авахгүй байх болно. Иймд Сүмийн гишүүд номлолын ажилд оролцох болно.

Сүмийн гишүүд мөн мянган жилийн турш ариун сүмийн ажилд оролцно. Уг Гэгээнтнүүд ариун сүм барихаар болон нас барсан эцэг өвгөдийнхөө өмнөөс ёслолуудыг үргэлжлүүлэн хүлээн авах болно. Тэд илэрхийлэлтээр удирдагдан өвөг дээдсийнхээ, бүр Адам Ева хоёроос эхлэн тэдний цэдгийг бэлтгэх болно.

1000 жилийн төгсгөл хүртэл, Сатан “өөрийн их цэргийг хамтад нь цуглувулж болохын тулд тэрээр багахан хугацаанд суллагдах” хүртэл бүрэн дүүрэн зөв шударга байдал, амар амгалан байдал үргэлжлэх болно. Мөн Михайл буюу Адамаар удирдуулсан тэнгэрийн их цэргийн эсрэг Сатаны их цэрэг тулалдах болно. Сатан болон түүний дагалдагчид ялагдаж мөн үүрд хаягдах болно (С ба Г 88:111–115-ыг үз).

Нэмэлт судрууд: С ба Г 45:55–59; 101:22–34; 133:25

Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийг мөн үз.

## Найдвар

Бид заримдаа *найдвар* хэмээх үгийг буруугаар ойлгодог. Бидний өдөр тутмын хэл ярианд уг үг нь тодорхой бус хоёрдмол утга санаагаар илэрдэг. Жишээ нь, цаг агаар өөрчлөгднө гэж найдаж байна, эсвэл найдж маань зочилно гэж найдаж байна гэж бид хэлж болно. Сайн мэдээний хэлэнд *найдвар* хэмээх үг нь лавтай, хөдөлшгүй, идэвхтэй мөн чанарыг харуулдаг. “Гүйвшгүй найдлага” (Алма 34:41) болон “амьд найдвартай” (1 Петр 1:3) бай хэмээн бошиглогчид заадаг. Бошиглогч Моронай “Иймийн тул, Бурханд итгэх хэн боловч, илүү сайн ертөнцөд лавтайя найдаж болно, тийм ээ, Бурханы баруун гар талд байх нэгэн байхын тулд буюу, уг найдвар нь итгэлээр ирж, хүмүүсийн бодгальд зангуу болдог тэр нь, тэднийг тууштай мөн хөдөлшгүй сайн үйлээр үргэлж дүүрэн, бас

## *Найдвар*

Бурханыг алдаршуулахад удирдагдах болгодог” хэмээн заажээ (Ифэр 12:4).

Найдвартай байхдаа бид Бурханы амлалтанд итгэдэг. Бидэнд хэрэв бид “зөв шударгын үйлсүүдийг” хийвэл “Энэ дэлхийд амар амгалан хийгээд ирэх дэлхийд мөнх амьдралыг хүлээн авах болно” гэсэн баттай итгэл байдаг (С ба Г 59:23). Иймэрхүү найдвар зөвхөн Есүс Христийн Цагаатгалаар дамжин ирдэг гэдгийг Мормон заасан: “Мөн та нар юуны тул найдах билээ? Болгоогтун, та нар Христийн Цагаатгалаар, мөн түүний амилуулалтын хүчээр мөнх амьдралд босгогдохын тулд найдахыг би та нарт хэлнэ, мөн энэ нь амлалтын дагуу түүнд итгэлтэйн тань учир болой” (Моронай 7:41).

Та сайн мэдээгээр амьдрахыг хичээхдээ “Ариун Сүнсний хүчээр та нар найдвараар бялхсан” чадвартaa осно (Ром 15:13). Та залбирч, Бурханы өршөөлийг эрэлхийлэх аваас найдвар дотроо осно. Мормоны Номонд Аарон хэмээх нэгэн номлогч Лэмэнчүүдийн хаанд итгүүлдэг. “Хэрэв та бүх нүглүүдээ наманчилвал, мөн Бурханы өмнө дооши бөхийвөл, та хүлээн авах болно гэдэгтээ найдсаар, мөн итгэлтэйгээр түүний нэрийг дуудвал, тэгвэл та хүссэнээ авах болно” (Алма 22:16). Та мөн судраас суралцан тэдний сургаалуудыг дагавал найдварыг олно. Төлөөлөгч Паул “учир нь эрт үед бичигдсэн аливаа зүйлс нь биднийг сургахын тулд бичигдсэн юм. Ингэснээр Судруудын тэвчээр болон урамшуулалтаар дамжуулан бидэнд найдвар байх юм” гэжээ (Ром 15:4).

Найдварын зарчим нь мөнх оршихуйд үргэлжилдэг боловч энэ нь танд өдөр тутмын амьдралын тань бэрхшээлүүдээр дамжуулан дэм өгөх болно. “Иаковын Бурханыг өөрийн тусламж болгон, өөрийн Бурхан Эзэнд найдагчид юутай ерөөлтэй вэ” хэмээн Дууллын зохиогч бичжээ (Дуулал 146:5). Найдвартайгаар амьдралдаа та баяр баяслыг олж чадна. Та “Та нар тэвчээртэй

байж, мөн та нар нэгэн өдөр өөрсдийн бүх зовлонгуудаас амарна гэсэн гүйвшгүй найдлагатайгаар тэдгээр зовлонг тэвчиж” чадна (Алма 34:41). “Та нар найдварын төгс гэрэлтэйгээр, мөн Бурханыг болон бүх хүмүүсийг хайрлах хайрыг агуулан Христэд тууштайгаар итгэн урагш тэмүүлэх ёстой. Иймийн тул, хэрэв та нар урагш тэмүүлэн, Христийн үгнээс зооглон, мөн эцсээ хүртэл тэвчих аваас, болгоогтун, Эцгийн тийн хэлсэнчлэн: та нарт мөнхийн амьдрал” байх болно (2 Нифай 31:20).

Нэмэлт судрууд: Иеремиагийн Гашуудал 3:25–26; 1 Коринт 15:19–22; 1 Петр 3:15; 1 Иохан 3:2–3; Иаков 4:4–6; Алма 13:28–29; 27:28; Ифэр 12:32; Моронай 8:26; 9:25; 10:22

Есүс Христийн Цагаатгал; Итгэл; Мөхөл; Энэрэлийг мөн үз.

## Наманчлал

Наманчлал нь сайн мэдээний анхны зрчмуудын нэг юм (Итгэлийн Тунхаг 1:4-ийг үз). Энэ нь энэхүү амьдралд хийгээд мөнх оршихуй дахь таны аз жаргалд зайлшигүй хэрэгцээтэй юм. Наманчлал нь буруу зүйлээ ухаарснаас илүү чухал билээ. Энэ бол Бурханы, өөрийн тухай хийгээд дэлхий ертөнцийн тухай шинэ үзэл бодол өгөх бодол санаа болон зүрх сэтгэлийн өөрчлөлт юм. Нүглийн ангижрал болон учлал эрэхээр Бурханд хандахыг хэлнэ. Бурханыг хайрлах хайр мөн Түүний зарлигуудыг дагах чин сэтгэлийн хүсэл л урам зориг оруулдаг.

## Наманчлалын Хэрэгцээ

“Цэвэр бус нэг ч зүйл тэнгэрийн хаант улсыг өвлөж чадахгүй” хэмээн Их Эзэн тунхаглажээ (Алма 11:37). Нүгэл таныг Тэнгэрлэг Эцгийн оршихуйд буцан очиход цэвэр бус—зохисгүй болгодог. Мөн энэ амьдралд бодгальд цөхрөл гасланг авчирдаг.

## Наманчлал

Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан Тэнгэрлэг эцэг танд нүглүүдээсээ өршөөгдөх цорын ганц замыг хангаж өгсөн (“Өршөөл” х.147–48-ыг үз). Есүс Христ нүглийн тань шийтгэлд шаналсан бөгөөд хэрэв та чин сэтгэлээсээ наманчлах аваас өршөөгджэй чадах юм. Наманчлан, Түүний авралын алдар сууд итгэвэл та нүглээсээ ангижрана. Тэрээр тунхаглахдаа:

“Би чамд наманчлахыг зарлиглаж байна—наманчил эс тэгвээс би чамайг амныхаа үгэн саваагаар, мөн хилэг нэлээрээ, мөн уураараа арчин хаях болно, мөн чиний зовлон гашуун байх болно—хэр зэрэг гашууныг чи мэдэх нь үгүй, хэр зэрэг хүчтэйг чи мэдэх нь үгүй, тийм ээ, тэвчихэд хэр зэрэг хэцүүг чи мэдэх нь үгүй.

“Учрыг болгоогтун, хэрэв тэд наманчлах аваас, тэд зовохгүй байж болохын тулд Бурхан, бибээр бүхний төлөө эдгээр зүйлүүдийг амссан билээ;

“Гэвч хэрэв тэд үл наманчлах аваас, бүр миний адиллаар тэд зовох ёстой;

“Бүр бүхнээс хамгийн агуу Бурхан намайг өвдөхийн улмаас дагжин чичрэх, мөн сүв бүрээс цус шүүрэх, мөн бие хийгээд сүнс аль алиныг нь зовоход хүргэсэн тэрхүү зовлон нь—мөн намайг тэрхүү гашуун аяганаас уухгүй, мөн айснаас эргэн буцахад хүргэж болохоор байсан билээ—

“Гэсэн хэдий ч, алдар суу нь Эцэгт байх болтугай, мөн бибээр хүртэж мөн хүмүүний үрсийн төлөө өөрийн бэлтгэлүүдийг дуусгасан билээ”( С ба Г 19:15–19).

### Наманчлалыг Хойшилуулахын Аюул

Нүглээ бүү өмөөр эсвэл наманчлалаа бүү хойшилуул. Амюлек сануулахдаа: “Учир нь болгоогтун, энэ амьдрал бол хүмүүний Бурхантай уулзахаар бэлтгэх үе юм; тийм ээ, болгоогтун, энэ амьдралын өдөр бол хүмүүний

өөрсдийн хөдөлмөрийг гүйцэтгэх өдөр юм. . . би та нараас эцсийг хүртэл наманчлалын өдрөө бүү хойшшуулаасай хэмээн гүйна; учир нь мөнхийн төлөө бэлтгэхээр бидэнд өгөгдсөн амьдралын энэ өдрийн дараа, болгоогтун, хэрэв бид энэ амьдралдаа цагийг сайнаар ашиглахгүй бол, тэгвэл ямар ч хөдөлмөр нь гүйцэлдэж чадахгүй шөнийн харанхуй ирэх бөлгөө” (Алма 34:32–33).

### Наманчлалын Хүчин Зүйлүүд

Наманчлал нь зовууртай явц боловч өршөөл болон үүрдийн амаар амгалан уруу хөтөлдөг. Бошиглогч Исаиагаар дамжуулан Их Эзэн “Та нарын нүглүүд час улаан мэт боловч цас шиг цагаан юм. Тэдгээр нь хүрэн улаан боловч ноос шиг болох болно” гэсэн (Исаиа 1:18). Энэ цаг үед Их Эзэн амлахдаа, “нүглээ наманчилсан тэрээр, мөнхүү тэр нь өршөөгддөг ажгуу, мөн Их Эзэн, би-бээр тэдгээрийг нь цаашид санах нь үгүй” гэжээ (С ба Г 58:42). Наманчлал нь дараах хүчин зүйлсийг агуулдаг:

Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христэд Итгэх Итгэл. Нүглийн хүч агуу юм. Үүнээс ангижрахын тулд та Тэнгэрлэг Эцэгтээ эргэн очиж, итгэлтэйгээр залбирах ёстoy. Тэнгэрлэг Эцэг таны залбирлыг сонсохооргүй тийм ихээр гомдсон хэмээн танд итгүүлэхийг Сатан хичээж болох юм. Энэ бол худал зүйл юм. Хэрэв та Түүн рүү наманчилсан зүрх сэтгэлээр ирвэл, Тэнгэр дэх Эцэг танд туслахад үргэлж бэлэн байдаг. Таныг эдгээх, нүглийг ялгуюуснаар даван туулахад тань туслах хүч Түүнд байдаг.

Наманчлал нь Есүс Христэд итгэх итгэлээ—Түүний Цагаатгалын хүчийг ойлгон ухаарах үйлдэл юм. Зөвхөн Түүний нөхцлөөр та учлагдаж чадна гэдгийг сана. Түүний Цагаатгал болон нүглээс таныг цэвэрлэх Түүний хүчийг талархалтайгаар таниваас та “наманчлалд хүргэх итгэлийг бий болгож” чадна (Алма 34:17).

Нүглийн Гэмшил. Өршөөгдөхийн тулд та нүгэл хийсэн гэдгээ өөрөө ухаарч ойлгох ёстай. Хэрэв та сайн мэдээгээр амьдрахаар хичээвэл ийм ухаарал “наманчлалыг бий болгон авралд хүргэх” “бурханлиг гэмшил” рүү хөтөлнө (2 Коринт 7:10). Бурханлиг гэмшил нь нүглийн төрөлхийн үр дагавраас эсвэл шийтгэлээс айхаас болж ирдэггүй; харин Тэнгэрлэг Эцэг болон Аврагчaa гомдоосон мэдлэгээс ирдэг. Хэрэв та бурханлиг гэмшилийг амсах үед танд өөрчлөгдөх чин сэтгэлийн хүсэлтэй байж, өршөөлийн шаардлага бүрт захирагдах эрмэлзэл байдаг.

Буруугаа Хүлээх. “Гэм нүглээ нуун далдлагч хэзээ ч амжилтанд хүрэхгүй. Харин гэм нүглээ хүлээн зөвшөөрч, тэдгээрийг мартдаг хүн хайр энэрлийг хүртэнэ” (Сургаал үгс 28:13). Өршөөлийн гол цөм нь Тэнгэрлэг Эцэгт юу хийсэн бүгдийг хэлэх хүсэл эрмэлзэлтэй байх явдал юм. Түүний өмнө нүглээ ухааран даруухан залбиртайгаар сөгд. Өөрийн буруу, ичгэвтэр явдлаа гарган хэлж, тусlamж хүс.

Ноцтой гэм, ариун явдлын хуулийн зөрчил зэрэг нь таны Сүмийн гишүүнчлэлийг унагааж болно. Түүнчлэн эдгээр нүглүүдийг Их Эзэн болон Сүм дэх Түүний төлөөлөгчдөд илчлэн хэлэх хэрэгтэй. Энэ нь Сүмийн шүүгч болон харгалзагчаар үйлчилдэг бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчийн, мөн гадасны эсвэл номлолын ерөнхийлөгчийн тусlamжтайгаар үйлдэж болно. Зөвхөн Их Эзэн нүглийг тань өршөөж чадах хэдий ч, эдгээр санваарын удирдагчид наманчлалын явцад чухал үүргийг гүйцэтгэж чадна. Тэд таны илчилж хэлсэн зүйлийг нууц болгон хадгалж, наманчлалын явцын турш танд туслах болно. Тэдэнд бүрэн үнэнч шударга хандаарай. Хэрэв та зарим зүйлээ нуун дарагдуулж зөвхөн хөнгөн алдаагаа дурдвал илүү ноцтой, илчилж хэлээгүй гэмээ та шийдэж чадахгүй. Та энэхүү явцыг аль болох хурдан эхлүүлбэл учлаа-

лын гайхамшигаас ирсэн амар амгалан, баяр баяслыг та удахгүй эдлэх болно.

*Нүглээ Орхих нь.* Хэдийгээр илчлэн хэлэх нь наманчлалын чухал хэсэг боловч хангалттай биш юм. “Хэрэв хүн нүглүүдээ наманчилсан бол та нар үүгээр нь мэдэж болох ажгуу—болгоогтун, тэрээр тэдгээрийг хүлээж мөн орхих болно” хэмээн Их Эзэн хэлжээ (С ба Г 58:43).

Тухайн гэмийг дахин давтахгүйн тулд шийдвэртэй алхам хий. Та энэхүү амлалтыг хадгалах үед тэрхүү нүглийн зовиурыг дахин хэзээ ч амсахгүй.

Аюултай байдлаас даруй зугт. Хэрэв тодорхой нөхцөл байдал таныг нүгэл үйлдэхэд нөлөөлөх буюу нүгэл үйлдүүлэхээр бол орхи. Та уруу таталтанд үлдэж, нүглийг давж гарна гэж найдаж чадахгүй.

*Хохиролгүй Болгох.* Θөрийн үйлдлийн буруугаас болж гэмтсэн хүний өмч хөрөнгө эсвэл сайн нэр төрийг нөхөн сэргээж өгөх ёстой. Хохиролгүй болгож өгөх хүсэлтэй байх нь Их Эзэнд наманчилж чадах бүхнээ та хийж байна гэдгийг харуулж буй хэрэг юм.

*Зөв Шударгаар Амьдрах.* Хилэнцэтийг эсэргүүцэхээр зүгээр нэг хичээх эсвэл амьдралаа нүглээс чөлөөлөх нь хангалтгүй юм. Та амьдралаа зөв шударга байдлаар дүүргэж, сүнслэг хүч авчрах үйл ажиллагаанд оролцох ёстой. Θөрийгөө сударт уусга. Θөрөөс тань гадна танд хүч чадлыг өгдөг Их Эзэнд өдөр бүр залбир. Зарим тохиолдолд онцгой адислал авахаар мацааг барь.

Бүрэн дүүрэн дуулгавартай байдал амьдралд тань сайн мэдээний бүрэн хүч болон алдаа дутагдлаа давж гарах өсөн нэмэгдэх хүч чадлыг авчирдаг. Энэхүү дуулгавартай байдал нь цуглаанд оролцох, аравны нэг төлөх, үйлчлэл үзүүлэх, болон бусдыг учлах зэрэг наманчлалын нэг хэсэг хэмээн таны таамаглаагүй байж болох үйл ажиллагааг хамруулна. “Наманчилж, мөн Их

## *Нигүүлсэл*

Эзэний зарлигуудыг биелүүлэх тэр нь өршөөгдөх болой” хэмээн Их Эзэн амласан (С ба Г 1:32).

Нэмэлт судрууд: Лук 15:11–32; 2 Нифай 9:19–24; Мозая 4:1–3, 10–13; 26:30–31; С ба Г 18:10–16

Авралын Төлөвлөгөө; Баптиسم; Есүс Христийн Цагаатгал; Итгэл; Нүгэл;Өршөөл; Сүмийн Сахилгын Зөвлөл; Уруу таталтыг мөн үз.

## **Нигүүлсэл**

Тэнгэрлэг Эцэг бидний сүл дорой байдал болон нүглийг мэддэг. Тэр бидний нүглийг учлан, биднийг Түүний оршихуйд эргэн амьдрахад нигүүлслийг үзүүлдэг.

Ийм хайр нь цэвэр бус зүйл Бурхантай амьдрахгүй хэмээх шударга ёсны шүүлттэй зөрчилдөж болохоор санагдаж магад (1 Нифай 10:21-ийг үз). Гэвч Есүс Христийн Цагаатгал үүнийг Бурханд “төгс, шударга, бурхан мөн түүнчлэн нигүүлсэнгүй байх” боломжтой болгосон (Алма 42:15).

Бурханы Нигүүлслийг Хүлээн Авах нь

Аврагч шударга ёсны шүүлтийн шаардлагыг Тэр бидний байранд зогсож бидний нүглийн шийтгэлд зовж шаналж байхдаа биелүүлсэн. Энэхүү амия үл бодсон үйлдлийн учир Эцэг нигүүлсэлтэйгээр биднээс шийтгэлийг буцааж, биднийг Түүний оршихуйд урин оруулж чадна. Их Эзэний өршөөлийг хүлээн авахын тулд бид нүглээ чин сэтгэлээсээ наманчлах ёстой. Бошиглогч Алмагийн зааснаар “Шударга ёс нь өөрийн бүх шаардлагуудыг гүйцээж, мөн түүнчлэн нигүүлсэл нь өөрийн болох бүгдийг өөртөө харьялуулдаг; мөн тийн үнэнээр гэмшигчээс өөр хэн ч аврагдахгүй” (Алма 42:24; мөн 22–23, 25-р шүлгүүдийг үз).

Нүглийн уучлал нь зөвхөн Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христээс ирсэн нигүүлслийн бэлэг биш юм. Таны хүлээн авдаг адислал бүр нь таны хэмжүүрээс илүү агуу нигүүлслийн үйлдэл юм. Мормон “Сайн болох бүх зүйл Христээс ирдэг; өөрөөр хэлбэл, хүмүүн нь унасан байсан, мөн тэдэнд ямар ч сайн зүйл ирэх аргагүй байсан” хэмээн заажээ (Моронай 7:24). Жишээ нь, Тэнгэрлэг Эцэг залбирлыг тань сонсож, хариулахдаа Ариун Сүнснээс удирдамж хүлээн авах үед, та санваарын хүчээр дамжуулан өвчинөөсөө эдгэрэх үед та тэнгэрлэг нигүүлслийг хүлээн авагч болдог билээ. Хэдийгээр иймэрхүү адислал бүр нь таны дуулгавартай байдлын үр дүн болж ирдэг ч та дан ганц өөрийнхөө идэвх зүтгэлээр үүнийг хэзээ ч хүлээн авч чадахгүй. Тэдгээр нь хайрлан, энэрдэг Эцэгээс ирдэг нигүүлсэл бүхий бэлэг билээ.

### Бусдад Нигүүлслийг Үзүүлэх нь

Аврагч шавь нартаа хандан тушаахдаа: “Та нарын Эцэг өршөөнгүй билээ. Түүнчлэн өршөөнгүй байгтун” гэжээ (Лук 6:36). Та Тэнгэрлэг Эцэгийн нигүүлслийн жишээг бусадтай харьцах харьцаандаа дагаж чадна. Хийрхэл, бардамнал, их зангаас амьдралаа хол байлгахаар шамд. Бусдын дутагдлыг ухамсарласан үедээ ч хайр халамжтай, хүндэтгэлтэй, училамттай, зөвлөн болон тэвчээртэй байх замыг эрэлхийл. Ийнхүү байваас, таны жишээ бусдыг нигүүлсэнгүй байхад удирдах ба та Бурханы нигүүлслийг ихээр хүртэх болно.

Нэмэлт судрууд: Матай 5:7; Лук 10:25–37; Алма 34:14–16

Ач Ивээл; Өршөөл; Шударга Байдал; Энэрэлийг мөн үз.

## Нийгмийн Халамжийн Бүлэг

Нийгмийн Халамжийн Бүлгийг Бошиглогч Иосеф Смит 1842 оны 3 дугаар сарын 17-нд Иллинойсын Навууд үндэслэжээ. Үндэслэж байх өдрүүддээ Нийгмийн Халамжийн Бүлэг үндсэн хоёр зорилготой байсан: ядуу хийгээд хэрэгцээтэй хүмүүст тусlamж үзүүлэх, мөн бодгалиудыг аврах. Тус байгууллага нь эдгээр анхныхаа зарчмуудад үнэнч хэвээр үлдэж, өнөөдөр ч мөн адил үйл ажиллагаа явуулсаар байна. Дэлхий даяар Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нар санваартан ах нартай Сүмийн номлолыг биелүүлэхээр хамтран ажилладаг.

Тэд бие биенээ:

- Есүс Христийн гэрчлэлийг залбирал болон судар судалснаар дамжуулан өсгөх.
- Ариун Сүнсний өдүүлбэрүүдийг дагаснаар сүнсний хүч чадлыг эрэлхийлэх.
- Гэрлэлт, гэр бүл, гэр орноо хүчирхэгжүүлэхэд өөрсдийгөө зориулах.
- Эхийн уужим сэтгэл, эгч дүүсийн барилдлагад баяр баяслыг олох.
- Үйлчлэл болон сайн үйлсэд баярлах.
- Амьдрал болон суралцах явдлыг хайрлах.
- Үнэн хийгээд зөв шударгын төлөө зогсох.
- Дэлхий дээрх Бурханы эрх мэдэл хэмээн санваарыг дэмжих.
- Ариун сүмийн адислалуудад талархах.
- Бурханлиг хувь тавилангаа ойлгож, өргөмжлөлийн төлөө хичээн чармайх.

Хэрэв та Нийгмийн Халамжийн Бүлэгт байдаг бол тус байгууллагын зорилгод хувь нэмэр оруулах нэг зам

бол айлчлагч багшаар үйлчлэх даалгаврыг хүлээн авах явдал юм. Өөрт оноогдсон эгч нарындаа айлчлан, үйлчлэхдээ сайн мэдээг заахад цаг зав гаргаж, нөхөрлөлөө бэхжүүл. Хувь хүмүүст үйлчлэхтэй холбогдуулан та гэр бүлүүдийг хүчирхэгжүүлэхэд чухал үүргийг гүйцэтгэж чадна.

Хэсэг болон салбарын удирдагчид айлчлагч багши нарыг 18 юм уу түүнээс дээш эгч бүрт хуваарилах хариуцлагатай. Санваарын болон Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид айлчлагч багшийг эгч бүрийн сүнсний болон зуурдын хэрэгцээг хангахад нь туслахад хяналт тавьдаг.

Нийгмийн Халамжийн Бүлгийн эгчийн хувьд та дэлхий даяар Есүс Христэд сүсэг бишрэлтэйгээр нэгдсэн эгч дүүсийн нэг гишүүн билээ. Та Бурханы бусад охидуудтай итгэл, сайн үйлс, мөрөөдөл болон энэрлийн эмэгтэй хүний ёсоор амьдралд утга учиртай, зорилго, чиглэлтэй байдаг гэсэн лавтай мэдлэгтэйгээр нэгддэг. Нийгмийн Халамжийн Бүлэгт хамрагдсанаар та өөртөө эгч дүүс, нөхөрлөлийг мэдрэх, утга төгөлдөр үйлчлэл үзүүлэх, гэрчлэл авьяас чадвараас хуваалцах болон сүнслэгээр өсөх боломжуудтай байдаг.

## Номлогчийн Ажил

Бид сайн мэдээгээр амьдрах адислалуудыг хүртэхдээ тэдгээр адислалуудыг бусадтай хуваалцахыг хүсдэг. Бид Түүний сайн мэдээг хуваалцсанаар бидний амьдралд ирдэг баяр баясгалангийн талаар Их Эзэн бидэнд хэлсэн юм.

“Хэрэв та нар энэ хүмүүст наманчлалыг тунхаглахад өөрсдийн бүхий л өдрүүдэд хөдөлмөрлөж, мөн зөвхөн нэг бодгалийг надад авчрах аваас миний Эцэгийн хаант

## Номлогчийн Ажил

улсад түүнтэй хамт, та нарын баяр хөөр хичнээн агуу байх билээ!

“Мөн эдүгээ, хэрэв миний Эцэгийн хаант улсад надад авчирсан нэг бодгальтай хамт та нар агуу баяр хөөртэй байх аваас, хэрэв та нар олон бодгалийг надад авчрах юм бол та нарын баяр хөөр хичнээн агуу байх билээ!” (С ба Г 18:15–16).

### Гишүүн Бүрийн Номлогчийн Үүрэг

Номлогчийн ажил бол бүх Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн үүрэг хариуцлага мөн хэмээн Их Эзэн тунхаглажээ (С ба Г 88:81). Их Эзэний Сүмийн гишүүний хүд та амьдралынхаа сайн тал хийгээд өөрийнхөө гэрчлэлийн хүч чадлаар гэр бүлийн гишүүд, найз нөхөд, бусад танилуудаа бүрэн цагийн номлогчидтой уулзахад тусалж чадна.

Таны илгээж чадах хамгийн хүчирхэг номлогчийн захиас бол таны өөрийн тань аз жаргалтай Хожмын Үеийн Гэгээнтний амьдралын үлгэр жишигээ юм. Хүмүүс Сүмд зөвхөн сайн мэдээний зарчмыг дагах гэж ордоггүй гэдгийг сана. Тэд өөрсдийн сүнсний хэрэгцээгээ хангахаас эхлэн ямар нэг зүйлийг мэдэрдэг учраас Сүмд нэгддэг. Тэдэнтэй харьцах таны харилцаа чин сэтгэлийнх бол тэд таны гэрчлэл болон аз жаргалын мөн чанарыг мэдэрч чадна.

Та сайн жишигээ үзүүлэхээс гадна “өөрийн тань доторх найдварын талаар асуух хүн бүрт хариулахад бэлэн байж чадна” (1 Петр 3:15). Та сэргээгдсэн сайн мэдээний талаар бусад хэлэх боломжуудын төлөө залбирч чадна. Олон хүмүүс энэхүү үнэнийг хүсэх учраас тэр үед та сэргэг бай.

### Бүрэн Цагийн Номлолд Үйлчлэх нь

Амигуулалтынхаа дараа Их Эзэн өөрийн шавь нартаа “явлж . . . бүх үндэстнийг дагалдагч болгож, Эцэг,

ХҮҮ, Ариун Сүнсний нэрээр баптисм хүртээ” хэмээн зарлигласан билээ (Матаий 28:19). Энэхүү зарлигийг бие-лүүлэхээр сүмийн залуу эрэгтэйчүүд сүнслэг байдлын, бие махбодын болон сэтгэл санааны хувьд бэлтгэлтэй байж бүрэн цагийн номлогчоор үйлчлэх үүрэгтэй байдаг. Ганц бие эмэгтэйчүүд болон төлөвшүүсэн хосуудад бүрэн цагийн номлолд үйлчлэх боломж бас байдаг. Та бүрэн цагийн номлолд үйлчлэхийг хүсвэл, бишоп болон салбарын ерөнхийлөгчтэйгөө ярилцана уу.

### Сүмийн Шинэ Гишүүдэд Тохинуулах нь

Номлогчийн ажил нь Сүмд нэгдэж байгаа хүмүүст туслан, дэмжихийг багтаадаг. Та энэхүү үүргийг тунгаан бодвол шинэ гишүүдийг сүмд нэгдэхэд сорилт тулгардаг гэдгийг сана. Тэдний шинэ амлалт үүрэг нь ихэнхдээ хуучин найз нөхөд, зуршилаасаа салахыг шаарддаг. Түүнчлэн, Сүмийн танилцуулах амьдралын хэв маяг өөр, үүрэг хариуцлага шаардсан мэт санагддаг.

Сүмийн гишүүн бүрт: найз, үүрэг хариуцлага, “Бурханы сайн үгээр” (Моронай 6:4) тэжээгдэх гэсэн гурван хэрэгцээ байдаг. Та энэхүү тусlamжийг үзүүлэх хичээл зүтгэлийн нэг хэсэг болж чадна. Та үргэлж анд нөхөр байж чадна. Танд Сүмийн албан ёсны дуудлага буюу үүрэг хариуцлага, албан тушаал байхгүй ч, шинэ гишүүдийн дэргэд үйлчлэлийн ажилд хамтран ажиллаж чадна. Мөн шинэ гишүүдтэй Бурханы үгсийг хуваалцах боломжуудыг эрэлхийлж чадна.

Нэмэлт судрууд: Марк 16:15; Алма 26:1–16; С ба Г 4; 60:2; 84:88; 123:12

### Нүгэл

Бурханы зарлигуудыг санаатайгаар зөрчихдөө бид нүгэл үйлддэг. Үнэний мэдлэгийг үл харгалзан зөв

## Нэгдмэл Байдал

шударга байхaa боливол бид мөн нүгэл үйлддэг (Иаков 4:17-г үз).

Бибээр “нүглийг очуүхэн төдий ч хүлцсэн янзаар хүлээн зөвшөөрч чадах нь үгүй” хэмээн Их Эзэн хэлсэн юм (С ба Г 1:31). Нүглийн үр дүн нь Ариун Сүнсийг огоорч, “цэвэр бус нэгээхэн зүйл ч Бурхантай оршиж эс чадахаар” мөнхөд Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд амьдарч чадахгүй байх болно (1 Нирафай 10:21).

Хүн бүр үнэний мэдлэгийн дагуу үйлдэхээ больдог эсвэл зарлигуудыг зөрчдөг. Төлөөлөгч Иохан заахдаа: “Хэрэв бид нүгэлгүй гэж хэлбэл өөрсдийгөө мэхэлж байгаа бөгөөд бидний дотор үнэн алга. Хэрэв бид нүглэх хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд биднийг училж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэршүүлэх болно” (1 Иохан 1:8–9). Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан бид наманчилж, нүглээсээ учлагдаж чадна.

Нэмэлт судрууд: Ром 3:23; 6:23; Алма 5:41–42; 11:37; Хиламан 5:10–11; С ба Г 82:1–3; 88:34–35

Дуулгавартай Байдал; Есүс Христийн Цагаатгал; Наманчлал; Нигүүлсэл; Сүнслэг Үхэл; Уучлал; Уруу Таталт; Шударга Байдлыг мөн үз.

## Нэгдмэл Байдал

Аврагч Цагаатгал хийхээсээ өмнөхөн сайн мэдээг заалгахаар дэлхийд илгээсэн Өөрийн шавь нарын төлөө залбирсан. Тэр мөн шавь нарынх нь үгийн учир Түүнд итгэх тэдний төлөө залбирсан. Тэр нэгдмэл байдлын төлөө залбирсан. “Энэ нь Эцэг та Миний дотор, Би Таны дотор байгаатай адил, тэд бүгдээрээ нэг байхын тулд мөн тэд Бидний дотор байж, Таны Намайг илгээсэн гэдэгт ертөнцийг итгүүлэхийн тулд билээ” (Иохан 17:21).

Энэхүү залбирлаас сайн мэдээ биднийг Тэнгэрлэг Эцэгтэй болон Есүс Христтэй мөн бие биетэйгээ хэрхэн

нэгдүүлдгийг сурдаг. Бид авралын ёслолуудыг хүлээн авч, гэрээгээ сахин сайн мэдээгээр амьдарвал бидний төрх өөрчлөгддөг. Аврагчийн Цагаатгал биднийг ариусгадаг ба бид эв нэгдэлтэйгээр энэ амьдралдаа амар амгаланг таашаан, Эцэг болон Түүний Хүүтэй мөнхөд амьдрахаар бэлтгэн амьдарч чадна.

“Хэрэв та нар нэг байхгүй аваас, та нар минийх биш” хэмээн Их Эзэн хэлсэн юм (С ба Г 38:27). Та эв нэгдлийн энэхүү жишигийг гэр бүлдээ болон Сүмд сурталчилж мөн эрэлхийлэх хэрэгтэй. Хэрэв та гэрлэсэн бол, та болон хань чинь нэг зорилго, үйлдэлд нэгдэж чадна. Та өөрийн онцгой шинж чанараараа хамтдаа бэрхшээлүүдтэй тулгарч мөн ойлголтод өсөхөд бие биендээ талархлын үг хэлж болно. Та гэр бүлийн бусад гишүүд болон Сүмийн гишүүдтэй хамт үйлчлэн, бие биендээ заан сургаж, нэг нэгнийгээ урамшуулан нэгдэж чадна. Та тэдний үгсийг сурч, зөвлөгөөг дагаваас Сүмийн Ерөнхийлөгч болон бусад Сүмийн удирдагчидтай нэг болж чадна.

Сүм дэлхий даяар өргөжин тэлвэл бүх Хожмын Үеийн Гэгээнтнүүд нэгдэж чадна. “Зүрх сэтгэлээ эв нэгдэл мөн нэг нэгнийхээ зүг хайранд нэгтгэдэг байх ёстой” (Мозая 18:21). Бид хувь хүмүүсийн онцлог болон олон янзын соёлд баярладаг боловч, бид бурханлигаар нөлөөлөгдсөн удирдагчдыг дагах, бид нэг Эцэгийн бүх хүүхдүүд гэдгийг санахад бий болдог “итгэлийн нэгдлийг” мөн эрэлхийлж чадна (Ефес 4:3–6, 11–13-ыг үз).

Дуулгавартай Байдал; Гэрлэлт; Сион; Үйлчлэл; Хайрыг мөн үз.

**Ням Гараг** (Бишрэн Шүтэх; Хүндэтгэлийн Өдрийг үз)

**Өмсгөл** (Ариун Сүмүүдийг үз)

Өр

## Өр

Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан “та нар бүх өрөө төлөх нь миний хүсэл зориг билээ” (С ба Г 104:78) гэж Их Эзэн хэсэг бүлэг Гэгээнтнүүдэд зарлиглажээ. Сүмийн эхэн үеэс эхлэн Их Эзэний бошиглогчид биднийг байнга өрийн боолчлооос зайлсхийхийг сануулж байсан билээ.

Өрийн том аюулзуудын нэг бол түүнийг дагалдах хүү юм. Зээлийн зарим нэг хэлбэр болох зээлийн картууд нь ялангуяа өндөр хүүтэй байдаг. Нэгэнтээ та өрөнд орсон бол хүүд ямар ч өршөөл үгүйг мэдэх болно. Өр нь таны ажилтай, ажилгүй, эрүүл, өвчтэй эсэхээс мөн нөхцөл байдлаас үл хамааран хуримтлагдсаар л байдаг. Өрийг барагдуултал өр танаас хэзээ ч холдохгүй. Зээл санал болгогчдод бүү хуурт, тэр ч байтугай тэд бага хүү, эсвэл тодорхой хугацааны туршид хүүгүй байхыг амлан өрийг хүний сэтгэл ханахуйц болгодог.

Санхүүгийн байдалдаа хяналт тавь. Худалдан авч болох зүйлдээ өр тавихаас зайлсхийн худалдан авч буй зүйлдээ хяналт тавь. Та ихэнх тохиолдолд өөрийн боломжийг ухаалгаар зохицуулан өрнөөс зайлсхийж чадна. Энгийн байр худалдан авах буюу сургуулиа дүүргэхийн тулд өр тавих бол аль болох хурдан буцааж төлөхөөр ажиллаж, өөрийгөө өрийн боолчлооос чөлөөл. Та өрөө дараад бага зэрэг хадгаламж хураасан бол өөртөө тохиолдох санхүүгийн хүндрэл бэрхшээлүүдэд бэлтгэлтэй байх болно. Та гэр бүлдээ орох оромжтой болох бөгөөд зүрх сэтгэлд тань амар амгалан байх болно.

Нэмэлт судрууд: Лук 16:10–11; С ба Г 19:35

**Өргөмжлөл** (Мөнх Амьдралыг γζ)

## Өршөөл

Судрууд нь өршөөлийг хоёр байдлаар авч үздэг. Их Эзэн бидэнд нүглээ наманчилж, Түүний өршөөлийг эрэлхийлэхийг тушаажээ. Тэр мөн биднийг гомдоосон тэднийг учлахыг зарлигласан билээ. Их Эзэний залбиралд Есүс Тэнгэрлэг Эцэгээс “Бид өртөнгүүдээ уучилсны адил бидний өрийт мөн учлаач” хэмээн асуухыг бидэнд зөвлөдөг (Матай 6:12).

Их Эзэнээс Өршөөлийг Эрэлхийлэх нь

Нүгэл нь хүнд ачаа юм. Энэ нь Тэнгэр дэх Эцэгийн хүслийн эсрэг үйлдэл хийсэн гэдгээ мэдсэн сэтгэлийн асар их зовлон хийгээд буруутай байдлыг авчирдаг. Энэ нь биднийг ухаарах бүр бидний гаргасан магадгүй бусдыг гомдоож, Эцэгийн бидэнд өгөхөд бэлэн байсан адислалыг хүлээн авахаас татгалзсан үйлдлийн улмаас байнга гэмшилийг авчирдаг.

Есүс Христийн Цагаатгалын улмаас бид чин сэтгэлийн хийгээд бүрэн наманчлалаараа дамжуулан нүгэлдээ учлалыг хүлээн авч чадна. Нүгэлтэй байдал нь зовлон шаналтыг авчирдаг ч Их Эзэний учлал, тайтгарал, баяр баясталанг авчирдаг. Их Эзэн амлахдаа:

“Болгоогтун, нүглүүдээ наманчилсан тэрээр, мөнхүү тэр нь өршөөгддөг ажгуу, мөн Их Эзэн, бибээр тэдгээрийг нь цаашид санах нь угүй” (С ба Г 58:42).

“Та нарын нүглүүд час улаан мэт боловч цас шиг цагаан болно, тэдгээр нь хүрэн улаан боловч ноос шиг болох болно” (Исаиа 1:18).

Та нар ноцтой нүгэл эсвэл өдөр тутмын алдаа дутагдлаа наманчлах шаардлагатай ч гэсэн энэхүү гайхамшигийг амсч чадна. Эрт цагт Аврагч хүмүүсээс гүйж байсны адилаар Тэр өнөөдөр танаас гүйж байна:

## Өришөөл

“Эцэж туйлдсан хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд над руу ир. Би та нарт амралтыг өгье.

“Буулгыг минь өөр дээрээ авч, Надаас суралц. Учир нь би зүрх сэтгэлдээ дөлгөөн, даруу билээ. Тэгээд та нар сэтгэлдээ амралтыг олох болно.

“Миний буулга амархан, Миний ачаа хөнгөн”  
(Матай 11:28-30)

“Та нар надад эргэн ирж, мөн нүглүүдээ наманчилж, мөн хөрвүүлэгдэхгүй гэж үү?

“Тийм ээ, үнэнээр би та нарт хэлнэ, хэрэв та нар надад ирэх аваас та нар мөнхийн амьдралыг авах болно. Болгоогтун, миний нигүүлслийн мутар та нарын зүг сунгаастай байна, мөн ирэх хэнийг боловч, түүнийг би хүлээн авах болно; мөн надад ирэх тэд ивээгдсэн болой”  
(3 Нифай 9:13-14).

Наманчлалын тайлбарыг “Наманчлал” х.133-137-г үзнэ үү.

### Бусдыг Уучлах нь

Нүгэлдээ уучлалыг эрэхийн тулд бид бусдыг уучлах хүсэлтэй байх ёстой. Их Эзэн хэлэхдээ: “Та нар бие-нээ уучлах ёстойг та нарт хэлнэ би; учир нь ах дүүгийн-хээ зөрчлийг үл уучилдаг тэрээр Их Эзэний өмнө буруушаагдахаар зогсох буюу; учир нь түүнд илүү их нүгэл үлддэг болой. Их Эзэн бибээр өршөөх түүнийг би өршөөх болно, харин бүх хүмүүнийг уучлах нь та нараас шаардагдана” (С ба Г 64:9-10).

Амьдралын өдөр тутмын нөхцөлд та мэдээж бусад хүмүүсийн өмнө заримдаа санамсаргүйгээр, зарим үед санаатайгаар буруутай болдог. Иймэрхүү нөхцөлд амархан уурлах, хорсох, эсвэл өшөө авах боловч энэ нь Их Эзэний зам биш юм. Аврагч “дайснуудаа хайрла, та нарыг хавчдаг хүмүүсийн төлөө залбир” хэмээн

зөвлөсөн (Матаї 5:44). Загалмай дээр байхдаа Тэрээр уччалын төгс жишээг үзүүлсэн. Түүнийг цовдолсон Ромын цэргүүдийн талаар тэрээр “Аав аа, тэднийг учлаач, учир нь тэд юу хийж байгаагаа мэдэхгүй байна” хэмээн залбирсан юм (Лук 23:34).

Өөрийг тань буруутгасан тэднийг учлах хүч чадлын төлөө залбир. Уур уцаар, хорсол эсвэл шүд зуух зэрэг мэдрэмжүүдээ үлдэн хөө. Бусдын бурууттай тал дээр төвлөрч, алдаа дутагдлыг нь олж харахын оронд бусдаас сайныг эрэлхийл. Бурханыг бусдын хор хөнөөлтэй үйлдлийн шүүгч байхаар болго. Гомдсон сэтгэлээ зүгээр л өнгөрүүлэх нь хэцүү боловч та Их Эзэний тусламжтайгаар хийж чадна. Та нар учлал нь үзэн ядалт хийгээд зөрчилдөөний хорыг зөвхөн Бурханы өгч чадах хайр хийгээд амар амгалангаар орлуулан аймшигтай шархыг эдгээж чадна гэдгийг олж мэдэх болно.

Нэмэлт судрууд: Матаї 6:14–15; 18:21–22; 1 Нифай 7:16–21

Бусдыг Шүүх нь; Есүс Христийн Цагаатгал; Наманчлалыг үз.

## Патриархын Адислалууд

Патриархын адислалыг Сүмийн зохистой гишүүдэд томилогдсон патриарх өгдөг. Таны патриархын адислал Израилийн гэр дэх удам угсааг тань тунхаглаж өгдөг бөгөөд Их Эзэнээс танд өгөх хувийн зөвлөгөөг агуулдаг.

Патриархын адислалаа судлахдаа дотор нь агуулагдаж байгаа зөвлөгөөг дагавал чамайг удирдаж, тайтгаруулж, хамгаалах болно. Патриархын адислалаа хэрхэн хүлээн авахаа мэдэхийн тулд бишоп юм уу эсвэл салбарын ерөнхийлөгчтэйгөө ярь.

## Удам Угсааны Тунхаглал

Таны патриархын адислал Абрахамын удам, Иаковын онцгой овогт багтсан Израилын гэрийн хүн гэдгийг илэрхийлэн, удам угсааны мэдүүлгийг агуулдаг. Олон Хожмын Үеийн Гэгээнтэн Их Эзэний хожмын үеийн ажлыг хөтлох үндсэн үүрэг хариуцлага хүлээсэн Ефраймын овгоос гаралтай байдаг.

Бидний язгуур угсаа холилдсон байдаг учраас нэг гэр бүлийн хоёр гишүүн Израилын өөр өөр овгоос ирсэн байж болно.

Израилын гэр дэх таны удам угсаа язгуур угсаагаар дамжсан байх эсвэл өргүүлсэн байх нь хамаагүй юм. Сүмийн гишүүний хувьд та Абрахамыг үр удам, Абрахамын гэрээнд багтсан бүх адислал хийгээд амлалтуудын өв залгамжлагч юм (“Абрахамын гэрээ” х.4-ийг үз).

## Патриархын Адислалаасаа Суралцах нь

Та патриархын адислал хүлээн авсан бол үүнийгээ даруухнаар, залбиралтайгаар байнга уншиж бай. Энэ нь таны хүч чадал, сул тал болон мөнхийн боломжийг мэддэг Тэнгэрлэг Эцэгээс ирсэн илэрхийлэл юм. Патриархын адислалаараа дамжуулан Тэр чамаас юу хүсч байгааг мэдэхэд тань туслах болно. Таны адислал амлалт, зэмлэл, сануулга агуулж болно. Цаг хугацаа өнгөрөх тусам та хүлээн авсан илэрхийллийнхээ хүчийг ойлгон ухаарах болно.

Адислал доторх зөвлөгөөг дагавал харьцангуй бага бүдэрнэ. Хэрэв та уг зөвлөгөөг үл тоомсорловол, амлагдсан адислалыг хүлээн авах чадваргүй байх болно.

Патриархын адислал бурханлигаар нөлөөлөгдсөн зөвлөгөө болон амлалт байх үед та бүх асуултууддаа эсвэл амьдралд тань тохиолдох дэлгэрэнгүй хариулт авахаар хүлээх ёсгүй. Хэрэв адислал тань бүрэн цагийн

номлол, гэрлэлт зэрэг чухал үйл явдлыг дурдаагүй бол, та тэрхүү боломжийг хүлээн авахгүй хэмээн таамаглах ёсгүй.

Үүнтэй адилаар, патриархын адислал дээр бичигдсэн бүх зүйл амьдралд биелэгдэх ёстой гэж таамаглах ёсгүй. Патриархын адислал нь мөнхийн бөгөөд, үүний амлалтууд нь мөнх оршихуйд үргэлжилж болно. Хэрэв та зохистой бол бүх амлалтууд Их Эзэний цаг хугацааны дагуу биелэгдэнэ гэдэгт итгэлтэй бай. Энэ амьдралд биелээгүй нь ирэх амьдралд биелэгдэнэ.

Таны патриархын адислал ариун нандин бөгөөд хувийн чанартай юм. Та үүнийг гэр бүлийнхээ гишүүдтэй хуваалцаж болох хэдий ч, олон нийтийн газар чангаар унших буюу орчуулуулах мөн уншуулахаар бусдад өгөхийг зөвшөөрөх ёсгүй. Тэр ч байтугай патриарх, бишоп, салбарын ерөнхийлögч тань үүнийг унших ёсгүй.

Патриархын адислалын үнэ цэнэтэй үгсийг зүрх сэтгэлдээ нөөцөл. Тэдгээрийг тунгаан бод, энэ амьдрал болон ирэх амьдралд амлагдсан адислалуудыг хүлээн авахын тулд зохистой амьдар.

## Порнографи

Порнографи бол сексийн мэдрэмж төрүүлэх замаар хүний бие буюу эсвэл сексийн харьцааг үзүүлэх аливаа материал юм. Үүнийг ном, сэтгүүл, зурагт, кино, хөгжим болон Интернетээр дамжуулан тараадаг. Энэ нь тамхи, архи, хар тамхи шиг сүнс болон биенд хор хөнөөлтэй юм. Ямар нэг байдлаар порнографийг ашиглах нь Бурханы зарлигийг зөрчиж байгаа хэрэг юм. “Чи садар самууныг үйлдэх буюу тэрчлэн энэ мэт ямар ч зүйлийг үйлдэх ёсгүй” (С ба Г 59:6). Энэ нь бусад ноцтой нүгэл рүү хөтөлж болно. Сүмийн гишүүд порнографиас

## **Саад Тоттор**

зайлсхийж, үүнийг үйлдвэрлэх, тараан түгээх, хэрэглэхийг эсэргүүцэх ёстой.

Порнографи нь хүнийг эмгэнэлтэйгээр донтуулдаг. Бусад донтуулагч зүйлтэй адил, хүмүүсийг сонирхон үзэх мөн илүү хүчтэй өдөөлтийг эрж хайхад хүргэдэг. Хэрэв та туршиж үзээд, үүнд хорхойтож эхэлвэл таны бодол санаа, зүрх сэтгэл болон сүнсийг муутган таныг сүйтгэх болно. Энэ нь амьдралын гоо сайхныг мэдрэх мэдрэхүй хийгээд өөрийгөө хүндэтгэх хүндэтгэлийг тань дээрэмдэх болно. Таныг сүйрүүлж, хилэнцэт бодол санаа хийгээд хилэнцэт үйлдэл рүү хөтөлнө. Гэр бүлийн харилцааг тань аймшигтайгаар сүйтгэнэ.

Порнографи донтуулах шинж чанар болон бие болоод сүнсэнд нөлөөлөх тэрхүү хор хөнөөлөөс болж, Бурханы үйлчлэгчид биднийг үүнтэй тэмцэхийг байнга сануулсаар ирсэн. Хэрэв та порнографийн занганд орсон бол даруй болж, тусламж хай. Наманчлалаар дамжуулан та уччалыг хүлээн авч, сайн мэдээнд найдварыг олж чадна. Бишоп эсвэл салбарын ерөнхийлögчөөсөө асуудлаа хэрхэн даван туулах болон Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан эдгэрийг эрэлхийлэх зөвлөгөөг авахаар яв. Энэхүү муухай зуршлыг давж гарах хүч чадал өгөхийг Их Эзэнээс хүс.

Нэмэлт судрууд: Матаи 5:27–28; Ром 6:12; Алма 39:9; С ба Г 42:23

Уруу таталт; Энэрлийг мөн үз.

## **Саад Тоттор**

Тэнгэрлэг Эцэгийн гэтэлгэлийн төлөвлөгөөний нэг хэсэг учраас та нар зуурдын байдалд саад totgorыг туулдаг. Хүнд сорилт, урам хугаралт, гуниг гутрал, өвчин хийгээд зүрхний шигдээс нь амьдралын хүнд хэсэг боловч та Их Эзэнд хандвал тэдгээр нь сүнсний өсөлт, өөрчлөлт хийгээд хөгжил руу удирдана.

Саад totgor нь янз бүрийн эх сурвалжаас шалтгаалан гардаг. Магадгүй та дуулгаваргүй байдал болоод бардам зангийнхаа үр дагаврын улмаас хүнд сорилтуудтай тулгарч болно. Зөв шударга амьдрал нь эдгээр хүнд сорилтуудыг зайлзуулж чадна. Бусад сорилтууд нь амьдралд байх ёстой бөгөөд заримдаа тэдгээр нь таныг зөв шударгаар амьдарч байхад ч ирж болно. Жишээ нь, хайртай хүмүүс тань өвчин зовлонтой, эсвэл үл мэдэгдэх шалтгаанаар нас барах цагт хүнд сорилт бий болдог. Саад totgor нь заримдаа бусдын буруу сонголтууд, өр өвтгөм үгс хийгээд үйл хөдлөлөөс болж бий болдог.

### Саад Тотгорт Итгэлтэйгээр Хандах нь

Эдүгээ болон мөнх оршихуй дахь таны аз жаргал хийгээд амжилт аль аль нь амьдралын хүнд хэцүү үед таны хэрхэн хандаж байгаагаас ихээхэн хамаарна.

Мормоны Номын шастир саад totgort хэрхэн өөр өөрөөр ханддагийг харуулдаг. Бошиглогч Лихай болон түүний гэр бүл олон өдрийн турш цөлд явах зуураа хоол олж идэхийн тулд нум сумаа агсаж, ан гөрөө хийж байлаа. Лихайн хөвгүүд нумаа ашиглаж чадахгүй болоход уг гэр бүл бэрхшээлтэй тулгарсан юм. Лэмэн Лэмүэл хоёрын нумын пүршны харимхай тасарч, Нифайн нум хугарсан байлаа. Өлсөж ядарсан Лэмэн Лэмүэл хоёр Их Эзэний эсрэг гомдоллож эхэлжээ. Тэр ч байтугай Лихай бувтнаж эхлэв. Харин Нифайн урам нь хугарсангүй. Тэрээр хөдөлмөрлөхөөр явлаа. Тэрээр ийн хэлэв: “Би, Нифай, модоор нум, шулуун саваагаар сум хийв; иймийн тул, би өөрийгөө нум болон сум, дүүгүүр бас чулуугаар зэвсэглэв. Мөн би эцэгтээ хандан: Би хааш одож хүнс залгуулах билээ?” гэжээ. Нифайн үгийн учир даруусгагдсан Лихай Их Эзэнээс хаашаа явж хүнс залгуулж болохыг асуужээ. Их Эзэн түүний

залбиралд хариулж Нифайг хоол олж болох газарт хүргэжээ (1 Нифай 16:15–31-ийг үз).

Зарим хүмүүс саад тогторой тулгарахдаа Лэмэн, Лэмүэл хоёртой адил байдаг. Тэд гомдоллож, хорсож эхэлдэг. Тэд “Ягаад энэ бүхэн надад тохиолдож байна вэ? Ягаад би үүнээс болж зовж шаналах ёстой юм бэ? Надад ясан гэж ийм зүйл тохиолдож байгаа юм бэ?” гэх мэтчилэн асуудаг. Гэвч эдгээр асуултууд тэдний бодлыг ноёрхох хүчтэй. Иймэрхүү асуултууд нь хүмүүсийг ойлгож ухаарахад нь саад болж, хүч чадлыг нь сорьж, Их Эзэний тэдэнд өгөхийг хүсч байгаа туршлагуудыг олж авахаас холдуулдаг. Ихгэж хариулахынхаа оронд та нар Нифайн жишээг дага. Бид юу хийх вэ? Үүнээс би юу сурч болох вэ? Би юуг өөрчлөх хэрэгтэй вэ? Би хэнд тусалж болох вэ? Энэ хүнд сорилтын үед өөрөөсөө би хэрхэн олон адислалаа санаж чадах вэ? зэрэг асуулт асууж, тунгаан бод.

Олон янзын саад тогтор нь олон янзын хариу үйлдлийг шаарддаг. Жишээ нь, та өвдөж туйлдсан бол танд итгэл, тэвчээр хэрэгтэй. Бусдын үг, үйл хөдлөлөөс болж шаналж байгаа бол таныг гомдоосон тэднийг учлах тал дээр ажиллах нь зүйтэй. Хэрэв та хүчирхийлэлд өртсөн бол шууд тусlamж эрэх хэрэгтэй. Та дуулгаваргүй байдлаасаа болж хүнд сорилттой учирсан бол өөрийн зан байдлаа засч, даруухнаар учлалыг эр.

Хэдийгээр саад тогтор хариулах хариу үйлдэл чинь өөр байж болох ч, нэг л хариулт—болох Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христэд итгэх таны итгэл л хувирашгүй байх ёстой. Бошиглогч Алма “Бурханд найдлага тавьсан хэн боловч өөрсдийн зүдгүүрүүдэд, мөн өөрсдийн бэрхшээлүүдэд мөн өөрсдийн зовлонгуудад дэмжигдэх болно, мөн эцсийн өдөр өргөгдөх болно гэдгийг би мэднэ” гэжээ (Алма 36:3).

## Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христэд Итгэх нь

Та Эцэг болон Хүүд итгэхдээ, Тэд таныг аз жаргалтай байлгахыг хүсдэг ба таныг сүнслэг байдлаар өсөхөд тань туслах учраас таныг төгс төгөлдрөөр хайрладаг гэдэгт итгэлтэй байдаг. Та зарлигуудыг сахьдаг. Та Тэдний хүслийг мэдэхийг эрэлхийлдэг бөгөөд та таны хүсч байгаа зүйлээс өөр зүйлийг шаардахад та хийдэг. Тайтгарлыг олж авахад залбирлууд тань Тэнгэрлэг Эцэг бүх хэргийг нэг дор шийдвэрлэхгүй, учир нь Тэр таныг хүлээлгэж, тэгснээр та үргэлжлүүлэн сурч өсч чадна гэдэг ойлголтын хамтаар дагалддаг. Та энэ бүхнээс аврагч сорилтуудыг чинь төгс төгөлдрөөр ойлгоно гэдэг баталгаанд тайвширалыг олдог. Түүний хэмжээлшгүй Цагаатгалын нэг хэсэгт Тэр Өөртөө “хүмүүсийн шаналал мөн өвчинүүдийг” авсан. Тэр Өөртөө “Түүний зүрх нь бие махбодын дагуу нигүүлслээр дүүргэгдэж болохын тулд, тэрээр бие махбодын дагуу өөрийн хүмүүсийг тэдний сул байдлуудын нь дагуу тэрээр өөр дээрээ тэдний сул дорой чанаруудыг авах болно” (Алма 7:11–12). Учир нь Тэр таны өвчин зовлонг туулсан. Тэр танд хэрхэн туслахаа мэднэ. Та Түүнд итгэвэл, Тэрээр танд тохиолддог ямарваа сорилтуудыг сөрж зогсоход тань таныг хүчирхэгжүүлэх болно.

Соригдож байхдаа та Их Эзэнд итгэхийг хичээхдээ Бошиглогч Иосеф Смитээр дамжуулж өгсөн доорх зөвлөмжийг санагтуун:

“Гай зовлон тохиолдоход итгэлтэй байдаг түүний, мөнхүү түүний шагнал нь тэнгэрийн хаант улсад илүү агуу бөлгөө.

“Үүнээс хойш тохиох тэдгээр зүйлүүдийн талаарх Бурханыхаа төлөвлөгөөг, мөн их гай зовлонгийн дараа дагалдах алдар сууг энэ үед та нар эгэл нүдээрээ болгоож чадах нь үгүй.

“Учир нь их гай зовлонгийн дараа адислалууд ирдэг болой” (С ба Г 58:2–4).

Саад Тотгын Үед Амар Амгалан хийгээд Баяр  
Баясгаланг Олох нь

Та бэрхшээл болон уйтгар гунигтай тэмцэхдээ амар амгалан хийгээд баяр баясгаланг олж чадна. Мормоны Ном нь энэхүү үнэнийг сурсан зөв шударга хүмүүсийн шастирыг агуулдаг. Хэрцгийн удирдагчийн дор боолчлолд шаналсан тэд Бурхандаа зүрх сэтгэлээ юулж байсан билээ (Мозая 24:8-12-ыг үз). Их Эзэн хариулжээ:

“Тэргүүнээ өргөцгөө мөн тайтгаартун, учир нь та нарын надад хийсэн гэрээний тухай би мэднэ; мөн өөрийн хүмүүстэй гэрээ хийх мөн тэднийг би боолчлолоос чөлөөлөх болно.

“Мөн та нарын мөрөн дээр тавигдсан байх тэр ачаануудыг би түүнчлэн хөнгөлнө, бүр тэдгээрийг нуруун дээрээ байгааг ч мэдрэхгүй болтол, бүр та нарыг боолчлолд байх үед буюу; мөн та нар цаашид миний гэрчлэгчид болон зогсож болох, мөн та нар, Их Эзэн Бурхан би өөрийн хүмүүст тэдний зүдгүүртэй үед зочилдог гэдгийг та нар гарцаагүй мэдэж болохын тулд би түүнийг хийх болно” (Мозая 24:13-14).

Хүмүүс итгэлтэйгээр хариулсан бөгөөд “[тэдний дээр] тавигдсан ачаанууд хөнгөлөгдсөн байлаа; тийм ээ, тэд ачаагаа амархан дааж чадахын тулд Их Эзэн тэднийг хүчирхэгжүүлсэн, мөн тэд баяртайгаар мөн тэвчээртэйгээр Их Эзэний бүх тааллуудад захирагдсан болой” (Мозая 24:15).

Эдгээр шударга хүмүүсийн адилаар та нар “Тэрээр та нарыг сорилтуудын үед хүчирхэгжүүлнэ гэдгийг мэдэн баяртайгаар мөн тэвчээртэйгээр Их Эзэний бүх тааллуудад захирагдаж чадна.” Тэр “зовж зүдэрсэн бүх зүйлдээ мөн миний нэрний алдар суутай нийлээд та нарын сайн сайхны төлөө ажиллах болно хэмээн Их Эзэн хэлж байна” гэдгийг амласан (С ба Г 98:3).

Нэмэлт ишлэлүүд: Еврей 4:15–16; 2 Нифай 2:11–24; Мозая 23:21–22; С ба Г 105:6; 121:7–9; 122

Авралын Төлөвлөгөө, Амар Амгалан, Найдвар, Наманчлал, Уучлал мөн γз.

## Садар Самуун (Ариун явдлыг γз)

### Сайн Мэдээ

Сайн мэдээ нь Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын төлөвлөгөө юм. Сайн мэдээний гол сургаал нь Есүс Христийн Цагаатгал юм.

Бошиглогч Иосеф Смит хэлэхдээ, “Сайн мэдээний анхдагч зарчмууд хийгээд ёслолууд нь: нэгдүгээрт, Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл; хоёрдугаарт, наманчлал; гуравдугаарт, нүглүүдийн ангижралын төлөөх усанд умбуулах баптисм; дөрөвдүгээрт, Ариун Сүнсний бэлгийн төлөөх гар тавилт” юм гэжээ (Итгэлийн Тунхаг 1:4). Сайн мэдээ нь γний бүрэн дүүрэн байдалд сэлэстиэл хаант улсад өргөмжлөгдөхөд бидэнд хэрэгтэй бүхий л сургаалууд, зарчмууд, хуулиуд, ёслолууд болон гэрээнүүдийг агуулдаг. Хэрэв бид сайн мэдээгээр итгэлтэйгээр амьдран энсээ хүртэл тэвчих аваас Аврагч Тэр Эцсийн шүүлтэнд бидний буруугүйг Эцэгийн өмнө өмгөөлөх болно (3 Нифай 27:16-г γз).

Бурханы хүүхдүүдийг γнийг хүлээн авахаар бэлтгэх үед сайн мэдээний бүрэн байдал нь бүхий л насныханд номлогдсоор ирсэн юм. Сайн мэдээ нь хожмын өдрүүдэд буюу цагийн бүрэн байдалд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан сэргээгдсэн юм.

Нэмэлт судрууд: Ром 1:16–17; 3 Нифай 27:13–22; С ба Г 11:24; 39:5–6

Авралын Төлөвлөгөө; Ариун Сүнс; Баптисм; Есүс Христ; Есүс Христийн Цагаатгал; Итгэлийг мөн γз.

## Сайн Мэдээг Заах нь

“Та нар онолд, зарчимд, номлолд, сайн мэдээний хуулинд, та нарын ойлголтод шаардлагатай Бурханы хаант улсад хамаардаг бүх зүйл илүү төгс зааварлагдаж болохын тулд хичээнгүйлэн заагтун та нар, мөн миний ач ивээл та нартай байх болно” хэмээн Их Эзэн тунхагласан билээ (С ба Г 88:77-78).

Энэхүү зарлигийг өгснөөр Их Эзэн бидэнд ариун үүрэг хариуцлагыг өгдөг. Тэр мөн ач холбогдол бүхий үйлчлэлийн төлөө тоо томшгүй олон боломжууд уруу биднийг хөтөлдөг. Цөөн хэдэн туршилагуудыг сайн мэдээг сурах болон түүгээр амьдрахад бусдад туслах баясгалантай харьцуулдаг.

Хэрэв та одоогоор багшийн албанд албан ёсоор дуудагдаагүй байгаа ч энэхүү зарлиг танд бас хамаарах болно. Танд гэр бүлийнхээ гишүүний хувьд, гэрийн багш эсвэл айлчлагч багшийн хувьд, тэр ч байтугай хамтран ажиллагч, хөрш болон найз нөхдийн хувьд багшлах боломж бий. Заримдаа та хэлэхээр бэлдсэн үгсээрээ заадаг. Заримдаа та сайн мэдээний үнэнийг хуваалцаж болох төлөвлөгөөгүй, хором мөчийг ашиглаж болно. Ихэнхдээ та өөрийн жишээгээр заа.

## Аврагчийн Заасны Дагуу Заах нь

Сайн мэдээг заах хичээл зүтгэлдээ Есүс Христийг жишээгээ болгон хар. Түүний зуурдын байдлын тохи-нууллын шастирыг судал, Түүний заасан шиг заах замыг эрэлхийл. Тэрээр үйлчилсэн бүхэндээ чин сэтгэлийн цэвэр хайр хийгээд халамж үзүүлдэг байсан. Тэр хүмүүсийг нэг бүрчлэн хүчирхэгжүүлж, сайн мэдээний зарчмуудыг тэдний амин хэрэгцээнд туслах замаар зааж байсан юм. Тэр сайн мэдээг ойлгох, мөн түүгээр амьдрах хүслийг заримд нь сэргээж өгсөн юм. Тэрээр сайн мэдээний

авралын үнэнийг Өөрийн чих тавин сонсдог хүмүүстээ юу хийх, юу мэдэх мөн, мөнхийн амьдралын бэлгийг хүлээн авахын тулд ямар байхыг ойлгуулахад туслан сургамжилсан юм.

Аврагчийн жишээг дагах аваас, таны сургамж бусдыг урамшуулж, тордож, тэдийг итгэлийг бий болгон, амьдралдаа бэрхшээлүүдтэй нүүр тулах итгэлийг өгнө. Нүглийг умартан, зарлигуудыг дагахад мөн тусална. Мөн Христ рүү очиж, Түүний хайранд оршиход туслана.

### Сүнсээр Заах нь

“Уг Сүнс итгэлийн залбирлаар та нарт өгөгдөх болно; мөн хэрэв та нар Сүнсийг эс хүлээн авбаас та нар заах нь үгүй” хэмээн Их Эзэн хэлсэн (С ба Г 42:14). Сүнс буюу Ариун Сүнс бол Бурхан Тэргүүтний нэг гишүүн мөн. Сүнсний нэг зорилго бол “бүх зүйлийн . . . үнэнийг мэдүүлэх” явдал юм (Моронай 10:4–5). Зөвхөн Сүнсний нөлөөллөөр дамжуулан сайн мэдээний сургаал нь бурханлигаар нөлөөлөгдөж мөн гэгээрсэн байдаг.

Сайн мэдээний багшийн хувьд таны эрх Ариун Сүнсний зааж, гэрчилж, мөн урамшуулж чадаж байгаагаар дамжуулан зэмсэг байх учиртай. Бошиглогч Нифайн зааснаар, “хүн Ариун Сүнсний хүчээр ярихад уг Ариун Сүнсний хүч үүнийг хүмүүний үрсийн зүрхэнд хүргэдэг болой” (2 Нифай 33:1).

Хэрэв та сүнслэгээр бэлтгэдэг бол Ариун Сүнс зааж байхдаа юу хэлэх, юу хийхийг мэдэхэд тань туслах болно. Та үргэлж залбирч, судраас судлан, сайн мэдээгээр амьран, даруу байхаар өөрийгөө бэлдэж чадна.

### Заах Арга Барилууд

Олон төрлийн зөв зүйтэй арга барил хэрэглэвэл таны хичээл маш их үр дүнтэй байна. Жишээ нь хүмүү-

## *Сайн Мэдээний Сэргээлт*

сийн анхаарлыг татахын тулд жишээ, түүх хуваалцан, хэрхэн сайн мэдээний зарчмуудыг өдөр тутмын амьдралдаа хэрэглэхийг харуулж чадна. Та бусад хүмүүсийн судрын шастирууд болон сайн мэдээний зарчмын ойлголтыг хүчирхэгжүүлэхийн тулд эд зүйл, зураг ашиглаж болно. Хөгжмөөр дамжуулан та өөртөө болон заалгаж байгаа хүмүүстээ Ариун Сүнсний нөлөөллийг урьж, бусад арга замаар илэрхийлэхэд хэцүү мэдрэмжүүдийг илэрхийлж чадна. Бодож, тунгаан ярилцлагыг хөхүүлэн дэмжих, мөн хувийн туршилагуудыг тохиромжтойгоор хуваалцахад хүргэх асуултуудыг асууж болно.

Та тодорхой арга барил хэрэглэн заахдаа өөрөөсөө дараах асуултуудыг асуу. Энэ арга барил Сүнсний нөлөөллийг урих уу? Миний зааж байгаа зарчмын нандин байдалтай энэ нь нийцэх үү? Миний зааж байгаа хүмүүсийг хүчирхэгжүүлж, гэгээрүүлж чадах болов уу?

Сайн мэдээний багшийн хувьд та Их Эзэнийг төлөөлдөг гэдгээ сана. Таны хийж байгаа, хэлж ярьж байгаа бүхэн Түүний хүслийн дагуу, бишрэл хүндэтгэлтэй байгаа эсэхийг хянан үз.

Сайн мэдээний талаарх нэмэлт санал зөвлөгөөг та *Teaching, No Greater Call* (36123); the *Teaching Guidebook* (34595); мөн “*Gospel Teaching and Leadership*,” section 16 of the *Church Handbook of Instructions, Book 2: Priesthood and Auxiliary Leaders*-ийг үзэж болно (35903).

Нэмэлт судрууд: Мозая 18:19; Алма 1:26; 17:2–3; 31:5; С ба Г 11:21

## **Сайн Мэдээний Сэргээлт**

Дэлхий дээр байхдаа Есүс Христ Өөрийн Сүмээ дагалдагчдынхаа дунд үндэслэн байгуулсан. Түүний Цовдлолт болон Өөрийн Төлөөлөгчдийн үхлийн дараа сайн мэдээний бүрэн байдал нь олон нийтийг хамарсан урвалтаас бодоод дэлхийгээс авагдсан юм (“Урвалт”

х.200-г үз). Олон эрэгтэй, эмэгтэй хүмүүс Агуу Их Урвалтын эрин зууны турш сайн мэдээний үнэний бүрэн байдлыг эрж хайсан боловч, тэд үүнийг олж чадаагүй юм. Хэдийгээр олон хүмүүс Аврагч, болон Түүний сайн мэдээний талаар чин сэтгэлээсээ номлож байсан ч хэнд ч Бурханаас ирэх санваарын эрх мэдэл буюу үнэний бүрэн байдал байгаагүй билээ.

Агуу Их Урвалт нь сүнслэг байдлын хувьд харанхуй үе байсан, харин бид “Христийн алдрын сайн мэдээний гэрлийг” хүртэж чадах цаг үед амьдарч байна (2 Коринт 4:4; мөн С ба Г 45:28-ыг үз). Сайн мэдээний бүрэн байдал сэргэж, Есүс Христийн үнэн Сүм газар дэлхий дээр дахин бий болсон. Өөр ямар ч байгууллагыг үүнтэй харьцуулж үл болно. Өөрчлөлт авчрахад өөрсдийн хүчээр бүгдийг хийж байгаа боловсролтой эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн шашны хөдөлгөөний үр дүн биш юм. Энэ бол Есүс Христийн үндэслэсэн Сүмийн сэргэлт билээ. Энэ бол Тэнгэр дэх Эцэг болон Түүний Хайрт Хүүгийн ажил юм.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүний хувьд та нар бараг 2000 жилийн турш дэлхийгээс авагдсан адислалуудыг хүлээн авч чадна. Баптист болон гишүүний баталгааны ёслолуудаар дамжуулан та нүглийн гэмшилийг хүлээн авч, Ариун Сүнсний байнгын нөхөрлөлийг мэдэрч чадна. Та сайн мэдээний бүрэн байдал хийгээд эгэл жирийн байдалд амьдарч чадна. Та Бурхан Тэргүүтний, Есүс Христийн Цагаатгалын шинж чанарын, газар дэлхий дээр амьдралын зорилго болон үхлийн амьдралын бодит байдлын ойлголтыг олж авч чадна. Өнөө цагт Бурханы хүслийг заадаг амьд бошиглогчоор удирдуулж байх эрх бий. Ариун Сүмийн ёслолууд, удирдамж, амар амгаланг хүлээн авах, мөнхийн амьдралд бэлтгэх, гэр бүлтэйгээ мөнхөд лацдан холбуулах мөн нас барсан өвөг дээдэстээ зориулан авралын ёслолуудаар хангах боломжийг танд олгодог.

## Сэргээлтийн Үйл Явдлууд

Дараах цаг хугацааны товчлол нь сайн мэдээний сэргээлт дэх цөөн хэдэн чухал үйл явдлыг болон “дэлхийн гадаргуу дээрх цорын ганц үнэн бөгөөд амьд сүм” хэмээн ИХ Эзэний тунхагласан Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн үндэслэгдсэнийг харуулж байна (С ба Г 1:30).

1820 оны хаврын эхэн *сар*. Есүс Христийн үнэн Сүмийг хайж байсан 14 настай Иосеф Смит Нью-Йоркийн Палмари дахь гэрийнхээ ойролцоо нэгэн ойн цоорхойд залбирчээ. Түүний даруухан залбирлын хариуд Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христ түүн дээр зочлон ирж, тэр үед байсан сүмүүдийн алинд ч нэгдэх ёсгүйг хэлсэн байна (Иосеф Смитийн Түүх 1:11–19-ийг үз). Сүмд бид үүнийг Иосеф Смитийн Анхны Үзэгдэл хэмээн нэрлэдэг.

1823 оны Есдүгээр сарын 21–22. Моронай хэмээх тэнгэр элч Иосеф Смит дээр хүрч иржээ. Моронай ирээдүйд болох үйл явдлыг бошиглож, Иосеф Смитэд алтан ялтсан дээр бичигдсэн Мормоны Номны бичвэрийн тухай өгүүлжээ. Нөгөөх тэнгэр элч Иосефийг ойролцоо Кумора хэмээх гүвээн дээр булсан тэрхүү алтан ялтсуудыг харахыг зөвшөөрсөн (Иосеф Смитийн Түүх 1:27–53).

1872 оны Есдүгээр сарын 22. Иосеф Смит өмнөх дөрвөн жилийн Есдүгээр сарын 22-нд Моронайтай уулзсаны дараа Кумора гүвээн дээр тэрхүү алтан ялтсуудыг хүлээн авчээ (Иосеф Смитийн Түүх 1:53, 59).

1829 оны Тавдугаар сарын 15. Алтан ялтсуудын орчуулга дээр ажиллаж байхдаа нүглийн ангижралын төлөөх баптисмын тухай уншаад Иосеф Смит болон түүний бичээч Оливер Каудери Их Эзэнээс уг хэрэгтэй холбоотой зүйлсийг асуухаар хувийн эзэмшлийн эзгүйрсэн газар руу явлаа. Пенсилеванийн Хармоний ойролцоо Сасквеиханна Голын эрэг дээр тэд залбирсныхаа хариуг олж авчээ. Амилуулагдсан хүн Иохан Баптист тэдэн дээр “тэнгэрээс үүлэн дотор бууж ирсэн нэгэн элч мэт” хүрч иржээ. Тэрээр тэдэнд Аароны Санваар олгосон байна. Дараа нь, түүний зааварчилгааг даган Иосеф, Оливер хоёр бие биендээ баптисм хүртээж, бие биенээ Аароны Санваарт томилсон ажээ (Иосеф Смитийн ТҮҮХ 1:68-72; мөн С ба Г 13-ыг үз).

1829 оны Тавдугаар сар. Эртний Төлөөлөгч Петр, Иаков, Иохан нар Мелкизедек Санваарыг Иосеф Смит, Оливер Каудери хоёрт хүртээжээ (С ба Г 128:20-ийг үз).

1829 оны Зургадугаар сар. “Бурханы хүч хийгээд бэлгээр” (С ба Г 135:3) удирдуулсан Бошиглогч Иосеф Смит Мормоны Номны орчуулгаа дуусгажээ.

1830 оны Гуравдугаар сарын 26. Мормоны Номны анхны хэвлэл Нью-Йоркийн Палмарид хэвлэгдэжээ.

1830 оны Дөрөвдүгээр сарын 6. Нью-Йоркийн Фейетте хотхонд зургаан гишүүнтэйгээр Сүм анхлан зохион байгуулагджээ.

1836 оны Гуравдугаар сарын 27. Энэ эрин үед баригдсан анхны ариун сүм болох Көртландын ариун

сүмийг ариулан адислажээ. Бошиглогч Иосеф Смитэд илчлэлтээр өгөгдсөн онцгойлон адислах залбирлыг хэлжээ (С ба Г 109-ийг үз).

1836 оны Дөрөөдүгээр сарын 3. Көртландын Ариун сүмд Аврагч Иосеф Смит, Оливер Каудери хоёр дээр хүрч иржээ. Мose, Елиа болон Елиас мөн хүрч ирэн, Иосеф, Оливер хоёрт санваарын түлхүүрүүдийг өгчээ. Елиас гэр бүлүүдийг хамтад нь мөнхөд лацдан холбоход боломжтой болгох лацдан холболтын хүчний түлхүүрүүдийг авчирчээ (С ба Г 110-ыг үз).

## Сүмийн Замнал

Хуучин Гэрээний бошиглогч Даниел Бурхан “хэзээ ч үл сүйтгэгдэх” “мөнхөд байх” “хаант улсыг бүтээн босгосон” хэмээн бошиглосон (Даниел 2:44). Энэхүү бошиглолыг бошиглосноор тэрээр Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм, өнөөдрийн дэлхий дээрх Бурханы хаант улсын талаар өгүүлжээ. Зургаан гишүүнтэй байгуулагдсан тэр өдрөөс хойш Сүм цэцэглэн хөгжиж, “бүх дэлхийг дүүргэх” хүртлээ цаашид өсөн дэвших болно (Даниел 2:35; мөн С ба Г 65:2-ыг үз). Жил бүр зуу зуун мянган хүмүүс баптист хүртдэг. Мормоны Ном олон хэл дээр орчуулагдсан юм. Дэлхий даяар ариун сүмүүдийг барьж байна. Сүмийн тэргүүн Есүс Христийн амьд бошиглогчид Сүмийн өсөлт дэвшилтийг дэлхий Аврагчийн Хоёр дахь Ирэлтэд бэлэн болох хүртэл удирдана.

Сэргээлтийн адислалуудын талаар Бошиглогч Иосеф Смит өгүүлэхдээ: “Эдүгээ, бид өөрсдийн хүлээн авсан сайн мэдээнд юуг сонсдог вэ? Баяр баясталангийн дуу хоолойг! Тэнгэрээс нигүүлслийн дуу хоолойг; мөн

газраас үнэний дуу хоолойг; мөн нас барагсдын талаарх баярт мэдээнүүдийг; амьд байгаа хүмүүс хийгээд нас барагсдын талаарх баярт мэдээний дуу хоолойг; агуу их баяслын баярт мэдээг буюу” гэжээ.

Нэмэлт судрууд: Исаиа 2:1–3; 29:13–14; Ўйлс 3:19–21; Илчлэлт 14:6–7; 2 Нифай 3:3–15; С ба Г 128:19–21; 133:36–39, 57–58; Иосеф Смитийн ТҮҮХ

Есүс Христийн Хоёр дахь Ирэлт; Илчлэлт; Иосеф Смит; Урвалтыг мөн үз.

## Салалт

“Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг”-д Тэргүүн Зөвлөл хийгээд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга “эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлтийг Бурхан заясан бөгөөд гэр бүл нь Түүний хүүхдүүдийн мөнхийн Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдгийг чин сэтгэлээсээ тунхаглаж байна” (номын 65–68-р хуудаснаас үз). Салалт нь эдгээр үнэнийг үл харгалзан олон нийтэд энгийн зүйл болоод байгаа бөгөөд тэр ч байтугай салалт Сүмийн гишүүдийн дунд өссөөр л байна. Энэхүү өсож буй тахал нь Бурханаас ирээгүй харин бусармаг муугийн бүтээл юм.

Гэрлэсэн хос бүр мөнхийн гэрлэлтийн адислалуудад зохицтой байхын тулд хамтдаа хөдөлмөрлөх хэрэгтэй. Хэрэв та гэрлэсэн бол та болон хань тань хүндрэл бэрхшээлийг туулж байгаа, ихэнх гэрлэлтээс бий болох сэтгэлийн дарамтыг салж сарниснаар эмчилдэггүй гэдгийг санаж ав. Энэхүү эмчилгээ нь Есүс Христийн сайн мэдээнд—наманчлал, учалал, шударга байдал хийгээд хайранд олддог. Энэ нь та өөртэйгөө ямар янзаар хандуулахыг хүсдэг шигээ ханьдаа хандахад оршино (Матай 7:12-ыг үз). Бишоп буюу салбарын ерөнхийлөг-

## *Санваар*

чөөсөө зөвлөгөө авахын тулд ханьтайгаа хамт явахыг хүсч болно.

Ариун Сүмүүд; Гэр бүл, Хайр; Гэрлэлт; Энэрэлийг мөн үз.

## **Санваар**

Санваар нь Бурханы эрх мэдэл хийгээд мөнхийн хүч юм. Санваарын хүчээр Бурхан Тэнгэрүүд болон газар дэлхийг бүтээж мөн захирдаг. Энэхүү хүчээр дамжуулан Тэр Өөрийн хүүхдүүдээ “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралд” өргөмжлөн гэтэлгэдэг юм (Мосе 1:39).

**Дэлхий Дээрх Эрэгтэйчүүдэд Өгсөн Санваарын  
Эрх Мэдэл**

Бурхан зохистой эрэгтэй гишүүдэд санваарын эрх мэдлийг өгсөн бөгөөд тэд Түүний нэрээр Түүний хүүхдүүдийн авралын төлөө ажиллаж чаддаг. Санваар аттагчид сайн мэдээг номлох, авралын ёслолуудыг гүйцэтгэх, дэлхий дээр Бурханы хаант улсыг захирах эрх мэдэлтэй байдаг.

Сүмийн эрэгтэй гишүүд санваарын үйлчлэлийг 12 нас хүрснийхээ дараа эхэлж болно. Тэд Аароны Санваарыг атгаж эхлээд, дараа нь Мелкизедек Санваарыг хүртэх шаардлагыг хангаж болно. Амьдралын янз бүрийн үеүдэд тэд өөр өөр үүрэг хариуцлагуудыг хүлээн авахаар өөрсдийгөө бэлдвэл тэд санваарын өөр өөр албуудыг жишигээ нь, Аароны Санваарын дикон, багши эсвэл санваартан, мөн Мелкизедек Санваарын ахлагч буюу дээд санваарыг атгадаг. (Аароны болон Мелкизедек Санваарын талаар тодорхой мэдээллийг х.3 болон х.123-аас үз).

Санваар атгах Сүмийн эрэгтэй гишүүдийн хувьд эрх мэдэлтэй санваар атгагч үүнийг түүнд хүртээж, тэрхүү санваарын албанд томилох ёстой (Еврей 5:4; С ба Г 42:11; Итгэлийн Тунхаг 1:5-ыг үз).

Хэдийгээр санваарын эрх мэдлийг зөвхөн Сүмийн зохистой эрэгтэй гишүүдэд хүртээдэг ч санваарын адислалууд нь бүх хүмүүст—эрэгтэй, эмэгтэй хүмүүс, хүүхдүүдэд хүртээмжтэй байдаг.

### Санваар болон Гэр бүл

Санваарын хүч чадлыг гэр бүлд хэрэгжүүлэх нь их чухал юм. Сүмийн гишүүн нөхөр, эцэг бүр Мелкизедек санваартай байхын тулд зохистой байхаар хичээх хэрэгтэй. Эрх тэгш оролцогч болох эхнэрийнхээ хамт тэрээр гэр бүлийн сүнслэг удирдагчийн ёсоор үйлчлэн зөв шударга байдал, хайраар тэргүүлдэг. Тэрээр гэр бүлээ тогтмол залбирал, судар судлах, гэр бүлийн үдшийг удирдан явуулдаг. Тэр эхнэртэйгээ хамт хүүхдүүддээ зааж сургаж, тэднийг авралын ёслолуудыг хүлээн авахаар бэлтгэхэд нь туслахаар ажиллах ёстой (С ба Г 68:25–28-ыг үз). Тэрээр удирдамж авах, илаашрах, мөн тайтгаруулахын тулд санваарын адислалыг өгдөг.

Олон гишүүдийн гэр бүлд итгэлтэй Мелкизедек Санваартан байдаггүй. Гэхдээ гэрийн багш болон санваарын удирдагчдын үйлчлэлээр дамжуулан Сүмийн бүх гишүүд санваарын хүчний адислалыг амьдралдаа талархалтайгаар мэдэрч чадна.

### Санваарын Чуулгууд

Санваарын чуулга нь ижил санваарын албыг хашдаг зохион байгуулалттай хэсэг ах нарын бүлэг юм. Чуулгын үндсэн зорилго нь бусдад үйлчлэх, эв нэгдэл болон ах дүүгийн барилдлагааг бий болгож, нэг нэгэндээ сургаал, зарчим, үүргүүдийг зааварчлах учиртай.

Чуулгууд нь Сүмийн бүхий л түвшинд оршдог. Сүмийн ерөнхийлөгч болон түүний зөвлөхүүд нь Тэргүүн Зөвлөлийн Чуулгыг бүрдүүлдэг. Арванхоёрын

## Санваар

Төлөөлөгч нь мөн чуулгыг бүрдүүлдэг. Ерөнхий Эрх Мэдэлтэй болон Бүсийн Эрх Мэдэл бүхий далууд аль аль нь чуулгуудад зохион байгуулагдсан байдаг. Гадасны Ерөнхийлөгч бүр гадасны бүх дээд санваартнуудаас бүрдсэн дээд санваарын чуулгыг тэргүүлдэг. Хэсэг буюу салбар бүр ерөнхийдөө ахлагч, санваартан, багш, болон диконуудын чуулгуудтай байдаг. Дээд санваартан дээд санваарын бүлэгтээ үйлчилж мөн хэсгүүдэд хуваагдана.

### Гэрийн Багшлалт

Санваар атгагчид багшийн албанд томилогдсон тэр цагаасаа хойш гэрийн багшаар үйлчлэх үүрэг ба боломжтой байдаг. Тэд “сүмийг ямагт харж хандан, мөн тэдэнтэй хамт байж мөн тэднийг бэхжүүлэх” үүргээ биелүүлэхийн төлөө ажилладаг (С ба Г 20:53).

Гэрийн багш нарт хувь хүмүүс болон гэр бүлүүдэд Сүмийн тусламжийн эхний эх сурвалж байх онцгой үүрэгтэй. Тэд хариуцсан гишүүддээ дор хаяж сар бүр зочилдог. Ингэж үйлчлэл үзүүлэн зочлохдоо тэд хариуцлагад нь эцэг эхчүүдийг дэмжиж, гэр бүлийн гишүүн бүрт сайн мэдээг зааж, нөхөрлөлийг тэтгэж, мөн гишүүдийг ариун сүмийн ёслолуудыг хүлээн авч, сайн мэдээний адислалуудыг авахад зохистойгоор амьдрахад бэлтгэхэд нь тусалдаг.

Хэсэг болон салбарын удирдагчид гэрийн багш нарт гэр бүл болон хувь хүмүүсийг оноож өгөх хариуцлагатай. Гишүүн бүрийн сүнслэг болон зуурдын байдлын хэрэгцээг хангахад туслахын тулд тэд гэрийн багш нарыг эргэн шалгадаг.

### Санваарын Түлхүүрүүд

Сүмд санваарын эрх мэдлийг хэрэгжүүлэх явдлыг санваарын түлхүүрүүдийг атгадаг тэд захирдаг (С ба Г

65:5; 124:123-ыг үз). Санваарын түлхүүр атгадаг тэдэнд шүүхийн хүрээнд Сүмийг удирдах, тэргүүлэх эрхтэй байна. Жишээ нь, бишоп өөрийн хэсгийг тэргүүлэх санваарын түлхүүрүүдтэй байдаг. Түүнчлэн, тухайн хэсгийн хүүхэд баптист хүртэхээр бэлтгэх үед, хүүхдэд баптист хүртэх гэж байгаа хүн бишопоос зөвшөөрөл авах ёстой.

Есүс Христ санваарын бүхий л түлхүүрүүдийг атгадаг. Тэрээр Өөрийн Төлөөлөгчиддөө Өөрийнхөө Сүмийг удирдахад шаардлагатай түлхүүрүүдийг өгсөн. Зөвхөн ахмад Төлөөлөгч, Сүмийн Ерөнхийлөгч (эсвэл өөр хүнийг ашиглахад нь зөвшөөрөл өгөх) Сүмийг бүхэлд нь захирах эдгээр түлхүүрүүдийг хэрэглэж болно (С ба Г 43:1-4; 81:2; 132:7-г үз).

Сүмийн Ерөнхийлөгч санваарын түлхүүрүүдийг бусад санваарын удирдагчдад өгдөг бөгөөд тэд өөрсдийн үүрэгтэй бүсээ тэргүүлж чадна. Санваарын түлхүүрүүдийг ариун сүмийн ерөнхийлөгчид, номлол, гадас болон дүүрэг, бишоп; салбарын ерөнхийлөгчид болон чуулгын ерөнхийлөгчид өгдөг. Эдгээр албын аль нэгэнд үйлчилдэг хүн зөвхөн албаасаа буух хүртлээ тэдгээр түлхүүрүүдтэй байна. Зөвлөхүүд түлхүүрүүдийг хүлээн авдаггүй боловч томилох хийгээд дуудах хариуцлага болон эрх мэдлийг хүлээн авдаг.

### Санваарыг Зөв Шударгаар Хэрэглэх нь

Хэрэв та санваартан бол санваар бүхий л цагт, бүхий л нөхцөл байдалд таны нэг хэсэг байдаг гэдгийг сана. Энэ нь дуртай үедээ өмсөөд тайлдаг хувцас биш юм. Санваарын албын аливаа томилот бол амьдралын турш үйлчлэл дэх Их Эзэн итгэлийн тань дагуу Түүний ажлыг хийлгэхээр таныг сонгож болох амлалттай хамт байдаг дуудлага билээ.

Санваарын хүчийг хүлээн авч мөн хэрэглэхийн тулд та зохистой байх ёстой. Ярьж буй үгс болон таны өдөр

## *Санваар*

тутмын зан байдал тань таны үйлчлэх чадварт нөлөө үзүүлдэг. Олон нийтийн газар биеэ авч явах байдал тань алдаа эндэгдэлгүй байх ёстой. Хувийн зан байдал тань илүү чухал юм. Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Их Эзэн: “Санваарын эрхүүд нь тэнгэрийн хүчтэй салшгүй холбоотой байдаг, мөн тэнгэрийн тэрхүү хүч нь зөв шударга ёсны зарчмуудаас бусдаар хянагдаж ч мөн шийдвэрлэгдэж ч үл чадах бөлгөө” хэмээн тунхаглажээ (С ба Г 121:36). Тэрээр санваар атгагчдад сануулахдаа:

“Бид нүглээ далдлахыг оролдоход, эсвэл бардамналаараа, хоосон санаархлаараа сайрхах, эсвэл хүмүүний үрсийг хянах, эзэгнэх, эсвэл албадахад, болгоогтун, тэнгэр өөрийгөө татан авдаг буюу; Их Эзэний Сүнс гашууддаг болой; мөн энэ нь буцаан татагдахад, тэр хүний санваарт эсвэл эрх мэдэлд Амен. Болгоогтун, төдөлгүй тэрээр ухаарахад . . . тэрээр ганцаараа үлддэг буюу.” (С ба Г 121:37–38).

“Сэнхрүүлээр, тэсвэр тэвчээрээр, эелдэг зөөлөн хийгээд номхон дөлгөөнөөр, чин сэтгэлийн хайраар; нинжин сэтгэл, мөн зусардалгүйгээр мөн заль мэхгүйгээр оюун санааг агуу ихээр өргөжүүлэн тэлдэг цэвэр мэдлэгээр” бус аваас та санваartaа ямарваа хүч хийгээд нөлөөг олж авч чадахгүй. Хэрэв та Ариун Сүнсээр хөтлөгдөх аваас хэн нэгнийг шүүмжил, дараа нь “тэрээр чамайг дайснаа гэж үзэхгүйн тулд, тэгээд та нар шүүмжилсэн түүнийг хайрлах хайраа нэмэгдүүлснээ харуул” (С ба Г 121:41–43).

Та санваараа зөв шударга байдал хийгээд хайранд ашиглах аваас Их Эзэний мутар дахь зэмсэг мэт үйлчлэхдээ баяр баясгаланг олох болно. Тэрээр хэлэхдээ:

“Хэвлэй дотор чинь тэрчлэн бүх хүмүүнд, мөн итгэлийн тогтмол байдалд энэрлээр дүүрэн байг, мөн бодол санааг чинь ариун журам зогсолтгүй чимэн гоёог, тийнхүү итгэлтэй байдал чинь Бурханы оршихуйд хүчтэй

болов болно мөн санваарын номлол тэнгэрээс буух шүүдэр лугаа адил чиний сүнсэн дээр намуухан буух болно.”

“Ариун Сүнс чиний байнгын хамтрагч мөн чиний очирт таяг, зөв шударга ёс хийгээд үнэний хувиршгүй очирт таяг байх болно, мөн эзэгнэл чинь үүрдийн эзэгнэл байх болно, мөн албадлагын арга хэрэгсэлгүйгээр энэ нь чам уруу үүрд мөн мөнхөд урсах болно” (С ба Г 121:45–46).

Нэмэлт судрууд: Иохан 15:16; Үйлс 8:14–20; Иаков 5:14–15; С ба Г 13; 20; 84; 107; Иосеф Смитийн—ТҮҮХ 1:68–73

Аароны Санваар; Ёслолууд; Мелкизедек Санваар; Сайн Мэдээний Сэргээлт; Сүмийн Захиргааг мөн γζ.

### Санвааарын Түлхүүрүүд (Санвааарыг γζ)

### Санваартан (Аароны Санваар; Санваар; Сүмийн Захиргааг γζ)

## Сатан

Муу ёр буюу чөтгөр хэмээн нэрлэгддэг Сатан нь зөв шударга байдлын болон Бурханыг дагахаар эрэлхийлдэг тэдний дайсан билээ. Нэгэнтээ тэр “Бурханы оршихуй дахь эрх мэдэл бүхий” тэнгэр элч байсан Бурханы сүнсэн хүү билээ (С ба Г 76:25; мөн Исаиа 14:12; С ба Г 76:26–27-г γζ). Гэвч зуурдын байдлын өмнөх Тэнгэр дэх Зөвлөгөөнд Люсифер (Сатаныг тэр үед ингэж нэрлэдэг байв) Тэнгэрлэг Эцэг болон авралын төлөвлөгөөний эсрэг босчээ. Бурханы эсрэг энэхүү бослогод Сатан “хүмүүний сонгох эрхийг эрэлхийлсэн юм” (Мосе 4:3). Тэрээр “нэг ч бодгаль хаягдахгүйгээр бибээр хүн төрөлхтнийг гэтэлгэх болно, мөн үүнийг би гарцаагүй хийх болно, иймийн тул, өөрийн алдар хүндэтгэлийг надад өгөгтүн” хэмээн хэлжээ.

## Сатан

“Эцэгээс урвуулахын тулд” “тэнгэрийн олны гуравны нэг хэсгийг” Сатан ятгасан билээ (С ба Г 29:36). Энэхүү бослогын үр дүнд Сатан болон түүний дагалдагчид Бурханы оршихуйгаас тусгаарлагдаж, бие махбодийг хүлээн авах адислалаа үгүй болгосон (Илчлэлт 12:9-ийг үз). Алдар суугийн хаант улсыг өвлөн авах тэдний боломжийг үгүй болгосон.

Тэнгэрлэг Эцэг Сатан болон Сатаны дагалдагчдийг зуурдын байдалд бидний туршилтын нэг хэсэг болгон биднийг уруу татахыг зөвшөөрсөн юм (2 Нифай 2:11–14; С ба Г 29:39-ийг үз). “Тэрээр бүх хүмүүнийг өөрийн адил зовлонт байж болохыг эрэлхийлдэг” учраас (2 Нифай 2:27) Сатан болон түүний дагалдагчид биднийг зөв шударга байдлаас холдуулахыг хичээдэг. Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын төлөвлөгөөний хамгийн чухал үзэл баримтлалыг тэр өөрийн хамаг хүчээ дайчлан эсэргүүцдэг. Жишээ нь, Тэр Цагаатгалын хүчийг сааруулж, илчлэлтийг гүйвуулж, үнэнээс биднийг холдуулж, хувь хүмүүсийн хариуцлагыг зөрчилдүүлэхийн тулд Аврагч болон санваарыг гутаахаар эрэлхийлдэг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүрэг болон бие биедээ харилцан татагдах чанарыг бусниулж, гэрлэлтээс гадуурх сексийн харилцааг сурталчилж, гэрлэлтийг тохуурхан басамжилж, үр хүүхдээ зөв шударгаар өсгөн хүмүүжүүлэх гэрлэсэн хосуудын урмыг хугалан гэр бүлийг дордуулах оролдлыг тэр хийдэг.

Та Сатаны уруу таталтанд орох албагүй. Сайн мууг ялгаж салгах хүч танд бий, залбирлаар дамжуулан Их Эзэний тусlamжийг үргэлж эрж хайж чадна (“Уруу таталт” х.201-ийг үз).

Нэмэлт судрууд: Исаиа 14:12–17; 1 Нифай 15:23–24; 2 Нифай 2:16–18; Моронай 7:12; С ба Г 10:5; 29:36–40, 46–47; 76:25–29

Нүгэл; Сонголт; Уруу таталтыг мөн үз.

## Сион

Сургаал ба Гэрээнд Их Эзэн Гэгээнтнүүдийг “Сионы ашиг сонирхлыг авчирч мөн төлөвшүүлэхийг эрэлхийлэгтүн” хэмээн зарлигласан олон хэсэг байдаг (С ба Г 6:6; мөн С ба Г 11:6; 12:6; 14:6-г үз).

Сион хэмээх үгний утга судруудад хэд хэдэн янзаар орсон байдаг. Энэ үгний хамгийн өрөнхий тодорхойлолт бол “зүрх сэтгэлдээ цэвэр ариун” гэсэн нь юм (С ба Г 97:21). *Сион* нь Их Эзэний хүмүүс болон Сүм мөн үүний гадаснуудыг авч үзэх замаар олонтаа хэрэглэгддэг (С ба Г 82:14-ийг үз).

Энэ эрин үеийн эхэнд Сүмийн удирдагчид Сионыг барьж байгуулахаар төв газар нүүн ирж, гишүүдтэйгээ зөвшилдсөн. Өнөөдөр манай удирдагчид биднийг амьдарч буй газраа Сионыг барихыг зөвлөдөг. Сүмийн гишүүдэд өөрсдийн унаган газартаа үлдэж, тэндээ Сүмийг үндэслэн байгуулахыг хүсдэг. Олон ариун сүмүүд баригдаж байна, иймээс дэлхий даяарх Хожмын Үеийн Гэгээнтнүүд ариун сүмийн адислалуудыг хүлээн авдаг.

*Сион* хэмээх үг нь дараах газарзүйн онцгой байрлаалуудыг мөн авч үзэж болно:

- Енохын хот (Моше 7:18–21-ийг үз).
- Эртний Иерусалим хот (2 Самуел 5:6–7; Хаадын дээд 8:1; Хаадын дэд 9:28-ыг үз).
- Миссурийн Жаксон мужид баригдах Шинэ Иерусалим (С ба Г 45:66–67; 57:1–3; Итгэлийн Тунхаг 1:10-ыг үз).

## Сонголт

Таны Тэнгэрлэг Эцэг сонгох болон өөрийнхөө өмнөөс үйлдэх чадвар болох сонголтыг танд өгсөн. Сонголт

нь авралын төлөвлөгөөнд их чухал юм. Үүнгүйгээр, та сурч, боловсорч, Аврагчийг дагах чадваргүй байх байсан. Та нар үүгээр “Бүх хүмүүний агуу Зуучлагчаар дамжуулан, эрх чөлөө болон мөнхийн амьдралыг сонгох, эсвэл чөтгөрийн хүч мөн боолчлолын дагуу, боолчлол болон үхлийг сонгох эрхтэй” (2 Нифай 2:27).

Танд таныг төрөхөөс өмнө ч сонгох хүч байсан. Тэнгэр дэх зуурдын байдлын өмнөх Тэнгэр дэх Зөвлөлд Тэнгэрлэг Эцэг сонголтын зарчмыг агуулсан Өөрийн төлөвлөгөөг танилцуулсан. Люсифер бослого гаргаж “хүмүүний сонгох эрхийг эрэлхийлжээ” (Моце 4:3). Үүний үр дүнд Люсифер болоод түүнийг дагасан тэдгээр нь зуурдын бие махбодыг хүлээн авах эрхээс татгалзсан. Дэлхий дээр таны оршин байгаа нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг дагахаар өөрийн сонголтыг ашигласныг баталж байгаа юм.

Та зуурдын байдалд үргэлжлүүлэн сонголт хийдэг. Энэ бэлгийг хэрэглэх нь энэ амьдралд болон ирэх амьдралд тохиох уйтгар гуниг, эсвэл аз жаргалыг тодорхойлдог. Та сонгох болон үйлдэхдээ эрх чөлөөтэй ч өөрийнхөө үйлдлийн үр дагаварт хариуцлага хүлээх ёстой. Үр дагаврууд нь шууд илрэхгүй байж болно, гэхдээ тэдгээр нь үргэлж хойноос дагаж байдаг. Зөв шударга болон сайн сонголтууд нь аз жаргал, амар амгалан болон мөнхийн амьдрал руу хөтөлдөг, харин хилэнцэт болон нүглийн сонголтууд нь мэдээж уй гашуу, өрөвдөлтэй байдалд хүргэдэг.

Та хийж байгаа шийдвэрүүддээ хариуцлага хүлээнэ. Та Бурханы зарлигийг зөрчих сонголт хийх байдалд нөхцөл байдал, гэр бүл, эсвэл найз нөхдөө буруутгах ёсгүй. Та агуу их хүч чадалтай Бурханы хүүхэд мөн. Нөхцөл байдлаас үл хамааран танд зөв шударга ёс хийгээд аз жаргалыг сонгох чадвар байдаг.

Та Тэнгэрлэг Эцэгийн танд өгсөн авьяас чадварыг хөгжүүлэх хэрэгтэй. Та тэрхүү чадвараараа юу хийх болон цагаа хэрхэн ашиглаж байгаадаа Түүний өмнө хариуцлага хүлээнэ. Залхуу хойрго байж цаг бүү алд. Шаргуу хөдөлмөрлөх хүсэлтэй бай. Чөлөөт хүслээрээ олон сайн зүйлийг хийхийг сонго.

Нэмэлт ишлэлүүд: Тооллого 11:26–28; 30:15–20; Иошуа 24:14–15; 2 Нифай 2; Хиламан 14:30–31; С ба Г 58:26–28; 101:78

Авралын Төлөвлөгөө; Дуулгавартай Байдал; Уруу таталтыг мөн үз.

## Судрууд

Бурханы ариун эрс Ариун Сүнсний хүчээр бичиж, ярихад тэдний үгс “судар байх болно, Их Эзэний хүсэл зориг байх болно, Их Эзэний оюун байх болно, Их Эзэний үг байх болно, Их Эзэний дуу хоолой байх болно, мөн аврал дахь Бурханы сүр хүч буюу” (С ба Г 68:4). Албан ёсны Сүмийн зөвшөөрөлтэй судрууд болох Библи, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувдыг жишиг бүтээлүүд гэж нэрлэдэг. Эдгээр судрын номуудыг х.108-д дүрслэн үзүүлэв.

### Өдөр Бүр Судраас Судлахын Ач Холбогдол

Судрын үндсэн зарчим нь биднийг Түүн рүү очиход болон мөнх амьдралыг хүлээн авахад туслан Христийг гэрчлэхэд байдаг (Иохан 5:39; 20:31; 1 Нифай 6:4; Мозая 13:33–35-ыг үз). Бошиглогч Мормон гэрчлэхдээ:

“Тийм ээ, чөтгөрийн бүх башир аргыг мөн урхи мөн залийг нь тасчин хуваах тэр, амьд мөн хүчирхэг тэр, мөн ёсон бусыг үйлдэгчдийг залгихаар бэлтгэгдсэн зовлонгийн үүрдийн ангал дээгүүр гарах, давчуу бөгөөд нарийн замаар Христийн хүмүүнийг удирдах тэр, Бурханы үгэн дээр тулгуурлахыг хүсэх хэн боловч тулгуурлаж—

“Мөн тэнгэрийн хаант улсад Бурханы баруун мутар талд, Абрахамтай, мөн Исаак, мөн Иаковтай, мөн бидний бүх ариун эцэг өвгөдийн хамт, цаашид гарагүйгээр суухаар өөрсдийн бодгалиудаа байрлуулж болохыг бид үзэж болно” (Хиламан 3:29–30).

Хожмын үеийн бошиглогчид биднийг өдөр бүр хувиараа болон гэр бүлтэйгээ хамт судраас судлахыг зөвлөдөг. Нифай ах нараа урамшуулж байсан шиг өнөөдөр амьдралдаа эртний хүмүүсийн нандин шастирыг ашиглах арга замыг олж, судруудыг өөрсөтгэйгөө адилтгахад тэд биднийг урамшуулан дэмждэг (1 Нифай 19:23–24-ийг үз). Биднийг “судраас судалж” (Иохан 5:39), “Христийн үгэн дээр хуримлахыг” хичээнгүйлэн сэнхрүүлдэг (2 Нифай 32:3).

Энэхүү зөвлөгөөг дагаснаар та их ашиг тусыг олох болно. Өдөр бүр, үр дүнтэй судраас судлах нь Ариун Сүнсний шивнээг хүлээн авахад танд тусалдаг. Уруу таталтын эсрэг таныг хамгаалдаг тэрхүү итгэлийг босгож, Тэнгэрлэг Эцэг хийгээд Түүний Хайрт Хүнд ойртон очиход тусална.

Судраас хувиараа судлах төлөвлөгөө боловсруул. Өдөр бүр судраас судлах цаг гарга. Тэр үедээ Сүнсний өдөөлтөд анхаарч, нарийн сайн унш. Тэнгэрлэг Эцэгээсээ таныг юу сурч, юу хийхийг хүсч буйг мэдэхэд нь туслахыг хүс.

Судруудаа, ялангуяа Мормоны Номыг амьдралынхаа турш үргэлжлүүлэн унш. Та судруудын эрдэнэсийг амьдралынхаа өөр өөр үеүдэд тэднийг судлахдаа шинэ утга, хэрэглээг олж дахин дахин нээх болно.

Хэрэв та гэрлэсэн бол гэр бүлтэйгээ судраас судлах цаг гарга. Хичээл зүтгэл нь хэцүү байж болно, гэвч гайхалтай, мөнхийн үр дүнг өгнө. Сүнсний удирдамжийн дагуу гэр бүлийнхээ хэрэгцээнд нийцүүлэн судар уншихаар төлөвлө. Бяцхан хүүхдүүдэд судар уншиж

өгөхөөс бүү эмээ. Нандин бичвэрийн тэрхүү хэллэг бяцхан хүүхдэд ч хүрэх хүч бий.

## Библи

Библи нь хоёр хэсэгт хуваагддаг: Хуучин Гэрээ ба Шинэ Гэрээ. Хуучин Гэрээ нь ариун газар дахь Өөрийн гэрээт хүмүүстэй харьцах харьцааны нандин бичвэр билээ. Энэ нь Мose, Иошуа, Исаиа, Иеремиа болон Даниел зэрэг бошиглогчдын заасан зүйлсийг агуулдаг. Шинэ Гэрээнд Аврагчийн төрөлт, зуурдын тохинуулал, хийгээд Цагаатгалыг цэдэглэсэн байдаг. Энэ нь Аврагчийн шавь нарын тохинууллаар төгсдөг.

Библийг олон удаа орчуулсан учраас өөр өөр хувилбараар хэвлэгджээ. Англи хэл дээрх Хaan Жeймсийн Библийн хувилбар нь Сүмийн судар болон хүлээн зөвшөөрөгджээ.

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд бид Библи болон үүний нандин заасан зүйлсийг хүндэтгэн үздэг. Бид Бурханы хүмүүстэй харилцсан харилцааны талаарх Библийн шастираас хүч чадал хийгээд тайвшралыг хүлээн авдаг.

## Мормоны Ном: Есүс Христийн Бас Нэгэн Гэрээ

Мормоны Ном нь Их Эзэний хүсэл зоригоор манай эрин үед ирсэн билээ. Энэ бол эртний Америк тивд амьдарч байсан хүмүүстэй харилцсан Бурханы харилцааны цэдэг юм. Их Эзэний Бошиглогчид анх цэдгээ алтан ялтсан дээр сийлбэрлэжээ. Мормоны Ном нь “Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдлыг агуулдаг” хэмээн Их Эзэн тунхагласан юм (С ба Г 20:9; мөн С ба Г 42:12-ыг үз).

1827 оны Есдүгээр сарын 22-нд Моронай хэмээх тэнгэр элч Мормоны Номны хамгийн сүүлчийн бошиглогч—эдгээр цэдгийг Бошиглогч Иосеф Смитэд

авчирчээ. Энэхүү Бурханы хүч хийгээд бэлгээр Бошиглогч Иосеф тэрхүү цэдгийг англи хэлнээ орчуулсан юм. Тэр цагаас хойш Мормоны Номыг бусад олон хэлээр орчуулж байна.

Мормоны Номын үндсэн зорилго нь бүх хүмүүст “өөрийгөө бүх үндэстнүүдэд үзүүлэх тэр Есүс бол Христ, Мөнхийн Бурхан” гэж ухуулан сэнхрүүлэхэд байгаа юм (Мормоны Номны эхний хуудас). Бүх хүмүүс “түүнд ирэх ёстой, эс бөгөөс тэд аврагдаж чадахгүй” хэмээн энэ нь заадаг (1 Нифай 13:40). Мормоны Ном бол “шашны маань тулгуурын чулуу, мөн бусад ямар ч номноос илүүгээр, үүний зааврыг мөрдсөнөөр хүмүүн Бурханд илүү ойртох болой” хэмээн Иосеф Смит хэлжээ (Мормоны Номын удиртгал).

Мормоны Ном бол Библид зааж сургадаг үнэний өөр нэг гэрч билээ. Орчуулгын алдаа эсвэл “Их Эзэний зөв замыг гажуудуулах” оролдлогоор “авч зайлцуулснаас” үүдэн Библиэс алдагдсан “эрхэм үнэт” үнэнийг мөн сэргээдэг (1 Нифай 13:24–27, 38–41-ийг үз). Библи болон Мормоны Ном “буруу сургаалыг бүрмөсөн үгүйсгэх мөн маргаан тэмцлийг намжаан, мөн хэвлүйн чинь үрсийн дунд амгаланг тогтоон хамтран нэгдэх болно” (2 Нифай 3:12).

Мормоны Номын төгсгөл хэсэгт бошиглогч Моронай бидэнд энэхүү ном үнэн гэдгийг яаж мэдэх вэ гэдгийг заадаг: “Мөн та нар эдгээр зүйлүүдийг хүлээн аваад, та нар Бурхан, Мөнхийн Эцэгээс, Христийн нэрээр, эдгээр зүйлүүд нь үнэн эсэхийг асуухыг би та нарт ухуулья; мөн хэрэв та нар Христэд итгэлтэй байж, чин сэтгэлтэйгээр, үнэн хүсэлтэйгээр асуух аваас, тэрбээр үүний үнэнийг, Ариун Сүнсний хүчээр та нарт мэдүүлэх болно” (Моронай 10:4; мөн шүлэг 3 ба 5-ыг үз).

## Сургаал ба Гэрээ

Сургаал ба Гэрээнд Бошиглогч Иосеф Смитэд өгсөн илчлэлтүүд багтдаг. Түүнчлэн үүнд бусад хожмын үеийн бошиглогчдод өгсөн цөөн хэдэн илчлэлтүүдийг агуулдаг. Энэхүү судрын ном нь хосгүй билээ. Учир нь энэ нь эртний бичвэрийн орчуулга биш. Энэ бол Их Эзэн хожмын өдрүүдэд Өөрийн сонгосон бошиглогчид доо өгсөн илчлэлтүүдийн цуглувалга юм.

Сургаал ба Гэрээ бол “эдгээр эцсийн өдрүүдэд Сүмийн суурь, мөн дэлхийд ашиг тус болж, бидний Аврагчийн хаант улсын нууцуудын түлхүүрүүд хүмүүнд дахин итгэл хүлээлгэн өгөгдсөн нь юм” хэмээн Бошиглогч хэлжээ (С ба Г 70-ын оршил хэсэг).

## Агуу Үнэт Сувд

Агуу Үнэт Сувд бол Мосегийн ном, Абрахамын ном, Бошиглогч Иосеф Смитийн Матай 24-р бүлгийн бурхан-лигаар урамшуулагдсан орчуулга болон Бошиглогч Иосефын зарим нэг бичвэрүүдийг агуулдаг.

Мосегийн ном нь Иосеф Смитийн Библийн бурхан-лигаар урамшуулагдсан орчуулгын жижиг хэсэг билээ. Энэ бол Хуучин Гэрээний Эхлэл номын эхэн дэх Мосегийн бичвэрүүдийн бүрэн цэдэг юм. Энэ нь Библиэс алдагдсан олон сургаал болон заасан зүйлийг багтаадаг бөгөөд авралын төлөвлөгөөний талаар, дэлхийн бүтээлт мөн Адам, Енохтой харьцсан Их Эзэний харьцааны талаар нэмэлт мэдээллийг өгдөг.

Абрахамын ном нь 1835 онд Сүмийн мэдэлд ирсэн муутуу цаасан дээр бичигдсэн эртний бичээсүүдийн орчуулга юм. Бошиглогч Иосеф Смит тэрхүү бичээсийг илчлэлтээр орчуулсан. Энэхүү ном зуурдын байдлын өмнөх Тэнгэр дэх Зөвлөл, дэлхийн үүсэл, Бурханы шинж чанар болон санваарын тухай үнэнийг агуулдаг.

## *Сургаал ба Гэрээ*

Иосеф Смит–Матай Хоёр дахь Ирэлтийнх нь тухай Аврагчийн заасан зүйлүүдийг мэдлэг дээр нэмж өгдөг.

Агуу Үнэт Сувд дахь Иосеф Смитийн бичээсүүд:

- Иосеф Смитийн Түүх нь Сүмийн Бошиглогчийн түүхээс авсан хэсэг юм. Энэ нь Сүмийн сэргээлт, Анхны Үзэгдэл, Бошиглогч Иосеф Смитэд Моронайгийн айлчлал, алтан ялтыг олж авч байгаа болон Аароны Санваарын сэргээлтийн талаар хүүрнэсэн үйл явдал юм.
- Бошиглогч Иосеф Смит итгэл хийгээд сургаалын үндсэн мэдэгдэл болгон бичсэн Итгэлийн Тунхагийг агуулдаг.

Нэмэлт судрууд: Ром 15:4; 2 Тимот 3:15–17; 2 Нифай 25:26; Алма 17:2–3; 3 Нифай 23:1–5; С ба Г 18:33–36; Итгэлийн Тунхаг 1:8

Бошиглогчид; Илчлэлт; Сайн Мэдээний Сэргээлтийг мөн үз.

## **Сургаал ба Гэрээ** (Судруудыг үз)

### **Сүмийн Захиргаа**

Есүс Христ бол сүмийн тэргүүн юм. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн үүрэг бол бүх хүмүүсийг Түүн рүү ирэхэд нь туслах юм (Моронай 10:32–ыг үз). Энэхүү үүргээ биелүүлэхийн тулд уг Сүм нь Их Эзээний “бид бүгд итгэл хийгээд Бурханы Хүүг мэдэх мэдлэгийн нэгдэл хүртэл . . . төлөвшсөн хүн болтол” илчилсэн загварын дагуу зохион байгууллагдсан (Ефес 4:12–13; мөн 11-р шүлгийг үз). Дараах гол санаа нь Сүмийн байгууллагын тухай товчлон үзүүлж байгаа юм.

## Өрх Гэр ба Гэр Бүл

Гэр бүл нь Сүмд суурь нэгж болдог ба өрх гэр нь сайн мэдээг сурхад хамгийн чухал газар мөн. Өөр ямар ч байгууллага гэр бүлийн орчинг бүрдүүлж чадахгүй. Тэр ч байтугай Сүм өсч өргөжсөн ч үүний зорилго нь гэр бүлүүд болон хувь хүмүүсийг сайн мэдээгээр амьдрах хичээл зүтгэлээр нь үргэлж хүчирхэгжүүлэн дэмжихэд оршино.

## Ерөнхий Захиргаа

Өнөөдөр Их Эзэн Өөрийн гэрээт хүмүүсээ бидний дэмждэг бошиглогч, үзмэрч болон илчлэгч болох Сүмийн Ерөнхийлөгчөөр дамжуулан удирддаг. Сүмийн Ерөнхийлөгч нь Сүмийг бүхэлд нь тэргүүлдэг. Тэр болон түүний зөвлөхүүд болох бошиглогчид, үзмэрч, илчлэгчид нь Тэргүүн Зөвлөлийн Чуулгыг бүрдүүлдэг.

Арванхоёрын Чуулгын гишүүд нь мөн бошиглогчид, үзмэрч, илчлэгчид юм. Тэд Тэргүүн Зөвлөлийн хамтаар “бүх дэлхийд Христийн нэрний тусгай гэрчүүд” билээ (С ба Г 107:23). Тэд Тэргүүн Зөвлөлийн удирдлага дор “сүмийг төлөвшүүлдэг, бүх үндэстний бүх хэрэг явдлыг зохицуулах” ажлыг гүйцэтгэдэг (С ба Г 107:33). Тэд “бүх үндэстэнд хаалгыг нээх болгөө” (С ба Г 107:35).

Далын Чуулгын гишүүд нь сайн мэдээг тунхаглах хийгээд Сүмийг барьж байгуулахаар дуудагддаг. Тэд Арванхоёр Төлөөлөгчийн удирдлага дор үйлчилдэг. Нэг дэх мөн Хоёр дахь Dalyn Чуулгын гишүүдийг Ерөнхий Эрх Мэдэлтнүүд болгон зохион байгуулдаг бөгөөд тэд дэлхийн аль ч хэсэгт үйлчлэхээр дуудагдаж болно.

Тэргүүлэх Бишопын Зөвлөл нь тус Сүмийн хувьд Аароны Санваарын ерөнхийлөгчийн зөвлөл юм. Тэргүүлэх Бишоп болон түүний зөвлөхүүд нь Тэргүүн

## *Сүмийн Захиргаа*

Зөвлөлийн удирдлага дор Сүмийн цаг зуурын үйл хэргийг удирдахаар үйлчилдэг.

Залуу Эрэгтэйчүүд, Нийгмийн Халамжийн Бүлэг, Залуу Эмэгтэйчүүд, Хүүхдийн Хэсэг болон Ням Гарагийн Сургууль байгууллагууд нь бүгдээрээ Сүм даяар зааварчилгаа болон удирдамж үзүүлэх ерөнхийлөн удирдах зөвлөлтэй байдаг.

### **Бүсийн Захиргаа**

Бүс нь газарзүйн байрлалын хувьд Сүмийн хамгийн том хэсэг юм. Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөл Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын удирдлага дор Сүмийн сонгосон хэсгүүдийг хянахаар шууд томилдог. Бүсийн Ерөнхийлөгч болон түүний Зөвлөлчүүд нь Арванхоёрын Чуулга болоод Далын Чуулгаас томилогддог.

Зарим ах нар Далын албад томилогддог боловч Ерөнхий Эрх Мэдэлтнүүд шиг үйлчилдэггүй. Тэднийг Бүсийн Эрх Мэдэлтэй Далууд гэх ба газарзүйн байрлалын дагуу Далын Нэг, Хоёрдугаар Чуулгаас бусад чуултууд руу томилдог. Тэдний хянах хяналт нь амьран суугаа ерөнхий бүсдээ хязгаарлагдмал байдаг. Бүсийн зарим Эрх Мэдэлтэй Далууд Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлчүүдэд үйлчилдэг.

### **Орон Нутгийн Захиргаа**

Хэсгүүд болон Салбарууд. Сүмийн гишүүд нь сүнслэг болон нийгмийн үйл ажиллагаанд тогтмол хамтдаа цуглардаг цуглаанд зохион байгуулалттайгаар оролцдог. Томоохон цуглааныг хэсэг гэнэ. Хэсэг болгоныг бишоп, хоёр зөвлөхийн туслалцаатайгаар тэргүүлдэг.

Жижиг цуглааныг салбар гэж нэрлэнэ. Салбар бүрийг салбарын ерөнхийлөгч, хоёр зөвлөхийн туслалцаа-

тайгаар тэргүүлнэ. Дор хаяж хоёр гишүүн гэр бүл бүсэд оршин сууж, гишүүдийн нэг нь зохистой Мелкизедек Санваартан буюу зохистой Аароны Санваартан байгаа тохиолдолд салбарыг зохион байгуулж болдог. Гадас, номлол, буюу дүүргийн ерөнхийлөгчийн зөвлөл тухайн салбарыг зохион байгуулж, хянадаг. Салбар нь гадаст байрладаг бол хэсэг болж өргөжиж болдог.

Хэсэг буюу салбар тус бүр тодорхой газарзүйн бүсийг хамардаг. Хэсэг буюу салбар дахь өөр өөр байгууллагууд нь Их Эзэний ажил болох: дээд санваартны бүлэг, ахлагч нарын чуулга, 18 буюу түүнээс дээш насны эмэгтэйчүүдэд зориулсан Нийгмийн Халамжийн Бүлэг, 12–17 насны залуу эрэгтэйчүүдэд зориулсан Аароны Санваарын чуулгууд, 12–17 насны залуу эмэгтэйчүүдэд зориулсан Залуу Эмэгтэйчүүдийн хөтөлбөр, 18 сараас 11 нас хүртэлх хүүхдүүдийн Хүүхдийн Хэсэг, 12 ба түүнээс дээш насны Сүмийн бүх гишүүдэд зориулсан Ням Гарагийн Сургуульд хувь нэмэр оруулдаг. Эдгээр байгууллагууд тус бүр нь сайн мэдээг заах, үйлчлэл үзүүлэх, мөн эцэг эхчүүдийг хүүхдүүддээ Есүс Христийн сайн мэдээнд хөрвүүлэхэд туслах ариун үүрэгт дэмжих чухал үүргүүдийг гүйцэтгэдэг. Эдгээр байгууллагууд нь гишүүдийг сайн мэдээг бусадтай хуваалцаад нь туслахын тулд хамтран ажилладаг.

*Гадас Номлол болон Дүүргүүд. Сүм зохион байгуулагддаг ихэнх газарзүйн бүсүүд нь гадаснуудад хуваагддаг. Гадас гэдэг үг нь хожмын өдрүүдэд Сүм гадаснуудаар тойруулан хамгаалагдсан майхан лугаа адил байх болно хэмээн бошиглосон бошиглогч Исаиагаас эхтэй (Исаиа 33:20; 54:2). Нэг гадасанд ихэвчлэн 5-12 хэсэг буюу салбар байдаг. Гадас бүрийг гадасны ерөнхийлөгч, хоёр зөвлөхийн туслалцаатайгаар тэргүүлдэг. Гадасны ерөнхийлөгчид нь Далын Ерөнхийлөгчийн Зөвлөл болон Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлөөс удирдамж хүлээн авч, улмаар мэдээлэл өгдөг.*

Номлол бол ерөнхийдөө гадасны хамрах бүсийг бодвол илүү өргөн хүрээтэй Сүмийн нэг нэгж юм. Номлол бүрийг номлолын ерөнхийлөгч, хоёр зөвлөхийнхөө туслалцаатайгаар тэргүүлдэг. Номлолын ерөнхийлөгчид нь Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн өмнө шууд хариуцлага хүлээдэг.

Салбар хэсгийн багасгасан хувилбарын адил, дүүрэг бол гадасны багасгасан хувилбар юм. Бүсэд хангарттай хэмжээний салбарууд байрлаж байвал дүүргийг хялбар харилцаа холбоо хийгээд дүүргүүдийн хурлууд руу аялахад хялбар байхыг бодож зөвшөөрөл олгож, зохион байгуулдаг. Дүүргийн ерөнхийлөгч нь хоёр зөвлөхүүдийн туслалцаатайгаар тэргүүлдэг. Дүүргийн ерөнхийлөгч нь номлолын ерөнхийлөгчид тайлангаа тавьдаг. Дүүрэг нь гадас болж өргөжиж болдог.

Ганц Бие Гишүүдэд Зориулсан Хөтөлбөрүүд. Сүмийн олон гишүүд урьд өмнө нь хэзээ ч гэрлэж байгаагүй буюу салсан, эсвэл бэлэвсэrsэн байдаг. Эдгээр гишүүдийг хоёр бүлэг: ганц бие залуу насанд хүрэгчид (18-aac 30 нас хүртэлх) ба ганц бие насанд хүрэгчид (31 буюу түүнээс дээш) гэж хуваадаг.

Ганц бие залуу насанд хүрэгчид болон ганц бие насанд хүрэгчдэд зориулсан бүх Сүмийг хамарсан хөтөлбөр байдагтүй. Харин үүний оронд, нэг бүсэд хангарттай олон ганц бие гишүүд амьдардаг бол орон нутгийн санваарын удирдагчдын удирдлага дор ажиллах ганц бие гишүүдийн төлөөлөгчдийг дуудахыг тэднээс хүсдэг. Ганц бие-гишүүн төлөөлөгчид бүжиг, үйлчлэлийн төслүүд болон галын дэргэдэх ярилцлага зэрэг үйл ажиллагаануудыг төлөвлөдөг. Эдгээр үйл ажиллагаанууд нь ганц бие гишүүд бие биетэйгээ уулзаж, хүчирхэгжүүлэх боломжийг олгодог. Ганц бие гишүүдийг санваарын удирдагчидтайгаа тогтмол уулзаж, сүнслэг байдлаараа

өсөх хийгээд үйлчлэлийн боломж, хэрэгцээний талаар ярилцахыг сайшаан дэмждэг.

Нэмэлт судар: С ба Г 107

Нийгмийн Халамжийн Бүлэг; Санваарыг үз.

## Сүмийн Сахилгын Зөвлөлүүд

Бишоп, салбарын ерөнхийлөгчид, гадас, номлол болон дүүргийн ерөнхийлөгчид нь гишүүдэд наманчлааар дамжуулан алдсыг даван туулахад нь туслах үүрэг хариуцлагатай байдаг. Хамгийн ноцтой алдсууд болох иргэний хуулийг ноцтойгоор зөрчих, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийлэл, завхайрал, хүчин болон цус нэгэнтэйгээ бэлгийн харьцаанд орох зэрэг нь ихэнхдээ Сүмийн албан ёсны сахилгыг шаарддаг. Сүмийн албан ёсны сахилга нь Сүмийн гишүүнчлэлээ алдах буюу Сүмийн гишүүнчлэлийн онцгой эрхийн хязгаарлалтыг хамруулж болно.

Албан ёсны сахилгын үйл явц нь тэргүүлэх санваарын удирдагч сахилгын зөвлөлийг дуудсанаар эхэлдэг. Сахилгын зөвлөлүүдийн зорилго нь алдас үйлдэгч бодьгалыг аврах, гэмгүй нэгнийг хамгаалах, цэвэр ариун, зарчимч байдал хийгээд Сүмийн сайн нэрийг хамгаалахад оршдог.

Сүмийн сахилга нь бурханлигаар нөлөөлөгдсөн үйл явц болон тодорхой хугацаа шаарддаг. Гишүүн энэхүү үйл явц болоод Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан нүглийн учалыг хүлээн авч, оюун санаандаа амар амгаланг олж, ирээдүй дэх алдсаас зайлсхийг хүчийг олж авч чадна. Сүмийн сахилга нь үйл явцын төгсгөл байх албагүй. Энэ нь Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийг хичээл зүтгэлээр Сүмийн бүрэн адислал хийгээд нөхөрлөлд эргэн очиход нь туслахад зориулагдсан юм. Хүссэн үр дүн

## **Сүнс**

нь хүн бүрмөсөн наманчлахын тулд шаардлагатай гэх ямарваа өөрчлөлтийг хийх явдал билээ.

Наманчлал; Өршөөлийг мөн γз.

## **Сүнс**

Та бол Тэнгэрлэг Эцэгийн хүүхэд бөгөөд дэлхий дээр мэндлэхээсээ өмнө сүнсэн байдлаар оршиж байсан юм. Дэлхий дээрх амьдралын турш таны сүнс зуурдын байдлын эцэг эхээс төрсөн бие махбодь дотор байрладаг.

Судраас бид сүнсний мөн чанарыг сурдаг. “Бүх сүнс матери мөн, харин энэ нь илүү нарийн, эсвэл цэвэр, мөн гагцүү илүү цэвэр мэлмийгээр ялгагдан танигдаж болно” гэдгийг бид сурдаг (С ба Г 131:7). “Хүмүүний сүнс нь өөрийнх нь биеийн адил төстэй байдал дахь хүмүүний сүнс болой, тэрчлэн бас амьтны сүнс, мөн Бурханы бүтээсэн бусад амьд болгоных бөлгөө” гэдгийг бид уншдаг (С ба Г 77:2; мөн Ифэр 3:7–16-г γз).

Судрууд бие махбодийн үхлийн үед тухайн сүнс үхдэггүй гэдгийг заадаг. Энэ нь биеэс салж, зуурдын байдлын дараах сүнсний дэлхийд амьдардаг. Амилуулалтын үед сүнс биетэй “тэд дахин ялзралыг үзэж чадахгүй болон, тийн бүхэл бүтнээрээ сүнслэг, мөн үхэшгүй байдалд” эргэн нэгддэг (Алма 11:45).

Нэмэлт судрууд: Ром 8:16–17; 2 Нифай 9:10–13; С ба Г 93:29, 33

Авралын Төлөвлөгөө; Амилуулалт; Бодгалийг мөн γз.

## **Сүнслэг Бэлгүүд**

Сүнслэг бэлэг нь Ариун Сүнсний хүчээр өгөгдсөн адислал буюу чадвар юм. Бурхан эдгээр бэлгүүдийн дор хаяж нэгийг Сүмийн итгэлтэй гишүүн бүрт өгдөг. Эдгээр бэлгүүдийг авснаар хувь хүний хувьд адисалж,

бусдад үйлчлэхэд тань тусална (С ба Г 46:8–12-ыг үз). Судруудад Сүнсний олон бэлгүүдийн талаар заадаг:

- “Есүс Христ бол Бурханы Хүү, мөн тэрээр дэлхийн нүглүүдийн төлөө цовдлогдсон” хэмээх мэдлэг (С ба Г 46:13).
- Есүс Христийг гэрчилдэг тэдний үгэнд итгэх чадамж (С ба Г 46:14-ийг үз).
- “Үйлчлэлийн ялгаануудын” талаарх мэдлэг (С ба Г 46:15; мөн 1 Коринт 12:5-ыг үз). Энэ бэлгийг Сүмийг тохинуулах болон удирдахад хэрэглэдэг.
- “Үйл ажиллагааны олон янз байдлыг, эдгээр нь Бурханаас байна уу эсвээс өөр бусад эх сурвалжаас байна уу” хэмээх мэдлэг (С ба Г 46:16; мөн 1 Коринт 12:6–7-г үз).
- “Мэргэн ухааны үгийн” бэлэг (1 Коринт 12:8; С ба Г 46:17). Энэ нь бидний мэдэх Мэргэн Ухааны Үгийн хууль биш юм. Цэцэн мэргэний бэлэг—мэдлэгийг зөв шударга замаар хэрэглэх чадвар юм.
- “Мэдлэгийн үгсийн” бэлэг (1 Коринт 12:8; С ба Г 46:18).
- Ариун Сүнсний хүчээр заах чадвар (Моронай 10:9–10; мөн С ба Г 46:18-ыг үз).
- Итгэлийн бэлэг (1 Коринт 12:9; Моронай 10:11-ийг үз).
- “Эдгэрэх итгэлтэй байх” бэлэг (С ба Г 46:19).
- “Эдгээх итгэлтэй байх” бэлэг (С ба Г 46:20; мөн 1 Коринт 12:9; Моронай 10:11-ыг үз).
- “Гайхамшигуудыг үйлдэх” (1 Коринт 12:10; С ба Г 46:21; мөн Моронай 10:12-ыг үз).

## Сүнслэг Бэлгүүд

- Бошиглолын бэлэг (1 Коринт 12:10; Моронай 10:13; С ба Г 46:22-ыг үз). Хайрт Иохан заахдаа: “Есүсийн гэрчлэл бол эш үзүүлэгчийн сүнс мөн” хэмээжээ (Илчлэлт 19:10).
- “Сахиулсан тэнгэрүүдийг мөн тохинуулах сүнснүүдийг болгоох нь” (Моронай 10:14).
- “Сүнснүүдийг ялган таних нь” (1 Коринт 12:10; С ба Г 46:23).
- Θөр хэлнүүдээр ярих бэлэг (1 Коринт 12:10; Моронай 10:15; С ба Г 46:24-ийг үз).
- “Хэлнүүдийг хөрвүүлэх” бэлэг (1 Коринт 12:10; С ба Г 46:25; мөн Моронай 10:16-г үз).

Эдгээр сүнслэг бэлэг болон сударт бичигдсэн бусад нь Сүнсний олон бэлгүүдийн зарим нэг жишээ билээ. Их Эзэн таны итгэлтэй байдалд, хэрэгцээ болоод таны үйлчилдэг тэдгээрийн хэрэгцээнээс хамааран таныг адисалж болно. Тэр биднийг идэвхтэй ажиллахыг зарлигласан бөгөөд бид сүнслэг бэлгүүдийг хүлээн авч чадна.

“Та нар мэхлэгдэхгүйн тулд болгоомжил; мөн та нар мэхлэгдэхгүйн тулд юуны төлөө тэдгээр нь өгөгдсөнийг ямагт санан хамгийн шилдэг бэлгүүдийг хичээнгүйлэн эрэлхийл;

“Учир нь үнэнээр би та нарт хэлж байна, эрэлхийлдэг, эсвэл nadaас асуудаг, мөн тэд үүнийг шуналт хүслээрээ үрчихэж болох тэрхүү тэмдгийн төлөө бус асуудаг тэд бүгд ашиг тусыг олж болохын тулд тэдгээр нь намайг хайлрадаг хийгээд миний бүх зарлигийг сахьдаг мөн түүнчлэн үйлдэхийг эрэлхийлдэг тэдний ашиг тусын төлөө өгөгддөг болой” (С ба Г 46:8–9; мөн шүлэг 26-г үз).

Нэмэлт судрууд: 1 Коринт 13; 14:1–33; Моронай 10:17–25; С ба Г 46:27–33; Итгэлийн Тунхаг 1:7

Ариун Сүнс; Илчлэлтийг мөн үз.

## Сүнслэг Үхэл

Сүнслэг үхэл гэдэг нь Бурханаас салахыг хэлнэ. Судрууд нь сүнсний үхлийн хоёр эх сурвалжийн талаар заадаг. Эхнийх нь Уналт ба хоёр дахь нь бидний хувийн дуулгаваргүй байдал юм.

Мормоны Номын бошиглогч Сэмүэл “Адамын унаалтаар Их Эзэний дэргэдээс тусгаарлагдсан тул, биеийн зүйлүүд мөн сүнсний зүйлүүдийн аль алинаар нь үхмэл мэт тооцогдсон бөлгөө” гэж сургажээ (Хиламан 14:16). Дэлхий дээрх амьдралынхаа туршид бид Бурханы оршихуйгаас салдаг бөгөөд Цагаатгалаар дамжуулан Есүс Христ хүн бүрийг сүнсний үхлээс гэтэлгэдэг юм. Сэмүэл Аврагчийн Амилуулалт “эхний үхэл—сүнсний үхлээс бүх хүн төрөлхтнийг гэтэлгэх. . . Гэвч болгоогтун, Христийн амилуулалт нь хүн төрөлхтнийг гэтэлгэх, тийм ээ, бүр хүн төрөлхтнийг, мөн тэднийг Их Эзэний дэргэд буцааж авчрах бөлгөө” хэмээн гэрчилжээ (Хиламан 14:16–17). Бошиглогч Лихай Цагаатгалын учир “бүхий л хүмүүн Бурханд ирэх болой; иймийн тул, түүнд байх тэр үнэн болон ариун байдлын дагуу түүгээр шүүгдэхийн тулд түүний дэргэд зогсох болно” (2 Нифай 2:10).

Цаашлаад сүнсний үхэл нь өөрийн дуулгаваргүй байдлын үр дүнгээр бий болдог. Бидний нүгэл биднийг цэвэр бус, Бурханы оршихуйд орших чадваргүй болгодог (Ром 3:23; Алма 12:12–16, 32; Хиламан 14:18; Моце 6:57-г үз). Гэвч зөвхөн Түүнд итгэх итгэлээ хөгжүүлэн, нүглээ наманчлан, зарчмуудыг болон сайн мэдээний ёслолуудыг дагавал Цагаатгалаар дамжуулан, сүнсний үхлээс гэтэлгэнэ хэмээн Есүс Христ санал болгосон (Алма 13:27–30; Хиламан 14:19; Итгэлийн Тунхаг 1:3-ыг үз).

Нэмэлт судрууд: 1 Нифай 15:33–35; Алма 40:26; 42:23

Дуулгавартай Байдал; Есүс Христийн Цагаатгал; Итгэл; Наманчлал; Нүгэл; Уналтыг мөн үз.

## **Сүнслэг Үхэл**

**Сүнслэг Үхэл** (Сүнслэг Үхлийг γз)

**Сүнсний Бэлгүүд** (Сүнслэг Бэлгүүдийг γз)

**Сүнсний Шорон** (Биеийн Үхэл; Диваажин; Тамыг γз)

**Сэлэстиэл Хаант Улс** (Алдар Суугийн Хаант Улсыг γз)

**Тайтгаруулагч** (Ариун Сүнсийг γз)

## **Талархал**

“Бүх эзүүлийг талархалтайгаар хүлээн авдаг тэрээр алдар суут болгогдох болно” хэмээн Их Эзэн амлажээ (С ба Г 78:19). Талархал гэдэг бол урам өгсөн, өргөмжлөхүйн хандлага юм. Магадгүй та зүрх сэтгэлдээ талархалтай байвал аз жаргалтай байдаг гэдгийг өөрийн туршлагаас хэлж чадна. Та баяр баясгалантай үедээ хорссон, хүйтэн, зэвүүн сүнстэй байж чадахгүй.

Өөрийн гайхалтай адислалууддаа талархалтай бай. Өөрт байгаа агуу их боломжууддаа баяртай бай. Эцэг эхдээ талархалтай бай. Тэдэнд баярлаж явдгаа мэдэгдэж бай. Найз нөхөд, багшдаа таларх. Чамд ямар нэгэн байдлаар тусалдаг, түшиж дэмждэг хүн болгонд талархлаа илэрхийл.

Тэнгэрлэг Эцэгтээ өөрт тань сайн байдагт нь таларх. Та Түүний гар бүх зүйлд оролцож байдгийг ухааран, Түүний танд өгдөг бүх зүйлд талархаж, Түүний зарлигуудыг сахиж, бусдад үйлчлэн Бурханд талархлаа илэрхийлж чадна. Түүнд Түүний Хайрт Хүү Есүс Христийн төлөө таларх. Аврагчийн агуу жишгээ, Түүний сургаалууд, Түүний тусалж дэмжих гэсэн бүхэнд хүрдэг гар, Түүний хэмжээлшгүй их Цагаатгалд талархлаа илэрхийл.

Их Эээнд Түүний сэргээгдсэн Сүмийн төлөө таларх. Танд санал болгодог бүх зүйлд таларх. Найз нөхөд болон гэр бүлдээ таларх. Баяр талархалын хандлагатай бай, таны өдрүүдийг адислаг. Баяртай байхын төлөө хөдөлмөрлө. Та үүнийг гайхалтай үр дүнг бий болгоно гэдгийг мэдэх болно.

Нэмэлт судрууд: Дуулал 100:3–4; Лук 17:11–19; Мозая 2:19–22; Алма 34:38; С ба Г 59:7

## Там

Хожмын үеийн илчлэлтүүд нь тамын талаар доод тал нь хоёр янзаар ярьдаг. Нэгдүгээрт, энэ нь “үнэний тухай мэдлэгтгүйгээр, эсвэл бошиглогчдийг эсэргүүцсэний улмаас нүглүүддээ нас нөхчсөн” тэдэнд зориулсан газар боллох зуурдын байдлын дараах сүнсний шоронгийн өөр нэг нэр юм (С ба Г 138:2). Сүнснүүд энэ газар сайн мэдээг заалгах мөн нүглээ наманчлах, ариун сүмүүдэд тэдний төлөө гүйцэтгэдэг авралын ёслолуудыг хүлээн авах түр зуурын байдалд байдаг юм (С ба Г 138:30–35-ыг үз). Тэд сайн мэдээг хүлээн авсан Амилуулалт хүртэл диваажинд амьдрах болно. Тэд амилуулагдаж, шүүгдсэний дараа зохистой хэмжээнийхээ дагуу алдар суугийн зэргийг хүлээн авна. Наманчлахыг сонгоогүй тэд тамын хүүхдүүд биш боловч там болон шийтгэлээс суллагдан, тэлэстиэл алдар сууд амилуулагдах үед сүнсний шоронд Мянган Жилийн эцэс хүртэл байх болно (С ба Г 76:81–85-ыг үз).

Хоёрдугаарт, *там* гэдэг үгийг чөтгөр, түүний элчүүд, чөтгөрийн хүүхдүүдийн амьдардаг газар болох гадаад харанхуйтай холбон үзэж болно (С ба Г 29:36–38; 76:28–33-ыг үз). Тамын хүүхдүүд нь “энэ дэлхийд ч, ирэх дэлхийд ч өршөөл үгүй—Ариун Сүнсийг хүлээн авсныхаа дараа үүнийг үгүйсгэсний учир мөн Эцэгийн Төрсон Ганц Хүүг үгүйсгэсний учир, түүнийг оюун санаандаа цовдолж мөн

## *Тамхи*

түүнийг нийтийн өмнө ичгүүрт тавьсан” тэд юм (С ба Г 76:34–35; мөн 31–33; 36–37-р шүлгүүдийг үз). Ийм хувь хүмүүс алдар суугийн хаант улсыг өвлөн авахгүй; тэдний хувьд там үлдсэн (С ба Г 76:38; 88:24, 32-ыг үз).

Алдар Суугийн Хаант Улсууд; Сатаныг мөн үз

## **Тамхи** (Мэргэн Ухааны Үгийг үз)

### **Төлөв Даруу Байдал**

Төлөв даруу байдал нь хувцаслалт, хэл яриа, зан харьцаандаа ёс журамтай мөн даруу байдлаар хандахыг хэлдэг. Хэрэв та төлөв даруу бол, өөртөө хэт их анхаарал тавихгүй байх болно. Үүний оронд, “биеэрээ болон сүнсээрээ Бурханыг алдаршуулахыг эрэлхийлэх болно” (1 Коринт 6:20; мөн шүлэг 19-ийг үз)

Хэрэв та хувцаслалтандаа эргэлзэж байвал, “Хэрэв би Их Эзэний өмнө байсан бол гадаад байдалдаа сэтгэл хангалауун байх уу?” хэмээн өөрөөсөө асуу. Мөн өөрийнхөө хэл яриа, зан байдлынхаа хувьд ч үүний ижил асуулт асууж болох юм: “Хэрэв Их Эзэний өмнө эдгээр үйл ажиллагаанд оролцох (эсвэл ийм үгийг хэлэх байсан болов уу?” Эдгээр асуултуудад хариулах таны үнэнч шударга хариулт таныг амьдралдаа чухал өөрчлөлтүүдийг хийхэд хөтлөх болно. Дараах мэдээлэл нь төлөв даруу байх таны хичээл зүтгэлд тусална.

### **Хувцаслалт ба Гадаад Төрх**

Даруухан хувцаслахыг бидэнд бошиглогчид үргэлж зөвлөсөөр ирсэн юм. Энэхүү зөвлөгөө нь хүний бие бол Бурханы нандин бүтээл гэдэг үнэн дээр үндэслэгдсэн юм. Хувцаслалт, гадаад байдлаараа та бие махбод тань ямар үнэ цэнэтэй болохыг Их Эзэнд харуулж чадна.

Хувцаслалт тань таныг хэн бэ гэдгийг харуулж өгдөг. Энэ нь таны тухай мэдээллийг дамжуулж, таны болон бусдын үйлдэлд нөлөөлнө. Та төлөв хувцаслааснаар Сүнсний нөхөрлөлийг урьж, эргэн тойрныхоо хүмүүст сайнаар нөлөөлнө.

Төлөв даруу байх зарлигийн гол цөм нь дэлхийд хүүхдүүдийг авчрах чадвар болох өсөн үржихүйн нандин хүчний тухай ойлголт юм. Энхүү хүч нь зөвхөн эхнэр нөхөр хоёрын хооронд хэрэглэгддэг. Ил гарсан, сексийн мэдрэмж төрүүлэм хувцас болох богино өмд, даашинз, бариу хувцас, гэдсээ гаргасан хувцас нь Их Эзэний ариун явдлын хуулийг зөрчдөг тэрхүү үйлдэл, хүслийг бадраадаг.

Түүнээс гадна, иймэрхүү хувцаслалтаас зайлсхийхийн тулд та хувцаслалт, гадаад байдал, үсний хэв маягтаяа хэт анхаарахаас татгалзах нь зүйтэй. Хувцаслалт, гадаад байдлаа үргэлж цэвэр, сайхан байж, хэзээ ч битгий хайш яиш, зохисгүй хувцасла. Биедээ нүх гарган, шивээс хийлгэж, өөрийгөө бүү доромжил. Эмэгтэй хүн чихээ цоолуулахыг хүсвэл, зөвхөн нэг хос даруу ээмэг зүү.

Ямар ч үед төлөв даруу байдлын ондөр жишгийг даган мөрд. Биедээ бусдын анхаарал татахуйц, буюу өгөөш тавьж өөрийн жишгээ бүү доошилуул. Есүс Христийн үнэн шавь нар орчин үеийн хийц загвар болон бусдын зүгээс ирэх дарамтыг огоорон Их Эзэний жишгийг голчилдог.

### Хэл Яриа болон Зан Байдал

Таны хувцаслалт болон гадаад байдлын адил хэл яриа, биеэ авч явах байдал тань зан байдлын илрэл юм. Үг яриа, үйлдлүүд танд болон бусдад асар их нөлөөлдөг. Эргэн тойронд байгаа хүмүүстaz жаргал авчрах цэвэр, эерэг, урам хайрлах хэл яриа үйлдлээрээ өөрийгөө

илэрхийл. Үг болон үйлсээрээ төлөв даруу байх хичээл зүтгэл тань Ариун Сүнснээс тайвшрал хийгээд өсөн нэмэгдсэн удирдамж уруу хөтөлнө.

Бохир хэл яриа, Их Эзэний нэрийг зохисгүй, үл хүндэтгэн хэрэглэх нь дэлхийд их түгээмэл байдаг тул эдгээрээс зайлсхий. Зохисгүй буюу маш аюултайгаар бие авч явах уруу таталтыг сөрж зогс. Иймэрхүү зохисгүй хэл яриа, зан харьцаа нь Ариун Сүнсний чимээгүй өдүүлбэрийг хүлээн авах чадварыг муутгана.

Нэмэлт судрууд: С ба Г 42:40–41; Итгэлийн Тунхаг 1:13

Ариун явдал; Биеэ Цоолох; Бохир Хэллэг; Шивээсийг мөн γз.

### Төлөөлөгч (Бошиглогчид; Сүмийн Захиргааг γз)

#### Төрөлтөд Хяналт Тогтоох нь

Гэрлэсэн хосууд бие махбодын хувьд эрүүл бол тэдэнд Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхдүүдэд зуурдын бие махбодыг хангаж өгөх онцгой эрх бий. Тэд Бурханы хүүхдүүдийг зуурдын байдлын туршлага хийгээд бие махбодыг хүлээн авахыг зөвшөөрдөг аз жаргалын агуу төлөвлөгөөний нэг хэсгийг гүйцэтгэдэг.

Хэрэв та гэрлэсэн бол ханийхаа хамт энэ дэлхийд хүүхдүүдийг авчрах хийгээд тэднийг зөв шударга ёсоор хүмүүжүүлэх нандин үүрэг хариуцлагын талаар ярилцах хэрэгтэй. Та нар ингэхдээ амьдралын утга учир, ариун байдлыг бодолцож үзээрэй. Гэр оронд хүүхдүүд байснаар ирж болох тэрхүү баяр баясгалангийн тухай тунгаан бод. Зөв шударга үр удамтай болохос ирэх мөнхийн адислаалуудыг бод. Та болон ханьтайгаа эдгээр зарчмуудын талаарх гэрчлэлтэйгээр хэзээ, хэдэн хүүхэдтэй болохыг залбиралтайгаар шийдэхэд бэлтгэгдэх болно. Иймэрхүү шийдвэрүүд нь та хоёр болон Их Эзэний хооронд л байна.

Та энэхүү нандин үйл явдлын талаар ярилцахдаа гэрлэлтийн бэлгийн харилцаа нь тэнгэрлэгээр батлагдсан гэдгийг санагтун. Эдгээр харилцааны нэг зорилго бол Бурханы хүүхдүүдэд бие махбодыг бий болгож өгөх явдал билээ. Өөр нэг зорилго бол нэг нэгэндээ хайраа илэрхийлэх эхнэр, нөхөр хоёрыг үнэнч, ариун ёс журмаар, хайр халамжаар болоод нийтлэг зорилгоор холбогход оршино.

### **Тэлэстиэл Хаант улс** (Алдар Суугийн Хаант Улсуудыг үз)

#### **Тэмдгүүд**

Тэмдгүүд нь Бурханы хүчийг нотлон үзүүлдэг үйл явдал буюу туршлага билээ. Тэдгээр нь ихэнхдээ гайхамшигтай байдаг. Аврагчийн төрөлт, үхэл, Хоёр дахь Ирэлт гэх мэт агуу үйл явдлуудыг зарлан тунхаглаж, тодорхойлдог. Тэдгээр нь Их Эзэн бидэнтэй хийсэн гэрээнүүдийг сануулдаг. Тэмдгүүд мөн тэнгэрлэг дуудлагын гэрч болох буюу Их Эзэнд тааламжгүй байгааг зааж болно.

Хэрэв тэмдгийг хүлээн авч чаддаг байсан бол Бурхан болон Түүний ажилд итгэх л байсан хэмээн зарим хүмүүс хэлдэг. Гэвч Их Эзэн хэлэхдээ: “итгэл тэмдгүүдээр ирдэггүй, харин итгэдэг тэднийг тэмдгүүд дагалддаг” гэжээ (С ба Г 63:9). Иймэрхүү тэмдгүүд нь итгэлтэй хийгээд дуулгавартай хүмүүсийн итгэлийг хүчирхэгжүүлэхийн тулд өгөгддөг.

Нэмэлт судрууд: Матай 12:38–39; Марк 13:22–27; Лук 2:8–17; Алма 30:43–52; Хиламан 14; 3 Нифай 1:13–21; 8:2–25; Ифэр 12:6; С ба Г 63:7–12

Нэмэлт судрууд: Матай 12:38–39; Марк 13:22–27; Лук 2:8–17; Алма 30:43–52; Хиламан 14; 3 Нифай 1:13–21; 8:2–25; Ифэр 12:6; С ба Г 63:7–12

## **Тэнгэр**

Дуулгавартай Байдал; Есүс Христийн Хоёр дахь Ирэлт; Итгэлийг мөн үз.

## **Тэнгэр**

Судруудад тэнгэр гэдэг үг хоёр утгаар хэрэглэгддэг. Нэгдүгээрт, Бурханы амьдардаг, итгэлтэй хүмүүсийн гэрийг хэлдэг (Мозая 2:41-ийг үз). Хоёрдугаарт, газар дэлхийн өргөн уудамтай холбоотой юм (Эхлэл 1:1).

Нэмэлт судрууд: Дуулал 11:4; Матай 6:9; 1 Нифай 1:8; Мозая 3:8; С ба Г 20:17

Алдар Суугийн Хаант Улсыг мөн үз.

## **Тэнгэр дэх Зөвлөгөөн** (Авралын төлөвлөгөөг үз)

## **Тэнгэрлэг Эцэг** (Бурхан Эцэгийг үз)

## **Тэргүүн Зөвлөл** (Бошиглогчид; Сүмийн Захиргааг үз)

## **Тэррэstriэл Хаант Улс** (Алдар Суугийн Хаант Улсуудыг үз)

## **Уналт**

Едений цэцэрлэгт Бурхан зарлиглахдаа, “цэцэрлэгийн мод болгоноос чи чөлөөтэйгөөр идэж болох буюу, харин сайн ба муугийн мэдлэгийн модноос чи идэж болохгүй, гэсэн хэдий ч, оорийнхөө төлөө сонгож болно, учир нь энэ нь чамд өгөгдсөн бөлгөө; харин үүнийг би хориглосон гэдгийг санагтуун; учир нь түүнээс идсэн тэр өдөртөө чи гарцаагүй үхэх болно” (Моше 3:16-17-г үз). Адам Ева хоёр энэ зарлигийг зөрчиж, сайныг хийгээд хилэнцэтийн мэдлэгийн модны жимснээс хүртсэн учраас тэд Бурханы оршихуйгаас зайлцуулагдсан (С ба Г

29:40–41-ийг үз). Өөрөөр хэлбэл тэд сүнсний үхлийг амсчээ. Тэд мөн бие махбодын үхэлд захирагдах—зуурдын байдалтай болсон.

### Бидний Уналтын Байдал

Бид Адам Ева хоёрын үр удмын хувьд зуурдын байдалтай байхдаа уналтын байдлыг өвлөн авдаг (Алма 42:5–9, 14-ийг үз). Бид Их Эзэний оршихуйгаас салж, бие махбодын үхэлд захирагддаг. Бид түүнчлэн амьдралын бэрхшээлүүд болон бусармаг зүйлийн уруу таталтад соригдох эсрэг тэсрэг байдалд байна (2 Нифай 2:11–14; С ба Г 29:39; Моце 6:48–49-ийг үз).

Бид энэхүү уналтын байдалд зөрчилдөөнтэй байдаг. Бид “Бурханлиг мөн чанарын хүртэгч байх” боломжтой Бурханы хүүхдүүд юм (2 Петр 1:4). Гэсэн хэдий ч, “бид [Бурханы] өмнө байх зохисгүй юм; учир нь уналтын улмаас бидний төрөлх чанар үргэлж хилэнцэт байхаар болсон болой” (Ифэр 3:2). Бид шударга бус дур хүслээ даван туулахыг үргэлжлүүлэн хичээх хэрэгтэй.

Тэнгэр элчийн үгсийг давтан Хаан Бэнжамин хэлэхдээ, “Эгэл хүн бол Бурханы дайсан, мөн Адамын уналтаас тийм байсаар ирсэн”. Хаан Бэнжамин энэхүү төрөлхийн буюу уналтын байдалд “Ариун Сүнсний таталтанд автагдан, эгэл хүмүүнээ орхиж, мөн Их Эзэн Христийн цагаатгалаар гэгээнтэн болж, хүүхэд шиг хүлцэнгүй, номхон даруухан, тэвчээртэй, хайраар дүүрэн, бүх хүүхэд өөрийн эцэгт захирагддаг шиг Их Эзэний түүний дээр ноогдуулах бүх зүйлийг хүлцэхэд бэлэн бус аваас үүрд мөн үргэлж тийм байхгүй” бол энэхүү төрөлхийн буюу уналтын байдалд хүн бүр Бурханы үүрдийн дайсан байх болно гэжээ (Мозая 3:19).

## Уналтын Ашиг Тус

Уналт нь Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөний хамгийн чухал хэсэг юм (2 Нифай 2:15–16; 9:6-г үз). Хэдийгээр дээд байдлаас доошоо унасан ч хүмүүний өсөлт хөгжлийг эхлэх үндэс суурийг тавьсан юм. Түүнчлэн бие махбодын үхэл хийгээд сүнсний үхэл гарч ирснээр биднийг дэлхий дээр төрж, сурч боловсрох боломжийг өгсөн юм. Зөв шударга сонголт болон чин сэтгэлийн наманчлалаар дамжуулан бид нүгэл үйлдсэн үедээ Христэд ирж, Түүний Цагаатгалаар дамжуулан мөнх амьдралын бэлгийг хүлээн авахаар бэлтгэж чадна. Бошиглогч Лихай:

“Хэрэв Адам гэмийг үйлдээгүй аваас тэрээр унахгүй байх байсан, харин тэр Едений цэцэрлэгт үлдсэн хэвээр байх байлаа. Мөн бүтээгдсэн бүх зүйл бүтээгдсэнийхээ дараа байсан тэр байдлаараа нэгэн адил үлдэх ёстой байсан бөлгөө; мөн тэд үүрд мөн төгсгөлгүйгээр үлдэх ёстой байсан бөлгөө.

“[Адам Ева хоёр] хүүхдүүдгүй байх байсан; иймийн тул, тэд зовлонг мэдээгүйн учир баяр баясал үгүй, гэм зэмгүй гэнэн байдалдаа хоцрох байсан; тэд нүглийг мэдээгүй байх учир сайныг үл үйлдэхсэн билээ.

“Гэвч болгоогтун, бүх зүйл, бүхнийг мэдэгч түүний мэргэн ухаанд хийгдсэн билээ.

“Адам хүмүүн байж болохын тулд унасан; мөн тэд баяр баясталтай байж болохын тулд хүмүүн байх бөлгөө.

“Мөн тэрээр хүмүүний үрсийг уналтаас гэтэлгэж болохын тулд, уг Мессая цагийн бүрэн дүүрэн үед ирэх болой” (2 Нифай 2:22–26; мөн 19–21, 27-г үз).

Адам Ева хоёр Уналтын үр дагавраас гарч ирсэн адислалууддаа талархлаа илэрхийлжээ.

“Мөн тэр өдөр Адам Бурханыг магтан дуулж мөн дүүргэгдсэн байв, мөн дэлхийн бүх гэр бүлийн талаар

бошиглож эхлэн хэлэв: Бурханы нэр адислагдаг, учир нь миний гэм буруугийн улмаас нүд минь нээгдсэн буюу, мөн энэ амьдралд би баяр хөөртэй байх болно, мөн ма-ханбодод бибээр Бурханыг дахин харах болно.

“Мөн түүний эхнэр Ева эдгээр бүх зүйлийг сонсоод мөн баяртай байж эхлэв: Хэрэв бидний зөрчил байгаагүй-сэн бол бид хэзээ ч үр удамгүй байх байсан, мөн сайн ба мууг, мөн бидний гэтэлгэлийн баяр баясгаланг мөн дуул-гавартай бүгдээд Бурханы өгсөн мөнх амьдралыг бид хэзээ ч мэдэхгүй байх байсан” (Мосе 5:10–11).

### Уналтаас Гэтэлгэгдэх нь

Бидний унасан, зуурдын байдал болон хувийн нүглүүдийн улмаас бидний цорын ганц найдвар бол Есүс Христ болон гэтэлгэлийн төлөвлөгөө юм.

Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан хүн бүр Уналтын нөлөөллөөс гэтэлгэгдэх болно. Бид амилуулагдах ба биднийг шүүхээр Их Эзэний оршихуйд буцаан авчрагдана (2 Нифай 2:5–10; Алма 11:42–45; Хиламан 14:15–17-г үз).

Уналтын бүх дэлхийн нөлөөллөөс биднийг гэтэлгээд зогсохгүй Аврагч биднийг өөрсдийн нүглээс ангижруулж чадна. Бид уналтын байдалд нүгэл үйлдэж, сүнсний үхлийг өөрсөд дээрээ авчран өөрсдийгөө Их Эзэнээс холдуулдаг. Төлөөлөгч Паулын хэлснээр “Бид нүгэл үйлдсэнээр Бурханы алдарт хүрдэггүй” (Ром 3:23). Бид нүгэлтэйгээ хоцорвол Бурханы оршихуйд оршиж чадахгүй учир нь “цэвэр ариун бус зүйл... Түүний оршихуйд оршиж чадах нь үгүй” (Мосе 6:57). Талархууштай нь, Цагаатгал нь бидэнд нүгэлдээ уучлалыг хүлээн авах болон Бурханы оршихуйд үүрд амьдрах байдлыг боломжтой болгон “Наманчлалын нөхцлийг хангасан” юм (Хиламан 14:18). Алма “Хүмүүн наманчилж болох хэмээн

## Урвалт

түүнд хугацаа өгөгдөв; тиймийн тул, энэ амьдрал нь сорилтын нөхцөл болсон; Бурхантай уулзахаар бэлтгэх цаг; үхэгсдийн амилуулалтын дараа ирэх, биднээр хэлэгдсэн тэр төгсгөлгүй байдалд бэлтгэх цаг буюу” хэмээн сургасан (Алма 12:24).

Аврагчийн Цагаатгалын Золиослолд Талархах нь

Өлсөх хүртлээ бид хоол хүсдэггүйн адил Аврагчийн хэрэгцээг мэдрэх хүртлээ бид мөнхийн авралыг бүрэн дүүрэн хүсдэггүй. Энэхүү ухаарал нь Уналтыг ойлгоход ирдэг. Бошиглогч Лихайн зааснаар “Иймийн тул бүхий л хүмүүс төөрөлдсөн бас унасан байдалд ордог буюу, тэд энэ Гэтэлгэгчид тулгуурлахгүй бөгөөс үргэлжид тийм байх бөлгөө” (1 Нифай 10:6).

Нэмэлт судрууд: Эхлэл 3; Мормон 9:12–14; Моце 4

Авралын Төлөвлөгөө; Анхдагч Нүгэл; Есүс Христийн Цагаатгал; Нүгэл; Сонголтыг мөн үз.

## Урвалт

Хувь хүмүүс буюу багаараа сайн мэдээний зарчмууд даас холдвол тэд урвалтын байдалд байна.

Ерөнхий урвалтын үеүд нь дэлхийн түүхэнд тохиолдсоор ирсэн юм. Зөв шударга ёсны дараа хүмүүс эргээд олонтаа ёс бус болж байв. Нэг жишээ бол Аврагчийн өөрийн Сүмийг байгуулсны дараа тохиосон Агуу Урвалт юм. Аврагч хийгээд Түүний төлөөлөгчдийн үхлийн дараагаар хүмүүс сайн мэдээний зарчмыг гүйвуулж, Сүмийн бүтэц зохион байгуулалт болон санваарын ёслолуудад эрх мэдэл өгөгдөөгүй өөрчлөлт хийсэн. Ийнхүү газар авсан ёс бус үйлдлийн улмаас Их Эзэн дэлхийгээс санваарын эрх мэдлийг татаж авсан юм.

Агуу Урвалтын үед хүмүүс амьд бошиглогчдоос авсан тэнгэрлэг удирдамжгүй байсан билээ. Олон сүм баригдсан боловч тэдэнд хүмүүсийг Бурхан Эцэг хийгээд Есүс Христийн үнэн мэдлэг рүү хөтлөх санваарын хүч байсангүй. Ариун судруудын зарим нь гүйвуулагдаж, алдагдсан ба хэнд ч Ариун Сүнсний бэлгийг хүртээх, эсвэл санваарын бусад ёслолуудыг гүйцэтгэх эрх мэдэл байсангүй. Энэхүү урвалт нь 1820 онд Тэнгэрлэг Эцэг хийгээд Түүний Хайрт Хүүг Иосеф Смитэд үзэгдэх хүртэл үргэлжилсэн ба сайн мэдээний бүрэн сэргээлтийн эхлэлийг тавьсан юм.

Өнөөдөр бид Есүс Христийн сайн мэдээг сэргээгдсэн үед амьдарч байна. Өнгөрсөн үеийн сүмтэй адилгүй, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм нь ерөнхий урвалтад өртөхгүй билээ. Судрууд нь Сүм дахин хэзээ ч сүйтгэгдэхгүй гэж заадаг (С ба Г 138:44; мөн Даниел 2:44-ийг үз).

Хэдийгээр үнэнээс урвах өөр нэг ерөнхий урвалт болохгүй ч бид тус бүртээ хувийн урвалтаас сээрэмжлэх ёстай. Та нар гэрээнүүдээ сахин, зарлигийг даган, Сүмийн удирдагчдыг сонсон, ариун ёслолоос хүртэн, мөн өдөр тутам судраас судалж, залбиral хийн, үйлчилснээр гэрчлэлээ тогтмол хүчирхэгжүүлэн өөрсдийгөө хувийн урвалтаас хамгаалж чадна.

Нэмэлт ишлэлүүд: Исаиа 24:5; Амос 8:11–12; Матай 24:4–14; Үйлс 20:28–30; 2 Тимот 3:1–5, 14–15; 4:3–4; 1 Нифай 13:24–29; Мормон 1:13–14; С ба Г 1:15–17; Иосеф Смитийн Түүх 1:17–19

Сайн Мэдээний Сэргээлт; Санваар; Сүмийн Захиргаа мөн үз.

## Уруу Таталт

Эцсийн өдрүүд бол “хэцүү цаг” юм хэмээн Төлөөлөгч Паул бошиглосон (2 Тимот 3:1). Муу ёрын нөлөөлөл толгой эргүүлсэн, тархмал байдаг. Гэвч та Сатаныг дийлж,

ургуу таталтыг даван туулж чадна. Тэнгэрлэг Эцэг танд тэрхүү муугаас сайныг ялган таних сонголтын бэлгийг өгсөн. “Та нар Их Эзэний өмнө өөрсдийгөө даруусган, мөн түүний ариун нэрийг дуудаж, мөн та нар өөрсдийн үүрч чадахаас илүүгээр тэр уруу таталтанд автахгүй” байж чадна (Алма 13:28). Та зарлигуудыг чин хүсэлтэйгээр дагавал Тэнгэрлэг Эцэг уруу таталтын эсрэг зогсожыг хүчирхэгжүүлнэ.

Дараах зөвлөгөө нь уруу таталтыг даван туулахад тусална:

*Аврагчид амьдралаа төвлөрүүл.* Бошиглогч Хиламан хүүдээ зөвлөхдөө, “Мөн эдүгээ, хөвгүүд минь, санагтун, Бурханы Хүү, Христ болох, Гэтэлгэгчийн маань хадан дээр та нар сууриа тавих ёстойг санагтун; иймээс чөтгөр хүчит салхия тийм ээ, хуй салхин дахь дайралтаар илгээхэд, тийм ээ, түүний бүхий л мөндөр мөн хүчит шуурга та нар дээр нүдэхэд, энэ нь та нарыг зовлонгийн мөн төгсгөлгүй халаглалын ангал тийш доопш чирж дийлэх хүчгүй байх болно, та нар дээр нь босгогдсон тэр, бат бөх суурь болох, хүмүүн нь үүний дээр баривал унах аргагүй суурь болох хадны учир болой” (Хиламан 5:12).

*Хүч чадлын төлөө залбир.* Амилсан Аврагч Нифайчууд дээр ирж, цугласан олонд заахдаа: “Та нар уруу таталтанд орохгүйн тул үргэлж сэрэмжилж мөн залбирах ёстой; учир нь тэр та нарыг буудай мэт шигшиж болохын тулд Сатан та нарыг эзэмдэхийг хүсч байна. Тиймийн тул та нар үргэлж миний нэрээр Эцэгт залбирах ёстой” (З Нифай 18:18–19). Хожмын өдрийдэд Тэр мөн адил зөвлөгөө өгсөн: “Ялан дийлэгч болж гараахын тулд чи ямагт залбир; тийм ээ, чи Сатаныг ялж гарагахын тулд, мөн түүний ажлыг дэмжиж байдаг Сатаны зарц нарын гараас зугтаахын тулд буюу” (С ба Г 10:5)

*Өдөр бүр судраас суралц.* Сайн мэдээний үнэнийг судалж, амьдралдаа тэднийг хэрэгжүүлбэл Их Эзэн

чамайг уруу таталтын эсрэг зогсох хүчээр адислана. Нифай “Бурханы үгийг дуулах, мөн үүнээс зууран барих хэн боловч, тэд хэзээ ч эрсдэх нь үгүй” бас хортны уруу таталтууд мөн галт сумнууд, тэднийг сүйрэл рүү удирдахаар тэднийг сохлон давамгайлах нь үгүй гэж заасан (1 Нифай 15:24; мөн Хиламан 3:29-30-ийг үз).

Амьдралаа сайн сайхан зүйлсээр дүүргэ. Та хилэнцэтийг хүртэх шаардлагагүй байхаар сонгох маш их зүйл байдаг. Амьдралаа сайн сайхан зүйлсээр дүүргэхэд өөр зүйлийг багтаах зай байхгүй.

*Уруу татаж байгаа газар болон нөхцөл байдлаас зайлсхий.* Та уруу таталтаас бүрэн зугтаж чадахгүй ч уруу татагдах газар эсвэл нөхцөл байдлаас зайлсхийж чадна. Та мөн ном, сэтгүүл, зурагт, кино, хөгжим болон Интернетээр гарах зохисгүй материалыаас зайлсхийж чадна.

*Бусдад сайнаар нөлөөлөхийг хичээ.* Гетсеманий Цэцэрлэгт зовж шаналхаасаа өмнөхөн Аврагч Өөрийн шавь нарынхаа төлөө залбирсан: “Би ертөнцийнх биш адил тэд ч бас ертөнцийнх биш тул ертөнц тэднийг үзэн ядсан юм. Би танаас тэднийг ертөнцөөс аваач гэж гүйхгүй, харин тэднийг муугаас хамгаалаач гэж гүйж байна. Би ертөнцийнх биш адил тэд бас ертөнцийнх бас биш. Үнэн дотор тэднийг ариусгаач. Таны үг бол үнэн. Та на-майг ертөнц рүү илгээсний адил Би тэднийг мөн ертөнц рүү илгээв” (Иохан 17:14–18). Есүс Христийн хожмын үеийн шавийн хувьд та “ертөнцийнх бус” харин дэлхий дээр байж болно. Өөрөөсөө уруу таталтыг зайлзуулахдаа та бусдад сайн, үр бүтээлтэй амьдралаар амьдрахад нөлөөлж чадна. Та зөв шударга байдлын жишээ болж, анд нөхөр байж, нийтийн үйлчлэлд оролцож, мөн зохистойгоор өөрийн дуу хоолойг ёс суртахууны үнэт зүйлсийг хамгаалахад хүргэж чадна.

*Уруу таталтын эсрэг зогсох өөрийн шийдвэртээ хэзээ ч бүг эргэлз.* “Уруу таталтуудад орсон хэдий ч тэдгээрт ан-

## Урьдчилсан Томилолт

хаарал тавиагүй” Аврагчийн жишээг дагахыг хичээ. (С ба Г 20:22). Сатан Есүсийг цөлд уруу татахыг оролдоход Есүс хэзээ ч тээнэгэлзэж байгаагүй. Түүний хариулт нь хурдан бөгөөд шийдвэртэй байлаа: “Чи өөрийн Бурхан Эзэндээ мөргөж, зөвхөн Түүнд үйлчил” (Лук 4:8). Өөрийн зөв шударга бодол, үг яриагаар дамжуулан муу ёрын уруу таталтыг нэгэн адил итгэлтэйгээр хариулж чадна. “Чөтгөрийг эсэргүүц, мөн тэр та нараас зайлна. Бурханд ойртогтун. Тэгвэл тэр та нарт ойртоно” (Иаков 4:7–8).

Нэмэлт судрууд: Ром 12:21; Ефес 6:11–17; Иаков 1:12, С ба Г 23:1; 31:12; Моце 1:12–22

Ариун Сүнс; Мацаг ба Мацгийн Өргөл; Наманчлал; Сатан; Сонголт; Ухамсар; Христийн Гэрлийг мөн үз.

## Урьдчилсан Томилолт

Зуурдын байдлын өмнөх Сүнсний дэлхийд Бурхан хэдэн сүнсийг тэдний зуурдын амьдралын үеүдэд тодорхой үүргүүдийг биелүүлэхээр томилсон. Үүнийг урьдчилсан томилолт гэдэг.

Урьдчилсан томилолт нь хувь хүн бүрийг дуудлагууд буюу үүрэг хариуцлагууд хүлээн авна гэсэн баталгаа өгдөггүй. Иймэрхүү боломжууд нь энэ амьдралд зөв шударга сонголтын үр дүнд, яг л зуурдын байдлын өмнөх байдалд зөв шударгын үр дүнд урьдчилсан томилолт ирсэний адил ирдэг юм.

Есүс Христ “ертөнцийн сууриас алагдсан Хурга” болж, Цагаатгалыг биелүүлэхээр урьдчилан томилогдсон билээ (Илчлэлт 13:8, мөн 1 Петр 1:19–21-ийг үз). Судрууд урьдчилан томилогдсон бусад хүмүүсийн талаар өгүүлдэг. Бошиглогч Абрахам өөрийн урьдчилсан томилолтыг зуурдын байдлын өмнөх сүнсэн дэлхийд өөрийгөө “нэр төртэй хийгээд агуу” сүнснүүдийн дунд байгаагаар харс-

наар сурч авчээ. “Мөн сайн байсан тэдгээр бодгалиудыг Бурхан харав, мөн тэрбээр тэдний дунд байлаа, мөн тэрбээр хэлэв: эднийг захирагчдаа болгох болно; учир нь тэрбээр сүнс байсан тэдний дунд зогсож байв, мөн тэрбээр сайн байсан тэднийг харав; мөн тэрбээр надад хэлэв: Абрахам, чи тэдний нэг болой; чи төрөхөөсөө өмнө сонгогдсон билээ” хэмээн тэрээр хэлэв (Абрахам 3:22–23). Их Эзэн Иеремиад “Эхийнхээ хэвллийд чамайг бүрэлдүүлэхээс өмнө би чамайг мэдсэн бөгөөд төрөхөөс чинь өмнө Би чамайг ариусгаж, чамайг үндэстнүүдэд эш үзүүлэгч болгон томилсон” гэжээ (Иеремиа 1:5). Иохан Баптист Аврагчийн зуурдын байдлын тохинуулалт хүмүүсийг бэлтгэхээр урьдчилан томилогдсон юм (Исаиа 40:3; Лук 1:13–17; 1 Нифай 10:7–10-ыг үз).

Урьдчилсан томилолтын сургаал нь Аврагч хийгээд Түүний бошиглогчид төдийгүй Сүмийн бүх гишүүдэд хамаатай. Дэлхийн үүслээс өмнө итгэлтэй эмэгтэйчүүдэд тодорхой хэдэн хариуцлагуудыг өгч, итгэлтэй эрэгтэйчүүдийг тодорхой хэдэн санваарын үүргүүдэд урьдчилан томилсон юм. Хэдийгээр та тэр цаг үеийг санахгүй байгаа ч Эцэгийн үйлчлэлд ач холбогдол бүхий үүрэг даалгавруудыг биелүүлэхээр зөвшөөрсөн л байх. Та нар өөрсдийнхөө зохистой гэдгийг баталвал танд тэр үед хүлээн авсан үүргээ биелүүлэх боломжууд өгөгдөх болно.

Нэмэлт судрууд: Алма 13:1–9; С ба Г 138:53–56

Авралын Төлөвлөгөө; Сонголтыг мөн үз.

## Ухамсар

Бүх хүмүүс буруу зөвийг ялган салгах чадвартай төрдөг. Энэхүү чадварыг ухамсар хэмээн нэрлэх ба энэ нь Христийн Гэрэл юм (Моронай 7:15–19-ийг үз).

Таны ухамсар бол сүнслэг байдлын хувьд хор хөнөөлтэй байдлуудаас хол байхад туслах хамгаалалт юм.

## Үйлчлэл

Та зарлигуудыг дуулгавартай даган, зөв шударга шийд-вэр гаргахдаа ухамсрын амар амгаланг мэдрэх болно.

Та шархадвал бие махбодын өвчин зовиурыг мэдэр-дэгийн адилаар нүгэл үйлдвэл гэмшил, эсвэл буруутай байдлыг мэдэрдэг. Энэ бол нүгэлд хариу үзүүлэх ухамсрын төрөлхийн хариулт бөгөөд энэ нь таныг наманчлалд хөтөлж чадна.

Наманчлал хийгээд учлал нь ухамсрын тань амар амгаланг дахин шинэчилдэг. Нөгөө талаар хэрэв та ухамсраа үл тоомсорловол мөн наманчлахгүй бол ухамсар тань “халуун төмрөөр тамгалагдсан” (1 Тимот 4:2) шиг сүйтгэгдэх болно.

Ухамсраа дагаж сур. Энэ нь сонголтоо хэрэгжүүлэх чухал хэсэг юм. Ухамсраа хичнээн их дагах тусам ухамсар тань төдий чинээ хүчтэй болох болно. Мэдрэмтгий ухамсар бол эрүүл сүнсний дохио билээ.

Нэмэлт судрууд: Мозая 4:1–3; С ба Г 84:45–47

Дуулгавартай Байдал; Сонголт, Уруу Таталт; Христийн Гэрлийг мөн үз.

## Үйлчлэл

Есүс Христийн үнэнч шавь нар эргэн тойрон дахь хүмүүстээ үйлчлэх хүсэлтэй байдаг. “Хэрэв та нар бие хайлрах юм бол үүгээр чинь бүх хүн та нарыг Миний шавь нар мөн гэдгийг мэдэх болно” хэмээн Аврагч хэлсэн (Иохан 13:35).

Баптиسم хүртэхдээ та Есүс Христийн нэрийг өөртөө авахаар гэрээ хийсэн. Бошиглогч Алма энэхүү гэрээг баптиism хүртэхийг хүссэн хэсэг бүлэг шинэ хөрвөгчдөд тайлбарласан. Тэрээр “Бурханы хороонд орох” хүсэл “нэг нэгнийхээ ачааг тэдгээр нь хөнгөн байхын тулд үүрэлцэж, мөн гашуудах тэдний хамт гашуудах, тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруулах” утга учиртай

үйлчлэл үзүүлэх хүслийг агуулсныг ажигласан (Мозая 18:8–9).

Та бусдад үйлчлэхээр хичээхдээ Аврагчаа жишээ болгон хар. Хэдийгээр Тэр дэлхийд Бурханы Хүү болж ирсэн ч Тэр Өөрийн эргэн тойронд байсан хүмүүстээ үйлчилсэн билээ. Тэрээр “би та нарын дунд үйлчлэгч мэт байдаг” хэмээн тунхагласан (Лук 22:27).

Аврагч сургаалт зүйрлэлийг үйлчлэлийн чухлыг заахдаа хэрэглэдэг байжээ. Сургаалт зүйрлэлд Тэр Өөрийн алдар суундаа дэлхийд эргэн ирж, ёс бусчуудаас шударга хүмүүсийг салгана. Зөв шударга хүмүүст Тэрээр: “Миний Эцэгээр ероөгдөгсөд өө, та нар нааш ир. Ертөнцийн сууриас та нарт бэлтгэсэн хаанчлалыг өвлөн авсугай. Учир нь намайг өлсөж байхад та нар Надад идэх юм өгсон, Намайг харь хүн байтал урьж оруулсан, нүцгэн байхад минь Намайг эргэж байсан, широнд байхад минь над руу ирсэн билээ” хэмээн хэлжээ (Матай 25:34–36).

Алмайран гайхсан шударга хүмүүс: “Эээн, бид хэзээ Таныг өлсөж байхыг тань хараад хооллож, цангаж байхыг тань хараад уух юм өгсөн юм бэ? Хэзээ бид Таныг харь газрынх байсныг тань хараад урьж оруулан, нүцгэн байхыг тань хараад хувцасласан юм бэ? Хэзээ бид Таныг өвчтэй байхыг хараад эргэж, широнд байхыг тань хараад очсон юм бэ?” хэмээн асууна (Матай 25:37–39).

Тэгээд Их Эзэн “Та нар эдгээр ах дүүсийн маань нэгэнд нь тэр байтугай хамгийн дордод нь тийнхүү хандсан бол Надад хийсэн хэрэг” гэж хариулдаг (Матай 25:40).

Аврагч таныг бусдын үйлчлэлд өөрийгөө зориулахыг урьдаг. Үүнийг хийх таны боломж хязгааргүй. Өдөр бүр зүрх сэтгэл баярлуулах, сайхан үг хэлэх, өөрсдөө хийж чадахгүй бусдын төлөө ажиллах, сургаалтыг хуваалцах замыг хай. Ариун Сүнсний шивнэлт таныг үйлчлэхийг сануулж байгааг хүлээн авч чадахаар бай. Аз жаргалын үнэн түл-

## Үнэний Сүнс

хүүр нь бусдын аз жаргалын төлөөх хөдөлмөр байдаг гэдгийг та олж мэднэ.

Нэмэлт судрууд: Матай 22:35–40; 25:41–46; Лук 10:25–37; Галат 5:13–14; Мозая 2:17

Хайр; Энэрлийг мөн үз.

## Үнэний Сүнс (Ариун Сүнсийг үз)

### Үр Хөндөлт

Өнөөдрийн нийгэмд үр хөндөлт нь худал хуурмаг зүйлээр хамгаалуулсан хэвийн үзэгдэл болсон байна. Та энэ асуудлын талаар бэрхшээлтэй асуултуудтай тулгарвал Их Эзэний илчилсэн хүсэл зоригийг дагаснаар аюулгүй байж чадна. Хожмын үеийн бошиглогчид үр хөндөлтийг Их Эзэний тунхаглалтай холбон буруутгахдаа “Чи хүн алах ёсгүй, . . . тэрчлэн энэ мэт ямар ч зүйлийг үйлдэх ёсгүй” гэжээ (С ба Г 59:6). Энэхүү хэргийн талаарх тэдний зөвлөгөө тодорхой байна: Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд үр хөндүүлэхийг хөхүүлэн дэмжиж, мөнгө төлж, төлөвлөж, гүйцэтгэх ёсгүй. Та нар ямар нэгэн байдлаар үр хөндөлтийг сайшааваас энэ нь Сүмийн дэг журмыг зөрчиж байгаа хэрэг юм.

Сүмийн удирдагчид зарим нэг хүндэтгэх шалтгаанаар, тухайлбал хүчиндүүлсний улмаас жирэмсэн болох, чадвартай эмчийн үзэж байгаагаар эхийн амь нас болон эрүүл мэнд хутганы ирэн дээр байх, эсвэл эхийн хэвлэлий дэх хүүхэд зулбах, гажиг согог ихтэй байх зэрэгт үр хөндөлтийг зөвтгөж болох юм. Гэхдээ ийм нөхцөлд ч гэсэн үр хөндөлтийг шууд зөвтгөж болохгүй. Иймэрхүү байдалтай тулгарч байгаа хүн орон нутгийн Сүмийн ахлагчтайгаа зөвшилцөж, мөн чин сэтгэлийн залбирлаараа дамжуулан баталгаа хүлээн авсны дараагаар үр хөндөлтийн тухай бодолцож үзэх хэрэгтэй.

Гэрлээгүй бүсгүй хүн жирэмсэн болоход тэр хүүхдийн эцэг эх гэрлэх ба хамтдаа мөнхийн гэр булийн холбоог тогтоохын төлөө ажиллах нь хамгийн сайн сонголт мөн. Хэрэв амжилттай гэрлэлт бий болохгүй бол тэд LDS Family Services /ХҮГ-ийн Сүмийн Гэр Бүлийн Үйлчлэл/-ээр дамжуулан хүүхдээ хүнд өргүүлэх нь зүйтэй (“Үр хөндөлт”, х.208-ыг үз).

Нэмэлт судрууд: Исаиа 2:2–3; 1 Нифай 13:37; С ба Г 35:24; 39:13; 45:68–71; 59:3–4; 64:41–43; 90:36–37; 97:18–28; 101:16–18; 105:5; 115:5–6; 136:31

## Хайр

Хайр бол бүхнээ зориулах, санаа тавих, мөн нөлөөлөх гүн мэдрэмж юм. Бурхан болон бусад хүмүүсийг хайрлах нь Есүс Христийн шавь хүний зан чанар юм (Матай 22:35–40; Иохан 13:34–35; 2 Нифай 31:20-ийг үз). Зарлигуудыг нь дагаж, Түүний хүүхдүүдэд үйлчилснээр бид Тэнгэрлэг Эцэгт хайртайгаа илэрхийлдэг. Бусдыг хайрлах бидний хайр тэдэнтэй эелдэг байж, тэдэнд үйлчилж, тэднийг сонсож, тэдэнтэй хамт гашуудаж, тэднийг тайтгаруулж, тэдний төлөө залбирч, тэдэнтэй сайн мэдээг хуваалцаж, мөн тэдний найз нөхөд байснаар илэрдэг.

Бид бүгд Бурханы хүүхдүүд—тиймээс бид сүнслэг ах эгч нар гэдгийг санах үед эргэн тойрныхоноо хайрлах бидний хайр нэмэгддэг. Энэ ойлголтоос төрж гарах хайр бүх үндэстнүүд, итгэл үнэмшил, мөн өнгөний хил хязгаараас хэтрэх болно.

Нэмэлт судрууд: Левит 19:18, 34; Дэд хууль 6:5; Лук 6:31–36; Иохан 15:9–15; 1 Иохан 4:7–21; Мозая 4:14–15; С ба Г 4:5; 12:8; 112:11; 121:41–45.

Дуулгавартай Байдал; Нигүүлсэл; Үйлчлэл; Энэрэлийг мөн үз.

## Халамжлах нь

Сүмийн гишүүн бүрт халамжлах хоёр үндсэн хариуцлага байдаг: биеэ даасан амьдралтай болох мөн ядуу болон гачигдалтай нэгнийг халамжлах.

Эцэг эхчүүдэд хүүхдүүдийнхээ бие махбодь болон сүнсний сайн сайхан байдлыг харж хандах хариуцлага байдаг. Хүүхдүүд өсөж том болоод өөрсдийн сайн сайханд илүү ихээр хариуцлага хүлээх хэрэгтэй болдог. Эцэг эхчүүд тэдэнд биеэ даасан амьдралтай болоход нь туслан, ирээдүйд гэр бүлийнхээ төлөө хангахад нь тэднийг бэлтгэх халамжийн үндсэн зарчмуудыг заах хэрэгтэй. Эцэг эхчүүд мөн хүүхдүүддээ ядуу хийгээд гачигдалтай нэгнийг халамжлахад туслах боломжуудыг хүүхдүүддээ өгч чадна.

Хэрэв та Сүмийн гишүүн бол дараах бүх зөвлөгөөнүүд танд шууд хамаатай. Хэрэв та залуу эмэгтэй эсвэл залуу эрэгтэй бол, хэдийгээр та эцэг эхээсээ бүрэн хамаардаг ч энэхүү зөвлөгөөнүүдийн ихэнх нь танд мөн хамаатай.

## Биеэ Даасан Амьдралтай Болох нь

Нийгмийн, сэтгэл санааны, бие махбодийн болон эдийн засгийн хувьд сайн байх нь юуны түрүүнд таныг, хоёрт гэр бүл, гуравт Сүмийг сэтгэл амар байлгадаг. Их Эзэний бурханлиг нөлөөллийн дор болон мөн өөрийн ажил хөдөлмөрөөр дамжуулан та өөрийгөө болон гэр бүлээ сүнсний хийгээд зуурдын амьдралын шаардлагуудаар хангах нь зүйтэй.

Биеэ даасан амьдралтай байснаар та өөрийгөө болон гэр бүлээ харж хамгаалах чадвартай байх болно. Та хэцүү үед бусдаас хамааралгүй эцсээ хүртэл тэвчихээр бэлтгэгдэх ёстой.

Та (1) боловсрол эээмшигэнээр; (2) хүнс тэжээл болон эрүүл ахуйн сайн нөхцөлд амьдарснаар; (3) боломжийн ажилд бэлтгэх болон олж авснаар; (4) хуулийн дагуу хоол хүнс, хувцас нөөцлөн бэлтгэснээр; (5) өөртөө байгаа нөөц баялгаа ухаалгаар зохицуулж, аравны нэг, өргөлүүдийг төлж, өрнөөс зайлсхийснээр; (6) сүнсний, сэтгэл санааны болон нийгмийн хүч чадлаа хөгжүүлснээр та биеэ даасан амьдралтай байж чадна.

Биеэ даасан амьдралтай болохын тулд та хөдөлмөрлөх хүсэлтэй байх ёстай. Их Эзэн биднийг ажилла хэмээн зарлигласан (Эхлэл 3:19; С ба Г 42:42-ыг үз). Ариун шударга ажил нь аз жаргал, өөрийгөө үнэлэх, мөн дэвжин дээшилэхийн үндэс юм.

Хэрэв та өөрийн хүчин чармайлт эсвэл гэр бүлийнхээ гишүүдийн дэмжлэг туслалцаагаар дамжуулан өөрийн үндсэн хэрэгцээг хангах чадваргүй байвал, Сүм танд тусалж болох юм. Эдгээр нөхцөл байдлуудад, Сүм ер нь танд болон танай гэр бүлийг дахин биеэ даасан болгохоор амьдралыг дэмжих нөөцөөр хангадаг.

### Ядуу болон Гачигдалтай Нэгнийг Халамжлах нь

Их Эзэн үргэлж Өөрийн хүмүүсээ ядуу, гачигдалтай нэгнийг халамжлахыг зарлигладаг байсан. Тэрээр “та нар ядуус хийгээд гачигдагсадад зочлон мөн тэднийг хөнгөвчлөх ёстай” хэмээн хэлжээ (С ба Г 44:6). Түүнчлэн тэрээр “ядуус хийгээд гачигдагсад, өвчтөнүүд хийгээд зовж шаналагсыг бүх зүйлд санаж байгтуун, учир нь үүнийг үл хийдэг тэрээр, мөнхүү тэр нь миний шавь биш бөлгөө” хэмээн зарлигласан юм (С ба Г 52:40).

Ядуу, гачигдалтай хүмүүсийг олон замаар халамжилж чадна. Нэг чухал зам бол ядуу тарчиг байдал, өвчин зовлон болон бусад зовлон зүдгүүрээс болж шаналж байгаа хүмүүст туслахаар хэсэг буюу салбарын ерөнхий-

## **Халуун Ундаанууд**

лөгчийн хэрэглэдэг мацгийн өргөлүүдийг өргөснөөр мөн мацаг барьснаар байж болно. Мөн та цаг заваа зарцуулж, автъяас чадвараа хуваалцаж чадна. Та хөрш зэргэлдээ амьдарч байгаа гэр оронгүй, тахир дутуу, бэлэвсэн болон бусад хүмүүст үйлчилж чадна.

Орон нутгийн болон хувь хүмүүсийг халамжлахаас гадна Сүм дэлхий даяар хүмүүсийн ямар шашинтайг үл харгалзан тэдгээр гай гамшиг, ядуу зүдүү байдал, өвчин зовлон болон бусад хямралын улмаас шаналж байгаа хүмүүст гар сунган тусалдаг. Сүм гэр бүл хийгээд хувь хүмүүст бие даан амьдрахын тулд хөдөлмөрлөхөд нь дэм үзүүлэх хүчин зүйлээр хангадаг. Сүмийн Боловсролын Сан боломж муутай Хожмын Үеийн Гэгээнтнүүдийг цаашид боловсролоо дээшлүүлэх хэрэгслээр хангадаг. Сүмийн үйлчлэлийн номлогчид өөрсдийн цаг, нөөц бололцоогоо бичиг үсэгт суралцах, эрүүл мэндийг хөхүүлэн дэмжих, сургалт явуулахыг дэмжин сайн дураараа ажилладаг.

Нэмэлт судрууд: Иаков 1:27; Иаков 2:17–19; С ба Г 42:31; 104:15–18

Мацаг ба Мацгийн Өргөлүүд; Үйлчлэлийг *мөн* үз.

## **Халуун Ундаанууд** (Мэргэн Ухааны Үгийг γɜ)

**Хандив** (Аравны Нэг; Мацаг Барих ба Мацгийн Өргөлүүдийг γɜ)

**Хараах** (Бохир Хэл Яриаг γɜ)

**Хар Тамхи** (Мэргэн Ухааны Үгийг γɜ)

## **Хөрвүүлэг**

“Махан биеийн бодол санаа бол үхэл, Сүнсний бодол санаа бол амь ба амар тайван болой” хэмээн Төлөөлөгч

Паул тунхагласан юм (Ром 8:6; 2 Нифай 9:39-ийг мөн үз). Бид унасан байдалдаа үргэлж уруу таталттай тэмцэлддэг бөгөөд заримдаа “чөтгөрийн сүнсэнд өгөх маханбодын тэр таалал мөн түүнд байх” сүнсэнд“ бууж өгдөг (2 Нифай 2:29; мөн “Уналт”-ыг хар, энэ номын хуудас 196) Мөнхийн амьдралын адислалыг хүлээн авах чадвартай байхын тулд бид “сүнслэг бодол санаа”-тай байж, шудрага бус хүслээ хянах хэрэгтэй. Бид өөрчлөгдөх хэрэгтэй. Бид илүү сайнаар, Аврагчийн Цагаатгалын хүчээр дамжуулан мөн Ариун Сүнсний хүчээр дамжуулан өөрчлөгдөх буюу хөрвүүлэгдэх хэрэгтэй. Энэхүү явцыг хөрвүүлэг гэж нэрлэдэг.

Хөрвүүлэг нь биеэ авч явж буй байдалд өөрчлөлтийг агуулдаг ч биеэ авч явж буй байдлаас гадуур болдог; өөрчлөлт нь бидний мөн чанарт бий болдог. Их Эзэн болон Түүний бошиглогчид үүнийг дахин төрөлт, зүрх сэтгэлийн өөрчлөлт, болон галын баптисмтай хамаатуулж үздэг тул энэ нь маш чухал өөрчлөлт юм. Их Эзэн хэлэхдээ:

“Бүх хүн төрөлхтөн, тийм ээ, эрчүүд мөн эмэгтэйчүүд, бүх үндэстэн, ястан, хэлтэн, мөн хүмүүс дахин төрөх ёстой гэдэгт бүү гайх; тийм ээ, Бурханаар төрөх, эгэл мөн унасан байдлаасаа, зөв шударга байдалд орж өөрчлөгдөн, Бурханаар гэтэлгэгдэн, түүний хөвгүүд мөн охид болох буюу;”

“Мөн тэд шинэ бүтээлүүд болох; мөн үүнийг хийхгүйгээр, тэд Бурханы хаант улсыг өвлөж чадах арга үгүй болгөө” гэжээ (Мозая 27:25–26).

### Хөрвүүлгийн Үйл Явц

Хөрвүүлэг нь үйл явдал биш харин үйл явц юм. Та нар Аврагчийг дагах зөв шударга идэвх чармайлтынхаа үр дүнд хөрвүүлэгдсэн билээ. Эдгээр хичээл зүтгэлд

## Хөрвүүлэг

Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлэх, нүглээ наманчлах, баптисм хүртэж, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авах болон итгэлд эцсээ хүртэл тэвчих зэрэг багтдаг.

Хэдийгээр хөрвүүлэг нь гайхалтай хийгээд амьдрал өөрчлөхүйц боловч энэ бол чимээгүй гайхамшиг билээ. Тэнгэр элчийн айлчлал хийгээд бусад онцгой үйл явдлууд нь хөрвүүлгийг авчирдаггүй. Тэр ч байтугай тэнгэр элч харсан Алма “олон хоног мацаг барьж, залбирсны” дараа л үнэний гэрч болохоор хөрвүүлэгдсэн юм (Алма 5:46). Амилуулагдсан Аврагчийг харсан Паул “Ариун Сүнсээр бус бол өөр хэн ч Есүс бол Эзэн гэж хэлж чадахгүй” гэдгийг заасан (1 Коринт 12:3).

Хөрвүүлэг нь чимээгүй, тууштай үйл явц учраас та нар одоо хөрвүүлэгдсэн боловч үүнийгээ ухаarahгүй байж болох юм. Та нар “тэдний надад итгэлийн нь учир, галаар мөн Ариун Сүнсээр батлуулсны адил, мөн үүнийг тэд мэдээ нь үгүй” Лэмэнчүүд шиг байж болно (3 Нифай 9:20). Итгэлээ хөгжүүлэх, Аврагчийг дагахаар хичээж буй идэвх чармайлт тань таныг агуу их хөрвүүлэг рүү хөтлөх болно.

## Хөрвүүлэгдсэн Хүмүүсийн Онцлог Шинж

Их Эзэнд хөрвүүлэгдсэн хүмүүсийг дүрсэлсэн дүрслэлийг Мормоны Номонд үзүүлдэг:

Сайныг үйлдэх хүсэл. Хаан Бэнжамины хүмүүс “Төгс Хүчит Их Эзэний Сүнс бидэнд хилэнцийг үйлдэх дурыг үгүй болгох, харин үргэлж сайнныг хийх болгон, бидэнд хүчирхэг өөрчлөлтийг үйлдсэн . . .” хэмээн тунхаглажээ (Мозая 5:2). “Жигшлээс өөрөөр нүглийг үзэж эс чадах болсон” хүмүүсийн талаар Алма өгүүлсэн байдаг (Алма 13:12).

Тэд Их Эзэний эсрэг босдоггүй. Мормон ёс бус хийгээд цусанд шунасан боловч “Их Эзэнд хөрвүүлэгд-

сэн” хэсэг бүлэг Лэмэнчүүдийн тухай ярьсан (Алма 23:6). Эдгээр хүмүүс нэрээ Антай-Нифай-Лихайчуд болгон өөрчилж “зөв шударга хүмүүс болсон; тэд Бурханы эсрэг бас өөрсдийн ах дүүсийн хэний нь ч эсрэг дахин тулалдахгүйн тулд эсэргүүцлийн зэр зэвсгээ доош тавьсан болой” (Алма 23:7).

Тэд сайн мэдээг хуваалцдаг. Инос, Алма, Залуу Алма, Мозаягийн хүүхдүүд, Амюлек болон Зиезром нар Их Эзэнд хөрвүүлэгдсэний дараа өөрсдийгөө сайн мэдээг номлоход зориулсан юм (Инос 1:26; Мозая 18:1; Мозая 27:32–37; Алма 10:1–12; 15:12-ыг үз).

Тэд хайраар дүүргэгдсэн байдал. Амилуулагдсан Аврагч Америкт буй хүмүүст хүрч иржээ. “Хүмүүс Их Эзэнд хөрвүүлэгдэв, мөн тэдний дунд арцалдаан байсан нь үгүй, мөн хүмүүн бүр нэг нэгтэйгээ шударгаар харьцаж байсан бөлгөө. . . .

“Мөнхүү улиран тохиох дор уг хүмүүсийн зүрх сэтгэлд орших Бурханы тэр хайрын учир, уг нутагт зөрчилдөөн огт байсангүй.

“Мөн атаяа жөтөө, хэрүүл маргаан, бас үймээн, садар самуун ч, худал хэлэх нь ч, аллага ч, ямар ч төрлийн шунал тачаал байсангүй; мөн Бурханы мутраар бүтээгдсэн тэдгээр бүх хүмүүсийн дунд илүү аз жаргалтай хүмүүс байх аргагүй нь гарцаагүй юм.

“Дээрэмчид ч, алуурчид ч, бас Лэмэнчүүд ч, бүр ямар ч –чууд байсангүй, харин тэд, Христийн хүүхдүүд мөн Бурханы хаант улсын өв залгамжлагчид гэгдэн нэг болсон байв” (4 Нифай 1:2; 15–17).

Агуу Их Хөрвүүлэгт Хичээх нь

Та нар өөрсдийнхөө хөрвүүлэгт юуны түрүүнд хариуцлага хүлээнэ. Хэн ч та нарын оронд хөрвүүлэгдэхгүй бөгөөд хэн ч чамайг хөрвүүлэхээр хүчлэхгүй. Гэсэн

## Христийн Гэрэл

хэдий ч, бусад хүмүүс хөрвүүлгийн үйл явцанд тань тусалж чадна. Гэр бүлийн гишүүд, Сүмийн удирдагчид болон багш нар, мөн судар дээрх эрэгтэй, эмэгтэйчүүдийн зөв шударга жишээнээс суралц.

Зүрх сэтгэлийн хүчтэй өөрчлөлтийг амсах боломж тань Аврагчийн төгс төгөлдөр жишээг дагахыг хичээвэл өсөн нэмэгдэх болно. Судраас суралц, итгэлтэйгээр залбир, зарлигуудыг дага мөн Ариун Сүнсний байнгын нөхөрлөлийг эрэлхийл. Хөрвүүлгийн үйл явцаа цаашид үргэлжлүүлвэл Сүнс “[тэдний] зүрх сэтгэлд нь хүчирхэг өөрчлөлтийг авчирсан” үед Хаан Бэнжамины хүмүүсийн үйлдсэнтэй адил “хэмжээлшгүй их баяр баяслыг” хүлээн авна (Мозая 5:2, 4-ийг үз). Та нар Хаан Бэнжамины “Та нар үүрдийн аврал мөн мөнх амьдралыг авч болохын тулд, та нар тэнгэрт авчрагдаж болохын тулд, Христ, Төгс Хүчит Их Эзэн Бурхан та нарыг өөрийнх байлгахаар лацдаж болохын тулд, би та нарыг хичээнгүй мөн гүйвшгүй байж, үргэлж сайн үйлүүдээр бялхаасай хэмээх” зөвлөгөөг дагах чадвартай байх болно. (Мозая 5:15).

Нэмэлт судрууд: Матай 18:3; Лук 22:32; Алма 5:7–14

Аврал; Ариун Сүнс; Баптиسم; Есүс Христийн Цагаатгалыг мөн үз.

## Христийн Гэрэл

Христийн Гэрэл нь “сансрыйн хязгааргүй уудмыг дүүргэхийн тулд Бурханы дэргэдээс урагш гардаг.” Энэ нь “бүх зүйлд байдаг, бүх зүйлд амьдралыг өгдөг, бүх зүйл түүгээр зохицуулагддаг хууль болох” гэрэл юм. (С ба Г 88:12–13; мөн шүлэг 6–11-ийг үз). Энэ хүч нь бүх хүмүүний амьдралд сайн нөлөөлөл үзүүлдэг (Иохан 1:9; С ба Г 93:2-ыг үз). Сударт, Христийн Гэрлийг зарим үед Их Эзэний Сүнс, Бурханы Сүнс, Христийн Сүнс, эсвэл Амьдралын Сүнс гэж нэрлэх нь бий.

Христийн Гэрлийг Ариун Сүнстэй андуурах ёсгүй. Энэ нь Ариун Сүнстэй адил хүмүүн биет биш юм. Энэ нь хүмүүсийг үнэн сайн мэдээг олж, баптисм хүртэж, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авахад нь чиглүүлдэг нөлөөлөл юм. (Иохан 12:46; Алма 26:14–15-ыг үз).

Ухамсар бол бидэнд сайн мууг ялгах боломжийг олгодог Христийн Гэрлийн илэрхийлэл юм. Бошиглогч Мормон заахдаа: “Христийн Сүнс нь хүн бүрт тэрбээр сайныг хилэнцтээс ялган мэдэж болохын тул өгөгдсөн байдаг, иймийн тул, би та нарт дүгнэх аргыг үзүүлье; учир нь Христэд итгүүлэхээр ятгахыг, мөн сайныг хийхийг урьдаг тэр зүйл болгон нь, Христийн хүч болон бэлгээр илгээгдсэн байдаг; иймийн тул та нар энэ нь Бурханаас гэдгийг төгс мэдлэгтэйгээр мэдэж болох бөлгөө. . . . Мөн эдүгээ, ах дүүс минь, түүгээр дүгнэж болох тэр, Христийн гэрэл болох тэр гэрлийг та нар мэдэх тул, буруугаар дүгнэхгүй байхаа мэдэгтүн; учир нь та нар шүүх тэрхүү шүүлтээрээ түүнчлэн шүүгдэх болно” гэжээ (Моронай 7:16, 18).

Нэмэлт судрууд: Иохан 8:12; Алма 28:14

Ариун Сүнс; Ухамсарыг мөн үз.

## Хувийн Илчлэлт (Илчлэлтийг үз)

### Хүндэтгэлийн Өдөр

Хүндэтгэлийн Өдөр нь амарч, бишрэхэд зориулсан Их Эзэний өдөр юм. Хуучин Гэрээний үед Бурханы гэрээт хүмүүс долоо хоногийн долоо дахь өдөр Хүндэтгэлийн Өдрийг сахьдаг байжээ, учир нь Бурхан газар дэлхийг бүтээж дуусаад долоо дахь өдрөө амарсан байдаг. Их Эзэн Арван Зарлиг дахь Хүндэтгэлийн Өдрийг сахихын чухлыг онцолжээ:

“Амралтын өдрийг санаж, үүнийг ариунаар сахь.

“Зургаан өдөр чи хөдөлмөрлөж, бүх ажлаа хий:

“Харин долоо дахь өдөр бол чиний Бурхан Эзэний амралт тул чи болон чиний хүү, чиний охин, чиний зарц, шивэгчин, чиний мал, танайд байгаа зочин ямар ч ажил хийж болохгүй.

“Учир нь Эзэн тэнгэр, газар, далай болон тэдгээрийн дотор байгч бүгдийг зургаан өдөр бүтээж, долоо дахь өдөрт амарсан” (Египетээс гарсан нь 20:8–11).

Долоо хоногийн эхний өдөр тохиосон Есүс Христийн Амилуулалтын дараа Их Эзэний шавь нар долоо хоногийн эхний өдөр Ням гарагт Хүндэтгэлийн Өдрийг сахиж эхэлсэн (Үйлс 20:7).

Хожмын өдрүүдэд Их Эзэн Хүндэтгэлийн өдрийг үргэлжлүүлэн сахихыг бидэнд зарлигласан. Хэрэв бид энэхүү зарлигийг дагах бол “дэлхийн бүрэн байдлыг” хүлээн авна хэмээн амласан (С ба Г 59:16–20-ыг үз).

Хүндэтгэлийн өдөр нь ариун өдөр учраас үүнийг зохистой болоод ариун үйл ажиллагаанд зориулах хэрэгтэй. Ажлаас хол байж, амралт чөлөөт цагтай байх нь хангалттай биш юм. Үнэндээ, хэрэв бид Хүндэтгэлийн Өдөр юу ч хийлгүй зүгээр суувал энэхүү өдрийг бид ариунаар нь хадгалж чадахгүй. 1831 онд Иосеф Смитэд өгөгдсөн илчлэлтээр Их Эзэн зарлиглахдаа: “Мөн чи өөрийгөө дэлхийгээс илүү бүрэн дүүрэн толбогүй байлгаж болгохын тулд, чи залбирлын өргөөнд очиж мөн миний ариун өдөрт ариун ёслолуудаа өргөх ёстой; учир нь үнэнээр энэ бол хөдөлмөрүүдээсээ амрахаар, мөн Бүхний Дээдэд чи бүхнээ зориулахаар чамд өгөгдсөн өдөр болой” гэжээ (С ба Г 59:9–10). Энэхүү илчлэлд нийцүүлэн бид ариун ёслолын цуглаанд долоо хоног бүр оролцдог. Хүндэтгэлийн Өдөр залбирах, бясалгах, судраас судлах, мөн хожмын үеийн бошиглогчдын сургаалууд, гэр бүлийн гишүүд, найз нөхөддөө захияа бичих, ашиг тустай материал унших, өвчтэй болон сэтгэл

санааны дарамттай хүмүүс дээр зочилж очих, Сүмийн бусад цуглаануудад оролцох зэрэг үйл ажиллагаануудыг хийж болно.

Нэмэлт судрууд: Египетээс гарсан нь 31:16–17; Мозая 18:23; С ба Г 59:11–14; 68:29

Ариун Ёслол; Бишрэл; Бишрэл Хүндэтгэлийг мөн үз.

## Хүүхэд Үрчлэх

Хүүхдүүдэд гэрлэлтийн амлалтыг хүндэтгэдэг, хайр болон дэмжлэг туслалцаа үзүүлдэг эцэг эхчүүдээр өсгүүлэх эрх олгогддог. Хүүхэд үрчилж авах нь энэ боломжийг аваагүй төрсөн олон хүүхдүүдийн хувьд агуу их адислал юм.

Бутач хүүхдийн хувьд гэвэл тэрхүү эцэг, эх гэрлэх болон хамтдаа мөнхийн гэр бүлийн холбоог тогтоохын төлөө ажиллах нь хамгийн сайн сонголт юм. Хэрэв амжилттай гэрлэлт бий болохгүй байвал тэд LDS Family Services /ХҮГ-ийн Сүмийн Гэр бүлийн Үйлчлэл/-ээр дамжуулан хүүхдээ хүнд өргүүлэх нь зүйтэй. LDS Family Services /ХҮГ-ийн Сүмийн Гэр бүлийн Үйлчлэл/-ээр дамжуулан нярайг үрчлэх нь гэрлээгүй хосуудад хүүхдээдээ хамгийн сайн гэгдэх зүйлийг хийхэд тусалдаг. Энэ нь хүүхэд ариун сүмд эцэг, эхтэйгээ лацдан холбуулдаг гэдгийг баталж, мөн үүнд хамаарах бүх хүмүүсийн амьдралд сайн мэдээний адислалууд ирнэ гэсэн горьдлогийг нэмэгдүүлдгийг баталж өгдөг. Хүүхэд үрчлүүлнэ гэдэг нь цусан төрлийн эцэг эх, хүүхэд болон үрчилж авч буйг гэр бүлийг адисалдаг бусдыг бодсон, зөв шийдвэр юм.

Гэрлэсний дараа та болон таны хань, хүүхэд үрчилж авахыг хүсвэл тус орны болоод засгийн газрын агентлагуудын оролцоотой хийгдэх бүх хууль зүйн шаардлагуудыг мэдэж авах хэрэгтэй. Санваарын удирдагчтайгаа болон хэрэв боломжтой бол LDS Family Services /ХҮГ-

## **Хүчирхийлэл**

ийн Сүмийн Гэр бүлийн Үйлчлэл/-ийн гишүүдтэй зөвлөлд. Хэрэв таны оршин суугаа газарт LDS Family Services /ХҮГ-ийн Сүмийн Гэр бүлийн Үйлчлэл/ байхгүй бол үрчилж авах эцэг, эх болоод хүүхдүүдийн аль алинийг нь хамгаалах эрх мэдэл олгогдсон агентлагуудыг санваарын удирдагчтайгаа хамт олохоор ажилла.

## **Хүчирхийлэл**

Хүчирхийлэл гэдэг бол бусдыг болон өөрийгөө гэмтээх буюу хор хохирол учруулах байдлаар хандаж байгаа хандлага юм. Энэ нь оюун санаа, сүнс болоод түүнчлэн ихэнхдээ биеийг гэмтээн сүйтгэдэг. Энэ нь төөрөгдөл, эргэлзээ, үл итгэлцэл болон айdas төрүүлдэг. Энэ нь нийгмийн хуулийг завхруулдаг бөгөөд бүхэлдээ Аврагчийн сургаалын эсрэг байдаг юм. Их Эзэн бие махбодын, бэлгийн, үг ярианы болон сэтгэл санааны ямарваа нэг хүчирхийллийг буруушаадаг. Хүчирхийлэх явдал нь Сүмийн сахилга руу хөтөлдөг.

## **Хүчирхийлэгчид Өгөх Зөвлөгөө**

Та аливаа харилцаандаа хүчирхийлэх хандлага гаргадаг бол нүглээ наманчлах ёстой. Их Эзэнээс өөрийгөө өршөөхийг гүй. Хор хөнөөл учруулсан бүх хүнээс учлалт гүйхыг эрэлхийл. Бишоп, эсвэл салбарын ерөнхийлөгчтэйгөө ярилц. Ингэснээр, хэрэв шаардлагатай бол тэрээр наманчлалын үйл явцаар дамжуулан танд нэмэлт зөвлөгөө өгч, бусад туслалцааг хүлээн авахад тань тусалж чадна.

Хэрэв уур хилэн таны хүчирхийлэх занг өдөөдөг бол уураа барихад суралц. Их Эзэнд залбиралтайгаар ирж, Түүнээс тусламж хүс. Та мөнхийн ойлголттойгоор уураа бараг байнга ач холбогдолгүй зүйлд хүргэдэг байсныг ойлгоно.

Хэрэв та бэлгийн хүчирхийлэлд буруутай бол оюун санаагаа сахилга баттай байлгахыг эрэлхийл. Таны бодол санаа амьдралд тань хүчтэй нөлөө үзүүлдгийг санагтун “учир нь тэр дотроо боддогтойгоо адил юм” (Сургаал Үгс 23:7). Бэлгийн хүслийг төрүүлэх порнографи болон ёс суртахуунгүй зүйлсээс хол бай. “Ариун журам бодол санааг чинь зогсолтгүй чимэн гоёх” чадварын төлөө залбир (С ба Г 121:45).

### Хүчирхийлэлд Өртөгчдөд Тусал

Хэрэв та хүчирхийлэлд өртөгч бол шууд тусlamж эрэлхийл. Санваарын удирдагчтайгаа, голдуу бишоп буюу салбарын ерөнхийлөгч, зарим тохиолдолд гадас, эсвэл дүүргийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүнтэй ярилц. Тэрээр танд юу хийхийг мэдэхэд тань тусалж чадна.

Та бусдын хор хөнөөлтэй явдлын буруутан нь биш гэдэгт итгэлтэй бай. Танд өөрийгөө буруутан мэт бодох хэрэггүй. Танихгүй хүн, танил, тэр байтугай гэр бүлийнхээ гишүүний хүчирхийлэлд өртөж, хүчингийн хэрэг эсвэл, бэлгийн бусад хүчирхийлийн хохирогч болсон бол та бэлгийн нүглийн буруутан нь биш юм. Та бол гэм зэмгүй бөгөөд Тэнгэрлэг Эцэг тань таныг хайрладаг гэдгийг ойлго.

Зөвхөн Есүс Христ болон Түүний Цагаатгалаар дамжин ирдэг амар амгалангийн төлөө залбир (Иохан 14:27; 16:33-ыг үз). Аврагч таны, тэр байтугай бусдын учруулсан өвчин зовлон, шаналлыг амссан бөгөөд Тэрээр танд яаж туслахаа мэддэг (Алма 7:11–12-ыг үз). Өшөө авахыг эрэлхийлэхийн оронд өөрийн санаа тавьдаг тухайлбал, амьдралынхаа төрх, үзэл бодолдоо анхаарлаа төвлөрүүл. Таныг гомдоосон тэднийг уучлах хүч чадлын төлөө залбир.

## **Хэсэг**

Санваарын удирдагчаасаа үргэлжлүүлэн тусlamж авбал тэр таныг сэтгэл санаагаараа эдгэрэх байдлаар удирдаж чадна. Та сайн мэдээний адислагаар дамжуулан хүчирхийлэгч зангаа татаж, өөрийн амсаж өнгөрүүлсэн шаналлаасаа чөлөөлөгдж чадна.

Нэмэлт судрууд: Матай 18:1–6; С ба Г 121:34–46

Өршөөл; Наманчлалыг мөн үз.

**Хэсэг** (Сүмийн Захиргааг үз)

**Цай** (Мэргэн Ухааны Үгийг үз)

**Цовдлуулалт** (Есүс Христийн Цагаатгал; Загалмайг үз)

**Чөтгөр** (Сатаныг үз)

**Чуулга** (Санваарыг үз)

## **Шивээс Хийлгэх нь**

Хожмын үеийн бошиглогчид биеэ цоолохыг хатуу эсэргүүцдэг. Энэхүү зөвлөгөөг ойшодоггүй тэдгээр нь Бурханыг болон өөрийгөө хүндэтгэхгүй байна гэсэн үг юм. Төлөөлөгч Паул бие махбодийн ач холбогдол болон санаатайгаар гутааж байгаагийн аюулыг заасан: “Та нар өөрсдөө Бурханы сүм мөн бөгөөд Бурханы Сүнс та нарын дотор оршидог гэдгийг мэддэггүй юм уу? Хэрэв хэн нэг нь Бурханы сүмийг устгавал Бурхан тэр хүнийг устгана” (1 Коринт 3:16–17).

Хэрэв танд шивээс байдаг бол та хийсэн алдааныхаа байнгын сануулгыг зүүж байна. Түүнийгээ арилгая хэмээн бодож магад.

Биеэ Цоолохыг үз.

## Шударга Байдал

Итгэлийн Тунхагийн арвангуравдугаарт “Бид шударга байхад итгэдэг” хэмээн тэмдэглэжээ. Шударга байна гэдэг нь бүхий л цаг үед чин сэтгэлээсээ, үнэнч мөн хуурахгүй байхыг хэлнэ.

Бүх талаараа шударга байвал бодол санаа тань амар амгалан байж, өөрийгөө хүндлэх хүндлэлийг төлөвшүүлэх чадвартай байж чадна. Та Бурхан болон бусдад үйлчлэхийг зөвшөөрөх хандлагaa бий болго. Та бол Бурханы мэлмийн өмнө болон өөрийг тань хүрээлж буй хүмүүсийн өмнө итгэл даах зохистой нэгэн юм.

Нөгөө талаар, ажил үйлс болон үг хэлээрээ үнэнч бус байвал та бас өөрийгөө болон өрөөл бусдыг хохиродог. Худал хэлж, хулгай хийж, хуурч мэхлэх буюу ажлаа цалгардуулдаг бол та өөрийгөө хүндэтгэн үзэх үзлээ алддаг. Ариун Сүнсний удирдамжийг алддаг. Магадгүй та гэр бүлийн гишүүд хийгээд наиз нөхдийнхөө харилцааг сүйтгэж, хүмүүс танд дахин итгэхгүй гэдгийг олж мэднэ.

Ялангуяа бусад хүмүүс таны шударга бус байдлыг шүүн тунгаах үед үнэнч шударга байх нь үргэлж зүрх зориг, золиослолыг шаарддаг. Та өөрийгөө иймэрхүү нохцөл байдалд байгааг мэдвэл үнэнч байдлаас ирдэг амар амгалан нь бусдыг сохроор дагахаас илүү үнэ цэнэтэй байдгийг сана.

Нэмэлт судрууд: Египетээс Гарсан нь 20:16; 2 Нифай 9:34; С ба Г 97:8

## Шударга Ёс

Шударга ёс нь үйлдлийн үр дагаврыг авчирдаг хувирашгүй хууль билээ. Шударга ёсны хууль байдаг учраас та Бурханы зарлигуудыг дагавал адислалуудыг хүлээн авна (С ба Г 130:21–22-ыг үз). Шударга ёсны хууль нь мөн таны үйлддэг нүгэл бүрийн тань төлоө хийгдэх

## Энэрэл

төлөөсийг шаарддаг. Цэвэр бус зүйлийг Бурхантай оршихыг зөвшөөрдөггүй (1 Нифай 10:21-ийг үз).

Аврагч цагаатгалыг үйлдэхдээ бидний нүглүүдийг Өөр дээрээ авсан. Тэрээр “хуулийн бүх шаардлагуудад хариулах” чадвартай байсан (2 Нифай 2:7) учраас бидний нүглүүдэд шаардлагатай шийтгэлд Өөрийгөө өгсөн юм. Ийнхүү үйлдсэнээр Тэрээр “шударга ёсны шаардлагуудыг гүйцэлдүүлж” мөн наманчилж мөн Өөрийг нь дагах тэд бүгдэд нигүүлсэнгүй хандсан (Мозая 15:9; Алма 34:14–16-г үз). Тэрээр нүглүүдийн тань төлөөсийг төлсөн учраас хэрэв та наманчлах аваас тэрхүү шийтгэлүүдээр шийтгэгдэхгүй байх болно (С ба Г 19:15–20-ийг үз).

Нэмэлт судрууд: 2 Нифай 9:26; Алма 42

Есүс Христийн Цагаатгал; Наманчлал; Нигүүлслийг мөн үз.

## Энэрэл

Энэрэл бол “Христийн цэвэр хайр” буюу “үүрдийн хайр” билээ (Моронай 7:47; 8:17). Бошиглогч Мормон “энэрэл нь удаан тэсвэрлэдэг, мөн сайхан сэтгэлтэй, мөн атаархаж жотөөрхөх үгүй, мөн онгируч хөөрдөггүй, өөрийнхийгөө эрэлхийлдэггүй, амар өдөөн хатгадаггүй, ямар ч хилэнцэтийг боддоггүй, мөн алдаст баясах нь үгүй, харин үнэнд баясдаг, бүх зүйлийг хүлцдэг, бүх зүйлд итгэдэг, бүх зүйлийг тэвчдэг билээ” гэж сургамжилсан (Моронай 7:45 мөн 1 Коринт 13:4–7-г үз).

Есүс Христ бол энэрлийн төгс төгөлдөр жишигээ билээ. Тэрээр өөрийн зуурдын тохинуулалд үргэлж сайн мэдээгээ зааж, ядарч зүдэрсэн, өвчтэй дарамттай хүмүүст өрөвч зөөлөн сэтгэлээр хандаж “явлж сайныг үйлдэж” байсан юм (Матай 4:23; Марк 6:6; Үйлс 10:38-ыг үз). Түүний энэрлийн хамгийн агуу илэрхийлэл бол Түүний хэмжээлшгүй Цагаатгал байсан юм. Тэрээр “нөхдийнхөө

төлөө амиа зориулахаас өөр агуу хайр байхгүй” хэмээжээ (Иохан 15:13). Энэ нь тэвчээр, сайхан сэтгэл болоод амиа үл бодсон бидний хэзээ ч үл ойлгом агуу их үйл байсан юм. Та аврагчийн мөнхийн хайрын ойлголттойгоор итгэлээ хөгжүүлж, нүглээ наманчилж чадвал Тэр таныг уучилж, таныг сайн мэдээгээр амьдрах хичээл зүтгэлээр тань хүчирхэгжүүлэх болно гэдэгт итгэлтэй байна.

Аврагч таныг Өөрийнхөө хайрыг хүлээн аваасай гэж хүсч байгаа мөн үүнийг бусадтай хуваалцахыг хүсч байгаа билээ. Тэрээр Өөрийнхөө шавь нартаа “Би та нарт бие биеэ хайрлагтуун, Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биеэ хайрлагтуун гэсэн шинэ зарлиг өгч байна. Хэрэв та нар бие биеэ хайрлавал үүгээр чинь бүх хүн та нарыг Миний шавь нар мөн гэдгийг мэдэх болно” гэж хэллээ (Иохан 13:34–35). Гэр бүлийн гишүүд болоод бусадтай харьцах харилцаандаа Аврагчийг өөрийн жишээ болгож хар. Түүний хайрладаг шиг мөхөшгүй хайр, тэвчээр хийгээд нигүүлслээр хайрлахыг хичээ.

Аврагчийн төгс төгөлдөр хайрыг үргэлжлүүлэн хүлээн авч, мөн бусдыг Христийн адил хайрлахаа нотолвол таны хайр осч болохыг та мэдэх болно. Их Эзэнд үйлчилснээр та баяр баясгалантай байдлыг мэдрэх болно. Ариун Сүнс таныг үйлчлэхэд болон бусадтай харьцах харилцааг тань удирдан таны байнгын хамтрагч байх болно. Тэр таныг Түүний ажилд бүхнээ зориулсны төлөө шагнах болоход та Их Эзэнтэй Шүүлтэн дээр уулзахаар бэлтгэгдэх болно. Мормон заахдаа:

“Хэрэв та нарт энэрэл үгүй бол, та нар хэн ч биш, учир нь энэрэл нь хэзээ ч үл барагддаг; иймийн тул, бүхнээс илүү агуу их тэр энэрлээс зуурган барь, учир нь бүх зүйл барагдах ёстой—

“Гэвч энэрэл нь Христийн цэвэр хайр, мөн энэ нь үүрд үл цөхрөх болно; мөн эцсийн өдөр үүнийг эзэмшиж байгаа нь олдсон хэн боловч, түүнд сайн байх болно.

## Энэрэл

“Иймийн тул, хайрт ах дүүс минь, та нар түүний Хүү Есүс Христийн үнэн дагалдагчид болох бүгдийн дээр түүний цутгасан тэр хайраар дүүргэгдэж болохын тулд; та нарын Бурханы хөвгүүд болж болохын тулд; тэрбээр үзэгдэхэд бид түүнтэй адил байх болно, учир нь бид түүнийг байгаагаар нь харах болно гэсний тул, бидэнд энэ найдвар байж болохын тулд бид түүний цэврийн адил цэвэр болгогдож болохын тулд” гэжээ (Моронай 7:46–48).

Нэмэлт судрууд: Матай 25:31–46; 1 Иохан 4:18; Ифэр 12:33–34; С ба Г 12:8; 34:3; 121:45

Хайр; Үйлчлэлийг мөн үз.

*Надаас сурагтун, мөн миний  
үгсийг анхаарагтун; миний Сүнсний  
номхон долгооң байдалд алхагтун,  
мөн надааар дамжин амар  
амгалан чамд байх болно.*

*Сургаал ба Гэрээ 19:23*

**ЕСҮС ХРИСТИЙН**  
ХОЖМЫН ҮЕИЙН  
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

MONGOLIAN



4 02368 63363 8  
36863 363